**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 11 сарын 28 өдөр Дугаар 185 Улаанбаатар хот

**Хуулийн төсөл нэн яаралтай хэлэлцүүлэх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг хэлэлцэх асуудлын тов, дарааллыг харгалзахгүйгээр Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлсүгэй.

2.Энэ захирамжийн 1 дэх заалтад заасан хуулийн төслийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо (Ц.Цэрэнпунцаг)-нд даалгасугай.

ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

2022000579

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 22 он 11 сарын 28 өдөр

Дугаар 3Г-1/149

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар нэн яаралтай хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000224003611

# МОНГОЛ УЛС
# ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 22 он 11 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар ХЭГ/2864

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011


УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх хугацааг товлох тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 19 хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Д.АМАРБАЯСГАЛАН

000225014179

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл:info@mof.gov.mn
Вэбсайт:www.mof.gov.mn

2022. 11. 23 № 01/7991

танай 2022.11.22-ны № 01/6843 -т

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрч байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761001558

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022.11.23 № 1/5930

танай ____________-ны №____________-т

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД Б.БАТ-ЭРДЭНЭ
ТАНАА

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Х.НЯМБААТАР

151605711

А5 Файл.2022

# МОНГОЛ УЛСЫН
# ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
# ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны 56 дугаар тэмдэглэлд:

"ХҮ.ХЭЛЭЛЦСЭН нь: Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов." гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ.
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД
Б.БАТ-ЭРДЭНЭ

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД
Х.НЯМБААТАР

# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

## Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

### 1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 4.2-т заасан эдийн засгийн тэргүүлэх салбарыг хөгжүүлэх зорилтын хүрээнд 2021-2030 онд “Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвар дээшилсэн байна.” гэж, мөн зорилт 8.2-т заасан эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтын хүрээнд 2021-2030 онд “Байгаль экологи, археологи, палеонтологи, нүүдлийн өв, түүх, соёл, рекреацийн нөөц, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлнэ” гэж тус тус заасан бөгөөд эдийн засгийг сэргээх үндсэн хөшүүргийн нэгээр аялал жуулчлалын салбарыг онцолж, тэдгээрийг биелүүлэх тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 27-д Монгол Улсын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан иргэн, хуулийн этгээд хооронд үүсэх харилцаа болон төрөөс аялал жуулчлалыг хөхиүлэн дэмжихтэй холбогдсон харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтыг дэвшүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.4-т “Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.” гэж, 3.4.5-д “Монголын нүүдлийн соёлын онцлогт тохирсон үндэсний шинэлэг, сор бүтээл, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, аялал жуулчлалыг дэмжинэ.” гэж, 3.4.7-д “Хил орчмын аялал жуулчлалыг дэмжиж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.” гэж, 3.4.9-д “Аялал жуулчлалын сургалтын төв байгуулж, салбарын чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх” гэж аялал жуулчлалыг эрчимжүүлэх үндсэн зорилтуудыг тус тус тодорхойлсон болно.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 333 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ын 4.1.5-д “Аялал жуулчлалын санг бий болгож, аялал жуулчлалыг хөгжүүлэх, дэд бүтцийг сайжруулах, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх төслүүдийг санхүүжүүлэх тогтолцоог бүрдүүлэх” гэж, 4.1.6-д “аялал жуулчлалын салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, нэмэгдүүлэх, бүтээн

байгуулалтын томоохон төслийг хэрэгжүүлэхийг бодлогоор дэмжих, төсвийн тогтвортой, үр ашигтай байх нөхцөлийг хангах чиглэлээр эрх зүйн орчин бүрдүүлэх" зорилтыг тус тус заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Боомтын сэргэлтийн 1.3-т "Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт, агаарын замын ашиглалтыг сайжруулан дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлалыг үе шаттайгаар үргэлжлүүлэх замаар ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, мөн аялал жуулчлалын салбарыг дэмжинэ." гэж, мөн тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 1.3.1-д "Агаарын замын байнгын ажиллагаатай олон улсын боомтын тоог нэмэгдүүлж, карго тээвэр, аялал жуулчлалыг хөгжүүлэх" гэж тус тус тодорхойлсон болно.

**1.2.Практик шаардлага**

Аялал жуулчлалын тухай хууль нь 2000 онд батлагдсан бөгөөд нийт 12 удаа нэмэлт, өөрчлөлт (2001, 2002, 2003, 2005, 2006, 2010, 2011, 2015, 2017, 2021, 2022) орсон хэдий ч эдгээр өөрчлөлтүүд нь нийгэм, эдийн засгийн хөгжил, аялал жуулчлалын салбарын хурдацтай өөрчлөлт, шинэчлэлтүүдтэй нийцэж чадаагүй байна.

Үүний улмаас жуулчны аюулгүй байдал, аялал жуулчлалын байгууллагын мэргэжлийн хариуцлагын даатгал, аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа тур оператор, тур агент, жуулчны үйлчилгээний байгууллагад тодорхой дэмжлэг үзүүлэх, аялал жуулчлалын үйл ажиллагаанд нутгийн иргэдийг дэмжих, агнуурын аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаадын жуулчны худалдан авсан бараа, бүтээгдэхүүнд татварын буцаан олголт олгох зэрэг нийгмийн хөгжлийн явцад аялал жуулчлалын хуулиар зохицуулагдах шаардлагатай шинэ төрлийн харилцаанууд ямар нэг эрх зүйн зохицуулалтгүй байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас аялал жуулчлалыг бооцоот морин уралдаан, бооцоот таавар, хонжворт сугалаа болон казинотой хослуулан хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх, аялал жуулчлалын зорилгоор хувийн жижиг онгоц, агаарын хөлөг болон бусад тээврийн хэрэгсэл ашиглах нөхцөлийг бусад хууль тогтоомжтой уялдуулан шинэчлэх, тэдгээртэй холбоотой төлбөр хураамжийг тодорхой болгох замаар агаарын тээврийн либералчлалыг дэмжих, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх санг бүрдүүлэн аялал жуулчлалыг дэмжих тогтвортой санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх зэрэг нийгэм, эдийн засгийн шаардлагаар бий болсон шинэ төрлийн харилцааг зохицуулах эрх зүйн орчин нэн тэргүүнд шаардлагатай байна.

Манай улсад ирсэн жуулчдын тоо цар тахлаас өмнө тогтмол өсөлттэй байсан бөгөөд 2019 онд 577,262 жуулчин хүлээн авч, мөн оны эцсийн байдлаар 607,213,369 ам доллар буюу 1.7 их наяд төгрөгийн орлогыг аялал жуулчлалын салбараас төвлөрүүлсэн нь тухайн оны ДНБ-ний 6.48%-ийг эзэлж байсан. Нөгөө талаас мөн онд манай улсаас нийт 2,080,276 жуулчин гадагш зорчсон нь дотоодын аялал жуулчлал сайн хөгжиж чадаагүйг илэрхийлж байна.

Ковид-19 цар тахлын улмаас уналтад орсон аялал жуулчлалын салбарыг эрчимтэй хөгжүүлэхээр Засгийн газраас 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарлаж, гадаад жуулчдын тоог 2024 он гэхэд 1,6 сая хүргэх зорилтыг дэвшүүлээд

байгаа хэдий ч хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Аялал жуулчлалын тухай хуульд жуулчны аюулгүй байдлыг хэрхэн хангах, тусгай сонирхлын аялал болон уулын спорт аялал, усан аялал, спорт агнуур, олзворын ан, нисдэг тэрэгний аялал, усны гүнд шумбах, авто спортын аялал зэрэг эрсдэл бүхий аяллын явцад тухайн чиглэлийн мэргэшсэн сургагч багш, зааварлагч, жуулчны хөтөчтэй аялах, даатгалд хамрагдахтай холбогдсон нарийвчилсан зохицуулалт тусгагдаагүйгээс үүдэн жуулчин эрүүл мэнд, эд хөрөнгө, амь насаараа хохирч, жуулчны аюулгүй байдалтай холбоотой гэмт хэрэг, зөрчил ихээхэн гарах болсон.

Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутаг нь аялал жуулчлалын үйл ажиллагаанд онцгой ач холбогдолтой бөгөөд нийт аялал жуулчлалын байгууллагын 80 орчим хувь нь тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаагаа явуулж байна. Харамсалтай нь тусгай хамгаалалттай газар нутагт явагдаж байгаа аялал жуулчлалын үйл ажиллагааны зохицуулалт дутмаг, аялагч болон жуулчин нь өөрийн хүссэн газартаа буудаллах, хог хаягдлыг ил задгай орхисноос үүдэн орчны бохирдол, газрын доройтол ихээхэн нэмэгдэж байгаа тул тухайн бүсэд орчны бохирдол бий болохоос урьдчилан сэргийлгэх, аялагч болон жуулчны тав тухтай аялах нөхцөлийг бүрдүүлэх, орон зайн төлөвлөлтийг зөв зохион байгуулах зорилгоор тодорхой бүс нутгийг аялал жуулчлал бүс болгон хөгжүүлэх, отоглох цэг байгуулах бодит хэрэгцээ байна.

Мөн НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас 2008 онд гишүүн орнууддаа хандаж гаргасан “Аялал жуулчлалын нэр томьёоны тайлбар”-т нийцүүлэн хууль тогтоомжид тусгагдсан нэр томьёог өөрчлөх, шинэчлэх нь үндэсний бизнес эрхлэгчид олон улсын аялал жуулчлалын зах зээлд үйл ажиллагаа тогтвортой эрхлэх боломжийг бий болгоно.

Аялал жуулчлалын салбар дахь гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, гадаадын өндөр чадвар бүхий мэргэжилтнүүд ажиллах орчин нөхцөлийг бий болгох, тур оператор болон тур агент, жуулчны хөтөч, харилцааг шинэ түвшинд зохицуулах, тур операторын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй болгох, мэргэжлийн хариуцлагын даатгалд албан журмаар даатгуулах замаар хариуцлагыг нэмэгдүүлэх, жуулчны аюулгүй байдлыг хангах, гадаадын жуулчдад үйлчилгээ үзүүлж буй аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагыг төрөөс үйлчилгээний экспортын үйлдвэрлэл гэж үзэн бодлогоор дэмжих, аялал жуулчлалын салбарт олон улсын жишгийг нэвтрүүлэх зайлшгүй хэрэгцээтэй байна.

Мөн аялал жуулчлалын салбарын харилцаанд төр, хувийн хэвшлийн түншлэлийн сайн жишиг хэдийн тогтсон тул үүнийг дэмжих, төрийн зарим чиг үүргийг салбарын мэргэжлийн холбоогоор гүйцэтгүүлэх нөхцөлийг илүү тодорхой хуульчлах, аялал жуулчлалын бүсийн менежментийг төр, хувийн хэвшил хамтарсан хэлбэрээр хэрэгжүүлэх боломжийг бий болгох шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Монгол Улсын аялал жуулчлалын салбарын дээр дурдсан тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх, жуулчдын тоог нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх, агаарын зорчигч тээврийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, Монгол Улсыг гадаад, дотоодод сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах, аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгох, хөгжүүлэх зорилгоор олон улсын жишгээр аялал жуулчлалыг хөгжүүлэх Засгийн газрын тусгай санг улсын нийт төсөвт нэмэлт дарамт үзүүлэхгүйгээр бий болгох шаардлагатай байна.

Иймд дээр дурдсан хууль зүйн үндэслэл, практик шаардлагад үндэслэн Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг тодорхойлсон болно.

**Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Аялал жуулчлалын тухай хуулийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай байх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 25.1.4-т заасны дагуу Аялал жуулчлалын тухай хуулийн төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үндэсний онцлог бүхий байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан тогтвортой аялал жуулчлалын үйлдвэрлэлээр эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, дэмжихтэй холбогдсон болон аялал жуулчлалын үйл ажиллагаанд төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулна.

Хуулийн төсөлд уг хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгана:

- Аялал жуулчлалын байгууллагыг тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага гэж ангилж, тур операторын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй эрхлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах шаардлагыг тодорхой зааж, тур оператор, аяллын агентлын эрхлэх үйл ажиллагааны ялгаа заагийг тодорхой болгоно;

- Тодорхой газар нутагт тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх, орон зайн зохистой төлөвлөлтийг бий болгох зорилгоор аялал жуулчлалын бүсийг улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүсийг байгуулан хөгжүүлэх, бүсийн менежментийг бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжийг бүрдүүлнэ;

- Аялал жуулчлалын салбар дахь орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, үүрэг хариуцлага, эрх хэмжээг тодорхой болгосон зохицуулалтыг тусгана. Тухайлбал, харьяалах нутаг дэвсгэртээ аялал жуулчлалын арга хэмжээг төлөвлөн мэргэжлийн холбоо, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх, жуулчин болон аялагч байрлах отоглох цэгийн төлбөр хураамжийг тогтоох эрхийг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай нийцүүлэн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд, отоглох цэгийн байршлыг тогтоох, аяллын маршрутыг тогтоох, тэмдэг тэмдэглэгээ байрлуулах эрхийг сум, дүүргийн Засаг даргад, дэвсгэртээ жуулчны мэдээллийн төв байгуулах эрхийг аймаг, нийслэлийн Засаг даргад тус тус олгож, отоглох цэгийн менежментийг хувийн хэвшил гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх, жуулчдын аюулгүй байдлыг хангахын тулд олон нийтийн англи хэлтэй жуулчин цагдаа ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

- Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага нь Монгол Улсын болон олон улсын холбогдох стандартын шаардлагыг хангаж ажиллах ба ялангуяа ариун цэврийн байгууламжийг онцгой анхаарч, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж барих, засварлах зардлыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хасагдах зардалд тооцох зохицуулалтыг тусгана;

- Хил орчмын аялал жуулчлалын үйл ажиллагааг батлагдсан маршрутаар олон улсын аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй тур оператор гүйцэтгэх зохицуулалтыг тусгана;

- Тусгай зориулалтын агнуурын аялал жуулчлалыг дэмжих зорилгоор сүргийн бүтцийг алдагдуулахгүйгээр тооцоо, судалгаанд үндэслэн аргаль хонь, янгир ямаа, идлэг шонхор, тул загасыг агнах, барих тусгай зөвшөөрлийг дуудлага худалдааны журмаар нээлттэй ил тод олгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ;

- Төрөөс аялал жуулчлалыг дэмжих тогтвортой санхүүжилтийг бүрдүүлэх зорилгоор Аялал жуулчлалыг хөгжүүлэх санг байгуулж, сангийн хөрөнгийг агаарын зорчигч тээврийн үйлчилгээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, аялал жуулчлалыг улирлын хамаарлыг бууруулах, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, Монгол Улсыг гадаад, дотоодод сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах, аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгох, хөгжүүлэхэд зарцуулах бөгөөд санхүүжилтийн эх үүсвэрийг казино, боооцоот морин уралдааны татварын орлого болон олон улсын нислэгийн зорчигчоос хураан авах аялал жуулчлалын төлбөрийн орлого, агаарын навигацийн үйлчилгээнээс улсын төсөвт төвлөрсөн орлогын тодорхой хувь, жуулчинд олгох татварын буцаан олголтын тодорхой хувь зэрэг эх үүсвэрээс бүрдүүлэх зохицуулалтыг тусгана;

- Жуулчдын худалдан авсан бараа, бүтээгдэхүүнд ногдуулсан нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгох, жуулчны татвар бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ;

- Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аялал жуулчлалын зарим төрлийн төрийн үйлчилгээг аялал жуулчлалыг мэргэжлийн холбоогоор гүйцэтгүүлэх, тухайлбал аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэл олгох, тур операторын тусгай зөвшөөрөл олгох, жуулчны хөтчийг бүртгэх чиг үүргийг гүйцэтгүүлэх эрх зүйн үндэслэлийг нарийвчлан тодорхойлно.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталж мөрдүүлснээр доор дурдсан зэрэг үр дүн гарна гэж үзэж байна. Үүнд:

1.Үндэсний онцлог бүхий байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан тогтвортой аялал жуулчлалын үйлдвэрлэлээр эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдэж, Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбар болох зорилтын хүрээнд 2030 он гэхэд 3 сая жуулчин хүлээн авах, дотоодын нийт бүтээгдэхүүний 30-аас доошгүй хувийг бүрдүүлэх боломжтой болно;

2.Тогтвортой хөгжлийн зарчим, ногоон эдийн засгийн хөгжлийн бодлогод нийцсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үндсэн дээр хөгжүүлэхэд иргэд, олон нийтийн оролцоог дэмжих, салбар дундын болон төв, орон нутгийн байгууллагын үйл ажиллагааны уялдааг хангах замаар мэргэжлийн бие даасан тогтолцоог бүрдүүлж, төрийн эрх мэдлийн төвлөрлийг сааруулна;

3.Дотоодын аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бодлогоор дэмжих, хариуцлагыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын байгууллагыг мэргэжлийн хариуцлагын даатгал болон жуулчныг эрсдэлийн, гэнэтийн ослын даатгалд хамруулснаар жуулчны аюулгүй байдал хангагдан, бодит эрсдэлээс урьдчилан сэргийлэх, учирсан хохирлоо нөхөн барагдуулах хөшүүрэгтэй болохоос гадна Монгол Улсын аялал жуулчлалын олон улсад өрсөлдөх чадвар нэмэгдэнэ;

4.Аялал жуулчлалын байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлж, мэргэжлийн түвшинд чадавхжуулах нөхцөл бүрдэж, аялал жуулчлалын салбарын олон улсад нийтлэг хэрэглэгддэг нэр томьёог шинэчлэн тодорхойлно;

5.Аялал жуулчлалын үйл ажиллагааг дэмжих тогтвортой санхүүжилтийн эх үүсвэр бүрдэж, аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн удирдлагын дийлэнх олонхыг олон нийтийн төлөөлөл хэрэгжүүлж, сангийн хөрөнгийн зарцуулалтыг хяналтыг төр, олон нийтийн төлөөлөл хамтран хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ;

6.Тусгай сонирхлын аялал жуулчлалын тэргүүлэх чиглэлд байгалийн нөөцийн зохистой менежментэд тулгуурласан тусгай зориулалтын агнуурын аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжих нөхцөл бүрдэнэ;

7.Гадаадын жуулчны виз олголтыг хөнгөвчлөх, хурдан шуурхай болгох, визгүй зорчих орны тоог нэмэгдүүлэх боломжтой болж, Монгол Улсыг зорин ирэх жуулчны тоо нэмэгдэнэ.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар**

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон холбогдох бусад хууль тогтоомжтой уялдуулан боловсруулна.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан Аялал жуулчлалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг дагалдуулан боловсруулна.

---оОо---

# ТАНИЛЦУУЛГА

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн
найруулгын төслийн тухай

Аялал жуулчлалын салбараас дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний 10,4 хувь буюу 8,8 их наяд ам.долларыг, нийт экспортын 7 хувь буюу 1,6 их наяд ам.долларыг тус тус бүрдүүлж, 319 сая ажлын байрыг бий болгосон нь нийт ажлын байрны 10 хувийг эзэлж байна.[1] Манай улсад ирсэн жуулчдын тоо цар тахлаас өмнө тогтмол өсөлттэй байсан бөгөөд 2019 онд 577,262 жуулчин хүлээн авч, оны эцсийн байдлаар 607,213,369 ам доллар буюу 1.7 их наяд төгрөгийн орлогыг аялал жуулчлалын салбараас төвлөрүүлсэн[2] нь Монгол Улсын хувьд уул уурхай болон мал аж ахуйн дараа орох томоохон салбар нь аялал жуулчлалыг салбарын болохыг илтгэдэг. Гэсэн хэдий ч өнөөг хүртэл аялал жуулчлалын салбар, энэ салбарт үйл ажиллагаагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдэд төрөөс бодит тусламж, дэмжлэгийг үзүүлж чадаагүй байна.

Аялал жуулчлалын тухай хууль 2000 онд батлагдсан хэдий ч Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай зэрэг хууль тогтоомжууд шинээр батлагдсан болон бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотойгоор нийт 12 удаа нэмэлт, өөрчлөлт орсон[3] нь тус хууль нийгмийн өөрчлөлт, шинэчлэлтийн явцад уялдан шинэчлэгдээгүй болохыг илтгэдэг.

Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх нь ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, үндэсний өв, уламжлал, соёл, ёс заншил, түүх, дурсгалын үнэт зүйлсийг сурталчлан таниулах улмаар эдийн засгийн эргэлтэд оруулах үйлсэд чухал ач холбогдолтой тул цаашид төрөөс тус салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, салбарын өмнө тулгамдсан асуудлыг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан шийдвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх практик шаардлага зүй ёсоор гарч байна.

Аялал жуулчлалын салбар дахь гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, гадаадын өндөр чадвар бүхий мэргэжилтнүүд ажиллах орчин нөхцөлийг бий болгох, тур оператор болон аяллын агент, жуулчны хөтөч, харилцааг шинэ түвшинд зохицуулах, тур операторын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй болгох, мэргэжлийн хариуцлагын даатгалд албан журмаар даатгуулах замаар хариуцлагыг нэмэгдүүлэх, жуулчны аюулгүй байдлыг хангах, гадаадын жуулчдад үйлчилгээ үзүүлж буй аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагыг төрөөс үйлчилгээний экспортын үйлдвэрлэл гэж үзэн бодлогоор дэмжих, аялал жуулчлалын салбарт олон улсын жишгийг нэвтрүүлэх зайлшгүй хэрэгцээ байна.

Ковид-19 цар тахлын улмаас уналтад орсон аялал жуулчлалын салбарыг эрчимтэй хөгжүүлэхээр Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарлаж[4], гадаад жуулчдын тоог 2024 он гэхэд нэг сая хүргэх зорилтыг[5] дэвшүүлээд байгаа хэдий ч хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Аялал жуулчлалын тухай хуульд жуулчны аюулгүй байдлыг хэрхэн хангах, уулын спорт аялал, усан аялал, спорт агнуур, олзворын ан, нисдэг тэрэгний аялал, усны гүнд шумбах, авто спортын аялал зэрэг эрсдэл бүхий тусгай сонирхлын аяллын явцад тухайн чиглэлийн мэргэшсэн сургагч багш, зааварлагч, жуулчны хөтөчтэй аялах, даатгалд хамрагдахтай холбогдсон нарийвчилсан зохицуулалт

---

[1] https://www.unwto.org/tourism-statistics

[2] Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2019 оны тоон мэдээлэл.

[3] www.legalinfo.mn сүүлийн нэвтрэлт 2022 оны 11 сар.

[4] Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 264 дугаар тогтоол.

[5] Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралт “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.4.4-т “Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, жуулчдын тоог нэг саяд хүргэнэ.” гэж заасан.

тусгагдаагүйгээс үүдэн жуулчин эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирч, жуулчны аюулгүй байдалтай холбоотой гэмт хэрэг, зөрчил ихээхэн гарах болсон.

Иймд дээр дурдсан үндэслэл, шаардлагыг харгалзан, аялал жуулчлалын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор өөрийн орны өвөрмөц онцлог, олон улсын жишиг, чиг хандлагад нийцүүлэн Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар үндэсний онцлог бүхий байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан тогтвортой аялал жуулчлалын үйлдвэрлэлээр эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, дэмжих болон аялал жуулчлалын үйл ажиллагаанд төр, иргэн, хуулийн этгээд хооронд үүсэх харилцааг зохицуулахаар боловсруулахдаа Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон холбогдох бусад хууль тогтоомжтой уялдууллаа.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан Аялал жуулчлалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг дагалдуулан боловсруулна.

Шинэчилсэн найруулгын төсөлд дараах онцлог зохицуулалтууд тусгагдсан. Үүнд:

1.Аялал жуулчлалын байгууллагыг тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага гэж ангилж, тур операторын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй эрхлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах шаардлагыг тодорхой тусгаж, тур оператор, аяллын агентын эрхлэх үйл ажиллагааны ялгаа заагийг нарийвчлан тусгав.

2.Тодорхой газар нутагт тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх, орон зайн зохистой төлөвлөлтийг бий болгох зорилгоор аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх, аялал жуулчлалын бүсийг улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүс байдлаар ангилах, бүсийн менежментийг бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх зохицуулалтыг тусгав.

3.Нутгийн иргэдэд түшиглэсэн нүүдлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжийг бүрдүүлж, малчид эвлэлдэн нэгдэж аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахыг төрөөс болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас бодлогоор дэмжлэг үзүүлэхээр заасан.

4.Хуулийн нэр томьёоны тодорхойлолтыг НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас гаргасан нэр томьёоны тайлбарт нийцүүлэн боловсруулж, тодорхойлсон.

5.Аялал жуулчлалын салбар дахь орон нутгийн оролцоог тодорхой болгов. Тухайлбал, харьяалах нутаг дэвсгэртээ жуулчин болон аялагч байрлах отоглох цэгийн хураамжийг тогтоох эрхийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд, отоглох цэгийн байршлыг тогтоох, аяллын маршрутыг тогтоох, тэмдэг тэмдэглэгээ байрлуулах эрхийг сум, дүүргийн Засаг даргад, дэвсгэртээ жуулчны мэдээллийн төв байгуулах эрхийг аймаг, Нийслэлийн Засаг даргад олгож, отоглох цэгийн менежментийг хувийн хэвшил гүйцэтгэх боломжийг бүрдүүлж, олон нийтийн аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хангуулах байдлаар тусгасан.

6.Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагууд нь стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай байх, байгууламж барих, засварлах зардлыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хасагдах зардалд тооцох зохицуулалтыг тусгаж, хил орчмын аялал жуулчлалыг олон улсын аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй тур оператор гүйцэтгэхээр зохицуулсан.

7.Ан агнуурын аялал жуулчлалыг дэмжих зорилгоор сүргийн бүтцийг алдагдуулахгүйгээр тооцоо, судалгаанд үндэслэн аргаль, янгир, идлэг шонхрыг агнах, тул загасыг барих, агнах тусгай зөвшөөрлийг дуудлага худалдаагаар олгох эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

8.Төрөөс аялал жуулчлалыг дэмжих чиглэлд аялал жуулчлалыг хөгжүүлэх санг байгуулж, сангийн эх үүсвэрийг казино, бооцоот морин уралдааны татварын орлого болон олон улсын нислэгийн зорчигчоос хураан авах аялал жуулчлалын төлбөрийн орлого, агаарын навигацийн үйлчилгээнээс улсын төсөвт төвлөрсөн орлогын тодорхой хувь, жуулчинд олгох татварын буцаан олголтын тодорхой хувь зэрэг эх үүсвэрээс бүрдүүлэх ба сангийн хөрөнгийг агаарын зорчигч тээврийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, аялал жуулчлалыг улирлын хамаарлыг бууруулах, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, Монгол Улсыг гадаад, дотоодод сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах, аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгох, хөгжүүлэхэд зарцуулахаар зохицуулсан.

9.Жуулчдын худалдан авсан бараа, бүтээгдэхүүнд ногдуулсан нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгох эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

10.Аялал жуулчлалыг мэргэжлийн холбоог байгуулж, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэл олгох, тур операторын тусгай зөвшөөрөл олгох, жуулчны хөтчийг бүртгэх, үнэмлэх олгох чиг үүргийг шилжүүлж болохоор тус тус тусгана.

Уг хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдэж, гадаад дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэхийн хэрээр орон нутагт ажлын байр олноор бий болж, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх нөхцөл бүрдэх бөгөөд улмаар аялал жуулчлалын салбараас ДНБ-ний 30, түүнээс дээш хувийг бүрдүүлэх нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

---o0o---

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

## АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь үндэсний онцлог бүхий байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан тогтвортой аялал жуулчлалын үйлдвэрлэлээр эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, дэмжихтэй холбогдсон болон аялал жуулчлалын үйл ажиллагаанд төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Аялал жуулчлалын хууль тогтоомж**

2.1.Аялал жуулчлалын хууль тогтоомж нь Иргэний хууль[1], Соёлын өвийг хамгаалах тухай хууль[2], Засгийн газрын тусгай сангийн тухай хууль[3], Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль[4], энэ хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Тусгай хамгаалалтай газар нутгийн тухай хуульд тухайлан зааснаас бусад аялал жуулчлалын үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулна.

**4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“аялал жуулчлал” гэж хүн өөрийн байнга оршин суудаг газар нутгаасаа нэг хоногоос 90 хоног хүртэлх хугацаагаар суралцах, ажил хөдөлмөр эрхлэхээс бусад зорилгоор өөр газарт аялан явахыг;

4.1.2.“жуулчин” гэж аялал жуулчлалын байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авч аялал жуулчлал хийж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;

4.1.3.“аялагч” гэж аяллын зорилгоор аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлж байгаа хүнийг;

---

[1]Иргэний хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.
[2]Соёлыг өвийг хамгаалах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2014 оны 23 дугаарт нийтлэгдсэн.
[3]Засгийн газрын тусгай сангийн тухай “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2019 оны 48 дугаарт нийтлэгдсэн.
[4]Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1997 оны 11 дугаарт нийтлэгдсэн.

4.1.4."аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ" гэж аялал жуулчлалын байгууллагаас жуулчдад санал болгож байгаа аяллын явцад шаардагдах 2, түүнээс дээш бүтээгдэхүүн, үйлчилгээг;

4.1.5."аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага" гэж зочид буудал, жуулчны бааз, амралтын газар зэрэг бусад төрлийн жуулчны байр сууц, тээвэр, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийг;

4.1.6."тур оператор" гэж аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөн бүрдүүлж, жижиглэн, эсхүл хоёр, түүнээс дээш бүтээгдэхүүн, үйлчилгээг багцлан шууд, эсхүл аяллын агентаар дамжуулан худалдан борлуулах, зохион байгуулах хуулийн этгээдийг;

4.1.7."аяллын агент" гэж тур оператор болон аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагаас гаргасан аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг жижиглэн, эсхүл хоёр, түүнээс дээш бүтээгдэхүүн, үйлчилгээг зуучлан худалдан борлуулж байгаа хүн, хуулийн этгээдийг;

4.1.8."жуулчны хөтөч" гэж жуулчинд үндэсний түүх, соёл, өв уламжлал, зан заншил, байгаль, газар зүйн онцлог болон шаардлагатай бүхий л мэдээллийг хүргэж аяллыг хөтлөн явуулах энэ хуульд заасан шаардлага хангасан хүнийг;

4.1.9."тусгай сонирхлын аялал жуулчлал" гэж жуулчин, эсхүл жуулчны бүлэгт урлаг, спорт, ан агнуур, адал явдалт болон танин мэдэхүйн зэрэг тэдний сонирхсон чиглэлээр үзүүлэх аялал жуулчлалын үйлчилгээг;

4.1.10."аялал жуулчлалын дэд бүтэц" гэж аялал жуулчлалын зориулалттай байр сууц, зам, тээвэр, усан хангамж, ариун цэврийн байгууламж, түр амрах цэг зэрэг байгууламж, харилцаа, холбоо, мэдээлэл технологийн цахим дэд бүтцийг;

4.1.11."аялал жуулчлалын нөөц" гэж аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг эрхлэхэд шаардагдах газрын гадаргуу дээрх байгалийн тогтоц, амьтан, ургамал, түүх, археологи, шашин, соёлын биет болон биет бус өв болон өв тээгчийг;

## ХОЁРДУГААР БҮЛЭГ.
## АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**5 дугаар зүйл.Аялал жуулчлалын үйлдвэрлэл**

5.1.Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, тэдгээрийг хэрэглэгчдэд хүргэх үйлдвэрлэл, үйл ажиллагаа нь аялал жуулчлалын үндсэн ба дагалдах бүтээгдэхүүн, үйлчилгээнээс бүрдэнэ.

5.2.Аялал жуулчлалын үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнд дараах үйлчилгээ хамаарна:

5.2.1.жуулчныг байр сууцаар хангах үйлчилгээ;
5.2.2.зорчигч тээврийн үйлчилгээ;
5.2.3.аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох, хөгжүүлэх үйлчилгээ.

5.3.Аялал жуулчлалын дагалдах бүтээгдэхүүн, үйлчилгээнд дараах үйлчилгээ хамаарна:

5.3.1.хоол үйлдвэрлэл, үйлчилгээ;
5.3.2.аялал жуулчлалын мэдээлэл, зар сурталчилгааны үйлчилгээ;
5.3.3.урлаг, үзвэр үйлчилгээ, соёлын бусад үйлчилгээ;
5.3.4.худалдаа үйлчилгээ;
5.3.5.аялал жуулчлалын гар урлалын бүтээгдэхүүн.

5.4.Төрөөс экспортын үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэг, хөнгөлөлтөд энэ хуулийн 5.2, 5.3-т заасан аялал жуулчлалын байгууллагын гадаадын жуулчинд үзүүлсэн үйлчилгээ нэгэн адил хамаарна.

**6 дугаар зүйл.Аялал жуулчлалын байгууллага**

6.1.Аялал жуулчлалын байгууллага нь аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг жуулчинд үзүүлэх зорилго бүхий Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан ашгийн төлөө хуулийн этгээд байна.

6.2.Аялал жуулчлалын байгууллагыг дараах байдлаар ангилна:

6.2.1.тур оператор;
6.2.2.аяллын агент;
6.2.3.аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага.

6.3.Энэ хуулийн 6.2.2-т заасан аяллын агентын үйл ажиллагааг Монгол Улсын иргэн эрхэлж болно.

6.4.Энэ хуулийн 6.2-т заасан ангилалд тусгагдаагүй байгууллага тусгай сонирхлын болон бусад төрлийн эрсдэл бүхий аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд энэ хуулийн 27.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бүртгүүлсэн байна.

6.5.Тур оператор, аяллын агент нь энэ хуулийн 27.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бүртгүүлсэн байна.

6.6.Энэ хуулийн 6.2.3-т заасан аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэлийг тогтоох, түүнийг олгох, бууруулах, хүчингүй болгох, энэхүү үйл ажиллагаанд авах үйлчилгээний хөлстэй холбоотой журмыг Засгийн газар батална.

6.7.Энэ хуулийн 6.6-д заасан журмын дагуу аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэлийг энэ хуулийн 27.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээд олгоно.

6.8.Аялал жуулчлалын байгууллага аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан борлуулахдаа гадаадын болон дотоодын жуулчдад ялгамжтай байдлаар үнэ тогтоож үйлчлэхийг хориглоно.

6.9.Аялал жуулчлалын байгууллага нь байгаль орчинд сөрөг нөлөөтэй, соёлын биет өв буюу түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалт зүйлийн бүрэн бүтэн байдал, хэлбэр, шинж чанарыг алдагдуулж, гэмтээх байдлаар аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

6.10.Аялал жуулчлалын байгууллага нь татварын цахим төлбөрийн систем, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдон үйл ажиллагаа явуулах бөгөөд бараа, ажил, үйлчилгээ үзүүлэх бүрд цахим төлбөрийн баримт олгоно.

**7 дугаар зүйл.Тур оператор**

7.1.Тур оператор нь дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

7.1.1.аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөх, бүрдүүлэх, бий болгох, сурталчлах, жижиглэнгээр, эсхүл хоёр, түүнээс дээш бүтээгдэхүүн, үйлчилгээг багцлан худалдан борлуулах, аялал зохион байгуулах;

7.1.2.жуулчдад зориулсан соёл, урлаг, олон нийтийн арга хэмжээг зохион байгуулах, борлуулах;

7.1.3.виз авахтай холбогдсон болон аяллын бусад бичиг баримтын бүрдүүлэлт хийх;

7.1.4.агаарын, төмөр замын болон бусад тээврийн хэрэгслээр зорчих билет /тийз/-ийн захиалга хийх, билет /тийз/ худалдах, борлуулах;

7.1.5.хуулиар хориглосноос бусад үйл ажиллагаа.

7.2.Тур оператор нь дараах үүрэгтэй байна:

7.2.1.Монгол Улсын түүх, зан заншлын талаар жуулчдад үнэн зөв, бодит мэдээлэл өгөх;

7.2.2.аялал жуулчлалын мэдээллийн санд өөрийн багц аяллын төрөл, чиглэл, үнэ, хүний нөөц, хөрөнгө оруулалт, үйлчлүүлсэн жуулчин, хамтран ажилладаг аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, хөтчийн талаарх мэдээллийг өгөх;

7.2.3.аяллыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулах, түүнд хяналт тавих, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө боловсруулж ажиллах;

7.2.4.байгаль, түүх, соёлын биет өвийг хамгаалахад өөрийн зүгээс шаардагдах арга хэмжээ авах, гарсан зөрчлийн талаар холбогдох байгууллагад мэдэгдэх;

7.2.5.жуулчны аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авах;

7.2.6.байгаль орчинд сөрөг нөлөөгүй, хүн амын эрүүл мэнд, уламжлалт зан заншилд харшлахгүй аялал жуулчлалын хэлбэрийг хөгжүүлэх;

7.2.7.өөрийн ажилтнуудаа мэргэжлийн сургалт, дамжаанд хамруулж байх;

7.2.8.хуульд заасан бусад.

**8 дугаар зүйл.Аяллын агент**

8.1.Аяллын агент дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

8.1.1.тур операторын бүтээгдэхүүнийг зуучлан худалдах, борлуулах үйл ажиллагаа;

8.1.2.энэ хуулийн 7.1.3, 7.1.4-т заасан үйл ажиллагаа;

8.1.3.хуульд заасан бусад.

8.2.Аяллын агент нь энэ хуулийн 8.1.2-т заасан үйл ажиллагааг эрхлэх бол энэ хуулийн 7.2-т заасан холбогдох үүргийг хүлээнэ.

8.3.Аяллын агент энэ хуулийн 7.1.1-д заасан үйл ажиллагааг эрхлэхийг хориглоно.

**9 дүгээр зүйл.Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага**

9.1.Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага нь зочид буудал, жуулчны бааз, амралтын газар зэрэг бусад төрлийн жуулчны байр сууц, тээвэр, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлнэ.

9.2.Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага нь дараах шаардлагыг хангаж ажиллана:

9.2.1.тухайн үйлчилгээний техникийн зохицуулалт, стандартын шаардлагыг хангасан үйлчилгээ үзүүлэх;

9.2.2.үйлчилгээний үнэ тарифыг энэ хуулийн 6.8-д заасныг баримтлан тогтоож үйлчлэх;

9.2.3.үйл ажиллагаандаа мөрдөж байгаа техникийн зохицуулалт, стандарт, үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай бусад мэдээллийг өөрийн албан ёсны цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглан нээлттэй, ил тод байршуулах;

9.2.4.аялал жуулчлалын байгууллагатай гэрээ байгуулсан тохиолдолд жуулчнаас үйлчилгээний хөлсийг давхардуулан авахгүй байх;

9.2.5.үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор таван жилийн дотор аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэлд хамрагдах талаарх бизнес төлөвлөгөөтэй байх.

**10 дугаар зүйл.Жуулчны хөтөч**

10.1.Хөтөч, тайлбарлагчийн сургалтад хамрагдаж, энэ хуулийн 27.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бүртгүүлж, үнэмлэх авсан хүн жуулчны хөтчийн үйлчилгээ үзүүлнэ.

10.2.Жуулчны хөтөч нь дараах эрх, үүрэгтэй байна:

10.2.1.энэ хуульд заасны дагуу олгосон энгэрийн тэмдэг, үнэмлэхийг хэрэглэх;

10.2.2.жуулчдыг үндэсний түүх, соёлын дурсгалт зүйл, өв уламжлал, зан заншлын талаар үнэн зөв, бодит мэдээллээр хангах;

10.2.3.аялал жуулчлалын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх.

10.3.Энэ хуулийн 10.1-д заасан жуулчны хөтчид үнэмлэх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10.4.Энэ хуулийн 10.3-т заасан журмын дагуу жуулчны хөтчид үнэмлэх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох чиг үүргийг энэ хуулийн 27.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд шилжүүлж болно.

10.5.Уулын спорт аялал, усан аялал, спорт агнуур, олзворын ан, морь, тэмээ унуулах, нисдэг тэрэгний аялал, усны гүнд шумбах, авто спортын аялал зэрэг эрсдэл бүхий тусгай сонирхлын аяллыг жуулчны хөтчөөс гадна тухайн чиглэлийн мэргэшсэн сургагч багш, зааварлагчтайгаар зохион байгуулна.

**11 дүгээр зүйл.Жуулчны үйлчилгээ үзүүлэгч иргэний үйл ажиллагаа**

11.1.Жуулчны үйлчилгээ үзүүлэгч иргэн нь орон нутагт гэр түрээслүүлэх, нүүдлийн соёл, ахуй зан заншлыг жуулчдад танилцуулан сурталчлах болон аялал жуулчлалын дагалдах бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэх хүн байна.

11.2.Жуулчны үйлчилгээ үзүүлэгч иргэд эвлэлдэн нэгдэж нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахыг төрөөс болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас бодлогоор дэмжлэг үзүүлнэ.

11.3.Жуулчны үйлчилгээ үзүүлэгч иргэнд дэмжлэг үзүүлэх, үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлагыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**12 дугаар зүйл.Тур операторын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл**

12.1.Энэ хуулийн 6.2.1-д заасан тур операторын үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.30 дахь заалтад заасан аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас олгох тусгай зөвшөөрөлтэй эрхэлнэ.

12.2.Энэ хуулийн 12.1-д заасан зөвшөөрөл нь дараах ангилалтай байна:

12.2.1.Монгол Улсаас бусад улс руу хийх аялал жуулчлалын үйлчилгээ;
12.2.2.бусад улсаас Монгол Улс руу хийх аялал жуулчлалын үйлчилгээ;
12.2.3.энэ хуулийн 12.2.1 болон 12.2.2-т заасан аялал жуулчлалын үйлчилгээг хамтад нь эрхлэх олон улсын аялал жуулчлалын үйлчилгээ.

12.3.Тур операторын үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлт гаргасан хуулийн этгээд нь Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан баримт бичгээс гадна дараах шаардлагыг хангасан талаарх баримт бичгийг зөвшөөрөл хүссэн хүсэлтэд хавсаргасан байна:

12.3.1.аяллын агентын чиглэлээр хоёроос доошгүй жил үйл ажиллагаа явуулсан байх;

12.3.2.аялал жуулчлалын салбарын мэдлэг туршлагатай гурваас доошгүй үндсэн ажилтантай байх;

12.3.3.өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон байгууллагын үйл ажиллагааны талаар олон нийтэд цахим болон хэвлэмэл хэлбэрээр нээлттэй танилцуулах боломжийг бүрдүүлсэн байх;

12.3.4.цахим төлбөрийн баримтын систем, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдсон байх;

12.3.5.энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлага хангасан жуулчны хөтөчтэй байх;

12.3.6.мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдсан байх;

12.3.7.энэ хуулийн 12.2.1, 12.2.3-т заасан үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авах тохиолдолд бусад улсын аялал жуулчлалын байгууллагатай хамтран ажиллах боломжтой байх.

12.4.Энэ хуулийн 12.1-д заасан тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохдоо Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1, 5.2, 5.3, 5.4, 5.5, 5.6, 6.1, 6.2, 6.3, 6.4 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

12.5.Энэ хуулийн 12.1-д заасан тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дараах тохиолдолд хүчингүй болгоно:

12.5.1.тур оператор, эсхүл түүний ажилтан Эрүүгийн хуульд заасан эдийн засаг, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон;

12.5.2.Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийг гурваас дээш удаа үйлдсэн.

12.6.Энэ зүйлд заасан тур операторын тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох чиг үүргийг энэ хуулийн 27.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд шилжүүлж болно.

**13 дугаар зүйл.Хил орчмын аялал жуулчлал**

13.1.Хил орчмын аялал жуулчлалаар гадаад улсын иргэн Монгол Улс руу нэвтрэх асуудлыг хөрш улсуудтай харилцан тохиролцож Монгол Улсын олон улсын гэрээгээр шийдвэрлэнэ.

13.2.Хил орчмын аялал жуулчлалын нутаг дэвсгэрт зорчих маршрутыг хууль зүйн болон аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

13.3.Энэ хуулийн 13.2-т заасан маршрутын дагуу хил орчмын аялал жуулчлалын үйл ажиллагааг энэ хуулийн 12.2.2-т заасан үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй тур оператор эрхэлнэ.

13.4.Энэ хуулийн 13.3-т заасан тур оператор нь хилийн зурвасын аюулгүй байдлыг хангах зорилгын хүрээнд улсын хил хамгаалах байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангана.

13.5.Хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах журмыг Засгийн газар батална.

13.6.Энэ хуулийн 13.3-т заасан тур оператор нь энэ зүйлд заасны дагуу хил орчмын аялал жуулчлалын үйлчилгээ авч буй гадаадын жуулчны мэдээллийг энэ хуулийн 28.1-д заасан мэдээллийн санд хүргүүлнэ.

Тайлбар: Энэ зүйлд заасан “хил орчмын аялал жуулчлалын нутаг дэвсгэр” гэж хил залгаа улстай хиллэж байгаа аймгийн нутаг дэвсгэрийг ойлгоно.

**14 дүгээр зүйл.Аялал жуулчлалын гэрээ**

14.1.Аялал жуулчлалын байгууллага жуулчинтай аялал жуулчлалын гэрээ байгуулахдаа Иргэний хуулийн 370-379 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

14.2.Хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол жуулчин, аялал жуулчлалын байгууллагын хооронд аялал жуулчлалын гэрээтэй холбогдон гарсан маргааныг энэ хуулийн 27.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлагчаар шийдвэрлүүлж болно.

**15 дугаар зүйл.Даатгал**

15.1.Тур оператор, аяллын агент нь үйл ажиллагаандаа алдаа гаргаж, үйлчлүүлэгчид хохирол учруулсан тохиолдолд түүнийг нөхөн төлөх зорилгоор мэргэжлийн хариуцлагын даатгалд заавал даатгуулна.

15.2.Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага нь үйл ажиллагааны төрөл, онцлогоос хамаарч шаардлагатай даатгалд хамрагдаж болно.

15.3.Уулын спорт аялал, усан аялал, спорт агнуур, олзворын ан, нисдэг тэрэгний аялал, усны гүнд шумбах, авто спортын аялал зэрэг эрсдэл бүхий аялал жуулчлалын үйл ажиллагаанд хамрагдах аялагч, жуулчин нь аяллын гэнэтийн ослын болон эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулна.

15.4.Энэ хуулийн 15.3-т зааснаас бусад тохиолдолд жуулчин болон аялагч нь аяллын гэнэтийн ослын болон эрүүл мэндийн даатгалд хамрагдаж болно.

15.5.Энэ хуулийн 15.3-т заасан аялагч болон жуулчныг уг даатгалд хамруулах үйл ажиллагааг аялал жуулчлалын байгууллага хариуцан зохион байгуулна.

**16 дугаар зүйл.Жуулчны аюулгүй байдал**

16.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт аялж байгаа жуулчинд шаардагдах аюулгүй байдлыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цагдаагийн байгууллага, аялал жуулчлалын байгууллага хангана.

16.2.Жуулчны аюулгүй байдалд жуулчны хувийн аюулгүй байдал, өмч хөрөнгө болон Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.11, 4.1.12-т заасан мэдээллийг хадгалах, хамгаалах үйл ажиллагаа хамаарна.

16.3.Жуулчин, аялагч эрсдэлт нөхцөл байдалд орсон, сураггүй алга болсон тохиолдолд эрэн хайх, аврах ажиллагааг тухайн орон нутгийн онцгой байдлын алба Гамшгаас хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу шуурхай эхлүүлнэ.

16.4.Энэ хуулийн 6.2-т заасан аялал жуулчлалын байгууллага нь жуулчдад байгалийн гамшигт үзэгдэл, аливаа гэмтэл, халдварт өвчин, тахал болон шаардлагатай бусад тохиолдолд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх бүхий л нөхцөл боломжийг бий болгосон байна.

16.5.Аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь жуулчдад учирч болзошгүй аюул, халдварт өвчин, тахал болон зорчиход аюултай газар, байршлын жагсаалтыг гарган тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, жуулчдад мэдэгдэх үүрэгтэй.

16.6.Энэ хуулийн 16.6-д заасан мэдээллийг Аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага байгууллага хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээгээр түгээж, өөрийн албан ёсны цахим хуудсанд байршуулна.

16.7.Жуулчин аяллын явцад эрсдэлт нөхцөлд орсон, гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, албадлагын арга хэмжээ авагдсан тохиолдолд аялал жуулчлалын байгууллага тухайн хэрэг, зөрчлийг боломжит богино хугацаанд шийдвэрлүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллана.

16.8.Тур оператор, аяллын агент нь аяллын явцад автомат ажиллагаатай бичлэгийн техник, хэрэгслээр тоноглогдсон, стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгслээр жуулчдад үйлчилгээ үзүүлнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## ТӨРӨӨС АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ДЭМЖИХ

### 17 дугаар зүйл.Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан

17.1.Аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн $21^4$.1-д заасан дараах үйл ажиллагааг санхүүжүүлнэ:

17.1.1.агаараар зорчигч тээвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

17.1.2.аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх;

17.1.3.Монгол Улсыг гадаад, дотоодод сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах;

17.1.4.аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгох, хөгжүүлэх.

17.2.Сангийн ажиллах журам болон хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулна.

17.3.Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан нь орон тооны бус удирдах зөвлөл, хяналтын хороотой байх бөгөөд уг удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний гуравны хоёроос доошгүй хувь нь аялал жуулчлалын байгууллагын төлөөлөл байна.

17.4.Энэ хуулийн 17.2-т заасан аялал жуулчлалын байгууллагын төлөөлөлд зочид буудал, агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэгчдээс тус бүр нэг төлөөлөл, бусад гишүүд нь энэ хуулийн 27.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн төлөөлөл байна.

**18 дугаар зүйл.Аялал жуулчлалын тусгай зориулалтаар амьтан агнах**

18.1.Амьтны тухай хуулийн 29.3-т заасны дагуу тусгай зориулалтаар аргаль хонь, янгир ямаа, идлэг шонхор шувуу, тул загасыг агнах, барих тусгай зөвшөөрлийг дуудлага худалдааны журмаар олгоно.

**19 дүгээр зүйл.Аялал жуулчлалын бүс**

19.1.Монгол Улс тодорхой газар нутгийг тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаадын болон дотоод хөрөнгө оруулалтыг татах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх зорилгоор орон зайн зохистой төлөвлөлтийг бий болгосон аялал жуулчлалын бүстэй байна.

19.2.Аялал жуулчлалын бүсийг дараах байдлаар ангилна:

19.2.1.улсын аялал жуулчлалын бүс;
19.2.2.орон нутгийн аялал жуулчлалын бүс.

19.3.Энэ хуулийн 19.2.1-д заасан аялал жуулчлалын бүсийг тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулах хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалах, байгаль, түүх, соёлын өвийг хамгаалах зорилгод нийцүүлэн Засгийн газраас тогтоож, хил заагийг батална.

19.4.Энэ хуулийн 19.2.1-д заасан улсын аялал жуулчлалын бүсийн хилийн заагийг тогтооход газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хорооны саналыг авна.

19.5.Энэ хуулийн 19.2.1-д заасан улсын аялал жуулчлалын бүсэд мөрдөгдөх техникийн зохицуулалтад нийцсэн газар зохион байгуулалтын болон менежментийн төлөвлөгөөтэй байна.

19.6.Энэ хуулийн 19.5-д заасан газар зохион байгуулалтын болон менежментийн төлөвлөгөө, бүсийн аялал жуулчлалын маршрутыг аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

19.7.Энэ хуулийн 19.2.2-т заасан орон нутгийн аялал жуулчлалын бүсийн хилийн заагийг аймаг, нийслэлийн аялал жуулчлалын нэгж боловсруулж, аймаг,

нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, газар зохион байгуулалтын нэгдсэн санд болон энэ хуулийн 28.1-д заасан мэдээллийн санд хүргүүлнэ.

19.8.Энэ хуулийн 19.2.2-т заасан орон нутгийн аялал жуулчлалын бүс нь газар зохион байгуулалтын болон менежментийн төлөвлөгөөтэй байна.

19.9.Энэ хуулийн 19.7-д заасан орон нутгийн аялал жуулчлалын бүсийн менежментийн төлөвлөгөөг аймаг, нийслэлийн асуудал хариуцсан нэгж боловсруулж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал батална.

19.10.Энэ хуулийн 19.2.1-д заасан аялал жуулчлалын бүсийн менежментийг аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, энэ хуулийн 19.2.2-т заасан орон нутгийн аялал жуулчлалын бүсийн менежментийг аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцан зохион байгуулна.

19.11.Аялал жуулчлалын бүсийн менежментийг бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.

19.12.Энэ хуулийн 19.2.2-т заасан орон нутгийн аялал жуулчлалын бүсийн газар нутгийн хилийн заагийг тогтоохдоо энэ хуулийн 19.2.1-д заасан улсын аялал жуулчлалын бүсийн газар нутгийн хилийн заагтай давхцуулж тогтоохыг хориглоно.

19.13.Энэ хуулийн 19.2.1-д заасан улсын аялал жуулчлалын бүстэй энэ хуулийн 19.2.2-т заасан орон нутгийн аялал жуулчлалын бүс давхацсан тохиолдолд давхацсан хэсгийг холбогдох иргэдийн Төлөөлөгчдийн хурал хүчингүй болгоно.

**20 дугаар зүйл.Отоглох цэг**

20.1.Тухайн бүс нутагт орчны бохирдол бий болохоос урьдчилан сэргийлэх, аялал жуулчлалыг зохистой зохион байгуулах, аялагчдын тав тухтай аялах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор отоглох цэгийг байгуулж болно.

20.2.Отоглох цэг байгуулах шийдвэрийг тухайн орон нутгийн аялал жуулчлалын асуудал эрхэлсэн газрын саналыг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга гаргана.

20.3.Энэ хуулийн 20.1-д заасан отоглох цэг нь тусгай хамгаалалттай газар нутагт байрлах тохиолдолд Тусгай хамгаалалтын газар нутгийн тухай хуулийн 30.6-д заасны дагуу тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа отоглох цэгийг байгуулах шийдвэр гаргана.

20.4.Отоглох цэгийн менежмент, хог хаягдлын менежментийг тухайн сум, дүүргийн захиргаа, эсхүл тухайн отоглох цэг нь тусгай хамгаалалттай газар нутагт байрлах тохиолдолд Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа тус тус хариуцна.

20.5.Отоглох цэгийн менежментийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.

20.6.Отоглох цэг нь байнгын, эсхүл зөөврийн байж болно.

20.7.Отоглох цэг нь стандартын шаардлага хангасан байна.

20.8.Отоглох цэгт олон нийтийн аюулгүй байдлыг хангах харилцааг Цагдаагийн албаны тухай хуулиар зохицуулна.

Тайлбар:Энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан “отоглох цэг” гэж машины зогсоол, майхан барих, ил гал түлэх тусгай талбай, ариун цэврийн байгууламж, хогийн цэг, гэрэлтүүлэг, сандал, саравч, бүхий цогц орчныг ойлгоно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТАЛААР ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГА, АШГИЙН ТӨЛӨӨ БУС БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

### 21 дүгээр зүйл.Засгийн газрын бүрэн эрх

21.1.Засгийн газар аялал жуулчлалын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.1.1.аялал жуулчлалын талаар төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

21.1.2.аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хороог байгуулах;

21.1.3.бүс нутгийг хамарсан аялал жуулчлалын олон улсын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэр гаргах;

21.1.4.аялал жуулчлалын салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих, зохистой харилцааг бий болгох;

21.1.5.энэ хуулийн 13.5-д заасан журмыг батлах;

21.1.6.Монгол Улсын аялал жуулчлалыг сурталчлах, хүний нөөцийг бэлтгэх, аялал жуулчлалын төрөлжсөн мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;

21.2.Энэ хуулийн 21.1.2-т заасан аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хороо /цаашид “Үндэсний хороо” гэх/ дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.2.1.аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого боловсруулах;

21.2.2.Монгол Улсыг бусад улсад сурталчлах үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар удирдах;

21.2.3.аялал жуулчлалын салбарт шинэчлэлт, өөрчлөлтийг нэвтрүүлэх;

21.2.4.аялал жуулчлалын салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах;

21.2.5.иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн агаарын зорчигч тээврийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

21.3.Үндэсний хороо нь дарга, аялал жуулчлал, төсөв, санхүү, эдийн засаг, тээвэр, хууль зүй, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосон тус бүр нэг, энэ хуулийн 27.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдээс санал болгосон гурван гишүүнээс тус тус бүрдэнэ.

21.4.Үндэсний хороог Ерөнхий сайд тэргүүлэх бөгөөд хорооны гишүүдийг томилж, чөлөөлнө.

21.5.Үндэсний хорооны ажиллах журмыг Засгийн газар батална.

**22 дугаар зүйл.Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

22.1.Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аялал жуулчлалын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

22.1.1.энэ хуулийн 6.6, 10.3, 11.3-т заасан журмыг батлах;

22.1.2.тусгай сонирхлын аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах журмыг батлах;

22.1.3.аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр улсын болон олон улсын хэмжээнд аялал жуулчлалын байгууллага хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хамтран ажиллах;

22.1.4.аялал жуулчлалын мэргэжлийн сургалт, эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлэх чиглэлээр холбогдох иргэн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;

22.1.5.аялал жуулчлалын бүсийн нөөц, даацыг тогтоох, аялал жуулчлалын бүсэд үйл ажиллагаа явуулах жуулчны үйлчилгээний байгууллагын тоо, байршлыг тогтоох, тэдгээрийн нэгдсэн бүртгэлийг хөтлөх;

22.1.6.Монгол Улсыг сурталчлах ажлыг холбогдох чиг үүргийн төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

22.1.7.аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого боловсруулах;

22.1.8.аялал жуулчлалын үйлчилгээний салбарт олон улсын стандартыг нэвтрүүлж байгаа аялал жуулчлалын байгууллагыг бодлогоор дэмжих;

22.1.9.дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого боловсруулах;

22.1.10.төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг төлөвлөх, төслийн санал гаргах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний хэрэгжилтийг хангах, хяналт тавих;

22.1.11 аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлэх;

22.1.12.олон улсад улсын аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бодлого боловсруулах.

**23 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх**

23.1.Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал аялал жуулчлалын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

23.1.1.нутаг дэвсгэртээ аялал жуулчлалын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, Засаг даргын тайланг хэлэлцэх;

23.1.2.газар нутгийнхаа тодорхой хэсгийг аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх шийдвэр гаргах.

23.2.Аялал жуулчлалын хөгжил, бүс нутгийн онцлогоос хамааран харьяалах сум, дүүрэгт аялал жуулчлалын асуудал хариуцсан нэгж байгуулан ажиллаж болно.

**24 дүгээр зүйл.Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх**

24.1.Аялал жуулчлалын талаар аймаг, нийслэлийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.1.1.аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах;

24.1.2.аялал жуулчлалын тухай хууль тогтоомж, холбогдох бусад хууль, дүрэм, журам, техникийн зохицуулалт, стандартын хэрэгжилтийг хангуулах;

24.1.3.харьяалах нутаг дэвсгэртээ аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх;

24.1.4.харьяалах нутаг дэвсгэртээ аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлэх бодлоготой уялдуулан төлөвлөгөө боловсруулах, зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд санал оруулах, батлагдсан хөтөлбөрийн дагуу аялал жуулчлалын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;

24.1.5.эрх хэмжээнийхээ хүрээнд харьяалах нутаг дэсвгэртээ байгуулах жуулчны үйлчилгээний байгууллагад газар эзэмших зөвшөөрлийг аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон нөөц, даац, тоо, байршлыг баримтлан зохих хууль тогтоомжийн дагуу олгож гэрээ байгуулах;

24.1.6.аялал жуулчлалын мэдээллийн санг хөтлөх;

24.1.7.аймаг, нийслэлийн хэмжээнд зохион байгуулагддаг наадам, бусад аялал жуулчлалын арга хэмжээний товыг тухайн жилийн 10 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө зарлах, тэдгээр арга хэмжээг зохион байгуулах, удирдлагаар хангах;

24.1.8.аймаг, нийслэлийн аялал жуулчлалын мэдээллийн санг бүрдүүлэх, холбогдох мэдээллийг жил бүрийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө аялал жуулчлалын мэдээллийн санд хүргүүлэх;

24.1.9.улсын аялал жуулчлалын бүсэд гүйцэтгэж байгаа аялал жуулчлалын бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

24.1.10.орон нутгийн аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

24.1.11.энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан отоглох цэгийн арчилгаа, үйлчилгээ, хог хаягдлын менежментийг харьяалах нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын асуудал хариуцсан байгууллагаар, эсхүл хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх шийдвэр гаргах;

24.1.12.харьяалах нутаг дэвсгэртээ жуулчны мэдээллийн төв байгуулах;

24.1.13.байгаль, түүх, соёлын өв бүхий аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан таниулах, хадгалж, хамгаалах;

24.1.14.харьяалах нутаг дэвсгэртээ аялал жуулчлалын байгууллага, жуулчин, аялагчийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг үр дагаврыг багасгах, арилгах арга хэмжээ авах.

24.2.Энэ хуулийн 19.2.1-д заасан улсын аялал жуулчлалын бүсийн төлөвлөлтөд тусгагдаагүй газарт Аймаг, нийслэлийн Засаг дарга газар эзэмших зөвшөөрөл олгохыг хориглоно.

Тайлбар:Энэ хуулийн 24.1.12-т заасан "жуулчны мэдээллийн төв" гэж жуулчдад шаардлагатай байр зүйн зураг, холбогдох бусад мэдээллийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргэх мэдээллийн үйлчилгээний цэгийг ойлгоно.

## 25 дугаар зүйл.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

25.1.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал аялал жуулчлалын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.1.1.энэ хуулийн 19.2.1, 19.2.2-т заасан аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

25.1.2.нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг орон нутгийн аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх саналаа аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх;

25.1.3.жуулчин болон аялагчийн отоглох цэгт байрлах хураамжийн хэмжээг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25.1.13-т заасан хязгаарт багтаан тогтоох;

25.1.4.хуульд заасан бусад.

## 26 дугаар зүйл.Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

26.1.Сум, дүүргийн Засаг дарга аялал жуулчлалын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

26.1.1.нутаг дэвсгэртээ аялал жуулчлалын арга хэмжээг зохион байгуулах, орон нутгаа сурталчлах;

26.1.2.сум, дүүргийн соёл, спорт, олон нийтийн арга хэмжээг аялал жуулчлалын үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;

26.1.3.сум, дүүргийн аялал жуулчлалын мэдээллийн сан бүрдүүлэх, жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө аймаг, нийслэлийн Засаг даргад холбогдох мэдээллийг хүргүүлэх;

26.1.4.аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч иргэний үйл ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

26.1.5.жуулчны аюулгүй байдлыг хангах арга хэмжээг харьяалах нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, нутгийн иргэдтэй хамтран зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

26.1.6.орон нутгийн иргэдийн өв соёлын үнэт зүйлс, гар урлал, уламжлалт соёлыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх зорилгоор орон нутагт аялал жуулчлалын хөрөнгө оруулалтыг татах нөхцөлийг хангах;

26.1.7.харьяалах нутаг дэвсгэртээ отоглох цэгийн байршил, аяллын маршрутыг тогтоох, тэмдэг тэмдэглэгээ, нэгдсэн хаягжуулалтыг бий болгох;

26.1.8.энэ хуулийн 25.1.3-т заасан хураамжийн орлогыг аялал жуулчлалын бүсийг тохижуулах, ариун цэврийн байгууламж байгуулах, хог хаягдлын менежментийг гүйцэтгэхэд зарцуулах.

26.2.Энэ хуулийн 26.1.7-д заасан аяллын маршрутыг тогтооход тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аялал жуулчлалын байгууллагын саналыг авах бөгөөд энэ хуулийн 19.2.1-д заасан улсын аялал жуулчлалын бүсийн маршруттай уялдуулна.

**27 дугаар зүйл.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо**

27.1.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, жуулчны хөтөч, жуулчны үйлчилгээ үзүүлэгч иргэний нэгдэл бүхий, аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйл ажиллагаанд оролцогчдыг сургалт, зөвлөгөө, мэдээлэл, мэргэжлийн арга зүйгээр хангах, аялал жуулчлалын байгууллагын ажилтны баримтлах мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлах, боловсронгуй болгох үндсэн чиг үүрэг бүхий ашгийн төлөө бус нийтийн эрх зүйн хуулийн этгээд /цаашид “нийтийн эрх зүйн хуулийн этгээд” гэх/ байна.

27.2.Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан тур операторын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн гишүүнчлэлд заавал хамрагдах үүрэгтэй.

27.3.Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн дүрэм, удирдлагын бүтэц, үйл ажиллагааны журам, санхүүжилт зэрэг зохион байгуулалтын бусад асуудлыг бүх гишүүдийн хурлаар бие даан шийдвэрлэнэ.

27.4.Нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь улс орны аялал жуулчлалын салбарын хөгжлийн талаар баримтлах төрийн бодлого, зохицуулалтад мэргэжлийн зөвлөгөө өгөх, салбарын мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр төрийн, ашгийн төлөө бус хуулийн этгээд болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж болно.

27.5.Нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь тухайн жилийн үйл ажиллагааны тайлангаа дараа оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад, аудитлагдсан санхүүгийн тайлангаа харилцагч санхүүгийн байгууллагад, татварын тайлангаа харьяалах татварын албанд хуульд заасан хугацаанд хүргүүлж, олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

**28 дугаар зүйл.Мэдээллийн сан**

28.1.Аялал жуулчлалын салбарын эдийн засагт үзүүлж байгаа өсөлтийг тодорхойлох, аялал жуулчлалын судалгаа, шинжилгээ, статистик мэдээллийг хөгжүүлэх зорилго бүхий аялал жуулчлалын мэдээллийн сан байна.

28.2.Энэ хуулийн 28.1-д мэдээллийн сан нь дараах мэдээллээс бүрдэнэ:

28.2.1.аяллын маршрутын мэдээлэл;

28.2.2.Монгол Улсын болон бусад улсын аялагч, жуулчны бүртгэл, мэдээлэл;

28.2.3.аялал жуулчлалын байгууллагын бүртгэл, мэдээлэл;

28.2.4.энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан аялал жуулчлалын бүсийн мэдээлэл;

28.2.5.энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан отоглох цэгийн мэдээлэл;

28.2.6.энэ хуулийн 16.6-д заасан жуулчдад учирч болзошгүй аюул, халдварт өвчин, тахал болон зорчиход аюултай газар, байршлын жагсаалтын мэдээлэл.

28.3.Энэ хуулийн 28.2-т заасан мэдээлэлтэй жуулчин цахим сүлжээгээр дамжуулан танилцах боломжтой байна.

28.4.Энэ хуулийн 28.1-д заасан цахим санг бүрдүүлэх, ашиглах үйл ажиллагааг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхэлнэ.

28.5.Энэ хуулийн 28.1-д заасан цахим санг бүрдүүлэх, ашиглах, баяжуулах журмыг аялал жуулчлал асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

28.6.Энэ зүйлд заасан мэдээллийн сан нь Улсын хил хамгаалах байгууллага болон Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим мэдээллийн санд мэдээлэл хүргүүлнэ.

28.7.Холбоо нь энэ зүйлд заасан мэдээллийн сангаас өөрийн үйл ажиллагаанд шаардлагатай мэдээллийг ашиглах эрхтэй байна.

## ТАВДУГААР БҮЛЭГ
## АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

### 29 дүгээр зүйл.Аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих хяналт

29.1.Аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих хяналт нь дараах төрөлтэй байна:

29.1.1.аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих төрийн хяналт;

29.1.2.аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналт.

29.2.Аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийн биелэлтэд аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бүх шатны Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.

29.3.Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн аялал жуулчлалын асуудал хариуцсан нэгж нь бүх шатандаа аялал жуулчлалын нөөцийг хамгаалах, бүрдүүлэх, зүй зохистой ашиглахад хяналт тавина.

29.4.Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь төрөөс аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих хяналтын улсын ерөнхий байцаагч байх бөгөөд улсын ахлах байцаагч, улсын байцаагч, орон нутаг дахь улсын байцаагчийг томилж, чөлөөлнө.

29.5.Аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн аялал жуулчлалын асуудал хариуцсан нэгж, аялал жуулчлалын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга нар хамтран хэрэгжүүлнэ.

29.6.Энэ зүйлд заасан аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих төрийн хяналтыг энэ хуулийн 27.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд шилжүүлж болно.

**30 дугаар зүйл.Аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналт**

30.1.Аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх талаар иргэн, хуулийн этгээд дараах эрх эдэлнэ:

30.1.1.аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийг зөрчсөн тухай мэдээлэх, өргөдөл, гомдлыг аймаг, нийслэлийн аялал жуулчлалын асуудал хариуцсан нэгж, эсхүл энэ хуулийн 27.1-д заасан байгууллагад гаргаж, шийдвэрлүүлэх;

30.1.2.аялал жуулчлалын хууль тогтоомж зөрчигдсөнтэй холбоотойгоор учирсан хохирлыг арилгуулахаар харьяалах шүүхэд нэхэмжлэл гаргах.

**31 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

31.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

31.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

**32 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт**

32.1.Энэ хуулийн 12 дугаар зүйлийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

32.2.Тур операторын ангиллын эрхийн гэрчилгээтэй хуулийн этгээд нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд энэ хуульд заасан тур операторын үйл ажиллагааг эрхэлнэ.

32.3.Энэ хуулийн 17 дугаар зүйлийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

32.4.Энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан аялал жуулчлалын мэргэжлийн холбоог үүсгэн байгуулах хурлыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн аялал жуулчлалын салбарт хамгийн олон гишүүнтэй, орон нутагт төлөөлөл бүхий төрийн бус байгууллагатай хамтран 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулна.

**33 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

33.1.Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

## АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**2000 оны 05 дугаар сарын 05-ны өдөр баталсан Аялал жуулчлалын тухай хуулийг хүчингүй болсон тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Аялал жуулчлалын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

## ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Иргэний хуулийн 370 дугаар зүйлийн 370.1 дэх хэсэг, 371 дүгээр зүйлийн 371.2 дахь хэсэг, 372 дугаар зүйлийн 372.2, 372.3 дахь хэсэг, 373 дугаар зүйлийн 373.1.3 дахь заалт, мөн зүйлийн 373.2, 373.3 дахь хэсэг, 376 дугаар зүйлийн 376.2 дахь хэсэг, 377 дугаар зүйлийн 377.1 дэх хэсэг, мөн зүйлийн 377.1.2 дахь заалт, 378 дугаар зүйлийн 378.2 дахь хэсгийн “аялал жуулчлал зохион байгуулагч” гэснийг “тур оператор, аяллын агент” гэж, 371 дүгээр зүйлийн 371.1 дэх хэсэг, 372 дугаар зүйлийн 372.6 дахь хэсэг, 375 дугаар зүйлийн 375.1 дэх хэсэг, 378 дугаар зүйлийн 378.1 дэх хэсгийн “аялал жуулчлал зохион байгуулагчид” гэсний “тур оператор, аяллын агентад” гэж, 371 дүгээр зүйлийн 371.3 дахь хэсэг, 372 дугаар зүйлийн 372.1, 372.4 дэх хэсгийн “Аялал жуулчлал зохион байгуулагч” гэснийг “Тур оператор, аяллын агент” гэж, 372 дугаар зүйлийн 372.3 дахь хэсэг, 374 дүгээр зүйлийн 374.2 дахь хэсгийн “аялал зохин байгуулагчаас” гэсний “тур оператор, аяллын агентаас” гэж, 373 дугаар зүйлийн 373.4 дэх хэсгийн “аялал жуулчлал,” гэснийг “тур оператор, аяллын агент,” гэж, 374 дүгээр зүйлийн 374.1 дэх хэсгийн “Аялал жуулчлал зохион байгуулагчийн” гэснийг “Тур оператор, аяллын агентын” гэж, 377 дугаар зүйлийн 377.1.1 дэх заалтын “аялал жуулчлал зохион байгуулагчийн” гэснийг “тур оператор, аяллын агентын” гэж, 375 дугаар зүйлийн 375.1 дэх заалтын “нэг сарын дотор” гэснийг “гурван сарын дотор” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Аялал жуулчлалын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

## ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, заалт нэмсүгэй:

**1/5 дугаар зүйлийн 5.3.26 дахь заалт:**

“5.3.26.Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан.”

**2/21$^4$ дугаар зүйл:**

**“21$^4$ дүгээр зүйл.Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан**

21$^4$.1.Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан нь төрөөс аялал жуулчлалыг дэмжих, аялал жуулчлалын байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээ, үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор дараах чиглэлийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ:

21$^4$.1.1.агаараар зорчигч тээвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

21$^4$.1.2.аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх;

21$^4$.1.3.Монгол Улсыг гадаад, дотоодод сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах;

21$^4$.1.4.аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгох, хөгжүүлэх.

21$^4$.2.Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан нь энэ хуулийн 6.1-д заасан эх үүсвэрээс гадна дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

21$^4$.2.1.Казиногийн төлөх онцгой албан татварын орлогын 5 хувь;

21$^4$.2.2.Бооцоот морин уралдааны онцгой албан татварын орлогын 5 хувь;

21$^4$.2.3.Иргэний нисэхийн тухай хуульд заасан агаарын навигацийн үйлчилгээнээс улсын төсөвт төвлөрсөн орлогын 20 хүртэл хувь;

21$^4$.2.4.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.30-д заасан зөвшөөрлийн хураамжийн орлого.

21$^4$.3.Энэ хуулийн 21$^4$.2-т заасны дагуу Аялал жуулчлалыг хөгжүүлэх санд хөрөнгө төвлөрүүлэх журмыг санхүү, төсвийн болон аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

21$^{4}$.4.Аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн дүрэм, Удирдах хорооны бүрэлдэхүүн, түүний ажиллах журам болон уг сангийн хөрөнгийг зарцуулах журмыг Засгийн газар батална.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

## АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

**1/15 дугаар зүйлийн 15.1.15 дахь заалт:**

"15.1.15.Аялал жуулчлалын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан аялал жуулчлалын байгууллага, отоглох цэг, авто замын дагуух түр амрах газар өөрийн ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлага хангахуйц болгож засварласны болон стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж шинээр байгуулсны зардал."

**2/21 дүгээр зүйлийн 21.1.15 дахь заалт:**

"21.1.15.Аялал жуулчлалын тухай хуулийн 6.2.1-д заасан байгууллагын үйл ажиллагааны орлого."

**3/22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсэг:**

"22.9.улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойш гурван жилийн хугацаанд Аялал жуулчлалын тухай хуулийн 5.2.3-т заасан гарааны компанийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтын орлогод ногдох албан татварыг;"

**2 дугаар зүйл.**Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсгийн "22.5.4-т" гэснийг "22.5.4, 22.9-д" гэж өөрчилсүгэй

**3 дугаар зүйл.**Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Аялал жуулчлалын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

## ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 10.14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**"10.14.Аялал жуулчлалын тухай хууль зөрчих**

1.Тусгай зөвшөөрөлгүйгээр тур операторын үйл ажиллагааг эрхэлсэн бол хууль бусаар олсон орлогыг хурааж, хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Бүртгэлгүйгээр аяллын агентын үйл ажиллагааг эрхэлсэн бол хууль бусаар олсон орлогыг хурааж, хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Жуулчны хөтчийн үйл ажиллагааг бүртгэлгүй, үнэмлэхгүй эрхэлсэн, эсхүл жуулчнаас шан харамж шаардсан бол хууль бусаар олсон орлогыг хурааж, хүнийг тавин нэгжээс зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Жуулчны үйлчилгээний байгууллага нь аялал жуулчлалын байгууллагын үйл ажиллагаа явуулсан бол хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Жуулчны үйлчилгээний байгууллага нь үйлчилгээний стандарт, техникийн зохицуулалт, зэрэглэлд тавигдах шаардлагыг зөрчиж үйл ажиллагаа явуулсан бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Аялал жуулчлалын байгууллага нь аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан борлуулахдаа гадаадын болон дотоодын жуулчдад ялгамжтай байдлаар үнэ тогтоож үйлчилсэн бол хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Тусгай сонирхлын аялал болон уулын спорт аялал, усан аялал, спорт агнуур, олзворын ан, нисдэг тэрэгний аялал, усны гүнд шумбах, авто спортын аялал зэрэг эрсдэл бүхий аяллыг жуулчны хөтөч, тухайн чиглэлийн мэргэшсэн сургагч багш, зааварлагчгүйгээр зохион байгуулсан бол хүнийг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийн арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүсэд хээрийн отоглох цэгийн байршлаас бусад газарт жуулчин, аялагч отоглосон бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно."

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Аялал жуулчлалын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

## НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

**1/15 дугаар зүйлийн $15.5^1$ дэх хэсэг:**

“$15.5^1$.Гадаад улсаас Монгол Улсад нэг хоногоос 90 хоног хүртэлх хугацаагаар суралцах, ажил хөдөлмөр эрхлэхээс бусад зорилгоор аялж байгаа гадаадын иргэний хувийн хэрэгцээнд зориулж гаалийн нутаг дэвсгэрээс худалдан авсан бараанд төлсөн албан татварыг 100 хувь буцаан олгоно.”

**2/15 дугаар зүйлийн 15.16, 15.17, 15.18 дахь хэсэг:**

“15.16.Энэ хуулийн $15.5^1$ дахь хэсэгт заасан буцаан олголтыг дараах нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд олгоно:

15.16.1.татварын албаны шаардлагад нийцсэн бүртгэлийн машин бүхий албан татвар суутган төлөгчөөс бараа худалдан авсан байх;

15.16.2.худалдан авалт цахим төлбөрийн баримтын системд бүртгэгдсэн байх;

15.16.3.татварын албаны шаардлагад нийцсэн цахим төлбөрийн баримт авсан байх;

15.16.4.буцаан олголт авах барааны төлбөрийн баримт дээрх худалдан авалт нь Засгийн газрын баталсан үнийн дүнгээс дээш байх;

15.16.5.барааг худалдан авснаас хойш 90 хоногийн дотор өөрийн биеэр улсын хилээр авч гарах.

15.17.Энэ хуулийн $15.5^1$ дэх хэсэгт заасан иргэн албан татвар буцаан авах хүсэлтийг олон улсын нисэх онгоцны буудлын шалган нэвтрүүлэх хэсгээр гарсны дараа гаргана.”

15.18.Энэ хуулийн $15.5^1$ дэх хэсэгт заасан иргэнд олгох буцаан олголтын төлбөрийн баримтыг бүртгэх, түүнд хяналт тавих журам, барааны жагсаалт, буцаан олгох татварын хувь хэмжээ, 15.16.4-т заасан үнийн дүнг Засгийн газар батална.”

**2 дугаар зүйл.**Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийн “15.6” гэсний дараа “, 15.17” гэж, 15.9 дэх хэсгийн “15.5” гэсний дараа “, $15.5^1$” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.14 дэх заалтын “аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг” гэснийг “тур оператор, аяллын агент” гэж, мөн заалтын “бичиг баримтыг нь бүрдүүлэх зэрэг гадаадын жуулчдад үзүүлсэн /тур оператор/ үйлчилгээ” гэснийг “виз авахтай холбогдсон болон аяллын бусад бичиг баримтын бүрдүүлэлт хийх зэрэг гадаадын жуулчинд үзүүлсэн үйлчилгээ” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

## ЗӨВШӨӨЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

| | |
|---|---|
| 1.30.Тур операторын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл | Аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага |

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Аялал жуулчлалын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

## АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Амьтын тухай хуулийн 29 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

"29.3.Энэ хуулийн 29.2.2-т заасан тусгай зөвшөөрлийн чиглэлээр олгох аргаль хонь, янгир ямаа, идлэг шонхор шувуу, тул загасыг агнах, барих тусгай зөвшөөрлийг нээлттэй дуудлага худалдааны журам /цаашид "дуудлага худалдааны журам" гэх/-аар олгоно.Дуудлага худалдааг цахимаар явуулж болно.

29.4.Энэ хуулийн 29.3-т заасан журмаар авсан тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлж болно.

29.5.Дуудлага худалдааг аймаг, нийслэлийн Засаг дарга ажлын хэсэг байгуулан тухайн аймгийн агнуурын бүс нутгаар зохион байгуулна.

29.6.Дуудлага худалдааг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын олзворын ангийн хуваарь баталсан шийдвэр гарснаас хойш 45 хоногийн дотор энэ хуулийн 29.5-д заасан этгээд зохион байгуулна.

29.7.Дуудлага худалдааг явуулах хугацааг товлосон шийдвэрийг дуудлага худалдаа явагдахаас 30 хоногийн өмнө гаргах ба дараах мэдээллийг тусгана:

29.7.1.дуудлага худалдаа явуулах он, сар, өдөр, цаг, хаяг;
29.7.2.аргаль хонь, янгир ямаа, идлэг шонхор, тул загасыг агнах, барих талаарх тооцоо, судалгаа;

29.7.3.дуудлага худалдааны босго үнэ, дэнчингийн хэмжээ, төлөх хугацаа, журам;

29.7.4.аргаль хонь, янгир ямаа, идлэг шонхор, тул загасыг агнах, барих байршлын талаарх мэдээлэл;

29.7.5.хуульд заасан бусад.

29.8.Энэ хуулийн 29.7.3-т заасан дуудлага худалдааны босго үнэ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 17.1.7-д заасан тухайн амьтны Засгийн газраас тогтоосон жишиг үнэ байна.

29.9.Дуудлага худалдааны дэнчин нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 17.1.7-д заасан тухайн амьтны Засгийн газраас тогтоосон жишиг үнийн

10 хувь байх бөгөөд дэнчинг дуудлага худалдаанд оролцохоос өмнө урьдчилан төлсөн байна.

29.10.Дуудлага худалдаанд хоёр, түүнээс дээш этгээд оролцох хүсэлтээ ирүүлж, үнийн санал өгсөн тохиолдолд дуудлага худалдааг хүчинтэйд тооцно.

29.11.Дуудлага худалдаанд агнуурын бүсийн менежмент хариуцагчаас бусад хүн, хуулийн этгээд оролцоно.

29.12.Дуудлага худалдаанд ялсан этгээд нь дуудлага худалдааны үнийг дуудлага худалдаа дууссанаас хойш ажлын таван өдрийн дотор төлнө.

29.13.Дуудлага худалдааны ялагч энэ хуулийн 29.12-т заасан өдрийн дотор дуудлага худалдааны үнийг төлөөгүй, эсхүл дуудлага худалдаанд хоёроос дээш оролцогч оролцоогүй, эсхүл үнэ хаялцаагүй тохиолдолд дуудлага худалдааг хүчингүй болгож дахин 35 хоногийн дотор дахин дуудлага худалдааг явуулна.

29.14.Дуудлага худалдаанд ялсан этгээд нь энэ хуулийн 29.12-т заасан үнийг төлсний дараа агнуурын бүс нутгийн менежмент хариуцагчтай ан агнуулах гэрээг байгуулна.

29.15.Сум, дүүргийн Засаг дарга ан агнуулах гэрээ, агнуурын нөөц ашигласны төлбөр, хураамжийг төлсөн баримтыг үндэслэн Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.23-т заасан тусгай зөвшөөрлийг олгоно.

29.16.Дуудлага худалдааны үнийн дүнгийн орлогыг Төсвийн тухай хуулийн 23.7.4, 23.9.4-т заасны дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

29.17.Дуудлага худалдааны үнийн дүнгийн орлогын 20 хувийг агнуурын бүс нутгийн амьтны нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээнд зориулан менежмент хариуцагчид олгоно.”

**2 дугаар зүйл.**Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6.1 дэх заалтын “арга хэмжээний төлөвлөгөө” гэсний дараа “төсөв” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.2 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийг доор дурдсан агуулгаар тус тус өөрчлөн найруулсугай:

**1/5 дугаар зүйлийн 5.4.2 дахь заалт:**

“5.4.2.амьтны нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээний зардлыг тухайн жилийн төсвийн төсөлд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1.2-т заасан хэмжээнээс бууруулахгүйгээр тусгаж, батлах;”

**2/29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг:**

“29.1.Тусгай төлбөр төлсөн иргэнд энэ хуулийн 24.3.3-т заасан зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.23-т заасны дагуу сум, дүүргийн Засаг дарга олгоно.”

**4 дүгээр зүйл.**Амьтны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.9 дэх заалтын “бүх төрлийн” гэснийг “моторын багтаамж нь 20, түүнээс дээш морины хүчтэй мотort” гэж,

22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийн “Сум, дүүргийн” гэснийг “Аймаг, нийслэлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Амьтны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8 дахь заалтын “зөвшөөрөл,” гэснийг хассугай.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

## БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

"17.2.энэ хуулийн 17.1.5-д заасан жишиг үнийг Засгийн газар тогтооно."

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Аялал жуулчлалын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

## УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

"29.1.12.тур операторын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүний хугацааг сунгахад 500 000-1 000 000 төгрөг;

29.1.13.отоглох цэгээр үйлчлүүлэхэд нэг хүн 3 000-10 000 төгрөг, нэг автомашин 5 000-10 000 төгрөг."

**2 дугаар зүйл.**Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн "35.1.4" гэсний өмнө "29.1.13," гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн "29 дүгээр зүйл" гэснийг "29.1.1-29.1.12 дахь заалт" гэж, 29 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 29.1 дэх хэсгийн "зөвшөөрөл олгоход" гэснийг "зөвшөөрөл олгох, сунгахад" гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Аялал жуулчлалын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

## ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

**1/34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсэг:**

"34.3.Энэ хуулийн 33.1-д зааснаас гадна газар ашиглах гэрээний ерөнхий хугацааг аялал жуулчлалын байгууллагыг дэмжих зорилгоор аялал жуулчлалын зориулалтаар ашиглуулах газарт ялгамжтай байдлаар тогтоож болно."

**2/40 дүгээр зүйлийн 40.1.3 дахь заалт:**

"40.1.3.аялал жуулчлалын зориулалтаар ашиглуулахаар олгосон газрыг зориулалтын бусаар ашиглаж байгаа нь тухайн газар нутгийн хамгаалалтын захиргаа, хамгаалалтын захиргаа байхгүй тусгай хамгаалалттай газрын сум, дүүргийн Засаг даргын дүгнэлтээр тогтоогдсон."

**2 дугаар зүйл.**Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

36.3.Аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглах тухай хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгжид доор дурдсан хугацаагаар газар ашиглах зөвшөөрөл олгоно:

36.3.1.Аялал жуулчлалын тухай хуулийн 12.2.1, 12.2.2, 12.2.3-т заасан тусгай зөвшөөрөл бүхий тур операторт 15 жилийн хугацаагаар;

36.3.2.Аялал жуулчлалын тухай хуулийн 12.2.4-т заасан тусгай зөвшөөрөл бүхий тур операторт 12 жилийн хугацаагаар;

36.3.3.Аялал жуулчлалын тухай хуульд заасан шаардлага хангасан аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, аяллын агентад 10 жилийн хугацаагаар.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Аялал жуулчлалын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

## ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий 23.7.4, 23.9.4 дэх заалт нэмсүгэй:

**1/23 дугаар зүйлийн 23.7.4 дэх заалт**

"23.7.4.Амьтны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.12 дахь хэсэгт заасан дуудлага худалдааны орлогын 40 хувь;"

**1/23 дугаар зүйлийн 23.9.4 дэх заалт**

"23.7.4.Амьтны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.12 дахь хэсэгт заасан дуудлага худалдааны орлогын 40 хувь;"

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Аялал жуулчлалын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**УЛААНБААТАР ХОТ**
**2022 ОН**

# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭ

## НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зарим зохицуулалт /зүйл, хэсэг, заалт/-д тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зохицуулалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Одоо үйлчилж буй Аялал жуулчлалын тухай хуулийн нь 2000 онд 6 бүлэг 24 зүйлтэй батлагдсан бөгөөд Иргэний хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай зэрэг хууль өөрчлөгдсөн, шинээр батлагдсантай холбогдуулан 2001, 2002, 2003, 2005, 2006, 2010, 2011, 2015, 2017, 2021, 2022 онуудад нийт 12 удаа хуульд нэмэлт, өөрчлөлт оржээ.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/-ийн зарим зохицуулалтын үр нөлөөг үнэлэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль, “Хуулийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлал”[1] /цаашид “аргачлал” гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ:

1.1.Шалгуур үзүүлэлтийг сонгох;
1.2.Хуулийн төслөөс үр нөлөө үнэлэх хэсгээ тогтоох;
1.3.Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
1.4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

## ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан аргачлалд дурдсан нийт 6 шалгуур үзүүлэлтээс дараах 2 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

2.1.Зорилгод хүрэх байдал
2.2.Харилцан уялдаа.

Дээрх шалгуур үзүүлэлтийг тухайлан сонгох болсон үндэслэл нь хуулийн төслийн үндсэн зорилго, зохицуулах харилцааны онцлогтой холбоотой.

Тодруулбал, хуулийн төслийн үзэл баримтлалд аялал жуулчлал эрчимтэй хөгжиж байгаа өнөө цагт үндэсний онцлог бүхий байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан тогтвортой аялал жуулчлалын үйлдвэрлэлээр дамжуулан эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, дэмжих, нийгэм, соёл, байгаль орчныг хадгалах, хамгаалах,

[1] Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1-д заасны дагуу 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан.

аялал жуулчлалаас үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, зохистой хэрэглээг нэвтрүүлэх, гадаад болон дотоод жуулчдын аюулгүй байдал, орон нутгийн иргэдийн оролцоог хангасан, хариуцлагатай аялал жуулчлалыг хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой талаар тусган байна.

Түүнчлэн Монгол Улсын аялал жуулчлалын дэд бүтцийн нэг болох Монгол Улсын түүх, соёл, уламжлалыг шингээсэн бүтээн байгуулалт, агаарын зорчигч тээврийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, аялал жуулчлалыг улирлын хамаарлыг бууруулах, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, Монгол Улсыг гадаад, дотоодод сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах үйл ажиллагааг санхүүжүүлэн Монгол Улсын аялал жуулчлалын хөгжлийг бодитойгоор эрчимжүүлэх, дэмжихэд санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх зорилго бүхий Аялал жуулчлалыг хөгжүүлэх санг бий болгох, энэ сан нь Засгийн газрын тусгай сан байх бөгөөд түүний эх үүсвэрийг улсын нийт төсөвт нэмэлт дарамт үзүүлэхгүйгээр бий болгох зорилтыг дэвшүүлсэн байна.

Жуулчдын худалдан авсан бараа, бүтээгдэхүүнд ногдуулсан нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгох, жуулчны татвар бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилтыг мөн тавьсан байна.

Мөн аялал жуулчлалын байгууллагын ангиллыг тодорхойлж, тур оператор нь тусгай зөвшөөрөл, тур агент, хөтөч нь бүртгэлийн үндсэн дээр тус тус үйл ажиллагаа явуулах бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хувьцааны 50, түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигчээр Монгол Улсын иргэн, хуулийн этгээд байх хязгаарлалт болон уг тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах шаардлагыг тодорхойлсон байна.

Эцэст нь тодорхой газар нутагт тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх, орон зай зохистой төлөвлөлтийг бий болгох зорилгоор тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрээс гадна аялал жуулчлалын бүсийг улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүс гэж ангилж, түүнийг менежментийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжийг бүрдүүлэхээр зорьсон байна.

"Зорилгод хүрэх байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан үндэсний онцлог бүхий байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан тогтвортой аялал жуулчлалын үйлдвэрлэлээр дамжуулан эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, дэмжих, аялал жуулчлалын байгууллагын ангиллыг тодорхойлон шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох, тодорхой бүс нутгийн аялал жуулчлалын бүс болгож, аялал жуулчлалын салбар дахь орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага нь Монгол Улсын болон олон улсын холбогдох стандартын шаардлагыг ханган ажиллах ба ялангуяа ариун цэврийн байгууламжийг онцгой анхаарч, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж барих, засварлах зардлыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хасагдах зардалд тооцох, хил орчмын аялал жуулчлалыг байнгын ажиллагаатай боомт, олон улсын боомт болон хил орчмын нутаг дэвсгэрт байрлах чөлөөт бүсэд олон улсын аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй тур оператор гүйцэтгэхээр зохицуулалтыг бий болгох, тусгай зориулалтын агнуурын аялал жуулчлалыг дэмжих зорилгоор сүргийн бүтцийг алдагдуулахгүйгээр тооцоо, судалгаанд үндэслэн аргаль, янгир, идлэг шонхрыг агнах, барих тусгай зөвшөөрлийг дуудлага худалдааны журмаар нээлттэй ил тод олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх санг бий болгож түүний эх үүсвэрийг улсын нийт төсөвт нэмэлт дарамт үзүүлэхгүйгээр бий болгох, жуулчдын худалдан авсан бараа

бүтээгдэхүүнд ногдуулсан нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгох, жуулчны татвар бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аялал жуулчлалын зарим төрлийн төрийн үйлчилгээг аялал жуулчлалыг мэргэжлийн холбоогоор гүйцэтгүүлэх, тухайлбал аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэл олгох, тур операторын тусгай зөвшөөрөл олгох чиг үүргийг гүйцэтгүүлэх эрх зүйн үндэслэлийг нарийвчлан тодорхойлох үндсэн зорилгод нийцсэн эсэх асуудлыг судалж, боломжит хувилбарыг тодорхойлохыг зорьсон.

"Харилцан уялдаа" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь шинэчилсэн найруулгын төсөл тул бүхэлд нь сонгож, хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Газрын тухай, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль зэрэг холбогдох хуульд нийцсэн эсэх, бусад байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх, уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах замаар шалгахаар сонгов.

## ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Аргачлалд заасны дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон тул түүнд хамаарах үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоохдоо хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан хамгийн чухал, ач холбогдолтой зүйл, хэсэг, заалтыг сонголоо:

Хүснэгт 1

| д/д | Шалгуур үзүүлэлт | Үр нөлөөг үнэлэх хэсэг |
|---|---|---|
| 3.1 | **Зорилгод хүрэх байдал** | **3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо**<br>3.1.Энэ хуульд хэрэглэсэн нэр томьёог дараах утгаар ойлгоно:<br><br>3.1.6."аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага" гэж зочид буудал, жуулчны бааз, бусад хэлбэрийн жуулчны байр сууц, тээвэр, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийг;<br>3.1.7."тур оператор" гэж аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг төлөвлөн бүрдүүлж, багц аяллыг шууд, эсхүл аяллын агентаар дамжуулан худалдах, зохион байгуулах хуулийн этгээдийг;<br>3.1.8."аяллын агент" гэж тур оператор болон аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагаас гаргасан аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг жижиглэн, эсхүл хоёр, түүнээс дээш үйлчилгээг худалдан борлуулж байгаа хүн, хуулийн этгээдийг;<br>3.1.9."жуулчны хөтөч" гэж жуулчинд үндэсний өв соёл, байгаль, газар зүйн онцлог болон шаардлагатай бүхий л мэдээллийг хүргэж аяллыг хөтлөн явуулах энэ хуульд заасан шаардлага хангасан хүнийг;<br>3.1.10."тусгай сонирхлын аялал жуулчлал" гэж жуулчин, эсхүл жуулчны бүлэгт урлаг, спорт, адал явдал болон танин мэдэхүйн зэрэг тэдний сонирхсон чиглэлээр үзүүлэх аялал жуулчлалын үйлчилгээг. |

| | | |
|---|---|---|
| 3.1.1 | **Зорилгод хүрэх байдал** | **5 дугаар зүйл.Аялал жуулчлалын байгууллага**<br>5.2.Аялал жуулчлалын байгууллагыг дараах байдлаар ангилна:<br>5.2.1.тур оператор;<br>5.2.2.аяллын агент;<br>5.2.3.аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага.<br><br>5.3.Тур оператор дараах чиглэлээр үйл ажиллагааг явуулна:<br>5.3.1.олон улсын аялал жуулчлалын үйл ажиллагаа;<br>5.3.2.дотоодын аялал жуулчлалын үйл ажиллагаа;<br>5.3.3.энэ хуулийн 5.3.1, 5.3.2-т заасан үйл ажиллагааг хамтад нь эрхлэх.<br><br>5.4.Энэ хуулийн 5.2.1-д заасан хуулийн этгээдийн хувьцааны 51, түүнээс багагүй хувийн хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээд байна.<br>5.5.Энэ хуулийн 5.2-т заасан ангилалд тусгагдаагүй байгууллага тусгай сонирхлын болон бусад төрлийн эрсдэл бүхий аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд энэ хуулийн 29.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бүртгүүлсэн байна.<br><br>6.1.Тур оператор нь дараах үйл ажиллагааг эрхэлнэ:<br><br>6.1.1.аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөх, бүрдүүлэх, бий болгох, сурталчлах, жижиглэнгээр, эсхүл хоёр, түүнээс дээш бүтээгдэхүүн, үйлчилгээг багцлан худалдан борлуулах, аялал зохион байгуулах;<br>6.1.2.жуулчдад зориулсан соёл, урлаг, олон нийтийн арга хэмжээг зохион байгуулах, борлуулах;<br>6.1.3.виз авахтай холбогдсон болон аяллын бусад бичиг баримтын бүрдүүлэлт хийх;<br>6.1.4.агаарын, төмөр замын болон бусад тээврийн хэрэгслээр зорчих билет /тийз/-ийн захиалга хийх, билет /тийз/ худалдах, борлуулах.<br><br>7.1.Аяллын агент дараах үйл ажиллагааг эрхэлнэ:<br>7.1.1.тур операторын бүтээгдэхүүнийг зуучлан худалдах үйл ажиллагаа;<br>7.1.2.энэ хуулийн 6.1.3, 6.1.4-т заасан үйл ажиллагаа;<br>7.1.3.хуульд заасан бусад. 7.2.Аяллын агент нь энэ хуулийн 7.1.2-т заасан үйл ажиллагааг эрхлэх бол энэ хуулийн 6.2-т заасан холбогдох үүргийг хүлээнэ.<br><br>8.1.Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага нь дараах шаардлагыг хангаж ажиллана:<br>8.1.1.тухайн үйлчилгээний техникийн зохицуулалтад нийцсэн, чанар, стандартын шаардлагыг хангасан үйлчилгээ үзүүлэх;<br>8.1.2.үйлчилгээний үнэ тарифыг энэ хуулийн 5.10-т заасныг баримтлан тогтоож үйлчлэх; |

| | | |
|---|---|---|
| | | 8.1.3.үйл ажиллагаандаа мөрдөж байгаа техникийн зохицуулалт, стандарт, үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай бусад мэдээллийг өөрийн албан ёсны цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглан нээлттэй, ил тод байршуулах;<br>8.1.4.аялал жуулчлалын байгууллагатай гэрээ байгуулсан тохиолдолд жуулчнаас үйлчилгээний хөлсийг давхардуулж авахгүй байх;<br>8.1.5.үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор таван жилийн дотор зэрэглэлд хамрагдах талаарх бизнес төлөвлөгөөтэй байх.<br><br>9.1.Хөтөч, тайлбарлагчийн сургалтад хамрагдаж, энэ хуулийн 29.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бүртгүүлж, үнэмлэх авсан хүн жуулчны хөтчийн үйлчилгээ үзүүлнэ.<br><br>11.1.Энэ хуулийн 5.2.1-д заасан тур операторын үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.30 дахь заалтад заасан тусгай зөвшөөрөлтэй эрхэлнэ.<br>11.2.Энэ хуулийн 11.1-д заасан зөвшөөрөл нь дараах ангилалтай байна:<br>11.2.1.Монгол Улсаас бусад улс руу хийх аялал жуулчлалын үйлчилгээ; 11.2.2.бусад улсаас Монгол Улс руу хийх аялал жуулчлалын үйлчилгээ;<br>11.2.3.энэ хуулийн 11.2.1 болон 11.2.2-т заасан аялал жуулчлалын үйлчилгээг хамтад нь эрхлэх;<br>11.2.4.дотоодын аялал жуулчлалын үйл ажиллагаа.<br>11.3.Тур операторын үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлт гаргасан хуулийн этгээд нь Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан баримт бичгээс гадна дараах шаардлагыг хангасан байна:<br>11.3.1.аяллын агентын чиглэлээр хоёроос доошгүй жил үйл ажиллагаа явуулсан байх;<br>11.3.2.аялал жуулчлалын салбарын мэдлэг, туршлагатай гурваас доошгүй ажилтантай байх;<br>11.3.3.аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах бизнес төлөвлөгөө болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журамтай байх;<br>11.3.4.энэ хуулийн 11.2.1, 11.2.3-т заасан үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авах тохиолдолд бусад улсын аялал жуулчлалын байгууллагатай хамтран ажиллах боломжтой байх.<br>11.4.Энэ хуулийн 11.1-д заасан тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохдоо Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1, 5.2, 5.3, 5.4, 5.5, 5.6, 6.1, 6.2, 6.3, 6.4 дүгээр зүйлд заасан журмыг баримтална. |
| 3.1.2 | **Зорилгод хүрэх байдал** | 4.1.Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, тэдгээрийг хэрэглэгчдэд хүргэх үйлдвэрлэл, үйл ажиллагаа нь аялал жуулчлалын үндсэн ба дагалдах бүтээгдэхүүн, үйлчилгээнээс бүрдэнэ.<br>4.2.Аялал жуулчлалын үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнд дараах үйлчилгээ хамаарна:<br>4.2.1.жуулчныг байр сууцаар хангах үйлчилгээ; |

| | | |
|---|---|---|
| | | 4.2.2.зорчигч тээврийн үйлчилгээ;<br>4.2.3.аялал жуулчлалыг зохион байгуулах үйлчилгээ.<br>4.3.Аялал жуулчлалын дагалдах бүтээгдэхүүн, үйлчилгээнд дараах үйлчилгээ хамаарна:<br>4.3.1.хоол үйлдвэрлэл, үйлчилгээ;<br>4.3.2.аялал жуулчлалын мэдээлэл, зар сурталчилгааны үйлчилгээ;<br>4.3.3.урлаг, үзвэр үйлчилгээ, соёлын бусад үйлчилгээ;<br>4.3.4.худалдаа үйлчилгээ;<br>4.3.5.аялал жуулчлалын гар урлалын бүтээгдэхүүн.<br>4.4.Төрөөс экспортын үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэг, хөнгөлөлтөд энэ хуулийн 4.2, 4.3-т заасан аялал жуулчлалын байгууллагын гадаадын жуулчинд үзүүлсэн үйлчилгээ нэгэн адил хамаарна.<br><br>**20 дугаар зүйл.Аялал жуулчлалын бүс**<br>20.1.Тодорхой газар нутгийг тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх, орон зайн зохистой төлөвлөлтийг бий болгосон аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлж болно.<br>20.2.Аялал жуулчлалын бүсийг дараах байдлаар ангилна:<br>20.2.1.улсын аялал жуулчлалын бүс;<br>20.2.2.орон нутгийн аялал жуулчлалын бүс.<br>20.3.Энэ хуулийн 20.2.1, 20.2.2-т заасан аялал жуулчлалын бүс нь өөрийн онцлогт тохирсон хөгжлийн төлөвлөгөөтэй байна. |
| 3.1.3 | **Зорилгод хүрэх байдал** | 26.1.Аялал жуулчлалын талаар аймаг, нийслэлийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br>26.1.3.газар нутагтаа аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх;<br>26.1.4.газар нутагтаа аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлэх бодлоготой уялдуулан төлөвлөгөө боловсруулах, зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд санал оруулах, батлагдсан хөтөлбөрийн дагуу аялал жуулчлалын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;<br>26.1.5.эрх хэмжээнийхээ хүрээнд газар нутагтаа газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд үндэслэн аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглах зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгож гэрээ байгуулах;<br>26.1.6.аялал жуулчлалын мэдээллийн санг хөтлөх;<br>26.1.7.аймаг, нийслэлийн хэмжээнд зохион байгуулагддаг наадам, бусад аялал жуулчлалын арга хэмжээний товыг тухайн жилийн 10 дугаар сарын 1-ээс өмнө зарлах, тэдгээр арга хэмжээг зохион байгуулах, удирдлагаар хангах; |

| | | |
|---|---|---|
| | | 27.1.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал аялал жуулчлалын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br>27.1.1.энэ хуулийн 20.2.1, 20.2.2-т заасан аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;<br>27.1.2.нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх саналаа аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх;<br>27.1.3.хуульд заасан бусад.<br>**28 дугаар зүйл.Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх** 28.1.Сум, дүүргийн Засаг дарга аялал жуулчлалын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br>28.1.1.газар нутагтаа аялал жуулчлалын арга хэмжээг зохион байгуулах, орон нутгаа сурталчлах;<br>28.1.2.сум, дүүргийн соёл, спорт, олон нийтийн арга хэмжээг аялал жуулчлалын үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;<br>28.1.3.сум, дүүргийн аялал жуулчлалын мэдээллийн сан бүрдүүлэх, хадгалах, хамгаалж жил бүрийн 01-р сарын 15-ны өдрөөс өмнө аялал жуулчлалын мэдээллийн санд холбогдох мэдээллийг хүргүүлэх;<br>28.1.4.аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч иргэний үйл ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;<br>28.1.5.жуулчны аюулгүй байдлыг хангах арга хэмжээг харьяалах нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, нутгийн иргэдтэй хамтран зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих; 28.1.6.орон нутгийн иргэдийн өв соёлын үнэт зүйлс, гар урлал, уламжлалт соёлыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх зорилгоор орон нутагт аялал жуулчлалын хөрөнгө оруулалтыг татах нөхцөлийг хангах;<br>28.1.7.харьяалах нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын мэдээллийн санг бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, заасан хугацаанд аймаг, нийслэлийн эрх бүхий байгууллагад хүргүүлэх;<br>28.1.8.харьяалах нутаг дэвсгэртээ отоглох цэгийн байршил, аяллын маршрутыг тогтоох, нэгдсэн хаягжуулалтыг бий болгох.<br>28.1.9.энэ хуулийн 25.1.3-т заасан хураамжийн орлогыг аялал жуулчлалын бүсийг тохижуулах, ариун цэврийн байгууламж байгуулах, хог хаягдлын менежментийг гүйцэтгэхэд зарцуулах |
| 3.1.4 | **Зорилгод хүрэх байдал** | 8.1.Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага нь дараах шаардлагыг хангаж ажиллана:<br>8.1.1.тухайн үйлчилгээний техникийн зохицуулалтад нийцсэн, чанар, стандартын шаардлагыг хангасан үйлчилгээ үзүүлэх;<br>8.1.3.үйл ажиллагаандаа мөрдөж байгаа техникийн зохицуулалт, стандарт, үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай бусад мэдээллийг өөрийн албан ёсны цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглан нээлттэй, ил тод байршуулах;<br>16.1.Аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 214 .1-д заасан дараах үйл ажиллагааг санхүүжүүлнэ: |

| | | |
|---|---|---|
| | | 16.1.4.аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгох, хөгжүүлэх;<br>21.7.Энэ хуулийн 21.1-д заасан отоглох цэг нь стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай байна.<br><br>**Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**<br><br>**1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг**<br>15.1.15.Аялал жуулчлалын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан аялал жуулчлалын байгууллага өөрийн ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлага хангахуйц болгож засварласны болон стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж шинээр байгуулсны зардал. |
| 3.1.5 | **Зорилгод хүрэх байдал** | **12 дугаар зүйл.Хил орчмын аялал жуулчлал**<br>12.1.Хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалыг энэ хуулийн 11.2.1, 11.2.3- т заасан олон улсын аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй тур оператор гүйцэтгэнэ. 12.2.Энэ хуулийн 12.1-д заасан тур оператор нь хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зорилгын хүрээнд улсын хил хамгаалах байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангана.<br>12.3.Хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах журмыг Засгийн газар батална. |
| 3.1.6 | **Зорилгод хүрэх байдал** | **17 дугаар зүйл.Амьтан агнах тусгай зөвшөөрөл**<br>17.1.Агнуурын аялал жуулчлалыг дэмжих зорилгоор сүргийн бүтцийг алдагдуулахгүйгээр тооцоо, судалгаанд үндэслэн аргаль, янгир, идлэг шонхор агнах, барих тусгай зөвшөөрлийг дуудлага худалдаагаар олгоно. 17.2.Энэ хуулийн 17.1-д заасан дуудлага худалдаа зохион байгуулах журмыг Засгийн газар батална. 17.3.Энэ хуулийн 17.1-д заасан дуудлага худалдаагаар олгосон эрх, зөвшөөрлийг гуравдагч этгээдэд шилжүүлэх, худалдахыг хязгаарлахгүй. |
| 3.1.7 | **Зорилгод хүрэх байдал** | 16 дугаар зүйл.Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан 16.1.Аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 214 .1-д заасан дараах үйл ажиллагааг санхүүжүүлнэ: 16.1.1.агаарын зорчигч тээврийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх; 16.1.2.аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх; 16.1.3.Монгол Улсыг гадаад, дотоодод сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах; 16.1.4.аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгох, хөгжүүлэх; 9 16.2.Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан нь аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд ажиллана.<br><br>**Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**<br>**1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.**<br>“5.3.26.Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан” |

| | | |
|---|---|---|
| 3.2 | **Харилцан уялдаа** | Хуулийн төсөл, төслийг дагалдан боловсруулсан хуулийн төсөл бүхэлдээ |

## ДӨРӨВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Аргачлалд заасны дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлт, үр нөлөөг үнэлэх хэсгийг тус тус тогтоож, тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар тодорхойллоо:

Хүснэгт 2

| Д/д | Шалгуур үзүүлэлт | Үр нөлөөг үнэлэх хэсэг | Тохирох шалгах хэрэгсэл |
|---|---|---|---|
| 4.1 | Зорилгод хүрэх байдал | - 3 дугаар зүйл<br>- 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 4.3,<br>- 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 5.3, 5.4, 5.5 дахь хэсэг<br>- 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг,<br>- 7 дугаар зүйлийн 7.1,<br>- 8 дугаар зүйлийн 8.1,<br>- 9 дүгээр зүйлийн 9.1,<br>- 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 11.3, 11.4,<br>- 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.3,<br>- 16 дугаар зүйлийн 16.1,<br>- 17 дугаар зүйлийн 17.1,<br>- 26 дугаар зүйлийн 26.1,<br>- 27 дугаар зүйлийн 27.1,<br>- 28 дугаар зүйл | **Зорилгод дүн шинжилгээ хийх:**<br>Хуулийн төслийн зохицуулалт нь төслийн үзэл баримтлалд дурдсан зорилгод нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийнэ. |
| 4.2. | Харилцан уялдаа | Хуулийн төсөл бүхэлдээ /Хуулийн төсөл Дөрвөн бүлэг, 35 зүйлтэй/ хуулийн төслийн дагалдан боловсруулсан 10 хуулийн төсөл | **Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах:**<br>Хуулийн төслийн уялдаа холбоог аргачлалын 4.10-т заасан асуултад хариулах замаар шалгана. |

### 4.1 Шалгуур үзүүлэлт: Зорилгод хүрэх байдал

"Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн 3 дугаар зүйл, 5 дугаар зүйлийн 5.2, 5.3, 5.4, 5.5 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 11.3, 11.4 дэх хэсэг тус тус сонгож, эдгээр зохицуулалт нь бодит байдал дээр зорилгод хүрэх боломжтой эсэхийг албан ёсны мэдээлэл, холбогдох баримтад тулгуурлан судалсан.

Хуулийн төслийн үзэл баримтлалд хуулийн төслөөр зохицуулах асуудлыг дараах байдлаар тусгажээ:

- хуулийн зорилт, Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас гаргасан зөвлөмжид нийцүүлэн хуулийн нэр томьёоны тодорхойлолтыг тусгах;
- аялал жуулчлалын байгууллагын ангилал, түүний явуулах үйл ажиллагааны төрөл, тухайн үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн эдлэх эрх, үүрэг, мэргэжлийн үйл ажиллагааны зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагааг тусгах;

- аялал жуулчлалын бүсийг тогтоох, тэдгээрийн хөгжлийн төлөвлөлт, уялдаа холбоо, эдгээр бүсүүдэд үйл ажиллагаа явуулах шалгуур болон холбогдох бусад зохицуулалтуудыг тусгах;
- орон нутгийн оролцоог тусгах;
- аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагад стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжийг байгуулах, сэргээн засварлах;
- хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх тусгайлсан зохицуулалтыг тусгах
- аялал жуулчлалыг дэмжих үйл ажиллагааны талаар тусгах;
- аялал жуулчлалыг хөгжүүлэх сан, түүний эх үүсвэр болон зарцуулалт, хяналтыг тусгах;

- **4.1.1.**Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 4.2-т заасан эдийн засгийн тэргүүлэх салбарыг хөгжүүлэх зорилтын хүрээнд 2021-2030 онд " жуулчинд зориулсан татварын буцаан олголтын зохицуулалтыг тусгах;
- төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аялал жуулчлалын салбарын зарим гүйцэтгэх үүргийг хувийн хэвшил, ашгийн төлөө бус хуулийн этгээдэд олгох зохицуулалтыг тусгах.

Иймд дээр дурдсан хуулийн төслийн зохицуулалтын хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалын "Үндэсний онцлог бүхий байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан тогтвортой аялал жуулчлалын үйлдвэрлэлээр дамжуулан эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, дэмжих, аялал жуулчлалын байгууллагын ангиллыг тодорхойлон шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох" гэх үндсэн зорилгод нийцсэн эсэхэд анхаарлаа хандууллаа.

2016 онд Монгол Улсад 404 гаруй мянган жуулчин аялж, аялал жуулчлалын салбараас дотоодын эдийн засагт 312 сая ам.долларын орлого оруулсан байна. Энэхүү статистик мэдээг өмнөх онтой харьцуулж үзэхэд 2012 оноос хойш анх удаа гадаадын жуулчдын тоо 4,4 хувиар, салбарын орлого 11,4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй, улсын хэмжээнд нийт 274 аялал жуулчлалын компани, 473 зочид буудал, 385 жуулчны бааз үйл ажиллагаа явуулж, тус салбараас 54,000 ажлын байрыг бий болгосон нь нийт ажлын байрны 4,8%-г бүрдүүлсэн байна.[2]

Харин 2019 онд 577,262 жуулчин хүлээн авч, Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвар дээшилсэн байна." гэж, мөн зорилт 8.2-т заасан эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтын хүрээнд 2021-2030 онд "Байгаль экологи, археологи, палеонтологи, нүүдлийн өв, түүх, соёл, рекреацийн нөөц, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлнэ" гэж тус тус заасан бөгөөд эдийн засгийг сэргээх үндсэн хөшүүргийн нэгээр аялал жуулчлалын салбарыг онцолж, тэдгээрийг биелүүлэх тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Мөн оны эцсийн байдлаар 607,213,369 ам доллар буюу 1.7 их наяд төгрөгийн орлогыг аялал жуулчлалын салбараас төвлөрүүлсэн бол 2021 онд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 36.9 их наяд төгрөгт хүрснээс аялал жуулчлалын салбар 6.48%-ийг бүрдүүлсэн байна. Нөгөө талаас мөн онд манай улсаас нийт 2,080,276 жуулчин гадагш зорчсон нь дотоодын аялал жуулчлал сайн хөгжиж чадаагүйг илэрхийлж байна. [3]

---

[2]http://www.mne.mn

[3] Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, 2022

Ковид-19 цар тахлын улмаас уналтад орсон аялал жуулчлалын салбарыг эрчимтэй хөгжүүлэхээр Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарлаж, гадаад жуулчдын тоог 2024 он гэхэд 1,6 сая хүргэх зорилтыг дэвшүүлсэн.

Аялал жуулчлал эрчимтэй хөгжиж байгаа өнөө цагт үндэсний онцлог бүхий байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан тогтвортой аялал жуулчлалын үйлдвэрлэлээр дамжуулан эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, дэмжихийн зэрэгцээ аялал жуулчлалын байгууллагын ангиллыг тодорхойлон тэдгээрийн шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох нь чухал ач холбогдолтой болж байна. Өөрөөр хэлбэл тухайн харилцаанд гол оролцогч болох тур оператор, аяллын агент, хөтчийн эрх үүргийг нарийвчлан тодорхойлох, тусгай зөвшөөрөл, бүртгэлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг байх нь өндөр ач холбогдолтой байна.

Үүнээс гадна НҮБ-ын Байгаль орчны Бага Хурлаас /1992 он/ гаргасан "Хэлэлцэх асуудал-21" (Agenda 21) хөтөлбөрт дэвшүүлсэн тогтвортой хөгжлийн зарчим, үзэл санааг үндэсний хууль тогтоомжид тусгах, мөн аялал жуулчлалын нэр томьёог Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас 2008 онд гишүүн орнуудаа хандан гаргасан "Аялал жуулчлалын статистикийн олон улсын зөвлөмж"-д нийцүүлэн өөрчлөх, 2015 оны 9 дүгээр сард НҮБ-ын ерөнхий Ассамблейн чуулганаар баталсан "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030" -д [4] бүх талын оролцоог тэгш хангаж, оролцогч талуудын харилцан ашигтай байх зарчмыг баримтлан тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх гэсэн зорилтыг хангах хүрээнд манай улсын аялал жуулчлалын хууль тогтоомжийг олон улсын жишигт нийцүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Иймд аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, жуулчин болон аялал жуулчлалын үйлчилгээ эрхэлж буй этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, түүний хариуцлага болон үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, ингэхдээ олон улсын жишигт нийцүүлэхэд анхаарлаа хандуулах зайлшгүй шаардлагатай байна.

Хуулийн төсөлд энэхүү зорилтыг хангах зорилгоор "хуулийн нэр томьёо"-ны зохицуулалтыг болон аялал жуулчлалын байгууллагын ангилал, тусгай зөвшөөрөл, бүртгэлийг шинээр буюу дараах байдлаар тусгажээ:

Хүснэгт 3

| |
|---|
| ***<u>Хуулийн төслөөс:</u>*** <br><br> **3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо** <br> 3.1.Энэ хуульд хэрэглэсэн нэр томьёог дараах утгаар ойлгоно: <br><br> 3.1.3."жуулчин" гэж аялал жуулчлалын байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авч аялал жуулчлал хийж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг; <br><br> 3.1.4."аялагч" гэж аяллын зорилгоор аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлж байгаа хүнийг; <br><br> 3.1.6."аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага" гэж зочид буудал, жуулчны бааз, бусад хэлбэрийн жуулчны байр сууц, тээвэр, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийг; |

[4] Transforming our world: the 2030 Agenda for Sustainable Development, 2015

3.1.7."тур оператор" гэж аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг төлөвлөн бүрдүүлж, багц аяллыг шууд, эсхүл аяллын агентаар дамжуулан худалдах, зохион байгуулах хуулийн этгээдийг;

3.1.8."аяллын агент" гэж тур оператор болон аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагаас гаргасан аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг жижиглэн, эсхүл хоёр, түүнээс дээш үйлчилгээг худалдан борлуулж байгаа хүн, хуулийн этгээдийг;

3.1.9."жуулчны хөтөч" гэж жуулчинд үндэсний өв соёл, байгаль, газар зүйн онцлог болон шаардлагатай бүхий л мэдээллийг хүргэж аяллыг хөтлөн явуулах энэ хуульд заасан шаардлага хангасан хүнийг;

**5 дугаар зүйл.Аялал жуулчлалын байгууллага**

5.2.Аялал жуулчлалын байгууллагыг дараах байдлаар ангилна:

5.2.1.тур оператор;
5.2.2.аяллын агент;
5.2.3.аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага.

5.3.Тур оператор дараах чиглэлээр үйл ажиллагааг явуулна:

5.3.1.олон улсын аялал жуулчлалын үйл ажиллагаа;
5.3.2.дотоодын аялал жуулчлалын үйл ажиллагаа;
5.3.3.энэ хуулийн 5.3.1, 5.3.2-т заасан үйл ажиллагааг хамтад нь эрхлэх.

5.4.Энэ хуулийн 5.2.1-д заасан хуулийн этгээдийн хувьцааны 51, түүнээс багагүй хувийн хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээд байна.
5.5.Энэ хуулийн 5.2-т заасан ангилалд тусгагдаагүй байгууллага тусгай сонирхлын болон бусад төрлийн эрсдэл бүхий аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд энэ хуулийн 29.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бүртгүүлсэн байна.

6.1.Тур оператор нь дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

6.1.1.аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөх, бүрдүүлэх, бий болгох, сурталчлах, жижиглэнгээр, эсхүл хоёр, түүнээс дээш бүтээгдэхүүн, үйлчилгээг багцлан худалдан борлуулах, аялал зохион байгуулах;
6.1.2.жуулчдад зориулсан соёл, урлаг, олон нийтийн арга хэмжээг зохион байгуулах, борлуулах;
6.1.3.виз авахтай холбогдсон болон аяллын бусад бичиг баримтын бүрдүүлэлт хийх;
6.1.4.агаарын, төмөр замын болон бусад тээврийн хэрэгслээр зорчих билет /тийз/-ийн захиалга хийх, билет /тийз/ худалдах, борлуулах.

7.1.Аяллын агент дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

7.1.1.тур операторын бүтээгдэхүүнийг зуучлан худалдах үйл ажиллагаа;
7.1.2.энэ хуулийн 6.1.3, 6.1.4-т заасан үйл ажиллагаа;
7.1.3.хуульд заасан бусад. 7.2.Аяллын агент нь энэ хуулийн 7.1.2-т заасан үйл ажиллагааг эрхлэх бол энэ хуулийн 6.2-т заасан холбогдох үүргийг хүлээнэ.

8.1.Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага нь дараах шаардлагыг хангаж ажиллана:

8.1.1.тухайн үйлчилгээний техникийн зохицуулалтад нийцсэн, чанар, стандартын шаардлагыг хангасан үйлчилгээ үзүүлэх;
8.1.2.үйлчилгээний үнэ тарифыг энэ хуулийн 5.10-т заасныг баримтлан тогтоож үйлчлэх;
8.1.3.үйл ажиллагаандаа мөрдөж байгаа техникийн зохицуулалт, стандарт, үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай бусад мэдээллийг өөрийн албан ёсны цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглан нээлттэй, ил тод байршуулах;

8.1.4.аялал жуулчлалын байгууллагатай гэрээ байгуулсан тохиолдолд жуулчнаас үйлчилгээний хөлсийг давхардуулж авахгүй байх;

8.1.5.үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор таван жилийн дотор зэрэглэлд хамрагдах талаарх бизнес төлөвлөгөөтэй байх.

9.1.Хөтөч, тайлбарлагчийн сургалтад хамрагдаж, энэ хуулийн 29.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бүртгүүлж, үнэмлэх авсан хүн жуулчны хөтчийн үйлчилгээ үзүүлнэ.

11.1.Энэ хуулийн 5.2.1-д заасан тур операторын үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.30 дахь заалтад заасан тусгай зөвшөөрөлтэй эрхэлнэ.

11.2.Энэ хуулийн 11.1-д заасан зөвшөөрөл нь дараах ангилалтай байна:

11.2.1.Монгол Улсаас бусад улс руу хийх аялал жуулчлалын үйлчилгээ; 11.2.2.бусад улсаас Монгол Улс руу хийх аялал жуулчлалын үйлчилгээ;

11.2.3.энэ хуулийн 11.2.1 болон 11.2.2-т заасан аялал жуулчлалын үйлчилгээг хамтад нь эрхлэх;

11.2.4.дотоодын аялал жуулчлалын үйл ажиллагаа.

11.3.Тур операторын үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлт гаргасан хуулийн этгээд нь Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан баримт бичгээс гадна дараах шаардлагыг хангасан байна:

11.3.1.аяллын агентын чиглэлээр хоёроос доошгүй жил үйл ажиллагаа явуулсан байх;

11.3.2.аялал жуулчлалын салбарын мэдлэг, туршлагатай гурваас доошгүй ажилтантай байх;

11.3.3.аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах бизнес төлөвлөгөө болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журамтай байх;

11.3.4.энэ хуулийн 11.2.1, 11.2.3-т заасан үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авах тохиолдолд бусад улсын аялал жуулчлалын байгууллагатай хамтран ажиллах боломжтой байх.

11.4.Энэ хуулийн 11.1-д заасан тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохдоо Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1, 5.2, 5.3, 5.4, 5.5, 5.6, 6.1, 6.2, 6.3, 6.4 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аялал жуулчлалын байгууллага нь аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг жуулчинд үзүүлэх зорилгоор аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлсэн ашгийн төлөө хуулийн этгээд байна.” гэж, 5.2-т түүний ангиллыг, 11 дүгээр зүйлд тур операторын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус тодорхой тусгасан байна.

Түүнчлэн хуулийн төсөлд 5.9-д аяллын агентыг нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бүртгүүлэхээр тусгасан байна.

Гэвч хуулийн төслийн нэр томьёо, аялал жуулчлалын байгууллагын ангилал, тэдгээрийн үйл ажиллагаа, тусгай зөвшөөрөл, бүртгэлийн хэсгийг Аялал жуулчлалын

тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор шинээр тусгаснаас харвал:

- жуулчин, аялагч гэх ойлголтыг шинээр тусгасан нь сайшаалтай боловч Аялал жуулчлалын тухай конвенцын 3 дугаар зүйлд жуулчин(tourist), аялагч(excursionist) гэсэн 2 ялгамжтай ойлголтын ялгааг нарийвчлан гаргаж тусгаагүй;

- аялал жуулчлалын байгууллагын ангилал, тэдгээрийн үйл ажиллагааны чиглэлийн талаар тусгахдаа тур оператор, аяллын агентын үйл ажиллагааны онцлог, гол ялгааг гаргаагүй, хууль зүйн үр дагавар үүсгэсэн зохицуулалтыг бүрэн тусгаагүй байна.

Өөрөөр хэлбэл, аялал жуулчлалын 2 байгууллагын аль аль нь аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг жуулчинд үзүүлэхээр байгаа боловч тур оператort хуулийн төсөлд аяллын агентаас илүү шаардлагыг тавьсан байна. Тухайлбал, аяллын агент нь зөвхөн бүртгүүлснээр үйл ажиллагаа явуулж болохоор заасан бол, тур оператор нь Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.30-д заасан тусгай зөвшөөрлийг авсны үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэхээр байна.

Иймд хуулийн төсөлд аялал жуулчлалын байгууллагын төрөл, тэдгээрийг ялгамжтай байдал зэргийг тодорхой тусгах, аялал жуулчлалын үйл ажиллагаа, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ зэргийг ялгах, ингэхдээ аялал жуулчлалын арга хэмжээнээс ялгаж тусгах нь зүйтэй байна.

Түүнчлэн аяллын агент нь хуулийн төслийн 3.1.8-д зааснаар хүн, хуулийн этгээд байхаар заасан боловч 5.2-т зөвхөн хуулийн этгээд байх, тур оператор нь Зөвшөөрлийн тухай хууль, энэ хуулийн төслийн 11 дүгээр зүйлд заасан тусгай зөвшөөрлийн үндсэн дээрх үйл ажиллагаа явуулахаар заасан бол мөн зүйлд зөвхөн бүртгүүлэхээр заасан байна.

Дээр дурдсан зүйлүүд нь практикт хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулах бөгөөд аялал жуулчлалын байгууллага гэх ойлголтыг тодорхойгүй болгох нөхцөлийг бүрдүүлж байна.

Мөн хуулийн төслийн үзэл баримтлалд тур операторын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 50, түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээд байхаар тусгай шалгуурыг тавихаар заасан боловч хуулийн төслийн 5.4-т тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 51, түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээд байхаар дэвшүүлсэн зорилтоос өөрөөр тусгасан байна.

Түүнчлэн дээрх хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчийн хувь хэмжээг 51, түүнээс дээш хувийг Монгол Улсын иргэн, хуулийн этгээд байхаар хатуу зааснаар хуулийн төслийн үзэл баримтлалын хоёр дахь зорилт буюу аялал жуулчлалын салбар дахь гадаад болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах гэсэн зорилтыг хангахад хүндрэлтэй болохоор байна.

- хуулийн төслийн үзэл баримтлалд аялал жуулчлалын бүсчлэл, түүний менежментийг хэрэгжүүлэх зохицуулалтыг заасан бол хуулийн төсөлд бүсчлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан. Гэвч тэдгээр зохицуулалт хууль зүйн үр дагавар үүсгэхгүй байх бөгөөд бүсчлэлийг бий болгосноор аялал жуулчлалын байгууллага, гадаад улсын болон Монгол Улсын хөрөнгө оруулагч нарт ямар давуу талыг бий

болгох, хөрөнгө оруулалтыг татах хөшүүрэг болох зохицуулалтын талаар тодорхойгүй байна.

Хэдийгээр энэ нь хуулийн төслийн үзэл баримтлалын зорилтыг хэрэгжүүлэх өнгөц ойлгогдох боловч хуулийн төсөлд тусгасан зохицуулалт нь зорилтыг бүрэн хангахааргүй байна.

**4.1.2.**Хуулийн төслийн үзэл баримтлалд “аялал жуулчлалын салбар дахь орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх үүрэг хариуцлага эрх хэмжээг тодорхой болгосон зохицуулалт тусгана.” гэсэн асуудлыг зохицуулахаар тусгажээ:

Хүснэгт 4

***<u>Хуулийн төслөөс:</u>***

**25 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх**

25.1.Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал аялал жуулчлалын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.1.1.газар нутагтаа аялал жуулчлалын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, Засаг даргын тайланг хэлэлцэх;

25.1.2.газар нутгийнхаа тодорхой хэсгийг аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх саналаа аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

25.1.3.жуулчин болон аялагч отоглох цэгт байрлах хураамжийн хэмжээг тогтоох.

26.1.Аялал жуулчлалын талаар аймаг, нийслэлийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

26.1.3.газар нутагтаа аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх;

26.1.4.газар нутагтаа аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлэх бодлоготой уялдуулан төлөвлөгөө боловсруулах, зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд санал оруулах, батлагдсан хөтөлбөрийн дагуу аялал жуулчлалын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;

26.1.5.эрх хэмжээнийхээ хүрээнд газар нутагтаа газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд үндэслэн аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглах зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгож гэрээ байгуулах;

26.1.6.аялал жуулчлалын мэдээллийн санг хөтлөх;

26.1.7.аймаг, нийслэлийн хэмжээнд зохион байгуулагддаг наадам, бусад аялал жуулчлалын арга хэмжээний товыг тухайн жилийн 10 дугаар сарын 1-ээс өмнө зарлах, тэдгээр арга хэмжээг зохион байгуулах, удирдлагаар хангах;

27.1.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал аялал жуулчлалын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

27.1.1.энэ хуулийн 20.2.1, 20.2.2-т заасан аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

27.1.2.нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх саналаа аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх;

27.1.3.хуульд заасан бусад.

**28 дугаар зүйл.Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх**

28.1.Сум, дүүргийн Засаг дарга аялал жуулчлалын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28.1.1.газар нутагтаа аялал жуулчлалын арга хэмжээг зохион байгуулах, орон нутгаа сурталчлах;

28.1.2.сум, дүүргийн соёл, спорт, олон нийтийн арга хэмжээг аялал жуулчлалын үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;

28.1.3.сум, дүүргийн аялал жуулчлалын мэдээллийн сан бүрдүүлэх, хадгалах, хамгаалж жил бүрийн 01-р сарын 15-ны өдрөөс өмнө аялал жуулчлалын мэдээллийн санд холбогдох мэдээллийг хүргүүлэх;

28.1.4.аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч иргэний үйл ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

28.1.5.жуулчны аюулгүй байдлыг хангах арга хэмжээг харьяалах нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, нутгийн иргэдтэй хамтран зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих; 28.1.6.орон нутгийн иргэдийн өв соёлын үнэт зүйлс, гар урлал, уламжлалт соёлыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх зорилгоор орон нутагт аялал жуулчлалын хөрөнгө оруулалтыг татах нөхцөлийг хангах;

28.1.7.харьяалах нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын мэдээллийн санг бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, заасан хугацаанд аймаг, нийслэлийн эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

28.1.8.харьяалах нутаг дэвсгэртээ отоглох цэгийн байршил, аяллын маршрутыг тогтоох, нэгдсэн хаягжуулалтыг бий болгох.

28.1.9.энэ хуулийн 25.1.3-т заасан хураамжийн орлогыг аялал жуулчлалын бүсийг тохижуулах, ариун цэврийн байгууламж байгуулах, хог хаягдлын менежментийг гүйцэтгэхэд зарцуулах

Хэдийгээр хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан аялал жуулчлалын салбар дахь орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, үүрэг хариуцлага, эрх хэмжээг тодорхой болгосон боловч үзэл баримтлалд тусгайлан заасан аялал жуулчлалын маршрутын тэмдэг тэмдэглэгээг байршуулах чиг үүргийг хэнд олгосон нь тодорхойгүй хэвээр байна.

Иймд хуулийн төсөлд отоглох цэгийн болон аялал жуулчлалын маршрутын тэмдэг тэмдэглэгээг байршуулах эрх хэмжээг Монгол Улсын Засаг захиргааны нэгж8 түүний удирдлагын тухай хуульд заасан чиг үүргийн дагуу сум, дүүргийн Засаг даргын эрх хэмжээнд нарийвчлан тусгах нь зүйтэй байна.

**4.1.3.**Хуулийн төслийн үзэл баримтлалд “аялал жуулчлалыг хөгжүүлэх сан”-ийн зохицуулалтыг Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нарийвчлан тусгасан байна.

Түүнчлэн уг сангийн эх үүсвэрт Казиногийн төлөх онцгой албан татварын орлогын 5 хувь, Иргэний нисэхийн тухай хуулийн 11.2.16-д заасан аялал жуулчлалын төлбөрийн орлого, аялал жуулчлалын хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн торгуулийн орлого, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.30-д заасан зөвшөөрлийн хураамжийн орлого хамаарахаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан байна.

Гэвч хуулийн төслийн үзэл баримтлалд санхүүжилтийн эх үүсвэрт “жуулчны татвар”-ыг бий болгож, дээрх сангийн эх үүсвэр байхаар дурдсан боловч Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд энэ талаарх зохицуулалтыг тусгаагүй, энэ төрлийн татварыг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлээгүй байгаа нь үзэл баримтлалын зорилтыг  хангаагүй байна гэж үзэхээр байна.

Иймд энэхүү үзэл баримтлалд заасан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “жуулчны татвар”-ыг сангийн эх үүсвэр болгохоор нэмэх, мөн Татварын ерөнхий хуульд “жуулчны татвар” гэсэн шинэ төрлийн татварын зохицуулалт нэмэх. Ингэхдээ

шинэ төрлийн татварыг бий болгох эсэх асуудлаар Сангийн яамтай зөвшилцөх нь зүйтэй болно.

Харин хуулийн төслийн үзэл баримтлалд туссан “жуулчдад нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгохтой холбоотой эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх” зорилт бүрэн хангагдсан байна. Өөрөөр хэлбэл Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдан боловсруулсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд жуулчны худалдан авсан бараа, бүтээгдэхүүнд ногдуулсан нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгохтой холбоотой зохицуулалтыг тусгасан байна. Энэ нь практикт бүрэн хэрэгжих боломжтой гэж үзэж байна.

**4.1.4.**Хуулийн төслийн үзэл баримтлалд “Хил орчмын аялал жуулчлалыг байнгын ажиллагаатай боомт, олон улсын боомт болон хил орчмын нутаг дэвсгэрт байрлах чөлөөт бүсэд олон улсын аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй тур оператор гүйцэтгэхээр зохицуулалтыг тусгана” гэж заажээ.

Хүснэгт 5

***Хуулийн төслөөс:***

**12 дугаар зүйл.Хил орчмын аялал жуулчлал**

12.1.Хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалыг энэ хуулийн 11.2.1, 11.2.3- т заасан олон улсын аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй тур оператор гүйцэтгэнэ.
12.2.Энэ хуулийн 12.1-д заасан тур оператор нь хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зорилгын хүрээнд улсын хил хамгаалах байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангана.
12.3.Хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах журмыг Засгийн газар батална.

Тайлбар: Энэ зүйлд заасан “хил орчмын нутаг дэвсгэр” гэж хил залгаа улстай хиллэж байгаа аймгийн нутаг дэвсгэрийг ойлгоно.

Хуулийн төсөлд зааснаар тухайн хил орчмын бүс нутагт олон улсын аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий тур оператор зөвхөн үйл ажиллагаа явуулахаар заасан бөгөөд 12 дугаар зүйлийн тайлбарт хил орчмын нутаг дэвсгэр гэж хилийн залгаа улстай хиллэж байгаа аймгийн нутаг дэвсгэрийг хэлэхээр заасан байна. Монгол Улс нь Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай 21 аймгаас 15 аймаг нь хиллэдэг болно.

Иймд Монгол Улсын дээрх 15 аймгийн нутаг дэвсгэрт зөвхөн олон улсын аялал жуулчлалын тусгай зөвшөөрөлтэй тур оператор үйл ажиллагаа явуулахаар байна. Харин 6 аймгийн нутаг дэвсгэрт олон улсын болон дотоодын аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж болохоор байна.

Хэдийгээр хуулийн төслийн дээрх зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлалд тодорхойлсон зорилтыг хэрэгжүүлэхээр байгаа боловч зөвхөн тодорхой нэг төрлийн аялал жуулчлалын байгууллагад хэтэрхий давуу эрхийг олгохоор байна.

Түүнчлэн энэхүү зорилт нь хуулийн төслийн үндсэн зорилт болох “Үндэсний онцлог бүхий байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан тогтвортой аялал жуулчлалын үйлдвэрлэлээр дамжуулан эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, дэмжихэд

чиглэгдсэн аялал жуулчлалын үйл ажиллагаанд төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахаар заасантай хэр нийцэх эсэх нь эргэлзээтэй байна.

Тодруулан үндэсний онцлог бүхий байгаль, түүх, соёлын өв нь гадаад улстай хиллэдэг 15 аймгийн нутаг дэвсгэрт бусад аймгийн нэгэн адил орших бөгөөд энэ аймгуудад дотоодын аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг тур оператор аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах боломжгүй болох тул үзэл баримтлалд заасан болон хуулийн төслийн гол зорилтыг хангахад хүндрэлтэй байна.

Мөн хуулийн 12 дугаар зүйлийн тайлбарт заасан “хил орчмын нутаг” дэвсгэр гэдгийг Монгол Улсын хилийн тухай хуулийн 3.1.14-т хил залгаа улстай хиллэж байгаа сумын нутаг дэвсгэрийг хэлэхээр заасан байдаг.

Иймд хуулийн төслийн 12 дугаар зүйлийн тайлбарыг Монгол Улсын хилийн тухай хуультай нийцүүлж, “хил орчмын нутагт” гэснийг зөвхөн хил залгаа улстай хиллэж байгаа **сумын нутаг** дэвсгэрийг ойлгохоор тусгах нь зүйтэй бөгөөд ингэснээр хуулийн төслийн үзэл баримтлалын үндсэн зорилтыг хангахад дөхөм болох юм.

Түүнчлэн хуулийн төслийн үзэл баримтлалд заасан “хил орчмын нутаг дэвсгэрийн чөлөөт бүсэд” гэсэн нутаг дэвсгэрийн хязгаарлалтыг хуулийн төсөлд зохицуулалт болгон оруулах нь зүйтэй байна.

**4.1.4.**Хуулийн төслийн үзэл баримтлалд “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аялал жуулчлалын зарим төрлийн төрийн үйлчилгээг аялал жуулчлалын мэргэжлийн холбоогоор гүйцэтгүүлэх, тухайлбал аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэл олгох, тур операторын тусгай зөвшөөрөл олгох чиг үүргийг гүйцэтгүүлэх эрх зүйн үндэслэлийг нарийвчлан тодорхойлно.” гэж заажээ.

Хүснэгт 6

***Хуулийн төслөөс:***

**5 дугаар зүйл.Аялал жуулчлалын байгууллагын ангилал**
5.5.Энэ хуулийн 5.2-т заасан ангилалд тусгагдаагүй байгууллага тусгай сонирхлын болон бусад төрлийн эрсдэл бүхий аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд энэ хуулийн 29.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бүртгүүлсэн байна.
5.6.Тур оператор, аяллын агент нь энэ хуулийн 29.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бүртгүүлсэн байна.

**9 дүгээр зүйл.Жуулчны хөтөч**
9.1.Хөтөч, тайлбарлагчийн сургалтад хамрагдаж, энэ хуулийн 29.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бүртгүүлж, үнэмлэх авсан хүн жуулчны хөтчийн үйлчилгээ үзүүлнэ.

**16 дугаар зүйл.Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан**
16.3.Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан нь орон тооны бус Удирдах зөвлөл, хяналтын хороотой байх бөгөөд уг Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 66 хувиас доошгүй хувь нь олон нийтийн мэргэжлийн байгууллагын төлөөлөл байна.

**29 дүгээр зүйл.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо**
29.4.Холбоо нь улс орны аялал жуулчлалын салбарын хөгжлийн талаар баримтлах төрийн бодлого, зохицуулалтад мэргэжлийн зөвлөгөө өгөх, салбарын мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр төрийн, төрийн бус болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж болно.

29.6.Энэ хуулийн 5.8-д аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэл олгох, 9 дүгээр зүйлд заасан жуулчны хөтчид үнэмлэх олгох, бүртгэх, 11 дүгээр зүйлд заасан тур операторын тусгай зөвшөөрөл олгох чиг үүргийг Холбоогоор гүйцэтгүүлж болно.

**31 дүгээр зүйл.Аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих хяналт**
31.6.Энэ зүйлд заасан аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих төрийн хяналтыг энэ хуулийн 29.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд шилжүүлж болно.

Энэхүү зохицуулалт нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын зарим чиг үүргийг хуулиар төрийн байгууллагаас бусад байгууллага болох ашгийн төлөө болон ашгийн төлөө бус хуулийн этгээдэд шилжүүлэн гүйцэтгүүлэх эрх олгосон зохицуулалт болно.

Хуулийн төсөлд тусгасан гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын чиг үүргийг шилжүүлэх дээрх зохицуулалтын хувьд бүртгэлийн, хяналтын, хамтын ажиллагааны, менежментийн чиг үүргийг шилжүүлж болохоор заасан байна.

Тухайлбал, хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.5, 5.6 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт тур оператор, аяллын агент, жуулчны хөтчийг бүртгэх эрхийг ашгийн төлөө бус хуулийн этгээдэд, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн удирдлагын бүрэлдэхүүний дийлэнх хувийг ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөлөлд шилжүүлэх, 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсгээр аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих хяналтыг ашгийн төлөө бус хуулийн этгээдэд тус тус шилжүүлэхээр байна.

Түүнчлэн хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт отоглох цэгийн менежментийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болохоор тусгасан байна.

Хуулийн төслийн дээрх зохицуулалтаас үзэхэд үзэл баримтлалд заасан зорилгыг биелүүлэхээр байна.

Харин хуулийн төслийн үзэл баримтлалд аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэл тогтоох чиг үүргийг шилжүүлэх зохицуулалтыг нарийвчлан тусгахаар тодорхойлсон байна. Гэвч хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэлийг мэргэжлийн холбооны саналыг үндэслэн орон нутгийн аялал жуулчлалын нэгж олгохоор тусгасан боловч аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэл олгох эрхийг хуулийн төсөлд ашгийн төлөө бус хуулийн этгээдэд олгож болох зохицуулалтыг орхигдуулсан байна.

Энэ нь үзэл баримтлалд заасан зорилтыг бүрэн биелүүлнэ гэж үзэхээргүй байна.

Иймд хуулийн төслийн үзэл баримтлалын зорилтод бүрэн нийцүүлэх хүрээнд хуулийн төслийн 21 дүгээр зүйлд аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэлийг тогтоох чиг үүргийг мэргэжлийн холбоонд шилжүүлж болох зохицуулалтыг нэмж тусгах шаардлагатай байна.

Мөн хуулийн төсөлд тусгасан аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, аялал жуулчлалын нөөц баялгийг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын салбарт ажиллагсдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, төрөөс аялал жуулчлалын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, Монгол Улсын аялал жуулчлалыг дотоод, гадаадын зах зээлд сурталчлах” зорилгыг практикт

хэрэгжүүлэх боломжгүй байх тул энэ байгууллагын талаар хуулийн төсөлд тусгахдаа бусад төрийн байгууллага, албан тушаалтны хуульд заасан чиг үүрэгтэй уялдуулан тусгах нь зүйтэй байна.

Хүснэгт 7

| |
|---|
| ***Хуулийн төслөөс:***<br><br>**ТАВДУГААР БҮЛЭГ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ**<br><br>**31 дүгээр зүйл.Аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих хяналт**<br><br>31.1.Аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих хяналт нь дараах төрөлтэй байна:<br>31.1.1.аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих төрийн хяналт;<br>31.1.2.аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналт. 31.2.Аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийн биелэлтэд аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бүх шатны Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.<br>31.3.Аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн аялал жуулчлалын асуудал эрхэлсэн захиргааны байгууллага, нэгж нь бүх шатандаа аялал жуулчлалын нөөцийг хамгаалах, бүрдүүлэх, зүй зохистой ашиглахад хяналт тавина.<br>31.4.Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн нь төрөөс аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих хяналтын улсын ерөнхий байцаагч байх бөгөөд улсын ахлах байцаагч, улсын байцаагч, орон нутаг дахь улсын байцаагчийг томилж, чөлөөлнө.<br>31.5.Аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн аялал жуулчлалын нэгж, аялал жуулчлалын улсын байцаагч нар хамтран хэрэгжүүлнэ.<br>31.6.Энэ зүйлд заасан аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих төрийн хяналтыг энэ хуулийн 29.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд шилжүүлж болно. 17 32 дугаар зүйл.Аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналт<br>32.1.Аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх талаар иргэн, хуулийн этгээд дараах эрх эдэлнэ:<br>32.1.1.аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийг зөрчсөн тухай мэдээлэх, өргөдөл, гомдлыг харьяалах Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргаж, шийдвэрлүүлэх;<br>32.1.2.аялал жуулчлалын хууль тогтоомж зөрчигдсөнтэй холбоотойгоор учирсан хохирлыг арилгуулахаар харьяалах шүүхэд нэхэмжлэл гаргах. |

Дээр дурдсанчлан хуулийн төсөлд “аялал жуулчлалын үйл ажиллагаа” гэдгийг төдийлөн тодорхой тусгаагүйгээс гадна хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлгийн гарчиг болон 31 дүгээр зүйлийн гарчгийг “Аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих хяналт” гэж нэрлэсэн нь Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд заасан бүхий л зохицуулалтад хяналт тавихгүй мэт ойлгогдож байгаа учраас “Аялал жуулчлалын тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт” гэж нэрлэх нь илүү оновчтой гэж үзэж байна.

### 4.2.Шалгуур үзүүлэлт: Хуулийн төслийн уялдаа холбоо

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах, хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг тогтоох зорилгоор Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 4.10-т заасан асуултад заасан асуултад хариулах замаар хуулийн төслийг бүхэлд нь дараах байдлаар шалгалаа.

**4.2.1.Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх:**

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн 1 дүгээр зүйлд тусгасан хуулийн зорилттой нийцэж байна.

Харин хуулийн төслийн 1 дүгээр зүйлд заасан хуулийн зорилтын тухайд "үндэсний онцлог бүхий байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан тогтвортой аялал жуулчлалын үйлдвэрлэлээр дамжуулан эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, дэмжих болон аялал жуулчлалын үйл ажиллагаанд төр, иргэн, хуулийн этгээд хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино." гэж тодорхойлсон байна.

Ямар ч хууль, дүрэм, журам нь тодорхой нэг төрлийн харилцааг зохицуулах зорилготой байдаг бөгөөд Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн дээрх зорилтыг үзэхэд 2 төрлийн ерөнхий агуулгыг илэрхийлэх бөгөөд "үндэсний онцлог бүхий байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан тогтвортой аялал жуулчлалын үйлдвэрлэлээр дамжуулан эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, дэмжих" гэдэг нь харилцаа гэхээс илүүтэй тодорхой "дэмжлэг" үзүүлэхийг шууд заасан байхаар томьёологдсон байна.

Иймд хуулийн төслийн зорилтын дээрх хэсгийг "үндэсний онцлог бүхий байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан тогтвортой аялал жуулчлалын үйлдвэрлэлээр дамжуулан эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулах" гэсэн агуулгаар тодруулж тусгах нь зүйтэй байна.

**4.2.2.Хуулийн төслийн "Хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх:**

Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт Иргэний хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль зэрэг хуулийг тусгасан байна. Эдгээр хуулиудаас тухайн харилцаанд шууд утгаараа хамааралтай, заавал тусгах шаардлагатай хуулиуд байна гэж үзлээ.

Түүнчлэн хуулийн төсөлд Байгаль орчныг хамгаалах тухай суурь хуулийг тусгах нь зүйтэй байна.

**4.2.3.Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх:**

Хуулийн төсөлд тодорхойлсон дараах нэр томьёог утга найруулгын хувьд ойлгомжтой болгох шаардлагатай байна. Тухайлбал,

-Төслийн 5 дугаар зүйлийн 5,1, 5.1.10, 5.1.11, 8.1.4, 11.3.4, 13.1, 15.5, 15.7, 24.1.4 дахь заалтуудад **"Аялал жуулчлалын байгууллага"** гэдэг нэр томьёог тусгасан ба хуулийн нэр томьёоны хэсэгт 3.1.6.**"аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага"** гэж зочид буудал, жуулчны бааз, бусад хэлбэрийн жуулчны байр сууц, тээвэр, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийг; хэлнэ гэж томьёолсон байна. Иймд дээрх зүйл заалтуудад байгаа "аялал жуулчлалын байгууллага" гэх нэр томьёог тус хуулийн нэр томьёоны хэсэгт тодорхойлсон нэршлээр ижил болгон өөрчлөх шаардлагатай.

- Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн тайлбар хэсэгт " Энэ зүйлд заасан "хил орчмын нутаг дэвсгэр" гэж хил залгаа улстай хиллэж байгаа аймгийн нутаг дэвсгэрийг хэлнэ"" гэж тусгасан бол Монгол улсын хилийн тухай хуулийн 3.1.14 – д дээрх нэр томьёог "хил залгаа улстай хиллэж байгаа сумын нутаг дэвсгэрийг хэлнэ" гэж тодорхойлсон байна. Иймд тус хуулийн төсөлд Монгол Улсын хилийн тухай хуулийн 3.1.14-д заасан нэр томьёог эшлэн тусгах нь зүйтэй байна.

- Хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.6 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт аялал жуулчлалын нөөц, аялал жуулчлалын бүсийн нөөц гэх зэргээр нэр томьёог хэд хэдэн удаа хэрэглэсэн байх бөгөөд уг аялал жуулчлалын нөөц гэдэгт юуг ойлгохыг хуулийн төсөлд тодорхойлоогүй, тайлбар оруулаагүй байгаа нь хуулийн хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэж болзошгүй байна.

Иймд аялал жуулчлалын нөөц гэсэн нэр томьёог хуулийн төсөлд тайлбар хийх, эсхүл зохицуулалтад тодорхойлж өгөх нь зүйтэй байна.

-Иргэний хууль, Орон сууцны тухай хуульд орон сууц, Эрүүгийн хуульд орон байр гэж тус тус нэр томьёоны холбогдох тодорхойлолтын тайлбарласан тул төслийн 3.1.8-д "байр сууц" гэсэн нэр томьёог энэхүү төсөлд тусгахдаа зохимжтой нэршлээр тусгах шаардлагатай байна.

**4.2.4.Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх:**

Хуулийн төслийн дараах зүйл, хэсэг, заалт нь дараах хууль тогтоомж болон хуулийн төсөл бусад зүйл, хэсэг8 заалттай нийцэхгүй байна. Үүнд:

-Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт дуудлага худалдааны журмыг Засгийн газар тогтоохоор заасан нь Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дуудлага худалдаагаар зөвшөөрлийг олгох харилцааг тухайлсан хуулиар нарийвчлан зохицуулахаар заасантай нийцэхгүй байна.

- Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн тайлбарт заасан "хил орчмын нутаг дэвсгэр" гэж хил залгаа улстай хиллэж байгаа аймгийн нутаг дэвсгэрийг ойлгохоор тусгасан нь Монгол Улсын хилийн тухай хуулийн 3.1.14-т "хил орчмын нутаг дэвсгэр" гэж хил залгаа улстай хиллэж байгаа сумын нутаг дэвсгэрийг хэлэхээр заасантай нийцэхгүй байна.

-Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1-д аялал жуулчлалын байгууллага гэдгийг тодорхойлохдоо "бүртгүүлсэн хуулийн этгээд байхаар" тусгасан нь мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д аяллын агентыг хуулийн этгээд байхаас гадна иргэн байхаар тодорхойлсонтой, мөн хуулийн 11 дүгээр зүйлд тур оператор нь Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.30 дахь заалтад заасан тусгай зөвшөөрөлтэй эрхлэхээр заасантай нийцэхгүй байна.

-Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.11 дэх хэсэгт аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 20.2.1-д заасан улсын аялал жуулчлалын бүсийг тогтоох саналыг Үндэсний хороонд хүргүүлэх", гэж заасан нь хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.2.5 дахь заалтын Засгийн газар нь аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн энэ хуулийн 20.2.1-д заасан бүсийг тогтоохоор заасантай нийцэхгүй байна.

Иймд дээрх хуулийн төслийн зөрчлийг арилгаж холбогдох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах шаардлагатай байна.

**4.2.5.Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх:**

Төслийн дараах зүйл, заалтууд нь уг төслийн болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн заалттай давхардсан агуулгатай байна. Тухайлбал:

- Хуулийн төслийн 16 дугаар зүйлд Аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн зохицуулалтыг тусгасан бөгөөд 16.2-т “аялал жуулчлалыг хөгжүүлэх сан нь аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд ажиллана.”гэж, 16.3-т “Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан нь орон тооны бус Удирдах зөвлөл, хяналтын хороотой байх бөгөөд уг Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 66 хувиас доошгүй хувь нь олон нийтийн мэргэжлийн байгууллагын төлөөлөл байна.” гэж тус тус заасан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан аялал жуулчлалын сангаас санхүүжүүлэх арга хэмжээ, сангийн харьяалал, сангийн удирдлага гэсэн зохицуулалттай давхардахаар байна. Иймд тус зохицуулалтыг хасах, эсхүл Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиас эшлэл авах нь зүйтэй байна.

- Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт “энэ хуулийн 17.1-д заасан дуудлага худалдаа зохион байгуулах журмыг Засгийн газар батална.” гэж заасан нь Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “29.4.Энэ хуулийн 29.3-т заасан аргаль хонь, янгир ямаа, тул загасыг агнах, барих тусгай зөвшөөрлийг дуудлага худалдаагаар олгох журмыг Засгийн газар батална.” гэж заасантай давхардахаар байна. Иймд Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 17.2 дахь хэсгийг хасах.

- Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.10 дахь заалтад “Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого боловсруулах” гэж тусгасан ба тус хуулийн төслийн 20.2.2 дахь заалтад орон нутгийн аялал жуулчлалын бүсийг тогтоох гэж тусгасан байна. Дотоодын аялал жуулчлал, орон нутгийн аялал жуулчлал нь утгын хувьд адил тул нэршлийн хувьд нэг болгох тусгах, цаашлаад тус хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.10 дахь заалтад “энэ хуулийн 20.2.2 дахь заалтад заасан аялал жуулчлалын бүсийг тогтоох” гэж эшлэн тусгах.

**4.2.6.Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх:**

Төслийн Дөрөвдүгээр бүлэг болон 6 дугаар зүйлд оролцогч этгээдийн бүрэн эрхийг тусгаж өгсөн тул төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан гэж үзэхээр байна.

**4.2.7.Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх:**

Хуулийн төсөлд дараах зохицуулалтыг орхигдуулсан гэж дүгнэхээр байна. Тухайлбал,

-Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 5-ны өдөр баталсан Аялал жуулчлалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэг буюу "Улсын тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахаар бол түүнтэй холбогдсон харилцааг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна." гэсэн заалтыг энэхүү хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгаагүй нь тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахаар бол газар ашиглахтай холбоотой харилцааг зохицуулсан эшлэл бүхий хуулийг орхигдуулсан гэж үзэхээр байна.

-Хуулийн төслийн үзэл баримтлалд аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэл тогтоох чиг үүргийг шилжүүлэх зохицуулалтыг нарийвчлан тусгахаар тодорхойлсон байна. Гэвч хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэлийг мэргэжлийн холбооны саналыг үндэслэн орон нутгийн аялал жуулчлалын нэгж олгохоор тусгасан боловч аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэл олгох эрхийг хуулийн төсөлд ашгийн төлөө бус хуулийн этгээдэд олгож болох зохицуулалтыг орхигдуулсан байна.

-Хуулийн төслийн үзэл баримтлалд "аялал татвар" бий болгох, уг татварын орлого нь Аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн эх үүсвэр болохоор заасан боловч Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд болон Татварын ерөнхий хуульд холбогдох зохицуулалтыг тусгаагүй байна.

-Хуулийн төсөл болон дагалдан боловсруулсан Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд аргаль, янгир, идлэг шонхор шувууг дуудлага худалдааны үндсэн дээр агнаж, барихаар тусгасан боловч Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлд дуудлага худалдааны үндсэн дээр зөвшөөрлийг олгох зохицуулалтыг тусгах нь зүйтэй байна. Түүнчлэн Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дуудлага худалдаа явуулах журмыг тусгаагүй орхигдуулсан байна.

Иймд дээрх зохицуулалтыг Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагах бусад хуулийн төсөлд

**4.2.8.Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх:**

Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгаагүй байна.

**4.2.9.Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх:**

Хуулийн төсөлд төрийн байгууллагын чиг үүргийг ашгийн төлөө бус хуулийн этгээд болох мэргэжлийн холбоо, ашгийн төлөө хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх зохицуулалтыг тусгахаас гадна аялал жуулчлалын мэргэжлийн холбооны нарийвчилсан зохицуулалтыг хуулийн төслийн 29 дүгээр зүйлд тусгасан болон.

Тухайлбал, хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.5, 5.6 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт тур оператор, аяллын агент, жуулчны хөтчийг бүртгэх эрхийг ашгийн төлөө бус хуулийн этгээдэд, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн удирдлагын бүрэлдэхүүний дийлэнх хувийг ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөлөлд шилжүүлэх, 31 дүгээр зүйлийн 31.6 дахь

хэсгээр аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих хяналтыг ашгийн төлөө бус хуулийн этгээдэд тус тус шилжүүлэхээр байна.

Түүнчлэн хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт отоглох цэгийн менежментийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болохоор тусгасан байна.

Харин төслийн 29 дүгээр зүйлд тусгасан аялал жуулчлалын мэргэжлийн холбооны чиг үүрэг болон дээрх бусад чиг үүргийг шилжүүлсэн зохицуулалтаас харахад төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх зохицуулалт хангалттай тусгажээ гэж үзэхээр байна.

**4.2.10.Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх:**

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон төслийг дагалдах бусад хуулийн төсөлд татвартай холбоотой дараах зохицуулалтыг тусгасан байна. Үүнд:

- Хуулийн төслийн үзэл баримтлалд аяллын албан татварыг бий болгохоор, уг татвар Аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн эх үүсвэр болохоор тусгасан,
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд жуулчны худалдан авсан бараа бүтээгдэхүүний нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгохтой холбоотой зохицуулалтыг тусгасан,
- Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах гарааны компанийн эхний 3 жилийн орлогын албан татварыг чөлөөлөхөөр тусгасан,
- Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагыг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг шинээр байгуулах, стандартад нийцүүлэн завсарлахтай холбогдон гаргах зардлыг орлогын албан татвар ногдох орлогоос хасаж тооцох зохицуулалтыг тусгасан,
- Отоглох цэгийн хураамжийн хэмжээг сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тогтоох зохицуулалтыг Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан,
- Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд олон улсын агаарын тээврийн тийзийн төлбөрийн хэмжээг тогтоохоор тусгасан байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан зохицуулалт нь татварын хууль тогтоомжтой нийцэж байна.

Мөн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт заасан "...татвар бий болгох, өөрчлөх, чөлөөлөх, хөнгөлөх, ногдуулах, төлөхтэй холбогдсон харилцааг зөвхөн татварын хуулиар зохицуулна:" гэж заасантай нийцэж байна.

Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт "Шаардлагатай тохиолдолд дотоодын аялал жуулчлалын тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хилээр нэвтрүүлж байгаа бага оврын онгоц, нисдэг тэргийг гаалийн татвараас чөлөөлж

болно.” гэж тусгасан нь Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт заасан “...татвар бий болгох, өөрчлөх, чөлөөлөх, хөнгөлөх, ногдуулах, төлөхтэй холбогдсон харилцааг зөвхөн татварын хуулиар зохицуулна:” гэж заасантай нийцэхгүй байх тул “тус харилцааг зөвхөн татварын хуулиар зохицуулна” гэсэн агуулгатай зохицуулалтыг тодотгон тусгах.

Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.3 дахь хэсэгт “жуулчин болон аялагч отоглох цэгт байрлах хураамжийн хэмжээг тогтоох” гэж тусгасан нь шинэ төрлийн татвар байх бөгөөд энэ нь Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт заасан “...татвар бий болгох, өөрчлөх, чөлөөлөх, хөнгөлөх, ногдуулах, төлөхтэй холбогдсон харилцааг зөвхөн татварын хуулиар зохицуулна:” гэж заасантай нийцэхгүй байх тул Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт хураамжийн төрөлд болон хэн уг татварын хэмжээг тогтоох талаар Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлд нэмэх нь зүйтэй болно.

Харин хуулийн төслийн үзэл баримтлалд айллын татварыг бий болгох талаар тусгасан байх боловч хуулийн төслийг боловсруулаагүй, холбогдох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгаагүй байх тул үнэлгээг хийх боломжгүй байна.

**4.2.11.Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх:**

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт тур оператор нь аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх зохицуулалтыг тусгасан байх бөгөөд хуулийн төслийг дагалдан боловсруулсан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 8.1 дүгээр зүйлийн 1.30 дахь заалтад тур операторын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгохоор заасан тусгасан.

**4.2.12.Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх:**

Төсөлд Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдаагүй байна.

**4.2.13.Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх:**

Хуулийн төсөл нь жендерийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.

**4.2.14.Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх:**

Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдаагүй байна.

**4.2.15.Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх:**

Хуулийн төсөлд энэ талаарх заалт тусгагдаагүй байна.

**4.2.16.Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх:**

Зөрчлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: "Зөрчил, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээг энэ хуулиар тогтооно." гэж, 3.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: "Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд зөрчлийн шинжийг харгалзан энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийтгэл оногдуулна." гэж тус тус заасан бөгөөд шийтгэл оногдуулах, шийтгэлээс чөлөөлөх бүхий л асуудлыг гагцхүү Зөрчлийн тухай хуулиар зохицуулах тул уг хуульд шийтгэл хүлээлгэх талаар ямар нэгэн зохицуулалтыг тусгах шаардлагагүй.

Хуулийн төслийн үзэл баримтлалд Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахаар тусгасан байх бөгөөд Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Уг хуулийн төсөлд дараах агуулгаар хариуцлага ногдуулахаар тусгасан байна. Үүнд:

- Тусгай зөвшөөрөлгүйгээр тур операторын үйл ажиллагааг эрхэлсэн бол хууль бусаар олсон орлогыг хурааж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

- Бүртгэлгүйгээр аяллын агентын үйл ажиллагааг эрхэлсэн бол хууль бусаар олсон орлогыг хурааж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

- Хөтөч жуулчнаас шан харамж шаардсан, эсхүл аялал жуулчлалын байгууллагын үйл ажиллагаа эрхэлсэн бол хүнийг сануулах, эсхүл тавин нэгжээс зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

- Жуулчны үйлчилгээний байгууллага нь аялал жуулчлалын байгууллагын үйл ажиллагаа явуулсан бол хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

- Жуулчны үйлчилгээний байгууллага нь үйлчилгээний стандарт, зэрэглэлд тавигдах шаардлагыг зөрчиж үйл ажиллагаа явуулсан бол хуулийн этгээдийг сануулах, эсхүл таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно."

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нийт 2 шууд хориглосон зохицуулалт байна. Тухайлбал, төслийн 5 дугаар зүйлийн 5.10-т "Аялал жуулчлалын байгууллага аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан борлуулахдаа гадаадын болон дотоодын жуулчдад ялгамжтай байдлаар үнэ тогтоож үйлчлэхийг хориглоно." гэж, 5.11-д Аялал жуулчлалын байгууллага нь байгаль орчинд сөрөг нөлөөтэй, түүх, соёлын үл хөдлөх дурсгал, хөдлөх дурсгалт зүйлийн бүрэн бүтэн байдал, хэлбэр, шинж чанарыг алдагдуулж, гэмтээх байдлаар аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахыг хориглоно." гэж тус тус тусгасан.

Гэвч хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.10-т "Аялал жуулчлалын байгууллага аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан борлуулахдаа гадаадын болон

дотоодын жуулчдад ялгамжтай байдлаар үнэ тогтоож үйлчлэхийг хориглоно." гэж тусгасан боловч Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санкц буюу хариуцлагыг тусгаж өгөөгүй байна.

Мөн хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.4-т "Тусгай сонирхлын аялал болон уулын спорт аялал, усан аялал, спорт агнуур, олзворын ан, нисдэг тэрэгний аялал, усны гүнд шумбах, авто спортын аялал зэрэг эрсдэл бүхий аяллыг жуулчны хөтчөөс гадна тухайн чиглэлийн мэргэшсэн сургагч багш, зааварлагчтайгаар зохион байгуулна.", 14 дүгээр зүйлийн 14.3-т "Тусгай сонирхлын аялал болон уулын спорт аялал, усан аялал, спорт агнуур, олзворын ан, нисдэг тэрэгний аялал, усны гүнд шумбах, авто спортын аялал зэрэг эрсдэл бүхий аялал жуулчлалын үйл ажиллагаанд хамрагдах аялагч болон жуулчин нь даатгалд хамрагдана." гэж тус тус заасан боловч Зөрчлийг тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дээрх дээрх зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, хөшүүргийн зохицуулалтыг тусгаагүй байна.

## ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ

Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх үе шатыг аргачлалын 5-д заасны дагуу дараах дараалаар хийлээ:

5.1.үр дүнг баримтжуулах;
5.2.үнэлэх;
5.3.зөвлөмж өгөх.

**5.1.Үр дүнг баримтжуулах:** Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг холбогдох шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн бөгөөд холбогдох хууль тогтоомж, бусад эрх зүйн акт болон хамаарал бүхий холбогдох мэдээлэл, тоо баримт зэрэг бусад материалыг ашиглаж, ашигласан материалын жагсаалтыг үнэлгээний тайланд хавсаргаснаас гадна үнэлгээ хийсэн хуулийн төслийг хавсаргасан болно.

Хуулийн төсөл нь үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах дүгнэлтийг хийж, зөвлөмж боловсрууллаа.

**5.2.Дүгнэлт:** Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх 2 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн ба шалгуур үзүүлэлт тус бүрээр дүгнэвэл:

**Зорилгод хүрэх байдал:** Хуулийн төслийг зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд туссан аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, олон улсын жишигт нийцүүлэхэд чиглэгдсэн зохицуулалт хуулийн төсөлд тусгагдсан байна. Тухайлбал, Монгол Улсыг гадаадад нэгдсэн бодлогоор сурталчлах, судалгаа хийх, сургалт зохион байгуулах, аялал жуулчлалын мэдээллийн сан болон аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүнийг бий болгох, Монгол улсын түүх, соёл, уламжлалыг шингээсэн бүтээн байгуулалтуудыг санхүүжүүлэн Монгол Улсын аялал жуулчлалын хөгжлийг бодитойгоор эрчимжүүлэхэд зарцуулагдах төсвийг бүрдүүлэх зорилгоор аялал жуулчлалын санг бий болгож түүний эх үүсвэрийг улсын нийт төсөвт нэмэлт дарамт үзүүлэхгүйгээр бий болгох асуудлыг шийдвэрлэхээр зорьсон зохицуулалт хуулийн төсөлд тусжээ.

**Харилцан уялдааг хангасан байдал**: Хуулийн төслийг харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд бүхэлд нь аргачлалд заасан асуултад хариулах замаар шалгахад хуулийн төслийн зарим зүйл, хэсэг, заалт өөр хоорондоо уялдаагүй, давхардсан, хуулийн төслийн зарим зүйл, хэсэг, заалтууд нь Газрын тухай, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Захиргааны ерөнхий хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай, Татварын ерөнхий хууль зэрэг хуультай уялдаагүй, давхардал, зөрчил үүсгэхээр байна.

/Энэ талаар энэхүү үнэлгээний 4.2 дахь хэсэгт тодорхой тусгасан болно./

**5.3.Зөвлөмж:**

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь үндэсний онцлог бүхий байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан тогтвортой аялал жуулчлалын үйлдвэрлэлээр дамжуулан эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, дэмжих болон аялал жуулчлалын үйл ажиллагаанд төр, иргэн, хуулийн этгээд хооронд үүсэх харилцааг зохицуулахаар зорилтыг тавьж, холбогдох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгажээ. Энэхүү хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажлын явцад гарсан дараах асуудлуудыг анхаарч, хуулийн төслийг боловсронгуй болгох, чанарыг сайжруулах чиглэлээр өөрчлөлт оруулах нь зүйтэй гэсэн зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна:

✓ Хуулийн төсөлд аялал жуулчлалын байгууллагын ангиллыг 5 дугаар зүйлд тусгасан боловч энэ нь аялал жуулчлалын байгууллагын төрлийг тодорхойлсон, тэдгээрийг ялгамжтай байдал зэргийг тодорхой тусгах, түүнчлэн аялал жуулчлалын үйл ажиллагаа, аялал жуулчлалын үйлчилгээ, аялал жуулчлалын арга хэмжээ, жуулчин, аялагч гэх зэрэг олон төрлийн ойлголтыг тусгах тохиолдолд тэдгээрийн ялгамж, заагийг тодорхой тусгах,

✓ Жуулчин, аялагч гэх ойлголтыг шинээр тусгасан нь сайшаалтай боловч Аялал жуулчлалын тухай конвенцын 3 дугаар зүйлд жуулчин(tourist), аялагч(excursionist) гэсэн 2 ялгамжтай ойлголтын ялгааг нарийвчлан гаргаж тусгаагүй;

✓ Аялал жуулчлалын тур оператор, аяллын агентын аль аль нь аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг жуулчинд үзүүлэхээр байгаа боловч тур операторт хуулийн төсөлд аяллын агентаас илүү шаардлагыг тавьсан байна. Тухайлбал, аяллын агент нь зөвхөн бүртгүүлснээр үйл ажиллагаа явуулж болохоор заасан бол, тур оператор нь Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.30-д заасан тусгай зөвшөөрлийг авсны үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэхээр байх тул үйл ажиллагааны онцлог, гол ялгааг гаргаж, хууль зүйн үр дагавар үүсгэсэн зохицуулалтыг бүрэн тусгах;

✓ Хуулийн төслийн үзэл баримтлалд тур операторын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 50, түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээд байхаар тусгай шалгуурыг тавихаар заасан боловч хуулийн төслийн 5.4-т тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 51, түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээд байхаар дэвшүүлсэн зорилтоос өөрөөр тусгасан байгааг нийцүүлэх;

✓ Хуулийн төслийн үзэл баримтлалд аялал жуулчлалын бүсчлэл, түүний менежментийг хэрэгжүүлэх зохицуулалтыг заасан бол хуулийн төсөлд бүсчлэхтэй

холбоотой зохицуулалтыг тусгасан боловч зохицуулалт хууль зүйн үр дагавар үүсгэхгүй байх бөгөөд бүсчлэлийг бий болгосноор аялал жуулчлалын байгууллага, гадаад улсын болон Монгол Улсын хөрөнгө оруулагч нарт ямар давуу талыг бий болгох, хөрөнгө оруулалтыг татах хөшүүрэг болох зохицуулалтын талаар тодорхойгүй байгааг анхаарах;

✓ Хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан аялал жуулчлалын салбар дахь орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, үүрэг хариуцлага, эрх хэмжээг тодорхой болгосон боловч үзэл баримтлалд тусгайлан заасан аялал жуулчлалын маршрутын тэмдэг тэмдэглэгээг байршуулах чиг үүргийг хэнд олгосон нь тодорхойгүй хэвээр байх уг чиг үүргийг Монгол Улсын Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан чиг үүргийн дагуу сум, дүүргийн Засаг даргын эрх хэмжээнд нарийвчлан тусгах;

✓ Хуулийн төслийн үзэл баримтлалд санхүүжилтийн эх үүсвэрт “жуулчны татвар”-ыг бий болгож, дээрх сангийн эх үүсвэр байхаар дурдсан боловч Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон татварын багц хуульд энэ талаарх зохицуулалтыг тусгаагүй байгааг анхаарах;

✓ Хуулийн төслийн үзэл баримтлалд аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэл тогтоох чиг үүргийг шилжүүлэх зохицуулалтыг нарийвчлан тусгахаар тодорхойлсон байна. Гэвч хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэлийг мэргэжлийн холбооны саналыг үндэслэн орон нутгийн аялал жуулчлалын нэгж олгохоор тусгасан боловч аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэл олгох эрхийг хуулийн төсөлд ашгийн төлөө бус хуулийн этгээдэд олгож болох зохицуулалтыг орхигдуулсан байгааг анхаарах;

✓ Хуулийн төслийг үзэл баримтлалын зорилтод бүрэн нийцүүлэх хүрээнд хуулийн төслийн 21 дүгээр зүйлд аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэлийг тогтоох чиг үүргийг мэргэжлийн холбоонд шилжүүлж болох зохицуулалтыг нэмж тусгах;

✓ Хууль, дүрэм, журам нь тодорхой нэг төрлийн харилцааг зохицуулах зорилготой байдаг тул Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зорилтыг “үндэсний онцлог бүхий байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан тогтвортой аялал жуулчлалын үйлдвэрлэлээр дамжуулан эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, дэмжихтэй холбогдсон болон аялал жуулчлалын үйл ажиллагаанд төр, иргэн, хуулийн этгээдийн хороонд үүсэх харилцааг зохицуулах” гэсэн агуулгаар тодруулж тусгах;

✓ Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн тайлбар хэсэгт “ Энэ зүйлд заасан “хил орчмын нутаг дэвсгэр” гэж хил залгаа улстай хиллэж байгаа аймгийн нутаг дэвсгэрийг хэлнэ”” гэж тусгасан бол Монгол улсын хилийн тухай хуулийн 3.1.14 – д дээрх нэр томьёог “хил залгаа улстай хиллэж байгаа сумын нутаг дэвсгэрийг хэлнэ” гэж тодорхойлсон байна. Иймд тус хуулийн төсөлд Монгол Улсын хилийн тухай хуулийн 3.1.14-д заасан нэр томьёог эшлэн тусгах;

✓ Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1-д аялал жуулчлалын байгууллага гэдгийг тодорхойлохдоо “бүртгүүлсэн хуулийн этгээд байхаар” тусгасан нь мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д аяллын агентыг хуулийн этгээд байхаас гадна иргэн байхаар тодорхойлсонтой, мөн хуулийн 11 дүгээр зүйлд тур оператор нь Зөвшөөрлийн

тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.30 дахь заалтад заасан тусгай зөвшөөрөлтэй эрхлэхээр заасантай нийцүүлэх;

✓ Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.11 дэх хэсэгт аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 20.2.1-д заасан улсын аялал жуулчлалын бүсийг тогтоох саналыг Үндэсний хороонд хүргүүлэх", гэж заасан нь хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.2.5 дахь заалтын Засгийн газар нь аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн энэ хуулийн 20.2.1-д заасан бүсийг тогтоохоор заасантай нийцэхгүй байгааг анхаарах;

✓ Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт "энэ хуулийн 17.1-д заасан дуудлага худалдаа зохион байгуулах журмыг Засгийн газар батална." гэж заасан нь Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд "29.4.Энэ хуулийн 29.3-т заасан аргаль хонь, янгир ямаа, тул загасыг агнах, барих тусгай зөвшөөрлийг дуудлага худалдаагаар олгох журмыг Засгийн газар батална." гэж заасантай давхардах тул Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 17.2 дахь хэсгийг хасах;

✓ Хуулийн төсөлд мэргэжлийн холбооны чиг үүргийг бусад төрийн байгууллага, албан тушаалтны хуульд заасан чиг үүрэгтэй уялдуулан залруулах;

✓ Хуулийн төслийн Тавдугаар бүлэг болон 31 дүгээр зүйлийн гарчгийг "Аялал жуулчлалын тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт" гэж өөрчлөх;

✓ Иргэний хууль, Орон сууцны тухай хуульд орон сууц, Эрүүгийн хуульд орон байр гэж тус тус нэр томьёоны холбогдох тодорхойлолтын тайлбарласан тул төслийн 3.1.8-д "байр сууц" гэсэн нэр томьёог энэхүү төсөлд тусгахдаа зохимжтой нэршлээр тусгах;

✓ Хуулийн төсөлд тусгасан "аялал жуулчлалын үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам батлах..."-тай холбоотой зохицуулалтын захиргааны хэм хэмжээний актын шинж агуулсан шийдвэрүүдийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн дүрэм, журмын агуулгыг болон батлах субъектийн хамт тодорхой томьёолох. Ингэхдээ аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд мөн зарим дүрэм, журмыг батлах эрхийг олгох;

✓ Хуулийн төсөлд "2 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ" гэсэн шинэ зүйл нэмж, 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт "Улсын тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахаар бол газар ашиглахтай холбогдсон харилцааг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна." гэсэн хэсэг нэмэх;

✓ Хуулийн төсөл болон дагалдан боловсруулсан Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд аргаль, янгир, идлэг шонхор шувууг дуудлага худалдааны үндсэн дээр агнаж, барихаар тусгасан боловч Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлд дуудлага худалдааны үндсэн дээр зөвшөөрлийг олгох зохицуулалт болон Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дуудлага худалдаа явуулах журмыг тус тус тусгах;

✓ Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт "Шаардлагатай тохиолдолд дотоодын аялал жуулчлалын тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хилээр нэвтрүүлж байгаа бага оврын онгоц, нисдэг тэргийг гаалийн татвараас чөлөөлж болно." гэж тусгасан нь Татварын ерөнхий хуулийн 3 дугаар

зүйлийн 3.2 дахь хэсэгт заасан "...татвар бий болгох, өөрчлөх, чөлөөлөх, хөнгөлөх, ногдуулах, төлөхтэй холбогдсон харилцааг зөвхөн татварын хуулиар зохицуулна:" гэж заасантай нийцэхгүй байх тул "тус харилцааг зөвхөн татварын хуулиар зохицуулна" гэсэн агуулгатай зохицуулалтыг тодотгон тусгах;

✓ Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.3 дахь хэсэгт "жуулчин болон аялагч отоглох цэгт байрлах хураамжийн хэмжээг тогтоох" гэж тусгасан нь шинэ төрлийн татвар байх бөгөөд энэ нь Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт заасан "...татвар бий болгох, өөрчлөх, чөлөөлөх, хөнгөлөх, ногдуулах, төлөхтэй холбогдсон харилцааг зөвхөн татварын хуулиар зохицуулна:" гэж заасантай нийцэхгүй байх тул Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт хураамжийн төрөлд болон хэн уг татварын хэмжээг тогтоох талаар Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлд нэмэх;

✓ Хуулийн төслийг дагалдан боловсруулсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 5.10, 9.4-т тусгасан зохицуулалттай холбоотой санкцыг тусгах;

✓ Хуулийн төслийн зарим зохицуулалт нь утга, найруулгын шаардлага хангахгүй байгааг анхаарч хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд бүрэн нийцүүлэн эцэслэн боловсруулах.

---oOo---

# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ДЭМЖИХ САНГИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛ

2022 оны 10 сарын 03 өдөр Улаанбаатар хот

Аялал жуулчлал нь эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжилд чухал ач холбогдол бүхий салбар бөгөөд Монгол улс аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдийн нэг болгон хөгжүүлэхээр Улсын Их Хурал, Засгийн газраас бодлогын хүчтэй дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050-ын үзэл баримтлалд "Ирэх 30 жилд манай эдийн засгийн бүтцэд эрс өөрчлөлт гарч боловсруулах аж үйлдвэр болон эрчим хүч, аялал жуулчлалын салбарууд хөгжиж, эдийн засаг бодитойгоор олон тулгуурт болох нөхцөл бүрдэж байна. Мөн үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх"[1] зорилтыг 2020-2030 онд дэвшүүлсэн байна. Уг урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төрийн бүтээмжийг сайжруулах зорилгоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"[2]-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэгт аялал жуулчлалын салбарыг дэмжинэ гэж тусгасан ба Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт[3] байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхээр төлөвлөсөн ба 3 дугаар зүйлийн 3.4.4-т аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, жуулчдын тоог нэг сая хүргэнэ гэж зорьсон нь аялал жуулчлалыг дэмжих санхүүжилтийг хэрэгцээ шаардлагын суурь нөхцөл гэж үзэж байна.

Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлснээр ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засгийг хөгжүүлэх гадаадын хөрөнгө оруулалтыг татах, үндэсний өв уламжлал, түүх, ёс заншил, дурсгалын үнэт зүйлийг сурталчлан таниулах ач холбогдолтой байна. Тиймээс аялал жуулчлалын салбарын бизнесүүдийг дэмжих, уг салбарт ногоон технологийг нэвтрүүлэх, стандартыг олон улсын жишигт нийцүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах, гадаадад нэгдсэн бодлогоор сурталчлах, судалгаа сургалт зохион байгуулах, аялал жуулчлалын мэдээллийн сан болон аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгох, тус салбарын тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, Монгол Улсын аялал жуулчлалын хөгжлийг бодитойгоор эрчимжүүлэх, тавигдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд санхүүжилтийн тогтолцоог бий болгоход **Аялал жуулчлалыг дэмжих сан** зайлшгүй ач холбогдол бүхий институц болно.

Аялал жуулчлалын салбарын орлого цар тахлын өмнөх үед 2018 оны байдлаар сүүлийн 5 жилд дунджаар 20%-иар тогтмол өссөн дүнтэй[4] байсан бөгөөд 2019 оны байдлаар энэхүү салбар нь нийт 88.7 мянган хүнийг ажлын байраар хангаж, 605.5 сая ам.долларын орлого оруулсан ба энэ нь ДНБ-ний 6.5%-ийг

---

[1] Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2019 он
[2] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390082532431
[3] https://legalinfo.mn/mn/detail?lawId=211219&showType=1
[4] БОАЖЯ-ны танилцуулга

бүрдүүлж байсан.[5] Гэвч цар тахлын хязгаарлалтын арга хэмжээнүүд аялал жуулчлалын салбарт хүндээр тусч аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаа доголдож, орлого ажлын байранд өөрчлөлт орсон. Урьдчилсан байдлаар зөвхөн жуулчин хүлээж авдаг тур оператруудын орлого 80 хувь, зочид буудлын орлого 63 хувиар, жуулчны баазуудын орлого 84 хувиар, ресторануудын орлого 50 хувиар, тэдгээрт ажиллаж буй ажиллах хүчний нөөцийн алдагдал 25-75 хувиар тус тус хумигдсан тооцоо байна.[6]

Аж ахуйн нэгжүүд бизнесээ эргэн сэргээхэд дэмжлэг үзүүлэх, цаашид тогтмол дэмжин ажиллаж, салбарт дорвитой өөрчлөлтийг хийхэд мөн л аялал жуулчлалыг дэмжих сангийн үзүүлэх нөлөө өндөр байх болно.

Аялал жуулчлалыг дэмжих санг байгуулан тус салбарыг онцгойлон дэмжин ажиллаж буй олон улсын сайн жишиг олон бий. Үүнээс БНСУ, Саудын Араб болон Туркын жишээ ихээхэн амжилттай байна. Турк улсын хувьд сангийн тухай зохицуулалтыг Аялал жуулчлалыг дэмжих хуульд бүлэг болгон зохицуулсан байх бол БНСУ болон Саудын Арабд сангийн үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан хуулийг баталсан байдаг. Монгол Улсын хувьд Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд уг хуулийн төсөлд сангийн үндэслэл, суурь зохицуулалтыг хамтатган батлах нь зүйтэй байна. Түүний талаарх нарийвчилсан харилцааг бусад хууль тогтоомжийн жишгийн дагуу Засгийн газрын баталсан хэм хэмжээний акт (журам) зохицуулах нь тохиромжтой юм.

БНСУ-ын хувьд аялал жуулчлалыг дэмжих, хөгжүүлэх санг байгуулах ач холбогдлыг уг салбарыг үр ашигтай хөгжүүлэх, аялал жуулчлалаар дамжуулан валютын орлогыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах гэж тодорхойлсон бол Саудын Арабын хувьд дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчид ач холбогдол бүхий бүсүүдэд аялал жуулчлалын чиглэлээр хөрөнгө оруулалт хийхийг дэмжих улмаар аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх зорилготой. Шинэ Зеландын аялал жуулчлалыг дэмжих сангийн хувьд аялал жуулчлалыг хөгжүүлэхээс гадна түүнтэй адил хэмжээнд байгаль орчны тогтвортой байдлыг хамгаалах нь сангийн зорилго байна. Харин Монгол улсын аялал жуулчлалыг дэмжих сангийн зорилгыг уг салбарыг хөгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж салбарын өрсөлдөхүйц чадавхийг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтөнд хувь нэмэр оруулах гэж төлөвлөж байна.

Мөн аялал жуулчлалыг дэмжихээр улс орон бүрд түүнчлэн улсын доторх засаг захиргааны нэгж бүрт тухайн орон нутагтаа аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилготой төрөөс хараат бус хувийн хуулийн этгээд байдлаар үйл ажиллагаа явуулдаг сан байх хэдий ч Монгол улсын хувьд аялал жуулчлалыг эдийн засгийн голлох салбар болгохоор төлөвлөж буй тул төрөөс дэмжлэгтэйгээр, бие даан үйл ажиллагаа явуулах нийтийн эрх зүйн хуулийн этгээд хэлбэрээр уг санг байгуулах нь оновчтой байна.

Нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь нийтийн зорилгыг хэрэгжүүлэхээр нийтийн эрх зүйн хууль тогтоомжинд үндэслэн байгуулагддаг ба төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байдаг. Аялал жуулчлалыг дэмжих сан нь аялал жуулчлалын тухай хуульд үндэслэн байгуулагдаж, санхүүжилтийн эх үүсвэрийн

---

[5] Үндэсний статистикийн хороо
[6] https://vip76.mn/content/81071

тодорхой хувийг төсвөөс дэмжлэг болгон авч Монгол улсын эдийн засгийн хөгжил, аялал жуулчлалын салбарын өрсөлдөх байдлыг нэмэгдүүлэхийн төлөө зорих тул иргэний хуулийн дагуу байгуулагдах сан эсхүл Засгийн газрын тусгай сангаас илүү дурьдагдсан байгууллагын хэлбэр зохимжтой.

Дээрхийг тодруулбал Иргэний хууль, Төрийн бус байгууллагын тухай хуульд заасан төрийн бус байгууллага биш харин хуулиар төрийн зарим эрхийг шилжүүлэн авсан нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг хэд хэдэн байгууллагуудтай адил статустай байхаар зорьж байна. Жишээлбэл, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэгт “Хуульчдын холбоо хуульчийн мэргэжлийн нэр хүнд, үйл ажиллагаа, хариуцлагын нэгдсэн стандарт тогтоох, хуульчдын эрх ашгийг хамгаалах, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх болон энэ хуулийн 45 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.” Мөн хуулийн 44.2 дахь хэсэгт “Хуульч бүр Хуульчдын холбооны гишүүн байна.” гэж тус тус заасан. Өмгөөлөгчдийн тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1 дэх хэсэгт “Өмгөөллийн Холбоо нь өмгөөлөгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, эрх ашгийг хамгаалах, хариуцлагын нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлэх, иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий өмгөөлөгчдийн заавал гишүүнчлэлтэй, мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллага мөн.”, мөн зүйлийн 38.2 дахь хэсэгт “Өмгөөлөгчдийн холбоо нь нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна.” Тус тус заасан байна. Иймд нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн статус нь хуулиар баталгааждаг тул төрийн бус байгууллагаас бүрэн ялгаатай бөгөөд Монголын Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо нь нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн эрх эдлэх байдлаар хуульд тусгагдсан байна. Үүнээс гадна Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрий танхим, Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах холбоо, Нотариатын танхим зэрэг байгууллагыг мөн жишээ татаж болно. Төр удирдлагын гэхээсээ илүү зохицуулалтын чиг үүргийг гүйцэтгэх болж, түүний зарим чиг үүргийг нийтийн ашиг сонирхлын үүднээс үйл ажиллагаа явуулдаг байгууллага руу шилжүүлэх хандлагатай байх тул үүнд ч аялал жуулчлалын салбарыг идэвхжүүлэн хөгжүүлэх төрийн зорилго чиг үүргийг “Аялал жуулчлалыг дэмжих сан”-р дамжуулан хэрэгжүүлэх нь уг хандлагад нийцнэ.

Өмнө нь дурьдсанчлан БНСУ, Турк, Саудын Арабын төрийн оролцоотой аялал жуулчлалыг дэмжих сангийн зохицуулалтыг тодорхой авч үзье.

**БНСУ-н Аялал жуулчлалын сангийн товч танилцуулга:**

1962 оны 06-р сарын 26-ны өдөр Солонгосын Аялал Жуулчлалын байгууллагыг байгуулсан бөгөөд энэхүү байгууллага аялал жуулчлалын томоохон төслүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэх, аялал жуулчлалыг дэмжих, хөгжүүлэх үндсэн зорилготой Засгийн газрын институц юм. Тус байгууллага нь 5 газар, 16 хэлтэс, 54 алба, 33 гадаад дахь салбар, 10 бүс нутгийн салбартайгаар[7] үйл ажиллагаагаа явуулдаг. Солонгосын аялал жуулчлалын байгууллагын бүрэлдэхүүнд Аялал жуулчлалыг дэмжих, хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа багтдаг. БНСУ нь аялал жуулчлалыг хөгжүүлэх, дэмжихэд онцгой анхаарал хандуулдаг бөгөөд сангийн үйл ажиллагааг тусгайлсан хууль тогтоомжоор зохицуулдаг. Тодруулбал, 1972 онд Аялал жуулчлалыг дэмжих, хөгжүүлэх сангийн тухай /Tourism promotion and

---

[7] Хавсралт - 1

development fund act/[8] хуулийг баталсан. Уг хуулийг анх батласнаас хойшхи 50 жилийн хугацаанд 16 удаа нэмэлт өөрчлөлт орсон байх ба сүүлд 2021 оны 4 сарын 13 өдөр нэмэлт өөрчлөлт орсон байна.

Уг аялал жуулчлалыг дэмжих, хөгжүүлэх сангийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт сангийн санхүүжилтийн эх үүсвэрийг дурьдсан байх ба үүнд:

2.2.1 Засгийн газрын санхүүжилт
2.2.2 Аялал жуулчлалыг хөгжүүлэх тухай хуулийн 30 дугаар зүйлд дурьдагдсан Казиногийн оператор бүр нийт борлуулалтын 10/100 хэмжээнд хамаарах хувь хэмжээгээр төлөх төлбөр
2.2.3 Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу тогтоосон Солонгосын нисэх онгоцны буудал, боомтоор дамжин гарч буй этгээд бүр 10,000 вон төлбөр
2.2.4 Баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн төлбөрийн 50/100 хэмжээ
2.2.5 Сангийн үйл ажиллагаанаас олж буй орлого болон бусад орлого

Уг сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд сангийн үйл ажиллагааны зарцуулалтыг нарийвчлан зохицуулсан байдаг. Үүнд:

5.1 Сангаас дараах дэд зүйлд хамаарах хэрэгцээнд зарцуулна.

5.1.1 Зочид буудлууд зэрэг төрөл бүрийн аялал жуулчлалын байгууламжийг засварлах, барих

5.1.2 Аялал жуулчлалд зориулагдсан тээврийн хэрэгслийг хамгаалах, засварлах

5.1.3 Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх дэд бүтцийг барих засварлах

5.1.4 Аялал жуулчлалын цогцолбор, жуулчдын ая тухтай байдлыг хангах байгууламжуудыг засварлах, барих

5.2 Спорт, аялал жуулчлал, соёлын сайдаас суурь байгууламжуудын талаарх бодлогын судалгаа явуулж буй байгууллагад сангаас олгох татаас хөрөнгө

5.3 Дараах дэд зохицуулалтанд хамаарах аж ахуй нэгжүүдэд зээл, татаас олгоно.

5.3.1 Аялагчдад олон хэлээр мэдээлэл хүргэх, жуулчдад зориулсан мэдээллийг хүргэх хөтөлбөр

5.3.2 Дотоодын болон гадаадын жуулчдад зориулсан мэдээллийн системийг сайжруулах, аялал жуулчлалын олон нийттэй харилцах хөтөлбөр

5.3.3 Аялал жуулчлалын салбарын ажилчдыг чадавхжуулах, боловсрол дээшлүүлэх хөтөлбөрүүд

5.3.4 Дотоодын аялал жуулчлалыг дэмжсэн, гадаадын жуулчдыг татахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр

[8] https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=56281&type=sogan&key=8

5.3.5 Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бүтээх, хөгжүүлэх хөтөлбөр

5.3.6 Аялал жуулчлалын бүс, цогцолбор газруудад нийтийн тав тухтай байдлыг хангах байгууламж суурилуулах хөтөлбөр

5.3.7 Олон улсын хурал, уулзалтыг зохион байгуулах

5.3.8 Хөгжлийн бэрхшээлтэй зэрэг эмзэг бүлгийн ангид зориулсан аялал жуулчлалын хөтөлбөр

5.3.9 Уламжлалт аялал жуулчлалыг дэмжих, хөгжүүлэх хөтөлбөрүүд

5.3.10 Бусад аялал жуулчлалын салбарын хөгжилд зайлшгүй бусад Ерөнхийлөгчийн зарлигаар тодорхойлсон зүйлс

5.4 Хувийн аялал жуулчлалын газруудад зайлшгүй шаардлагатай бол дараах дэд зүйлсэд тусгагдсан бизнес, холбоодод хөрөнгө оруулж болно.

5.4.1 Аялал жуулчлалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 6 болон 7 дугаар хэсэгт заасан аялал жуулчлалын төв, цогцолбор байгуулах төсөл

5.4.2 Олон улсын уулзалт, хуралдааны салбарыг дэмжих хуулийн 2 дуугар зүйлийн 3 дахь хэсэгт заасан олон улсын хурал зохион байгуулах байгууламжийг өргөтгах, барих төслүүд

5.4.3 Аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулах зорилго бүхий хөрөнгө оруулалтын холбоод

5.4.4 Бусад аялал жуулчлалын салбарын хөгжилд зайлшгүй бусад Ерөнхийлөгчийн зарлигаар тодорхойлсон зүйлс

Уг 'Аялал жуулчлалыг дэмжих, хөгжүүлэх сангийн тухай' хуулиар сангийн үйл ажиллагааг Спорт, аялал жуулчлал, соёлын сайд удирдах ба сангийн эрх зүйн зохицуулалт нь сайн жишиг болохуйц нарийвчилсан заалтуудыг агуулсан байх бөгөөд манай улсын хувьд сангийн зохицуулалтыг болон ажиллах процедурыг[9] бий болгохдоо зайлшгүй анхааран үзэх нь зүйтэй байна.

**Саудын Араб улсын аялал жуулчлалын сангийн товч танилцуулга:**

Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан нь Саудын Арабын хурдацтай хөгжиж буй салбаруудын нэг болох Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх зорилгоор 2020 оны 6 дугаар сард Саудын Арабын Хааны зарлигаар байгуулагдсан. Дөрвөн тэрбум ам.долларын хөрөнгөтэй Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан нь дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчид ач холбогдол бүхий бүсүүдэд аялал жуулчлалын чиглэлээр хөрөнгө оруулалт хийхийг дэмжих улмаар аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх зорилготой.

Саудын-Араб Улсын Аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа нь Аялал жуулчлалыг дэмжих сангийн тухай[10] хуулиар зохицуулагддаг.

---

[9] Хавсралт 2
[10] Law of Tourism Development Fund https://www.tdf.gov.sa/content/TDF/TDF/en/AboutUs.html#About-Fund

Аялал жуулчлалыг дэмжих сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар Сан нь холбогдох стратеги, бодлогын дагуу Саудын Араб улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх нь түүний эрхэм зорилго байна.

Сан нь санхүү, захиргаа нь хараат бус байх нийтийн эрх зүйн хуулийн этгээд мөн бөгөөд үйл ажиллагаагаа Үндэсний хөгжлийн санд тайлагнана.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаар тус сан нь дараах эх үүсвэрээс санхүүжих боломжтой. Үүнд:

a) Төрөөс олгож буй төсвийн хөрөнгө;
b) Сангийн хөрөнгөөс олгогдож буй зээлийн мөнгөн урсгал;
c) Санд олгосон хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын өгөөж;
d) Сангийн үйл ажиллагааны үйлчилгээний хураамж;
e) Сангийн Удирдах зөвлөлөөс хүлээн зөвшөөрсөн бэлэг, хандив, тусламж, гэрээслэл гэх мэт хандивын орлого;
f) Холбогдох хууль тогтоомжийн дагуу Удирдах зөвлөлөөс баталсан аливаа бусад эх үүсвэр;

Тус хуулийн 4 дүгээр зүйлд Сангийн эрх хэмжээг хуульчилж өгсөн байдаг. Тухайлбал:

a) Шууд эсхүл төр болон аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран тодорхой байршилд аялал жуулчлалын бүс нутгийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор хөрөнгө оруулалт хийх, өөрийн хөрөнгийг захиран зарцуулах;
b) Аялал жуулчлалын салбарын техник технологи, дэд бүтэц болон тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудыг санхүүжүүлэх. Мөн Саудын Арабын Төв банкнаас зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдэд Удирдах зөвлөлөөс тогтоосон журмын дагуу батлан даалт гаргах;
c) Энэ зүйлийн (б)-д заасан чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад баталгаа гаргах, эсхүл бүрэн, хэсэгчлэн болон нэмэлт санхүүжилт олгох гэрээ, хэлцэл байгуулах;
d) Энэ зүйлийн (1)(б)-д заасан чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөгөө өгөх;
e) Аялал жуулчлалын чиглэлээр мэргэшсэн сургалтын төв, судалгааны хөтөлбөр, хүрээлэнгүүдийг санхүүжүүлэх. Мөн аялал жуулчлалын чиглэлээр мэргэшсэн сургалтын хөтөлбөрүүдийг холбогдох хууль тогтоомжийн дагуу, холбогдох агентлагуудтай уялдуулан зохион байгуулах;
f) Зээлийн хугацааг сунгах, бусад хэлбэрээр санхүүжилт олгох;
g) Үндэсний өрийн удирдлагын төв (the National Debt Management Center), Үндэсний хөгжлийн сантай (the National Development Fund) хамтран зээл олгох, бусад өр, санхүүжилтийн хэрэгсэл гаргах;
h) Сангийн үйл ажиллагаатай холбоотой төсөл боловсруулах, хэрэгжүүлэх;
i) Сангийн зорилтод хүрэхийн тулд Удирдах зөвлөлөөс баталсан үйл ажиллагааг явуулах зэрэг болно.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар Тус сан нь Аялал жуулчлалын сайдаар ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй удирдах зөвлөлтэй байна. Удирдах зөвлөлийн гишүүдийг Аялал жуулчлалын сайд санал болгосноор, Үндэсний хөгжлийн сангийн ТУЗ-ийн даргын шийдвэрээр гурван

жилийн хугацаагаар томилно. Сангийн Удирдах зөвлөлийн гишүүнийг нэг удаа улируулан сонгож болно.

**Бүгд Найрамдах Турк Улсын Аялал жуулчлалын сангийн товч танилцуулга:**

Бүгд Найрамдах Турк улсын Засгийн газар болон олон нийт 1960-иад оноос аялал жуулчлал нь эдийн засгийн хөгжил дэвшлийн хөдөлгөгч хүч болохыг хүлээн зөвшөөрч уг салбарт ихээхэн анхаарал хандуулан ажилласан[11] ба Ковидын өмнөх нөхцөл байдлар 2018 онд нийт ажил эрхлэлтийн 7.7 хувь нь аялал жуулчлалын салбарт хамаарч байсан ба 2.2 сая хүнийг шууд ажлын байраар хангаж байсан. Аялал жуулчлалын нийт орлого нь нийт ДНБ-ний 3.8 хувийг эзэлж байсан. Аялал жуучлалын экспорт нь нийт үйлчилгээний экспортын 51.9 хувийг эзэлж байсан.[12] 2022 оны 4, 5, 6 дугаар сард аялал жуулчлалын орлого 8 тэрбум 717 сая 103 мянган долларт хүрсэн байна.[13]

Үүний тулд анх 1962 онд Аялал жуулчлалыг дэмжих сан нь аялал жуулчлал идэвхтэй бүсүүдэд зочид буудал барихад зориулсан зээл, тусламж үзүүлэх зорилготойгоор US.AID-н санхүүжилтээр хэрэгжиж байсан байна. 1982 онд батлагдсан “Аялал жуулчлалыг дэмжих тухай хууль” нь аялал жуулчлалыг салбарыг эрчимтэй өсгөж, хөрөнгө оруулалтыг их хэмжээгээр татаж, аялал жуулчлалыг бүхий л талаар өсөхөд онцгой нөлөөлсөн. Уг хуулийн 21 дүгээр зүйлд үндэслэн “Аялал жуулчлалыг хөгжүүлэх”(The tourism development fund) санг байгуулсан байдаг. Хуулийн дагуу сан нь Соёл, Аялал жуулчлалын яамны харьяа дор байгуулагдсан байдаг хэдий ч хожим Аялал жуулчлалын банк (The Tourism bank, 1955 онд байгуулагдсан) уг санг үйл ажиллагаандаа нэгтгэн авч банкинд харьялагдах болсон.[14]

1982 онд батлагдсан “Аялал жуулчлалыг дэмжих тухай хууль”[15]-ийн 21 дүгээр зүйлээс 25 дугаар зүйл хүртэлх хэсэгт “Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан”-гийн талаар зохицуулсан байдаг.

Тухайлбал, Аялал жуулчлалыг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар Бүс нутгийн болон аялал жуулчлалын төвүүдийн соёл, хөгжил, хадгалалт, хамгаалалтыг бий болгоход нийт хөрөнгө оруулалтын 15 хүртэлх хувийг 20 хүртэлх жилийн эргэн төлөлтийн дээд хугацаатай төлөх зээлийн эх үүсвэрээр дэмжих зорилгоор "Аялал жуулчлалыг дэмжих сан"-г Соёл, Аялал жуулчлалын яамны харьяа дор байгуулна.

Тус хуулийн 22 дугаар зүйлд зааснаар Аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн орлого дараахь орлогуудаас бүрдэнэ. Үүнд:

---

[11] Ahmet NOHUTÇU, “Development of Tourism policies in Turkey throughout the Republican period in socio-political, economic and administrative perspective: From state-sponsored development to various forms of cooperation.”, 2002, Mugla University Journal of the Social Sciences Institute https://dergipark.org.tr/tr/download/article-file/217166

[12] OECD Tourism Trends and Policies 2020, https://www.oecd-ilibrary.org/sites/f3b16239-en/index.html?itemId=/content/component/f3b16239-en

[13] Turkish Statistical Institute, https://data.tuik.gov.tr/Bulten/Index?p=Tourism-Statistics-Quarter-II:-April---June,-2022-45787&dil=2

[14] Ahmet NOHUTÇU, “Development of Tourism policies in Turkey throughout the Republican period in socio-political, economic and administrative perspective: From state-sponsored development to various forms of cooperation.”, 2002, Mugla University Journal of the Social Sciences Institute

[15] Law for the Encouragement of tourism, https://www.ktb.gov.tr/EN-113295/law-for-the-encouragement-of-tourism.html

- Соёл, Аялал жуулчлалын яамны төсвөөс  жил бүр хуваарилагдах санхүүжилт;
- (б) Турк Улсын Аялал жуулчлалын банкны  Төрийн сангийн хувьтай тэнцэх  хэсгийн ашиг;
- (в) Сангаас олгох зээлийн хүү;
- (г) Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор тогтоосон Триптик буюу хилээр нэвтрэх үнэмлэх (camet de passage)-аас олсон орлогын  тодорхой хувь хэмжээ; (*)
- (д) Энэ хуульд заасны дагуу аялал жуулчлалын байгууллага, аж ахуйн нэгжүүдэд оногдуулсан торгууль;
- (е) Үйлчилгээний хураамжийн орлого болон бусад тусламж, хандив.

Аялал жуулчлалыг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлд зааснаар Сангийн ашиглалтыг хуульчлан өгсөн. Үүнд зарцуулалт хийх зүйлсийг нарийн тодорхойлоогүй харин уг сангийн зарцуулалтыг тус улсын Аялал жуулчлалын банк-нд олгосон байдаг. Уг Сангийн аудитыг Сангийн яаманд  хариуцуулсан.[16]

Дээрхээс гадна 2013 оноос эхлэн 2023 он хүртэлх хугацаанд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр Туркын Засгийн газартай хамтран “Future Lies in Tourism Support Fund” төслийг хэрэгжүүлж байна. Уг төслийн хэрэгжүүлэгч нь Турк улсын Засгийн газрыг төлөөлөн Туркын аялал жуулчлал, соёлын яам байна. Уг сангийн зорилго нь ажил эрхлэх боломжийг өсгөж, тэгш байдлыг дээдэлсэн бодлогын үндсэн дээр таатай ажиллах орчинг бүтээх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, эдийн засагт хувь нэмрээ оруулах болно. Төсөлд НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн техникийн зөвлөгөө өгч ажиллаж байх бөгөөд ‘Anadolu Efes Turkey’ санхүүжүүлж, донор байгууллагаар ажиллаж байна.[17] Ингэхдээ тэд төр болон хувийн байгууллагуудтай хамтран ажиллаж байх боловч санхүүжилт болон сангийн зарцуулалтын хувьд төрийн байгууллагаас хамаарахгүй байх тул тэдний туршлагыг Монгол улс Аялал жуулчлалыг дэмжих санг байгуулсны дараагаар сангийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх хүрээнд туршлага судлах нь үр дүнтэй байх болно.

Үүнээс гадна бусад орны жишгийн хувьд Шинэ Зеландын жишээг товч авч үзье. Бизнес, инноваци, хөдөлмөр эрхлэлтийн яамны харьяа аялал жуулчлалыг дэмжих 2 сан үйл ажиллагаа явуулдаг байна. Үүнд International Conservation and Tourism Levy (IVL) болон Tourism Infrastructure Fund хамаарна. IVL санг санхүүжүүлэхдээ 2019 оны 7 сарын 1 өдрөөс эхлэн тухайн улсад түр хугацаагаар ирж буй ихэнх хүн бүрээс 35 долларыг татан төвлөрүүлж байна. Үүнд амралт, зарим богино хугацааны виз болон оюутны виз зэрэг хамаарна. Гэхдээ уг төлбөрийг төлөхгүй иргэд ч мөн бий. Мөн Аялал жуулчлал болон байгаль хамгааллын сайд нар хамтран тэргүүлэх зэргийн ач холбогдол бүхий урт хугацааны төслүүдийг сонгон хөрөнгө оруулж байгаль хамгаалах болон аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тэнцүү хувиарлан санг удирддаг. Тэд уг сангийн зорилгыг байгаль орчны тогтвортой байдлыг хангаж хамгаалах болон хүртээмжтэй аялал жуулчлалыг хөгжүүлэхээр төслүүдэд хөрөнгө оруулах гэж үзэж байна.

---

[16] Law for the Encouragement of tourism, https://www.ktb.gov.tr/EN-113295/law-for-the-encouragement-of-tourism.html

[17]https://www.undp.org/turkiye/projects/futuretourism#:~:text=Future%20Lies%20in%20Tourism%20Support,with%20public%20and%20private%20institutions.

## Хавсралт – 1. БНСУ-ын Аялал жуулчлалын байгууллагын бүтэц



## Хавсралт – 2. БНСУ-ын Аялал жуулчлалыг дэмжих сангаас зээл олгох зохицуулалт

# Loan Process

A. Operating Funds




B. Provision of facility funds




C. Apply for a loan after notification of the result of selection of operating funds (operating funds ④) and approval of allocation of facility funds (facility funds ③)

- After applying for a loan, there may be delays depending on the business procedure of the bank or the financial situation of the fund.

- For facility funds, apply for loan support according to the amount recognized for the completed high school within the scope of the required funds for the current period.

- Advance payment (construction contract) can be supported up to 40% of the loan allocation amount before construction begins. In this case, the completed amount is recognized only for the remaining construction parts excluding the construction parts paid in advance.

- Application for land acquisition costs for tourist destinations/tourism complex development projects and special tourism zone promotion plans implemented by local governments or public corporations (hereinafter referred to as "public corporations, etc.") can be applied for within 60% of the loan allocation amount.

D. Provision of facility funds (facility funds ④)

- The actual loan amount for the tourism facility expansion fund is determined according to the results of the inspection of the bank that handles the loan.

# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2022 ОН

## АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ СУДАЛГАА

### НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аялал жуулчлалын тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ Хууль тогтоомжийн тухай хууль, “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”[1] /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан хийж гүйцэтгэлээ.

Аялал жуулчлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ /цаашид “үнэлгээ” гэх/ хийх нь хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг илрүүлэх болон харьцуулан үнэлэх ажиллагаа бөгөөд энэхүү үнэлгээ хийх ажлын зорилт нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход оршино.

Аялал жуулчлалын тухай хууль нь 2000 оны 5 дугаар сарын 5-ны өдөр 6 бүлэг 24 зүйлтэйгээр батлагдсан бөгөөд хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи 22 жилийн хугацаанд нийт 12 удаа буюу 2001, 2002, 2003, 2005, 2006, 2010, 2011, 2015, 2017, 2021, 2022 онуудад нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр тус хуульд 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийг шинээр нэмж, тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан аргачлалууд хамаарахгүй байх нийт 24 тохиолдлыг тоочин заасан. Мөн аргачлалын 1.3 дахь хэсэгт энэхүү аргачлал хамаарахгүй буюу аргачлалын дагуу үнэлгээ хийх шаардлагагүй 5 тохиолдлыг тоочин заасан бөгөөд Аялал жуулчлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх нь дээрхи тохиолдлуудын алинд ч хамаарахгүй байх тул аргачлалын дараагийн хэсгүүдэд заасны дагуу үнэлгээг үргэлжлүүлэн гүйцэтгэлээ.

### ХОЁР.ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮЕ ШАТ

Аялал жуулчлалын тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ аргачлалын 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараахь үе шаттайгаар хийлээ:

1.Төлөвлөлтийн үе шат;
2.Хэрэгжилтийн үе шат;
3.Үнэлэх үе шат.

---

[1] Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1-д заасны дагуу 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан.

# 1.ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮЕ ШАТ

Төлөвлөлтийн үе шатны зорилго нь үнэлгээ хийх шалтгаан, хүрээг тогтоож түүнд тохирсон шалгуур үзүүлэлт, харьцуулалтын аргыг тодорхойлоход чиглэх бөгөөд аргачлалын 3.1 дэх хэсэгт заасны дагуу төлөвлөлтийн үе шатыг дараахь дараалаар хийж гүйцэтгэлээ:

1.1.Үнэлгээ хийх шалтгаан;
1.2.Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
1.3.Шалгуур үзүүлэлтийг тогтоох:

1.3.1.Зорилгод хүрсэн түвшин;
1.3.2.Зардлын өсөлт, бууралт ;
1.3.3.Зардал үр өгөөжийн харьцаа;
1.3.4.Хүлээн зөвшөөрөгдсөн байдал;
1.3.5.Практикт нийцэж байгаа байдал;
1.3.6.Бусад үр дагавар;

1.4.Харьцуулах хэлбэрийг сонгох:

1.4.1.Байх ёстой, одоо байгаа;
1.4.2.Хууль батлагдахаас өмнөх/хууль батлагдсанаас хойшхи;
1.4.3.Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэнээс хойш;
1.4.4.Тохиолдол судлах;

1.5.Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
1.6.Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

### *1.1.Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох*

Аргачлалд заасны дагуу хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судлахад Нэн тэргүүнд тодорхой шалтгаан байх хэрэгтэй тул Аялал жуулчлалын тухай хууль нь тухайн харилцааг зохицуулж чадаж буй эсэх, түүний нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэхийн тулд үнэлгээний ажлыг эхлэхээс өмнө үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлохыг зорилоо:

**<u>Үнэлгээ хийх шалтгаан 1</u>**

Аялал жуулчлалын тухай хууль нь 2000 онд батлагдсанаас хойш 22 жил хэрэгжиж байгаа хэдий ч хуулийг хэрэгжүүлэх явцад түүний зохицуулалт нь хуулийн зорилтыг бүрэн хангах боломжгүй, нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцорсон, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг бүрэн хамарч чадаагүйгээс гадна үүнээс шалтгаалсан сөрөг үр дагавар үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг байна.

Тодруулбал хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Аялал жуулчлалын тухай хууль нь 2000 батлагдсан бөгөөд нийт 12 удаа нэмэлт, өөрчлөлт (2001, 2002, 2003, 2005, 2006, 2010, 2011, 2015, 2017, 2021, 2022) орсон хэдий ч эдгээр нь хуулийн үндсэн агуулга, нийгмийн харилцаанд өөрчлөлт, шинэчлэлттэй холбоотой бус зөвхөн бусад хууль тогтоомж өөрчлөгдсөн, шинэчлэгдсэнтэй холбоотой тул хуулийн үндсэн агуулга, зохицуулах харилцааны хүрээ хязгаарт өөрчлөлт ороогүй байна.

Мөн аялал жуулчлалын харилцаанд хамаарах дараах хэм хэмжээний актууд (дүрэм, журам, стандарт, аргачлал г.м.) мөрдөгдөж байна. Үүнд:

- Тусгай хамгаалалттай газар нутаг /ТХГН/-т аялал жуулчлал явуулах журам[2];
- "ТХГН-д үзүүлэх ажил үйлчилгээний нэг удаагийн хөлс төлөх журам[3];
- Аялал жуулчлалын байгууллагын ангилал тогтоох журам[4];
- Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутаг дэвсгэрт газар ашиглах, зөвшөөрөл олгох түр журам[5];
- Дээд зэрэглэлийн зочид буудал, жуулчны баазад зэрэглэл тогтоох журам[6];
- Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам[7];
- Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага MNS 5927 : 2008[8];
- Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага MNS 5927 : 2008[9];
- Дэн буудал. Ерөнхий шаардлага MNS 5738 : 2007[10];
- Амралт сувилалын үйлчилгээ Амралт, сувилалын газар. Техникийн шаардлага MNS 4958 : 2000[11];
- Амралтын газар, жуулчны баазад тавих ерөнхий шаардлага MNS 6034 : 2019[12];
- Аялал, жуулчлал. Байрны төрлийн үндсэн нэр томьёо MNS 5409 : 2004[13];
- Аялал жуулчлалын байр сууцны төрөл, үндсэн шаардлага MNS 5824:2007[14];
- Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын нэр томьёо, тодорхойлолт[15];

---

[2] https://legalinfo.mn/mn/detail?lawId=204302&showType=1
[3] https://legalinfo.mn/mn/detail?lawId=204303&showType=1
[4] https://legalinfo.mn/mn/detail?lawId=205117&showType=1
[5] https://legalinfo.mn/mn/detail?lawId=204353&showType=1
[6] https://legalinfo.mn/mn/detail?lawId=204258&showType=1
[7] https://tourism.ub.gov.mn/wp-content/uploads/2015/09/juram.1.pdf
[8] https://estandard.gov.mn/standard/v/1895
[9] https://estandard.gov.mn/standard/v/1895
[10] https://estandard.gov.mn/standard/v/1717
[11] https://estandard.gov.mn/standard/v/3670
[12] https://estandard.gov.mn/standard/v/2750
[13] https://estandard.gov.mn/standard/v/5746
[14] https://estandard.gov.mn/standard/v/1145
[15] https://estandard.gov.mn/standard/v/29

- Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6426 : 2013[16]
- Жуулчны мэдээллийн төв - Жуулчинд мэдээлэл өгөх ба жуулчдыг хүлээн авах үйлчилгээ-Шалгуур үзүүлэлт MNS ISO 14785 : 2021[17]
- Адал явдалт аялал жуулчлал- аюулгүй ажиллагааны менежментийн тогтолцоо- шаардлагууд ISO 21101:2022[18]
- Адал явдалт аялал жуулчлал. Удирдагчид –Боловсон хүчний чадамж MNS ISO 21102 : 2022[19]
- Адал явдалт аялал жуулчлал- Оролцогчдод өгөх мэдээлэл MNS ISO 21103 : 2022[20]
- Жуулчны авто тээврийн  үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5231 : 2003[21]
- Автотээврийн үйлчилгээ. Зорчигч тээврийн автобуудал. Ерөнхий шаардлага. MNS 6300 : 2011[22]
- Жуулчны баазад олгох гэрчилгээний загвар[23];
- Зэрэглэлийн шаардлага хангасан зочид буудалд олгох гэрчилгээ, тэмдгийн загвар[24];
- Зочид буудал, жуулчны баазын үйл ажиллагааны талаарх тайлангийн загвар[25];
- Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутаг дэвсгэрт газар ашиглуулах тухай гэрээний маягт[26];
- Аялал жуулчлалын байгууллагын ангиллын гэрчилгээний загвар[27];

Аялал жуулчлалын тухай хууль нь манай нутаг дэвсгэр дээр аялал жуулчлалыг хөхүүлэн дэмжих, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх, жуулчны үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулах үндсэн зорилготой.

Гэтэл Монгол Улс нь 1990 онд НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагад нэгдэн орж, гишүүн орон болсон. Тус байгууллагаас гаргасан Аялал жуулчлалын конвенцид заасныг харахад "аялал жуулчлал" гэдэг маш өргөн хүрээнд байхаар заасныг гадна тус байгууллагаас хийсэн судалгаагаар "дэлхий даяар 2020 онд аялах жуулчдын тоо 1995 онтой харьцуулахад 3 дахин нэмэгдэж

---

16 https://estandard.gov.mn/standard/v/3679
17 https://estandard.gov.mn/standard/v/6754
18 https://estandard.gov.mn/standard/v/61?fbclid=IwAR0d9lMPjPZVY6OvDRCkqVY9IwsazIE5lqi0mcfFaa62o2_ReY6wx46CHUc
19 https://estandard.gov.mn/standard/v/64?fbclid=IwAR0Vo4K4Gx5ybTgdEpeJW6rr9AEt11kMQ5ZyprpT5sjGBe6iir6p3Bkqkrl
20 https://estandard.gov.mn/standard/v/3481?fbclid=IwAR27HR8-b0eDb_l-55aMmKLyYD4hboeZZF1l0TWCTDEx_4oOrn-8fTYHbmU
21 https://estandard.gov.mn/standard/v/4684
22 https://estandard.gov.mn/standard/v/193
23 https://legalinfo.mn/mn/detail?lawId=204260&showType=1
24 https://legalinfo.mn/mn/detail?lawId=204260&showType=1
25 https://legalinfo.mn/mn/detail?lawId=204259&showType=1
26 https://legalinfo.mn/mn/detail?lawId=204354&showType=1
27 https://legalinfo.mn/mn/detail?lawId=205118&showType=1

1,6 тэрбумд хүрэх бөгөөд Ази, Номхон далайн бүс нутагт аялах жуулчдын тоо дэлхийн бусад бүсүүдээс илүү хурдацтай нэмэгдэх"-ийг тогтоожээ.

Түүнчлэн Засгийн газрын 2015 оны 324 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн зорилгыг аялал жуулчлалын салбарын хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж, тогтвортой хөгжлийг хангаан тус салбарын олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэнэ гэж тодорхойлж, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр/цаашид "МУ-ын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр" гэх/ - ийн 4.4-т Аялал жуулчлалын салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд "Аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг бүс нутгийн хэмжээнд дээшлүүлж, эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ" гэж тусгахдаа 4.4.1-т "Аялал жуулчлалыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэх, бүтээгдэхүүн, дэд бүтцийг хөгжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах цогц бодлого хэрэгжүүлнэ", 4.4.2-т "Үндэсний зан заншил, уламжлал, түүх, соёл, унаган байгаль, нүүдэлчин ахуйг түшиглэсэн аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, нийслэл, аймаг, бүс нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалын дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ", 4.4.3-т " "Бурхан халдун", "Хорго-Тэрх", "Хамарын хийд", "Отгонтэнгэр", "Хар-Ус", "Хөвсгөл", "Хархорин" зэрэг байгалийн үзэсгэлэнт, өвөрмөц тогтоц бүхий газар нутгийг түшиглэсэн түүхэн болон төрөлжсөн аялал жуучлалын төв, цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын хөрөнгө оруулалтаар байгуулахыг бодлогоор дэмжинэ" гэх зэрэг хэд хэдэн зорилтыг дэвшүүлсэн байсан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2021 оны "Монгол Улсын Хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай" 12 дугаар тогтоолын[28] хавсралтын 27 дугаарт "Аялал жуулчлалын тухай" хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг Засгийн газар санаачлан Байгаль орчин, аялал жуулчлалын яам хуулийн төслийг хариуцан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барихаар тогтоосон.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын[29] 1 дүгээр хавсралтаар батлагдсан *"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдэдийн 3 дахь хэсэгт* "Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвар дээшилсэн байна." *хэмээн заасан бол зорилт 8.2-т "Эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх"-ээр заах, энэхүү зорилтыг хэрэгжүүлэх I үе шат(2021-2030)-ын 1 дэх хэсэгт* "Байгаль экологи, археологи, палеонтологи, нүүдлийн өв, түүх, соёл, рекреацийн нөөц, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлнэ.", *II үе шат(2031-2040)-ын 1 дэх хэсэгт* "Аялал жуулчлалын салбарт орчин үеийн дэвшилтэт технологийг

[28] Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоол.
[29] Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол

нэвтрүүлэх замаар хүртээмж, орлогыг нэмэгдүүлсэн байх"-аар тус тус заасан буюу эдийн засгийг сэргээх үндсэн хөшүүргийн нэгээр аялал жуулчлалын салбарыг онцолж, тэдгээрийг биелүүлэх тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн.

Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлах хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэх үндсэн зорилго бүхий Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын [30] нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Боомтын сэргэлтийн 1.3 дахь хэсэгт "Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт, агаарын замын ашиглалтыг сайжруулан дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлалыг үе шаттайгаар үргэлжлүүлэх замаар ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, мөн аялал жуулчлалын салбарыг дэмжинэ.", мөн тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 1.3.1-д "Агаарын замын байнгын ажиллагаатай олон улсын боомтын тоог нэмэгдүүлж, карго тээвэр, аялал жуулчлалыг хөгжүүлэх", 1.4.2-т "Зарим боомтыг түшиглэн хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх", "Зургаан боомтыг аялал жуулчлалын боомт болгон хөгжүүлж, боомтын зэрэглэлийг нэмэгдүүлсэн байна.", 2.1.2-т "Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөж, зүүн бүсийн уул уурхай, аялал жуулчлалын төслүүдийн эрчим хүчний хэрэглээг хангах", "Зүүн бүсийн өсөн нэмэгдэж байгаа цахилгаан эрчим хүчний хэрэглээ ба Дорнод, Сүхбаатар аймгийн сум, суурин газар, уул уурхайн ордын баяжуулах, олборлох үйлдвэрүүд, аялал жуулчлалын цогцолборуудыг тасралтгүй, найдвартай эрчим хүчээр хангасан байна." гэж тус тус заасан Аялал жуулчлалын тухай хууль, түүний хэрэгжилт Ковид-19 цар тахлын дараах нийгэм, эдийн засгийн сэргэлтийг бүрэн хэрэгжүүлэхэд нийцэх нь эсэхийг үнэлэх нь зүйтэй байна.

Цаашид Аялал жуулчлалын тухай хуулийн зохицуулалт, ялангуяа хуулийн зорилтыг илүү боловсронгуй болгож, зохицуулалтын утга, агуулга, хуульд хэрэглэсэн нэр томьёог тодорхой, ойлгомжтой тодорхойлох шаардлагатайгаас гадна олон улсын жишигт нийцүүлэх зүйтэй бөгөөд цаашид уг хуулиар зохицуулсан харилцаанд сөрөг үр дагавар үүсгэх эрсдэлийг бууруулах шаардлагатай гэж үзэж байна.

**Үнэлгээ хийх шалтгаан 2**

Ковид-19 цар тахал дэгдсэнээр дэлхийн аялал жуулчлалын салбар 2020 онд -73%, 2021 онд -76% тус тус буурч, тэр дундаа Ази Номхон далайн бүс нутгийн аялал жуулчлал -94% хүрч буурсан байна.[31] Ковид-19 цар тахлын нийгэм, соёл, эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулахаар ихэнх улс орнууд бодлогын чанартай ажлуудыг хийж байна. Дэлхийн 220 орноос 167 орон нь Ковид-19 цар тахлын хор уршгийг арилгаж бууруулах, аялал жуулчлалаа сэргээх, шинэ эгэл байдалд зохицож ажиллахаар улс орны болон бүс нутгийн хэмжээний

[30] Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол.
[31] https://www.unwto.org/news/tourism-grows-4-in-2021-but-remains-far-below-pre-pandemic-levels

сэргийлэх, сэргээх арга хэмжээ буюу төлөвлөгөө боловсруулж, үүнээс 144 улс төсөв, татвар мөнгөний бодлого баримтлаж, 100 гаруй улс ажлын байр дэмжих, сургалтыг дэмжих чиглэлээр төлөвлөгөө хэрэгжүүлж байна.[32]

Цар тахлын нөлөө хамгийн хүндээр туссан салбаруудын нэг нь аялал жуулчлалын салбар бөгөөд 2020 онд Ази, номхон далайн бүс нутгийн орнуудын аялал жуулчлалын салбарын орлого 1.6 их наяд ам.доллар ба 53.7%-иар буурч, салбарын ажиллах хүчний тоо 34.1 сая хүн ба 18.4%-иар буурсан байна.[33] Энэхүү нөлөө Монгол Улсад ч хүндээр тусч байгаа бөгөөд 2018 онд 529 мянган гадаад жуулчин хүлээн авч дотоодын эдийн засагт 596 сая ам.доллар буюу 1.5 их наяд төгрөгийн орлогыг төвлөрүүлж байсан хэдий ч цар тахлын нөлөөгөөр 2021 оны I-V саруудад 8,554 жуулчин хүлээн авсан бөгөөд 6,330,573 ам.долларын орлого олсон бол 2022 оны I-V саруудад 42,060 жуулчин хүлээн авч, түүнээс 37,925,168 ам.долларын [34] орлого тус тус олсон бөгөөд эдийн засгийн гол хөшүүргийн нэг болсон Аялал жуулчлалын салбарыг бүхий л талаас нь дэмжих шаардлага үүсээд буй.

Мөн дэлхий дахин тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхийг эрмэлзэж буй энэхүү цагт манай улсын сэргэлтийн бодлогын үндсэн цөм болсон Алсын хараа – 2050, Шинэ сэргэлтийн бодлогыг дэлхийн өнөөгийн чиг хандлагад нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байгаа тул үүний үндсэн суурь болох холбогдох хууль тогтоомж, холбогдох гарсан хэм хэмжээний актуудыг шинэчлэх аялал жуулчлалын салбарыг санхүүгийн хөшүүрэг болгон ашиглах боломжийг бий болгоно.

**<u>Үнэлгээ хийх шалтгаан 3</u>**

Ковид-19 цар тахал болон нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн тогтворгүй нөхцөл байдлаас үүдэн дотоодын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа доголдох болж, Монгол Улсын аялал жуулчлалын зах зээлд гадаадын компаниуд өрсөлдөх болсноор мянгаас дээш жуулчин хүлээн авч, аялал зохион байгуулах хүчин чадалтай үндэсний компаниудын тоо эрс цөөрч байгаа бөгөөд 2021-2022 онуудад аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй 188 аж ахуйн нэгжийн дунд судалгаа явуулахад 43.6% нь тур оператор, 32.4% нь жуулчны бааз, ресорт, амралтын газар, гэр буудал, 19.7% нь зочид буудал, 4.3% нь ресторан байсан бөгөөд Ковид-19 цар тахал бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлсөн тухай тодруулахад нийт судалгаанд оролцсон жуулчны бааз (ресорт, амралтын газар, гэр буудал), зочид буудал, ресторааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчдийн 40% нь үйл ажиллагаагаа түр зогсоосон, дахин эхлэхээр төлөвлөж байгаа бол 55% нь үйл ажиллагаагаа явуулж байна. Харин 4 аж ахуйн нэгж аялал жуулчлалын салбараас бүр мөсөн гарч, үйл ажиллагааны чиглэлээ өөрчилсөн байна.

---

[32] https://www.unwto.org/taxonomy/term/347#:~:text=Based%20on%20the%20current%20evidence,trillion%20in%20international%20tourism%20receipts.

[33] Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Аялал жуулчлалын хөгжлийн төв, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим, Аялал жуулчлалын боловсрол, Хөгжлийн нийгэмлэг, "Аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчдэд үзүүлж буй цар тахлын нөлөө", 2022.

[34] Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2022 оны эхний тавдугаар сарын жуулчдын мэдээг 2021 оны мөн үетэй харьцуулсан мэдээ.

Улмаар судалгаанд оролцсон байгууллагууд аж ахуйн нэгжүүд бизнесийн үйл ажиллагаагаа сэргээхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн ойролцоогоор 40%-ийг өөрийн хөрөнгөөр, 60%-ийг ямар нэгэн гадны зээл, эх үүсвэрээр санхүүжүүлэх төлөвлөгөөтэй [35] байгаа тухай дурдсан буюу гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэх, дотоодын зах зээлд эрсдэл нүүрлэх, улмаар үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хүртэл нөхцөл үүсч болзошгүй байна.

Гадаад улсын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд манай улсад бизнесийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн боломж нь Компанийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуулиар тус тус зохицуулагдсан. Тодруулбал, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт "Дараах салбарт үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд эзэмших тохиолдолд зөвшөөрөл авна:, мөн зүйлийн 21.1.1.уул уурхай; 21.1.2.банк, санхүү; 21.1.3.хэвлэл, мэдээлэл, харилцаа холбооны салбар байхаар заасан. Товчхондоо аялал жуулчлалын салбарт гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд үйл ажиллагаа явуулах бүрэн боломжтой бөгөөд тусгай зөвшөөрөл авах шаардлагагүйгээр зохицуулагдсан. Энэ нь тус салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, хамтран ажиллах боломжийг бий болгож байгаа хэдий ч нөгөө талдаа аялал жуулчлалын салбарын дотоодын зах зээл ямар нэг хамгаалалтгүй байгааг илэрхий харуулж байна.

Иймээс дотоодын аялал жуулчлалын байгууллагын чадавх эрс суларч буй энэ үед гадаадаас жуулчин хүлээж авах, гадагшаа жуулчин аялуулах тур операторын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй болгох замаар нэг талаас хариуцлагыг нэмэгдүүлж, жуулчдын аюулгүй байдлыг хангах, дотоодын аж ахуйн нэгжүүдийн зах зээлийн орчинг хамгаалах, төрөөс бодлогоор дэмжлэг үзүүлэх нэн чухал юм.

**<u>Үнэлгээ хийх шалтгаан 4</u>**

Монгол Улсын Үндсэн хуулийн аравдугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт "Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна.", мөн зүйлийн 10.2 дахь хэсэгт "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.", мөн зүйлийн 10.3 дахь хэсэгт "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ." хэмээн заасанчлан манай улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж, дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил дагаж мөрдөхөөр заасан.

Монгол Улс тогтвортой хөгжлийн болон аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаанд хамааралтай хэд хэдэн олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орсон

[35] Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Аялал жуулчлалын хөгжлийн төв, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим, Аялал жуулчлалын боловсрол, Хөгжлийн нийгэмлэг, "АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ҮЗҮҮЛЖ БУЙ ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ", 2022.

хэдий ч 2000 онд батлагдсан Аялал жуулчлалын тухай хуулийн үндсэн зарчим, агуулга холбогдох гэрээ конвенцтой уялдаж чадаагүй байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаас 2015 оны 9 дүгээр сард баталсан "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030" болоод "Бүх талын оролцоог тэгш хангаж, оролцогч талуудын харилцан ашигтай байх зарчмыг баримтлан тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх" гэсэн 33 дахь зорилтыг хангахад Аялал жуулчлалын хуулийг нийцүүлэх шаардлагатай байна.

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас баталсан "Аялал жуулчлалын ёс зүйн конвенц"-д "Аялал жуулчлал, хүрээлэн буй орчны тогтвортой байдлын хүчин зүйл", "Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд оролцогч талуудын үүрэг, хариуцлага" зэрэг конвенцын өндөр ач холбогдол бүхий, нэн чухал зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд Аялал жуулчлалын тухай хуулийн үндсэн агуулгыг нийцүүлэх, мөн НҮБ-ын "Цөлжилттэй тэмцэх конвенц"-ын хүрээнд Монгол Улс газрын доройтлыг багасгах, цөлжих эрсдэлтэй бүс нутгийг хамгаалах зорилго бүхий шат дараалсан хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа бөгөөд үүний нэг нь тусгай хамгаалалттай газар нутагт Аялал жуулчлалын зориулалтаар ашиглагдаж буй газрын доройтол, хөрсний элэгдэл, түүний хүрээлэн буй орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах зорилт юм. Түүнчлэн НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас 2008 онд гишүүн орнууддаа хандаж гаргасан "Аялал жуулчлалын нэр томьёоны тайлбар"-т нийцүүлэн хууль тогтоомжид тусгагдсан нэр томьёог өөрчлөх, шинэчлэх шаардлага бий эсэхийг дүгнэх нь зүйтэй юм.

**<u>Үнэлгээ хийх шалтгаан 5</u>**

Аялал жуулчлалын тухай хуулийг хэрэгжүүлэх явцад тодорхой байх шаардлагатай хуулийн нэр томьёо, аялал жуулчлалын байгууллага, түүний ангилал, үйл ажиллагаа, эрх хэмжээ, хөтөч-тайлбарлагчид тавих шаардлага, түүний эрх, үүрэг зэрэг зохицуулах олон асуудлыг хуульд тусгасан хэдий ч эдгээр нь бодит байдалтай нийцдэггүй, тухайн харилцааг хангалттай зохицуулах боломжгүй, олон улсын жишигт нийцдэггүй зэрэг дутагдалтай байна.

Энэхүү асуудлаар салбарын төлөөлөл болон Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбооны гүйцэтгэх захирал Б.Мөнхбаттай уулзахад "манай холбоо хөтөч тайлбарлагч нарыг сургаад, сайжруулаад, чадавхжуулаад байгаа боловч сургалтыг маань төгссөн сурагчид улсаас зөвшөөрөгдсөн үнэмлэхтэй төгсөж чадахгүй байна. Үүнийг хуулиар уу, эсхүл журмаар зохицуулах уу гэдгийг бид мэдэхгүй байгаа бөгөөд Аялал жуулчлалын хөгжлийн төв ч гэсэн уг асуудлыг шийдэж чадахгүй байна. Аялал жуулчлалын хөгжлийн төв хэлэхдээ мэргэжлийн холбоотойгоо нийлүүлж байгаад үүнийг журмаар зохицуулаад танай сургалтыг төгссөн хүүхдүүдийг үнэмлэхтэй болгоё гэж байгаа. Мэргэжлийн үнэмлэх гэдэг нь хөтөч тайлбарлагчийн сургалтыг төгсөөд тодорхой хэмжээний мэдлэг ур чадварыг хуримтлуулсны дараагаар жуулчинд үйлчлэх боломжтой болсон гэдэг нь

үнэмлэх“[36] тухай илэрхийлсэн буюу хөтөч-тайлбарлагч, түүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалт маш дутмаг байгааг анхааруулжээ.

Мөн, “Аялал жуулчлалын байгууллага”-ын хувьд зэрэглэл гэж байхгүй, харин ангилалтай байх бөгөөд ангилалаа эрх бүхий байгууллагаар тогтоолгохоор хуульд зохицуулснаас гадна “жуулчны үйлчилгээний байгууллага” гэх зэрэг ойлгомжгүй ойлголт хуульд туссан байх жишээтэй.

Гэтэл дээр дурдсан Монгол Улсын Их Хурлын болон Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, тэдгээрийн зорилтуудад заасан Аялал жуулчлалыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэх, бүтээгдэхүүн, дэд бүтцийг хөгжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах цогц бодлого хэрэгжүүлнэ гэх зорилтууд болон Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас гаргасан “Аялал жуулчлал-2020 он” судалгаанд “XXI зуунд аялал жуулчлалын төрлүүдээс Адал явдалт аялал жуулчлал, Эко аялал жуулчлал, Тусгай сонирхлын аялал жуулчлал, Тойрон аялал, Соёл-танин мэдэхүйн аялал жуулчлал, Хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, яармагийн аялал жуулчлал, Эрүүл мэндийн аялал жуулчлалын төрлүүд эрчимтэй хөгжиж байна” гэж дурджээ.

Эдгээрээс дүгнэн үзвэл хуулийг хэрэгжүүлэх явцад түүний зохицуулалт нь бодит байдалтай нийцээгүй, тухайн харилцааг хангалттай зохицуулдаггүй, олон улсын жишигт нийцүүлэх зэрэг хэрэгцээ шаардлага үүссэн байх тул хуулийн нэр томьёо, аялал жуулчлалын байгууллага, түүний ангилал, үйл ажиллагаа, эрх хэмжээ, хөтөч-тайлбарлагчид тавих шаардлага, түүний эрх, үүрэг гэх зэрэг ойлголт, тэдгээрийн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

**Үнэлгээ хийх шалтгаан 6**

Аялал жуулчлалын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд энэ хуульд заасан захиргааны, эрүүгийн, зөрчлийн гэх зэрэг хариуцлага хүлээлгэхээр хариуцлагын асуудлыг тусгасан боловч эдгээр зохицуулалт нь шүүхийн практикт хэрэглэн хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хүндрэл, бэрхшээл бий болгох, ойлгомжгүй, зөрчилтэй байгаагаас харахад үүнээс шалтгаалсан хууль хэрэглээнд сөрөг үр дагавар үүсэх бүрэн боломжтой байна.

Аялал жуулчлалын тухай хууль зөрчсөнтэй холбоотой шүүхийн шийдвэрийг Зөрчлийн тухай хуулийн 10.14 дүгээр зүйл буюу Аялал жуулчлалын тухай хууль зөрчсөн, уг зөрчилд хариуцлага тооцуулсан шийдвэртэй холбоотой утгаар Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан буюу shuukh.mn руу орж түлхүүр үгээр хайлт хийн 2019 оны 9 дүгээр сарын 26-ны өдрөөс 2022 оны 6-р сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд захиргааны хэргийн анхан шатны шүүхээр

[36] Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбооны гүйцэтгэх захирал Б.Мөнхбаттай 2022 оны 06-р сарын 30-ны өдөр хийсэн уулзалтын тэмдэглэл, хавсралт – 1.

шийдвэрлэсэн 260 шийдвэртэй танилцсан болович дээрх агуулгаар шийдвэрлэгдсэн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр олдоогүй болно.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны “Монгол Улсын Хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 12 дугаар тогтоолын[37] хавсралтын 27 дугаарт “Аялал жуулчлалын тухай” хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг Засгийн газар санаачлан Байгаль орчин, аялал жуулчлалын яам хуулийн төслийг хариуцан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барихаар тусгасан бөгөөд үүний зорилго нь Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх нь ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засгийг хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, үндэсний өв, уламжлал, соёл, ёс заншил, түүх, дурсгалын үнэт зүйлсийг сурталчлан таниулах, улмаар эдийн засгийн эргэлтэд оруулахад чухал ач холбогдолтойг харгалзан тус салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, салбарын өмнө тулгамдсан асуудлыг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан шийдвэрлэх юм.

Өөрөөр хэлбэл, үндсэн чиглэлд энэ салбарт гарсан тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр хуулийг шинэчлэн найруулахаар тусгасан нь хууль зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх зохицуулалтууд нь хууль, шүүхийн практикт хэрэглээнд хүндрэл үүсгэх зохицуулалтыг сайжруулах зорилго агуулжээ.

Иймд дээрх зохицуулалтаас үүдэн гарах сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлж, хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж байна.

**<u>Үнэлгээ хийх шалтгаан 7</u>**

Өнөөгийн нөхцөл аялал жуулчлалын салбарын төрийн бодлого, түүний удирдлага зохицуулалтыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газар хариуцан гүйцэтгэж байгаа бөгөөд тус газар 5-8 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 08-р сарын 25-ны өдрийн 71 дүгээр “Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” тогтоолоор Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын чиг үүргийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгон хөгжүүлэх;
- аялал, жуулчлалын талаарх бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжийг боловсронгуй болгох;
- тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөгөө өгөх;

---

[37] Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоол.

- аялал жуулчлалын талаарх бодлого, төсөл хөтөлбөр, хууль тогтоомжийг боловсронгуй болгох;
- тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах;
- байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх;
- аялал жуулчлалын байгууллага, аж ахуйн нэгжийн менежментийг сайжруулах ажлыг зохион байгуулах;
- аялал жуулчлалын мэдээллийг нэгтгэж дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлж, хэрэглэгчийг мэдээллээр хангах;
- гадаад сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагааг идэвхжүүлж жуулчдын тоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;
- нэгдсэн удирдлагаар хангах;
- аялал жуулчлалын талаар нутгийн захиргааны байгууллага, мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллага, иргэдийг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Харамсалтай нь бодит байдалд 5-8 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж буй Байгаль орчин, аялал жуулчлалын яамны тус нэгж дээрх 11 үйл ажиллагааг нэг бүрчлэн хэрэгжүүлэх, мөн улс орны хэмжээнд аялал жуулчлалын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган ажиллахад учир дутагдалтай бөгөөд салбарын оролцогчид аялал жуулчлалын асуудлыг хариуцсан тусгайлсан төрийн захиргааны байгууллага зайлшгүй байх шаардлагатайг онцолж байна.[38]

Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын үйл ажиллагаа нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргад Засгийн газрын бодлогын хэрэгжилтийг хангахтай холбогдсон шийдвэр боловсруулан гаргахад дэмжлэг үзүүлэх, сайдад мэргэшлийн зөвлөгөө, шаардлагатай мэдээлэл, шуурхай үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжинэ.

Тус газраас үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, аялал жуулчлалын байгууллага, аж ахуйн нэгж байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, аялал жуулчлалын чиглэлээрх дотоод, гадаадын байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэд байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Соёлын яам, Сангийн яам, нутгийн захиргааны байгууллага, холбогдох бусад газар, мэргэжлийн холбоод, салбарын аж ахуйн нэгжүүд байна.

Олон улсад тухайн орны аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, түүнийг бусад улс орнуудад сурталчилах, шаардлагатай үйл ажиллагааг дэмжих, санхүүжүүлэх, гадаадын болон дотоодын аялал жуулчлалыг ангилан зохион байгуулах, шаардлагатай менежмент, төслийг хэрэгжүүлэх төрийн хүчирхэг институцийн загварыг нэгэнтээ бий болгосон байдаг.

[38] Монголын зочид буудлуудын холбооны тэргүүн С.Мөнхбаттай 2022 оны 07-р сарын 01-ний өдөр хийсэн уулзалтын тэмдэглэл.

Жишээлбэл, БНСУ-ын тухайд 1962 оны 06-р сарын 26-ны өдөр Аялал жуулчлалын байгууллагыг байгуулсан бөгөөд тус байгууллагын үндсэн зорилгыг "Аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын хүний нөөцийг бүрдүүлэх, аялал жуулчлалын үйлдвэрлэлийн сургалт, судалгааг явуулах болон мэргэжилтнүүдийг бэлтгэх БНСУ-ын аялал жуулчлалын байгууллагыг байгуулж үндэсний эдийн засагт дэмжлэг үзүүлэх"-д оршдог байна. Энэхүү байгууллага өнөөг хүртэл тогтвортой үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд 5 газар, 16 хэлтэс, 54 нэгж, 33 гадаад дахь салбар болон бүс нутгийн 10 салбар гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулдаг байна.[39]

Дэлхийн улс орнууд ийнхүү аялал жуулчлалын салбарыг бүхэлд нь зохион байгуулах чадавхи бүхий төрийн томоохон институцын бүтэцтэйгээр ажиллаж байгаа хэдий ч Монгол Улсын хувьд салбарын яамны нэг газар хариуцан ажиллаж байгаа нь аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулж чадаж байгаа эсэх, түүнд үнэлэлт дүгнэлт өгөх, тухайн бүтцийг өргөжүүлэх шаардлагатай эсэхийг практик судалгаанд үндэслэн дүгнэх хэрэгцээг бий болгож байна.

Түүнчлэн, Аялал жуулчлалын брэндийг бусад улсуудад нэгдсэн зохион байгуулалтаар сурталчлах, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, дэмжих, хүний нөөцийг бэлтгэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, жуулчдын тоог нэмэгдүүлэх үндсэн зорилгоор БНСУ-ын Аялал жуулчлалын корпорацын жишгийн дагуу "Аялал жуулчлалын хөгжлийн төв" ТӨҮГ-ыг 2017 онд байгуулсан хэдий ч тус байгууллага өнөөг хүртэл үндсэн зорилго, зорилтуудаа хангалттай биелүүлээгүй, мөн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж чадахгүй байна. Үүний шалтгаан нь тус байгууллага холбогдох байгууллагуудтай байгуулсан хамтран ажиллах гэрээгээ хангалттай биелүүлээгүй, гүйцэтгэх удирдлагад тавих хяналт, хариуцлагын механизм дутмаг, байгууллагын үйл ажиллагаа тогтворгүй, санхүүжилтийн эх үүсвэр, түүний зарцуулалт хаалттай зэрэг хэд хэдэн шалтгаанаас нөхцөлдсөн бөгөөд энэхүү хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэх зорилгоор тус байгууллагыг нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлтэй уялдуулан өөрчлөн байгуулах шаардлага үүсээд байна.

Иймээс Монгол Улсыг гадаад улсад нэгдсэн зохион байгуулалттайгаар сурталчлах үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар удирдах, бусад улсуудтай харилцах, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх улсын бодлогыг өдөр тутам удирдан зохион байгуулах бүтцийг хуульд илүү тодорхой зохицуулах шаардлагатай эсэх, өнөөгийн бүтэц алдаа дутагдлыг илрүүлэх, олон улсын жишигт нийцсэн бүтцийг нэвтрүүлэх хэрэгцээг судлах зайлшгүй хэрэгцээтэй байна.

**<u>Үнэлгээ хийх шалтгаан 8</u>**

Аялал жуулчлалын тухай хуулиар аялал жуулчлалын талаарх Засгийн газрын бүрэн эрх, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

[39] https://kto.visitkorea.or.kr/eng.kto

байгууллагын бүрэн эрх, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх зэргийг зохицуулсан хэдий ч төрийн байгууллагын эрх хэмжээ, чиг үүрэг, төр, хувийн хэвшлийн уялдаа холбоог хангалттай зохицуулаагүйгээс хэрэгжүүлэх явцад тулгамдсан асуудал үүсдэг байна.

Тодруулбал, Аялал жуулчлалын тухай хуульд Засгийн газар аялал жуулчлалын бүсийг улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлоготой уялдуулан тогтоох, аялал жуулчлалын бүсэд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх этгээдэд санхүүгийн дэмжлэг олгохоор зохицуулсан хэдий ч энэхүү агуулга хэрэгжсэн эсэх нь туйлын эргэлзээтэй байна.

Аялал жуулчлалын жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аялал жуулчлалын бүсэд үйл ажиллагаа явуулах жуулчны бааз, зочид буудал, амралт, рашаан сувиллын газрын тоо, байршлыг тогтоох, тэдгээрийн нэгдсэн бүртгэл хөтлөх, мөн аялал жуулчлалын хөгжилд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулахыг хориглох бүрэн эрхтэй боловч өнөөгийн байдлаар энэхүү эрхээ хэрэгжүүлсэн талаарх тоон мэдээлэл байхгүй байна.

Эдгээрээс дүгнэвэл, хуульд заасны дагуу Засгийн газар холбогдох бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй буюу Монгол Улсад аялал жуулчлал хөгжүүлэх бүс нутгийг улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлоготой уялдуулан тогтоогоогүй, аялал жуулчлалын салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, зохистой харьцааг бий болгоогүй, харин Төрийн захиргааны төв байгууллага нь холбогдох бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй буюу бүртгэл хөтлөөгүй, хуульд заасны дагуу Жуулчны үйлчилгээний байгууллагад газар эзэмших зөвшөөрлийг олгож гэрээ байгуулахад баримтлах “тоо, байршил”-ийг Засаг дарга тогтоох ёстой боловч одоогоор практикт тогтоосон тоо, байршил байхгүй байна.

Иймд үндсэн чиглэлд туссан зорилтыг хангах хүрээнд хуульд заасан чиг үүргийг зайлшгүй хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авах хэрэгцээ шаардлага байна.

***1.2.Үнэлгээ хийх хүрээг тогтоох***

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.3.1 дэх заалтын дагуу үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ.

Үнэлгээ хийх хүрээг тогтоох нь аргачлалд заасны дагуу үнэлгээ хийх болсон шалтгаануудтай харилцан уялдаа, хамааралтайгаар хийгдэх ажиллагаа бөгөөд тодорхойлогдсон эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон хуулийн зохицуулалтыг илрүүлэх зорилготой бөгөөд үнэлгээ хийх хүрээг тогтоохдоо хуулийг бүхэлд нь, эсхүл түүний зүйл, хэсэг, заалтыг сонгож болох тул хуулийн зохицуулалтыг бүхэлд нь шалгах нь хүний нөөц, цаг хугацаа, санхүүгийн хувьд зардал өндөр гардагийг

харгалзан зөвхөн энэхүү хуулийн зорилго, үнэлгээний шалгуурт хамгийн ихээр нөлөөлж болохуйц хуулийн зохицуулалтыг зөв сонгох шаардлагатай гэж үзэн дараахь үнэлгээний хүрээг сонголоо.

Хүснэгт 1

| ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ | |
|---|---|
| **Д/д** | **Үнэлгээний хүрээ** |
| 1 | ✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг:<br>Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аялал жуулчлалыг хөхүүлэн дэмжих, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх, жуулчины үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино. |
| 2 | Аялал жуулчлалын тухай хуулийн 3 дугаар зүйл- Хуулийн нэр томьёо:<br>✓ 3.1.1 дэх заалт:<br>"аялал жуулчлал" гэж хувь хүн өөрийн байнга оршин суудаг газар нутгаасаа нэгээс 183 хүртэлх хоногийн хугацаагаар амралт, сувилал, танин мэдэхүйн зорилгоор болон шашин шүтлэг, ажил мэргэжлийн шугамаар өөр газар нутагт аялан явахыг;<br>✓ 3.1.5 дахь заалт:<br>"жуулчин" гэж аялал жуулчлал хийж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;<br>✓ 3.1.6 дахь заалт:<br>"жуулчины үйлчилгээний байгууллага" гэж зочид буудал, жуулчины бааз, зоогийн газар, амралт сувилал, тээвэр, холбоо, үзвэрийн **<u>зэрэг</u>** үйлчилгээг жуулчинд үзүүлж байгаа байгууллагыг;<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 4 дүгээр зүйл:<br>“Аялал жуулчлалын байгууллага, түүний ангилал”,<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 8 дугаар зүйл:<br>“Аялал жуулчлалын байгууллагын бүрэн эрх”,<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 12 дугаар зүйл:<br>“хөтөч-тайлбарлагчид тавих шаардлага”,<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 13 дугаар зүйл:<br>“Хөтөч-тайлбарлагчийн эрх, үүрэг” |
| 3 | ✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.6:<br>“аялал жуулчлалын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд энэ хуульд заасан захиргааны шийтгэл ногдуулах”,<br>✓ 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг:<br>“Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” |
| 4 | ✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 11 дүгээр зүйл:<br>“Аялал жуулчлалыг төрөөс хөхүүлэн дэмжих”<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 14 дүгээр зүйл:<br>“Аялал жуулчлалын талаархи Засгийн газрын бүрэн эрх”<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 16 дугаар зүйл:<br>“Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх” |

| | |
|---|---|
| | ✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйл:<br>“Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх |

### *1.3.Шалгуур үзүүлэлтийг тогтоох*

Аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлт бүр хуулийн хэрэгжилтийн бодит байдлыг тодорхойлоход чиглэсэн байдаг бөгөөд дээр дурдсан үнэлгээний хүрээн дэх зохицуулалтын хэрэгжилтийг шалгаж чадах, тэдгээрийг хэмжих боломжтой байх шаардлагатай.

Иймд дээрх шаардлагад нийцүүлэн аргачлалын 3.4 дэх хэсэгт заасан 6 шалгуур үзүүлэлтээс аль нь оновчтой, бодитой, тухайн асуудлыг хэмжиж болох шалгуур үзүүлэлтийг дараахь байдлаар сонгож тогтоолоо:

Хүснэгт 2

| д/д | Шалгуур үзүүлэлт | Ойлголт, онцлог | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Зорилгод хүрсэн түвшин | Хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэх байдлыг тогтооно. | Ингэхдээ гол зорилгыг тодорхойлно. |
| 2 | Практикт нийцэж байгаа байдал | Хуулийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно. | Энэ шалгуур үзүүлэлтээр хуулийн зохицуулалтын ойлгомжтой байдал, түүнийг хэрэгжүүлэх боломж бололцоо практикт байгаа эсэхийг тооцно |
| 3 | Бусад үр дагавар | Урьдчилан тооцоогүй болон шинээр гарч болзошгүй ямар үр дагавар байж болохыг тодорхойлно. | Зорилгоос гадна тооцох аргагүй буюу сөрөг үр дагавар дагуулсан асуудал байгаа эсэхийг тогтооно. |

Түүнчлэн шалгуур үзүүлэлт болон үнэлгээний хүрээг тогтоох асуудал нь бие биенээсээ харилцан хамааралтай байдаг тул аргачлалд заасны дагуу нэг үе шатанд үндсэндээ нэг зэрэг явагддаг тул үнэлгээний хүрээнд тохирох шалгуур үзүүлэлтийг дараахь байдлаар тогтоолоо:

Хүснэгт 3

| ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ | | |
|---|---|---|
| **д/д** | **Үе шат** | |
| **1.1** | **Үнэлгээний хүрээ** | ✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг:<br>Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аялал жуулчлалыг хөхүүлэн дэмжих, аялал жуулчлалын |

| | | |
|---|---|---|
| | | үйл ажиллагаа эрхлэх, жуулчины үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино. |
| 1.2 | **Тогтоосон шалгуур үзүүлэлт** | Зорилгод хүрсэн түвшин |
| 2.1 | **Үнэлгээний хүрээ** | Аялал жуулчлалын тухай хуулийн 3 дугаар зүйл- Хуулийн нэр томьёо:<br>✓ 3.1.1 дэх заалт:<br>"аялал жуулчлал" гэж хувь хүн өөрийн байнга оршин суудаг газар нутгаасаа нэгээс 183 хүртэлх хоногийн хугацаагаар амралт, сувилал, танин мэдэхүйн зорилгоор болон шашин шүтлэг, ажил мэргэжлийн шугамаар өөр газар нутагт аялан явахыг;<br>✓ 3.1.5 дахь заалт:<br>"жуулчин" гэж аялал жуулчлал хийж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;<br>✓ 3.1.6 дахь заалт:<br>"жуулчины үйлчилгээний байгууллага" гэж зочид буудал, жуулчны бааз, зоогийн газар, амралт сувилал, тээвэр, холбоо, үзвэрийн **<u>зэрэг</u>** үйлчилгээг жуулчинд үзүүлж байгаа байгууллагыг;<br><br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 4 дүгээр зүйл:<br>“Аялал жуулчлалын байгууллага, түүний ангилал”,<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 8 дугаар зүйл:<br>“Аялал жуулчлалын байгууллагын бүрэн эрх”,<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 12 дугаар зүйл:<br>“хөтөч-тайлбарлагчид тавих шаардлага”,<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 13 дугаар зүйл:<br>“Хөтөч-тайлбарлагчийн эрх, үүрэг” |
| 2.2 | **Тогтоосон шалгуур үзүүлэлт** | Бусад үр дагавар буюу урьдчилан тооцоогүй болон шинээр гарч болзошгүй үр дагаврууд |
| 3.1 | **Үнэлгээний хүрээ** | ✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.6:<br>“аялал жуулчлалын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд энэ хуульд заасан захиргааны шийтгэл ногдуулах”,<br>✓ 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг:<br>“Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” |
| 3.2 | **Тогтоосон шалгуур үзүүлэлт** | Практикт нийцэж байгаа байдал |

| | | |
|---|---|---|
| 4.1 | **Үнэлгээний хүрээ** | ✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 11 дүгээр зүйл: “Аялал жуулчлалыг төрөөс хөхүүлэн дэмжих”<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 14 дүгээр зүйл: “Аялал жуулчлалын талаархи Засгийн газрын бүрэн эрх”<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 16 дугаар зүйл: “Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх”<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйл: “Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх |
| 4.2 | **Тогтоосон шалгуур үзүүлэлт** | Практикт нийцэж байгаа байдал |

### *1.4.Харьцуулах хэлбэрийг сонгох*

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.5.1-т заасны дагуу хууль хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход харьцуулах хэлбэрүүдийг ашиглах тул аргачлалын 3 дугаар зүйлийн 3.5.3-т заасан дөрвөн төрлийн харьцуулах хэлбэрээс дээр тогтоосон шалгуур үзүүлэлт бүрт тохируулж дараахь байдлаар сонголоо:

4.1.байх ёстой, одоо байгаа;
4.2.тохиолдол судлах.

Хүснэгт 4

| **ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ** | | |
|---|---|---|
| **д/д** | **Үе шат** | |
| **1.1** | **Үнэлгээний хүрээ** | ✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг:<br>Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аялал жуулчлалыг хөхүүлэн дэмжих, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх, жуулчины үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино. |
| **1.2** | **Тогтоосон шалгуур үзүүлэлт** | Зорилгод хүрсэн түвшин |
| **1.3** | **Харьцуулах хэлбэрийг сонгох** | Байх ёстой болон одоо байгаа:<br>хууль хэрэгжиж эхэлснээс хойш гарсан үр дагаврыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хуулийн зорилтын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтооно. |
| **2.1** | **Үнэлгээний хүрээ** | Аялал жуулчлалын тухай хуулийн 3 дугаар зүйл- Хуулийн нэр томьёо:<br>✓ 3.1.1 дэх заалт: |

| | | |
|---|---|---|
| | | "аялал жуулчлал" гэж хувь хүн өөрийн байнга оршин суудаг газар нутгаасаа нэгээс 183 хүртэлх хоногийн хугацаагаар амралт, сувилал, танин мэдэхүйн зорилгоор болон шашин шүтлэг, ажил мэргэжлийн шугамаар өөр газар нутагт аялан явахыг;<br>✓ 3.1.5 дахь заалт:<br>"жуулчин" гэж аялал жуулчлал хийж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;<br>✓ 3.1.6 дахь заалт:<br>"жуулчины үйлчилгээний байгууллага" гэж зочид буудал, жуулчины бааз, зоогийн газар, амралт сувилал, тээвэр, холбоо, үзвэрийн **<u>зэрэг</u>** үйлчилгээг жуулчинд үзүүлж байгаа байгууллагыг;<br><br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 4 дүгээр зүйл:<br>"Аялал жуулчлалын байгууллага, түүний ангилал",<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 8 дугаар зүйл:<br>"Аялал жуулчлалын байгууллагын бүрэн эрх",<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 12 дугаар зүйл:<br>"хөтөч-тайлбарлагчид тавих шаардлага",<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 13 дугаар зүйл:<br>"Хөтөч-тайлбарлагчийн эрх, үүрэг" |
| **2.2** | **Тогтоосон шалгуур үзүүлэлт** | Бусад үр дагавар буюу урьдчилан тооцоогүй болон шинээр гарч болзошгүй үр дагаврууд |
| **2.3** | **Харьцуулах хэлбэрийг сонгох** | Тохиолдол судлах:<br>- Үнэлгээний хүрээгээр тогтоосон хуулийн зохицуулалт нь ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд буюу бусад улсад, өөр орон нутагт хэрхэн хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийнэ. |
| **3.1** | **Үнэлгээний хүрээ** | ✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.6:<br>"аялал жуулчлалын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд энэ хуульд заасан захиргааны шийтгэл ногдуулах",<br>✓ 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг:<br>"Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ" |
| **3.2** | **Тогтоосон шалгуур үзүүлэлт** | Практикт нийцэж байгаа байдал |
| **3.3** | **Харьцуулах хэлбэрийг сонгох** | Байх ёстой болон одоо байгаа:<br>-хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагаврыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хуулиар тогтоосон шаардлага, норм зэргийг харьцуулах хэлбэрээр хуулийн энэхүү зохицуулалтын зорилгын |

| | | |
|---|---|---|
| | | хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтооно. |
| **4.1** | **Үнэлгээний хүрээ** | ✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 11 дүгээр зүйл: “Аялал жуулчлалыг төрөөс хөхүүлэн дэмжих” ✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 14 дүгээр зүйл: “Аялал жуулчлалын талаархи Засгийн газрын бүрэн эрх” ✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 16 дугаар зүйл: “Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх” ✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйл: “Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх |
| **4.2** | **Тогтоосон шалгуур үзүүлэлт** | Практикт нийцэж байгаа байдал |
| **4.3** | **Харьцуулах хэлбэрийг сонгох** | Тохиолдол судлах: - Үнэлгээний хүрээгээр тогтоосон хуулийн зохицуулалт нь ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд буюу бусад улсад, өөр орон нутагт хэрхэн хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийнэ. |

***1.5.Шалгуур үзүүлэлтийг томьёолох***

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.6.1-т заалтад заасны дагуу тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглалыг дэвшүүлж, эсхүл асуулт тавьж шалгуур үзүүлэлтийг дараахь байдлаар томьёоллоо:

Хүснэгт 5

| **ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ** | | |
|---|---|---|
| **д/д** | **Үе шат** | |
| **1.1** | **Үнэлгээний хүрээ** | ✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг: Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аялал жуулчлалыг хөхүүлэн дэмжих, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх, жуулчины үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хоорондх үүсэх харилцааг зохицуулахад оршино. |
| **1.2** | **Тогтоосон шалгуур үзүүлэлт** | Зорилгод хүрсэн түвшин |
| **1.3** | **Харьцуулах хэлбэрийг сонгох** | Байх ёстой болон одоо байгаа: хууль хэрэгжиж эхэлснээс хойш гарсан үр дагаврыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хуулийн зорилтын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтооно. |
| **1.4** | **Шалгуур үзүүлэлтийг томьёолох** | Аялал жуулчлалыг хөхүүлэн дэмжих, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх, жуулчины үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын |

| | | |
|---|---|---|
| | | хооронд үүсэх харилцааг зохицуулах хуулийн зорилтод хүрсэн эсэх |
| **2.1** | **Үнэлгээний хүрээ** | Аялал жуулчлалын тухай хуулийн 3 дугаар зүйл- Хуулийн нэр томьёо:<br>✓ 3.1.1 дэх заалт:<br>“аялал жуулчлал” гэж хувь хүн өөрийн байнга оршин суудаг газар нутгаасаа нэгээс 183 хүртэлх хоногийн хугацаагаар амралт, сувилал, танин мэдэхүйн зорилгоор болон шашин шүтлэг, ажил мэргэжлийн шугамаар өөр газар нутагт аялан явахыг;<br>✓ 3.1.5 дахь заалт:<br>“жуулчин” гэж аялал жуулчлал хийж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;<br>✓ 3.1.6 дахь заалт:<br>“жуулчины үйлчилгээний байгууллага” гэж зочид буудал, жуулчины бааз, зоогийн газар, амралт сувилал, тээвэр, холбоо, үзвэрийн **зэрэг** үйлчилгээг жуулчинд үзүүлж байгаа байгууллагыг;<br><br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 4 дүгээр зүйл:<br>“Аялал жуулчлалын байгууллага, түүний ангилал”,<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 8 дугаар зүйл:<br>“Аялал жуулчлалын байгууллагын бүрэн эрх”,<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 12 дугаар зүйл:<br>“хөтөч-тайлбарлагчид тавих шаардлага”,<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 13 дугаар зүйл:<br>“Хөтөч-тайлбарлагчийн эрх, үүрэг” |
| **2.2** | **Тогтоосон шалгуур үзүүлэлт** | Бусад үр дагавар буюу урьдчилан тооцоогүй болон шинээр гарч болзошгүй үр дагаврууд |
| **2.3** | **Харьцуулах хэлбэрийг сонгох** | Тохиолдол судлах:<br>- Үнэлгээний хүрээгээр тогтоосон хуулийн зохицуулалт нь ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд буюу бусад улсад, өөр орон нутагт хэрхэн хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийнэ. |
| **2.4** | **Шалгуур үзүүлэлтийг томьёолох** | Хууль тогтоогч урьдчилан тооцоогүй, шинээр гарч ирж болзошгүй үр дагавруудыг тодорхойлох |
| **3.1** | **Үнэлгээний хүрээ** | ✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.6:<br>“аялал жуулчлалын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд энэ хуульд заасан захиргааны шийтгэл ногдуулах”,<br>✓ 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг:<br>“Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” |

| | | |
|---|---|---|
| 3.2 | **Тогтоосон шалгуур үзүүлэлт** | Практикт нийцэж байгаа байдал |
| 3.3 | **Харьцуулах хэлбэрийг сонгох** | Байх ёстой болон одоо байгаа:<br>-хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагаврыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хуулиар тогтоосон шаардлага, норм зэргийг харьцуулах хэлбэрээр хуулийн энэхүү зохицуулалтын зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтооно. |
| 3.4 | **Шалгуур үзүүлэлтийг томьёолох** | Хуулийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, тийнхүү хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэлүүд байгаа эсэхийг тодорхойлох, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон эерэг болон сөрөг үр дагавруудыг тодорхойлох |
| 4.1 | **Үнэлгээний хүрээ** | ✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 11 дүгээр зүйл: “Аялал жуулчлалыг төрөөс хөхүүлэн дэмжих”<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 14 дүгээр зүйл: “Аялал жуулчлалын талаархи Засгийн газрын бүрэн эрх”<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 16 дугаар зүйл: “Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх”<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйл: “Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх |
| 4.2 | **Тогтоосон шалгуур үзүүлэлт** | Практикт нийцэж байгаа байдал |
| 4.3 | **Харьцуулах хэлбэрийг сонгох** | Тохиолдол судлах:<br>- Үнэлгээний хүрээгээр тогтоосон хуулийн зохицуулалт нь ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд буюу бусад улсад, өөр орон нутагт хэрхэн хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийнэ. |
| 4.4 | **Шалгуур үзүүлэлтийг томьёолох** | Хуулийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, тийнхүү хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэлүүд байгаа эсэхийг тодорхойлох, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон эерэг болон сөрөг үр дагавруудыг тодорхойлох |

### *1.6.Мэдээлэл цуглуулах аргыг сонгох*

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.7.3.1-т заасны дагуу мэдээллийг цуглуулахдаа хуулийг хэрэгжихэд гаргасан практик, тухайн сэдвээр гарсан ном, эмхэтгэл, илтгэл, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эх сурвалжийг ашиглана.

Өмнөх үе шатанд тулгуурлан мэдээлэл цуглуулах аргыг дараахь хүснэгтэд заасны дагуу сонголоо:

Хүснэгт 6

| ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ | | |
|---|---|---|
| **д/д** | **Үе шат** | |
| **1.1** | **Үнэлгээний хүрээ** | ✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг:<br>Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аялал жуулчлалыг хөхүүлэн дэмжих, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх, жуулчины үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино. |
| **1.2** | **Тогтоосон шалгуур үзүүлэлт** | Зорилгод хүрсэн түвшин |
| **1.3** | **Харьцуулах хэлбэрийг сонгох** | Байх ёстой болон одоо байгаа:<br>хууль хэрэгжиж эхэлснээс хойш гарсан үр дагаврыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хуулийн зорилтын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтооно. |
| **1.4** | **Шалгуур үзүүлэлтийг томьёолох** | Аялал жуулчлалыг хөхүүлэн дэмжих, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх, жуулчины үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулах хуулийн зорилтод хүрсэн эсэх |
| **1.5** | **Мэдээлэл цуглуулах арга** | Энэ чиглэлээр гарсан ном, эмхэтгэл, илтгэл, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн болон олон улсын эх сурвалжийг ашиглана. |
| **2.1** | **Үнэлгээний хүрээ** | Аялал жуулчлалын тухай хуулийн 3 дугаар зүйл- Хуулийн нэр томьёо:<br>✓ 3.1.1 дэх заалт:<br>“аялал жуулчлал” гэж хувь хүн өөрийн байнга оршин суудаг газар нутгаасаа нэгээс 183 хүртэлх хоногийн хугацаагаар амралт, сувилал, танин мэдэхүйн зорилгоор болон шашин шүтлэг, ажил мэргэжлийн шугамаар өөр газар нутагт аялан явахыг;<br>✓ 3.1.5 дахь заалт:<br>“жуулчин” гэж аялал жуулчлал хийж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;<br>✓ 3.1.6 дахь заалт:<br>“жуулчины үйлчилгээний байгууллага” гэж зочид буудал, жуулчины бааз, зоогийн газар, амралт сувилал, тээвэр, холбоо, үзвэрийн **<u>зэрэг</u>** үйлчилгээг жуулчинд үзүүлж байгаа байгууллагыг;<br><br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 4 дүгээр зүйл:<br>“Аялал жуулчлалын байгууллага, түүний ангилал”,<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 8 дугаар зүйл: |

| | | |
|---|---|---|
| | | "Аялал жуулчлалын байгууллагын бүрэн эрх",<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 12 дугаар зүйл: "хөтөч-тайлбарлагчид тавих шаардлага",<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 13 дугаар зүйл: "Хөтөч-тайлбарлагчийн эрх, үүрэг" |
| **2.2** | **Тогтоосон шалгуур үзүүлэлт** | Бусад үр дагавар буюу урьдчилан тооцоогүй болон шинээр гарч болзошгүй үр дагаврууд |
| **2.3** | **Харьцуулах хэлбэрийг сонгох** | Тохиолдол судлах:<br>- Үнэлгээний хүрээгээр тогтоосон хуулийн зохицуулалт нь ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд буюу бусад улсад, өөр орон нутагт хэрхэн хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийнэ. |
| **2.4** | **Шалгуур үзүүлэлтийг томьёолох** | Хууль тогтоогч урьдчилан тооцоогүй, шинээр гарч ирж болзошгүй үр дагавруудыг тодорхойлох |
| **2.5** | **Мэдээлэл цуглуулах арга** | Энэ чиглэлээр  гарсан ном, эмхэтгэл, илтгэл, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн болон олон улсын эх сурвалжийг ашиглана. |
| **3.1** | **Үнэлгээний хүрээ** | ✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.6:<br>"аялал жуулчлалын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд энэ хуульд заасан захиргааны шийтгэл ногдуулах",<br>✓ 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг:<br>"Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ" |
| **3.2** | **Тогтоосон шалгуур үзүүлэлт** | Практикт нийцэж байгаа байдал |
| **3.3** | **Харьцуулах хэлбэрийг сонгох** | Байх ёстой болон одоо байгаа:<br>-хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагаврыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хуулиар тогтоосон шаардлага, норм зэргийг харьцуулах хэлбэрээр хуулийн энэхүү зохицуулалтын зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтооно. |
| **3.4** | **Шалгуур үзүүлэлтийг томьёолох** | Хуулийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, тийнхүү хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэлүүд байгаа эсэхийг тодорхойлох, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон эерэг болон сөрөг үр дагавруудыг тодорхойлох |
| **3.5** | **Мэдээлэл цуглуулах арга** | Энэ чиглэлээр  гарсан ном, эмхэтгэл, илтгэл, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн болон олон улсын эх сурвалжийг ашиглана. |
| **4.1** | **Үнэлгээний хүрээ** | ✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 11 дүгээр зүйл: "Аялал жуулчлалыг төрөөс хөхүүлэн дэмжих"<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 14 дүгээр зүйл: |

| | | |
|---|---|---|
| | | “Аялал жуулчлалын талаархи Засгийн газрын бүрэн эрх”<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 16 дугаар зүйл:<br>“Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх”<br>✓ Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйл:<br>“Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх |
| **4.2** | **Тогтоосон шалгуур үзүүлэлт** | Практикт нийцэж байгаа байдал |
| **4.3** | **Харьцуулах хэлбэрийг сонгох** | Тохиолдол судлах:<br>- Үнэлгээний хүрээгээр тогтоосон хуулийн зохицуулалт нь ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд буюу бусад улсад, өөр орон нутагт хэрхэн хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийнэ. |
| **4.4** | **Шалгуур үзүүлэлтийг томьёолох** | Хуулийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, тийнхүү хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэлүүд байгаа эсэхийг тодорхойлох, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон эерэг болон сөрөг үр дагавруудыг тодорхойлох |
| **4.5** | **Мэдээлэл цуглуулах арга** | Энэ чиглэлээр гарсан ном, эмхэтгэл, илтгэл, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн болон олон улсын эх сурвалжийг ашиглана. |

## 2.ХЭРЭГЖИЛТИЙН ҮЕ ШАТ

Хэрэгжилтийн үе шатны гол зорилго нь хэрэгцээтэй, шаардлагатай байгаа, ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулах ажиллагааг үнэлгээ хийж буй субьект буюу багийн тусламжтайгаар бодит ажил болгон гардаж хийх юм.

Энэ үе шатанд богино хугацаанд, бага зардлаар, үнэлгээнд хэрэгтэй мэдээлэл авах үндсэн зарчмаа баримтлан төлөвлөлтийн үе шатанд сонгосон мэдээлэл цуглуулах арга болон энэ үе шатанд анхаарах асуудлын үндсэн дээр доорх хүснэгтэд дурдсаны дагуу мэдээлэл цуглуулах ажиллагааг хийлээ.

Хүснэгт 7

| ХЭРЭГЖИЛТИЙН ҮЕ ШАТ |
|---|
| Өмнө нь мэдээлэл цуглуулах аргыг сонгосон байгаа бөгөөд энэ үе шатанд тэдгээр /асуудлыг зохицуулж буй хуулийг судлах, холбогдох байгууллагын мэдээ, тайланг харах, холбогдох судалгааг ашиглах, бусад хэм хэмжээг судлах/ аргын тусламжтайгаар мэдээллээ цуглуулах, судалгаа явуулах ажлаа бодитойгоор хэрэгжүүлнэ.<br>Олон улсын аялал жуулчлалын хөгжлийн чиг хандлага, үүнтэй холбоотой асуудалд гол анхаарлаа төвлөрүүлнэ. |

## 3.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх үе шат нь үнэлгээний ажлыг эцэслэн, тайлан бичих, үнэлгээний үр дүнгээ нэгтгэн, зөвлөмж боловсруулах ажил хийхэд чиглэгдэнэ. Өөрөөр хэлбэл, үнэлэх үе шат нь хэрэгжилтийн үе шатны дүн шинжилгээнд тулгуурлах бөгөөд үнэлгээ хийгдэж буй тухайн зохицуулалтын харьцуулсан үнэлгээгээс бүрдэнэ.

Энэ үе шатанд мэдээллийг цуглуулж, хооронд харьцуулан дүгнэлт хийхдээ тухайн мэдээллийг агуулгын хувьд дүн шинжилгээ хийлээ.

Хүснэгт 8

| д/д | ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ | |
|---|---|---|
| 1.1 | **Үнэлгээний хүрээ** | **Хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг:** Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аялал жуулчлалыг хөхүүлэн дэмжих, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх, жуулчины үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино. |
| 1.2 | **Тогтоосон шалгуур үзүүлэлт** | Зорилгод хүрсэн түвшин |
| 1.3 | **Сонгосон харьцуулах хэлбэр** | Байх ёстой болон одоо байгаа: хууль хэрэгжиж эхэлснээс хойш гарсан үр дагаврыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хуулийн зорилтын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтооно. |
| 1.4 | **Томьёолсон шалгуур үзүүлэлт** | Аялал жуулчлалыг хөхүүлэн дэмжих, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх, жуулчины үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулах хуулийн зорилтод хүрсэн эсэх |
| 1.5 | **Мэдээлэл цуглуулах арга** | Энэ чиглэлээр гарсан ном, эмхэтгэл, илтгэл, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн болон олон улсын эх сурвалжийг ашиглана. |

**1.6.Үнэлсэн байдал**

Аялал жуулчлалын тухай хууль нь 2000 онд батлагдсанаас хойш 22 жил хэрэгжиж байгаа хэдий ч хуулийг хэрэгжүүлэх явцад түүний зохицуулалт нь хуулийн зорилтыг бүрэн хангах боломжгүй, нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцорсон, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг бүрэн хамарч чадаагүйгээс гадна үүнээс шалтгаалсан сөрөг үр дагавар үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг байна.

Тодруулбал, уг хууль нь манай нутаг дэвсгэр дээр аялал жуулчлалыг хөхүүлэн дэмжих, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх, жуулчины үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулах үндсэн зорилготой.

Гэтэл Монгол Улс нь 1990 онд НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын

байгууллагад нэгдэн орж, гишүүн орон болсон. Тус байгууллагаас гаргасан Аялал жуулчлалын конвенцид зааснаас харахад “аялал жуулчлал” гэдэг маш өргөн хүрээнд байхаар зааснаас гадна тус байгууллагаас хийсэн судалгаагаар “дэлхий даяар 2019 онд аялах жуулчдын тоо 1995 онтой харьцуулахад 3 дахин нэмэгдэж 1,6 тэрбумд хүрсэн бөгөөд Ази, Номхон далайн бүс нутагт аялах жуулчдын тоо дэлхийн бусад бүсүүдээс илүү хурдацтай нэмэгдэх”-ийг тогтоожээ.

Түүнчлэн “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн зорилгыг аялал жуулчлалын салбарын хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж, тогтвортой хөгжлийг ханган тус салбарын олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэнэ гэж тодорхойлж, “МУ-ын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4-т Аялал жуулчлалын салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд “Аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг бүс нутгийн хэмжээнд дээшлүүлж, эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ” гэж тусгахдаа 4.4.1-т “Аялал жуулчлалыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэх, бүтээгдэхүүн, дэд бүтцийг хөгжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах цогц бодлого хэрэгжүүлнэ”, 4.4.2-т “Үндэсний зан заншил, уламжлал, түүх, соёл, унаган байгаль, нүүдэлчин ахуйг түшиглэсэн аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, нийслэл, аймаг, бүс нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалын дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ”, 4.4.3-т “ “Бурхан халдун”, “Хорго-Тэрх”, “Хамарын хийд”, “Отгонтэнгэр”, “Хар-Ус”, “Хөвсгөл”, “Хархорин” зэрэг байгалийн үзэсгэлэнт, өвөрмөц тогтоц бүхий газар нутгийг түшиглэсэн түүхэн болон төрөлжсөн аялал жуучлалын төв, цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын хөрөнгө оруулалтаар байгуулахыг бодлогоор дэмжинэ” гэх зэрэг хэд хэдэн зорилтыг дэвшүүлээд байсан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын[40] 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдэдийн 3 дахь хэсэгт “*Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвар дээшилсэн байна.*” хэмээн заасан бол зорилт 8.2-т “Эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх”-ээр зааж, энэхүү зорилтыг хэрэгжүүлэх I үе шат(2021-2030)-ын 1 дэх хэсэгт “*Байгаль экологи, археологи, палеонтологи, нүүдлийн өв, түүх, соёл, рекреацийн нөөц, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлнэ.*”, II үе шат(2031-2040)-ын 1 дэх хэсэгт “Аялал жуулчлалын салбарт орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх замаар хүртээмж, орлогыг нэмэгдүүлсэн байх”-аар тус тус заасан буюу эдийн засгийг сэргээх үндсэн хөшүүргийн нэгээр аялал жуулчлалын салбарыг онцолж, тэдгээрийг биелүүлэх тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн.

Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх

[40] Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол

!"#"$%&"'""''()$%*++#++',-%-"$/''()$%-01$,,#',-%-23(&%12)'()$%4,$%,'5,'$2)%
6 ()578#'8-%2&5!8&%19#('$9%*2-()%: 9&$9'%; '!<&%=-%>+#'<&%?@?A%9&<%A@B%5+$,,#%
C9$C99'<&[!]"%&8$52$88#%-,7!#,'C,,#%*,C',$5!,&%DE (&8%!8#$8'C()&%*95'9$9FG<&%
H99IC<&% !8#$8'C()&% AJK% 5,-L% -8!8$C% D: 9&$9'%; '!<&% ,$,,#<&% 1,)&% 19-(9&%
*,)$++','C.%,$,,#<&%1,I<&%,6 ($','C<$%!,)/#++',&%5,I/ (&%"&$"#"-%,$,,#<&%
-"'$()&% C99$% &8I8$522'/ %,$,,#<&% C887#()&%'(*M#,'3','<$% 2M% 6 ,CC,)$,,#%
2#$8'/'22'8-%1,I,,#%,3,,%C887#()&%1,&$(',,%C"7()$%*()%*9'$9/ %I"&%,0','%
/++'3','<&% !,'*,#<$% 58I/ (&8JF% I"&% C9$C99'<&% -9N#5+$,,#% -,7!#,'C,,#%
*,C',$5!,&%CE (&8% !8#$8'C()&%*95'9$POG<$%-8#8$/22'8-%8-&()%2M%6 ,C&<%2)'%
,/('',$,,&<%-"C"'*"#FG()&%AJKJAG5 "Q$,,#<&%1,I<&%*,)&$<&%,/('',$,,C,)%9'9&%
+'!<&%*99IC<&%C99$%&8I8$522'/ %R,#$9%C8878#%,0','%/++'3','<$%-"$/22'8-",
AJSJ?CC "T,#(I%*99IC<$%C26 ($'8&%-('%9#3I<&%,0','%/++'3','<$%-"$/22'8-",
"T+#$,,&% *99IC<$% ,0','% /++'3','<&% *99IC% *9'$9&% -"$/22'/ % *99IC<&%
18#8$'8'()$%&8I8$522'!8&%*,)&,J", ?JAJ?CC "U9)*,'!,&$()&%5+',,&<%4,-('$,,&%
!C,&4<&%-23(&%3,5'<$%V@%: WCG,,#%"#$"C$"/ %122&%*2!()&%++'%++#-,)%,0','%
/++'3','<&%C"!'225()&%8#3(I%-23&()%-8#8$'88$%-,&$,-", "T22&%*2!()&%"!"&%
&8I8$58/%*,)$,,%4,-('$,,&% 8#3(I% -23&()% -8#8$'88% *,%X9#&95 %Y2-*,,C,#%
,)I$()&%!+I %!++#(&%$,1,# %++'%++#-,)&%9#5<&%*,0/++',-%9'*9#'9-%2)'578#225 %
,0','% /++'3','<&% 49$49'*9#++5<$% C,!#,'C$2) % &,)57,#C,)% 8#3(I% -2388#%
-,&$,!,&%*,)&,J" $8/%C+!%C+!%1,,!,&%*"$""5%4,#%C,-',,!%2258'C8)%85()&%1,!$()&%
-2&5#8'()$%5,7,&%C++',-%2&5!8&%,#$,%-8#8$!'()&%&8$%&L%,0','%/++'3','<$%
!,'*,#<$%58I/(-%*,)&,J%%
%
% >++'()&% 19#('C99!%-,#,-,5% -++'L% -8#8$/!8&88#%: 9&$9'%; '!<&%&+C,$%
587!$8#% 588#% ,0','%/++'3','<$% -"-22'8&% 58I/ (/ % ,0','%/++'3','<&%2)'%
,/('',$,,%8#-'8-%/++'3(&<%2)'3('$88%2122'8-C8)%-9'*9$5++',&%C"#%(#$8&%,/%
,-+)&%&8$/ %*,)$++'',$<&%-99#9&5%22!8-%-,#('4,,$%19-(4++',-%N!C9)%*9' %*+!,5%
*95'9$<&%*,#(IC%*(3$88!%-,#,-,5%8&8%-++'(,#%5876 22'!8&%19#('C<&%-2#88&5%*+!%
-,#(&%('22%"#$"&%-2#88&5%,0','%/++'3','<&%!,'*,#<$%-"$/22'8-%4,,6',,5%
!,'*,#<&%-"$/''()&%C+'$,I5!,&%,!++5'++5<$%6 ()578#'8/ %C9$C79#C9)%-"$/''()$%
-,&$,&%C+!%!,'*,#<&%9'9&%+'!,5%"#!"'5"-%3,57,#<$%5886 '22'8-85%3($'8/%*,)$,,%
&L%C959#-9)%*,)&,J%%%
%
% Z8$78'%,&-%8&8-22%-++'()$%*,C',&%$,#$,!,&%6 ,'C$,,& %588#-%19#('C<$%
5876 22'!8&% 2&58!'8' % 6 ,,#5',$<$% C95#++',-,,#% ?@@?% 9&<% -++'()&% 218'%
*,#(IC','%19&(#-79'[!#]%[%
%
% G%%D: 9&$9'%+'!,5%,0','%/++'3','<$%-"$/22'8-%C,',,#%A\\VG?@@V%9&5%
*,#(IC',-%2&5!8&%3($'8'FG5%$,5,,5 %59C995<&% ,0','%/++'3','<$%C+!%9#&<%
-"$/''()&%C8#$22'8-%!,'*,#<&%-8I/88&5%-2#$8/ %85()&%1,!$()&%C9$C79#C9)%218'%
*,#(IC','5%&()422'8&%"&5"#%2#%,6 ($C,) %8R!]9#C<&%3($'8'()&%*(M%5,,!,&%

[41] Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол.
[42] ХЗДХЯ-ГТХАН хамтарсан төслөөс гаргасан "Иргэн, эдийн засгийн хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлын тайлан/Аялал жуулчлалын тухай хууль/, 2017 он

салбар болгон хөгжүүлэхээр, мөн аялал жуулчлалын бизнес эрхлэгчдийн анхдугаар зөвлөгөөнд оролцогчид Монгол Улсын Их Хурал, Засгийн Газарт хандаж гаргасан илгээлтдээ “Аялал жуулчлалын тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцэж батлах, аялал жуулчлалыг үйлдвэрлэл болгон хөгжүүлэх төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхийн тулд Үндэсний аялал жуулчлалын байгууллагыг Засгийн газрын дэргэд байгуулах” зэрэг шаардлага тавьжээ.

- 1998 оны 6 дугаар сард Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих олон улсын чуулга уулзалт Улаанбаатар хотноо болох зэрэг гадаад, дотоод нөхцөл байдал нь Монгол улсад аялал жуулчлалыг хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг төрийн бодлогод нийцүүлэн хуулийн хэмжээнд зохицуулах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүргэж байна гэжээ.

- Дэлхийн жуулчины байгууллагаас гаргасан мэдээгээр 1996 онд манай гарагийн нийт хүн амын 592 сая хүн аялалд хамрагдаж жуулчины үйлдвэрлэлийн орлого 423 млрд.ам.долларт хүрчээ. 2000 онд 702 сая хүн, 2020 он гэхэд 1.6 млрд. хүн аялах тооцоо гаргасан ажээ. Тус байгууллагын судалгаагаар аялал жуулчлалын үйлдвэрлэлд 255 сая хүн ажиллаж байгаа бөгөөд ирэх 10 жилд шинээр 130 сая ажлын байр бий болгох юм байна.

Дээрхи тооцоо, олон улсын хөгжлийн нааштай чиг хандлагыг харгалзан Монголд аялал жуулчлалыг нэгдсэн бодлого, зорилготой хөгжүүлэх асуудал зүй ёсоор тавигдаж байна гэж тэмдэглэжээ.

-Харин хуулийн төслийн зарчим, агуулгын хувьд “Аялал жуулчлалыг экологийн баримжаатай, улс орны эдийн засгийн бие даасан, тэргүүлэх салбарын хэмжээнд хүргэж хөгжүүлэх, аялал жуулчлал эрхэлж буй мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааны онцлогийг харгалзан тэдгээрийн хэлбэрийг хуульчлан тогтоох, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, бүртгэх системийг боловсронгуй болгох, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүтэц, тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, аялал жуулчлалын салбарыг дэмжих санхүү, эрх зүйн хэм хэмжээний шинэ механизм бий болгох үзэл баримтлалд тулгуурлаж боловсруулав” гэжээ.

Харин 2017 оны 10 дугаар сарын байдлаар 425506 жуулчин Монгол Улс хүлээн авсан бол, үүнийг 2016 оны мөн үетэй харьцуулбал 70118 жуулчнаар илүү буюу 16,48%-аар өссөн байна.[43] Цар тахлын нөлөөгөөр 2020 онд Ази, номхон далайн бүс нутгийн орнуудын аялал жуулчлалын салбарын орлого 1.6 их наяд ам.доллар ба 53.7%-иар буурч, салбарын ажиллах хүчний тоо 34.1 сая хүн ба 18.4%-иар буурсан байна.[44] Энэхүү нөлөө Монгол Улсад ч хүндээр тусч байгаа

[43] Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2017 оны эхний 10 сарын жуулчдын мэдээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулсан мэдээ, 2017 он

[44] Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Аялал жуулчлалын хөгжлийн төв, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим, Аялал жуулчлалын боловсрол, Хөгжлийн нийгэмлэг, “Аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчдэд үзүүлж буй цар тахлын нөлөө”, 2022.

бөгөөд 2018 онд 529 мянган гадаад жуулчин хүлээн авч дотоодын эдийн засагт 596 сая ам.доллар буюу 1.5 их наяд төгрөгийн орлогыг төвлөрүүлж байсан хэдий цар тахлын нөлөөгөөр 2021 оны I-V сарууддад 8,554 жуулчин хүлээн авсан бөгөөд 6,330,573 ам.долларын орлого олсон бол 2022 оны I-V сарууддад 42,060 жуулчин хүлээн авч, түүнээс 37,925,168 ам.долларын [45] орлого тус тус олжээ.

Дээрх мэдээллийг 2005 онд манай улсын хилээр нэвтэрсэн зорчигчдын судалгаатай харьцуулбал 344635 гадаадын зорчигчид ирсэнтэй харьцуулахад 80,871 жуулчин байна.[46] Өөрөөр хэлбэл, сүүлийн 12 жилийн хугацаанд манай улсад аялсан жуулчдын өсөлтийг харвал, жилдээ манай улсад аялдаг жуулчдын тоо 2005 онтой харьцуулахад 16-19 орчим хувиар өссөн байна.

Хэдийгээр манай улсад ирэх жуулчдын тоо өссөн нь сайшаалтай боловч 2017 он байдлаар дэлхий дээрх нийт ажилчдын 8% нь аялал жуулчлалын салбарт ажилладаг, дэлхийн үйлдвэрлэлийн 11%-г аялал жуулчлалын салбар дангаар бүрдүүлдэг [47] гэсэн судалгааны дүнтэй харьцуулахад дээрх хуулийн зорилт, бусад бодлогын баримт бичиг зэрэгт туссан зорилтод хүрч чадахгүй байгаа нь харагдаж байна. Монгол улс 2019 онд хамгийн их буюу 577 мянган гадаадын жуулчин хүлээн авч, аялал жуулчлалын салбар эдийн засагт 607 сая ам.долларын орлого оруулж, 88 мянган ажлын байр бий болгосон. 2019 оны байдлаар улсын хэмжээнд бүртгэлтэй 570 гаруй тур оператор компани, 460 зочид буудал, 400 гаруй жуулчны бааз үйл ажиллагаа явуулж байгаагаас тур оператор компануудын 80 хувь нь инбаунд зах зээл дээр ажилладаг буюу гадаадаас Монгол улс руу жуулчин хүлээж авах, үйлчлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг байна.[48]

Үүнээс гадна Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас гаргасан судалгаанд жуулчдын урсгал Ази, номхон далайн бус нутаг луу чиглэнэ гэсэн таамаглал дэвшүүлсэн[49] бөгөөд бодлогын баримт бичгүүдэд туссан манай улсад аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, цаашлаад салбарын хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж, тогтвортой хөгжлийг ханган тус салбарын олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэж байгаа нь зорилтыг хангахын тулд хуулийн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэх шаардлага зайлшгүй гарч байна.

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас 2019 онд гаргасан Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын индексээр манай улс нийт 140 орноос 93 дугаарт жагссан бөгөөд ийнхүү хойно жагсах болсон үндсэн шалтгаан нь байгаль орчны тогтвортой байдал, агаарын тээврийн дэд бүтэц, газрын дэд бүтэц, жуулчны

---

[45] Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2022 оны эхний тавдугаар сарын жуулчдын мэдээг 2021 оны мөн үетэй харьцуулсан мэдээ.
[46] "Аялал жуулчлалын салбарт төрөөс гүйцэтгэх үүргийг оновчтой болгох нь" Илтгэл, Э.Энхзаяа, 2017 он
[47] "Аялал жуулчлалын салбарт төрөөс гүйцэтгэх үүргийг оновчтой болгох нь" Илтгэл, Э.Энхзаяа, 2017 он.
[48] Аялал жуулчлалын хөгжлийн төвийн 2020 оны тоон мэдээ.
[49] www.unwto.org

<table>
<tr><td colspan="3">үйлчилгээний дэд бүтэц, олон улсад нээлттэй байдал зэрэг үзүүлэлтүүд муу байсантай холбоотой байна. Эдгээр нь үнэлэгдэж буй хэсэг болох хуулийн зорилт хангалтгүй хэрэгжсэний нэгэн илрэл гэж үзэж болох юм.<br><br>Иймээс Аялал жуулчлалын тухай хуулийн зорилтыг илүү боловсронгуй болгож, зохицуулалтын утга, агуулга, хуульд хэрэглэсэн нэр томьёог тодорхой, ойлгомжтой тодорхойлох шаардлагатайгаас гадна олон улсын жишигт нийцүүлэх зүйтэй бөгөөд цаашид уг хуулиар зохицуулсан харилцаанд сөрөг үр дагавар үүсгэх эрсдэлийг бууруулах шаардлагатай гэж үзэж байна.</td></tr>
<tr><td>2.1</td><td>Үнэлгээний хүрээ</td><td>Хуулийн 3 дугаар зүйл- Хуулийн нэр томьёо:<br>✓ 3.1.1 дэх заалт:<br>"аялал жуулчлал" гэж хувь хүн өөрийн байнга оршин суудаг газар нутгаасаа нэгээс 183 хүртэлх хоногийн хугацаагаар амралт, сувилал, танин мэдэхүйн зорилгоор болон шашин шүтлэг, ажил мэргэжлийн шугамаар өөр газар нутагт аялан явахыг;<br>✓ 3.1.5 дахь заалт:<br>"жуулчин" гэж аялал жуулчлал хийж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;<br>✓ 3.1.6 дахь заалт:<br>"жуулчны үйлчилгээний байгууллага" гэж зочид буудал, жуулчны бааз, зоогийн газар, амралт сувилал, тээвэр, холбоо, үзвэрийн зэрэг үйлчилгээг жуулчинд үзүүлж байгаа байгууллагыг;<br><br>Хуулийн 4 дүгээр зүйл:<br>“Аялал жуулчлалын байгууллага, түүний ангилал”,<br>Хуулийн 8 дугаар зүйл:<br>“Аялал жуулчлалын байгууллагын бүрэн эрх”,<br>Хуулийн 12 дугаар зүйл:<br>“хөтөч-тайлбарлагчид тавих шаардлага”,<br>Хуулийн 13 дугаар зүйл:<br>“Хөтөч-тайлбарлагчийн эрх, үүрэг”</td></tr>
<tr><td>2.2</td><td>Тогтоосон шалгуур үзүүлэлт</td><td>Бусад үр дагавар</td></tr>
<tr><td>2.3</td><td>Сонгосон харьцуулалтын хэлбэр</td><td>Тохиолдол судлах:<br>- Үнэлгээний хүрээгээр тогтоосон хуулийн зохицуулалт нь ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд буюу бусад улсад, өөр орон нутагт хэрхэн хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийнэ.</td></tr>
<tr><td>2.4</td><td>Томьёолсон шалгуур үзүүлэлт</td><td>Хууль тогтоогч урьдчилан тооцоогүй, шинээр гарч ирж болзошгүй үр дагавруудыг тодорхойлох</td></tr>
<tr><td>2.5</td><td>Мэдээлэл</td><td>Энэ чиглэлээр гарсан ном, эмхэтгэл, илтгэл, судалгааны</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | **цуглуулах арга** | тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн болон олон улсын эх сурвалжийг ашиглана. |
| **2.6.Үнэлсэн байдал** | | |

Аялал жуулчлалын тухай хуулийг хэрэгжүүлэх явцад тодорхой байх шаардлагатай хуулийн нэр томьёо, аялал жуулчлалын байгууллага, түүний ангилал, үйл ажиллагаа, эрх хэмжээ, хөтөч-тайлбарлагчид тавих шаардлага, түүний эрх, үүрэг зэрэг зохицуулах олон асуудлыг хуульд тусгасан хэдий ч эдгээр нь бодит байдалтай нийцдэггүй, тухайн харилцааг хангалттай зохицуулах боломжгүй, олон улсын жишигт нийцдэггүй зэрэг дутагдалтай байна.

Жишээлбэл, “Аялал жуулчлалын байгууллага”-ын хувьд зэрэглэл гэж байхгүй, харин ангилалтай байх бөгөөд ангилалаа эрх бүхий байгууллагаар тогтоолгохоор хуульд зохицуулснаас гадна “жуулчины үйлчилгээний байгууллага” гэх зэрэг ойлгомжгүй ойлголт хуульд туссан байх жишээтэй.

Гэтэл МУ-ын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.1-т “Аялал жуулчлалыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэх, бүтээгдэхүүн, дэд бүтцийг хөгжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах цогц бодлого хэрэгжүүлнэ” гэх зорилтыг дэвшүүлснээс гадна Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас гаргасан “Аялал жуулчлал-2020 он” судалгаанд “XXI зуунд аялал жуулчлалын төрлүүдээс Адал явдалт аялал жуулчлал, Эко аялал жуулчлал, Тусгай сонирхлын аялал жуулчлал, Тойрон аялал, Соёл-танин мэдэхүйн аялал жуулчлал, Хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, яармагийн аялал жуулчлал, Эрүүл мэндийн аялал жуулчлалын төрлүүд эрчимтэй хөгжиж байна” гэж дурджээ.

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын “Аялал жуулчлалын конвенц”-ийн 1 дүгээр зүйлийн b-д “аялал жуулчлал” гэж жуулчин, аялагч, аялал зохион байгуулагчийн зэрэг аль алийг хамарсан зочлох үйл ажиллагаа гэх ерөнхий агуулгаар ойлгохоор тусгажээ.[50] Гэтэл хуульд "аялал жуулчлал гэж хувь хүн өөрийн байнга оршин суудаг газар нутгаасаа нэгээс 183 хүртэлх хоногийн хугацаагаар амралт, сувилал, танин мэдэхүйн зорилгоор болон шашин шүтлэг, ажил мэргэжлийн шугамаар өөр газар нутагт аялан явахыг” ойлгохоор тусгасан нь өдрөөс өдөрт хөгжиж, бүтээгдэхүүний төрөл нь нэмэгдэж буй аялал жуулчлал гэх олон улсын жишиг ойлголтын хүрээг нилээн хязгаарласан байна.

Аялал жуулчлалын тухай хуульд “жуулчин” гэх ойлголтыг тусгасан бол Аялал жуулчлалын конвенцид жуулчин(tourist), аялагч(excursionist) гэсэн 2 ойлголтыг тусгасан байгаагаас үзэхэд мөн эдгээр нэр томьёог ч хуульд ойлгомжтой тусгах шаардлагатай.

Аялал жуулчлалын тухай хуульд "жуулчины үйлчилгээний байгууллага гэж зочид буудал, жуулчины бааз, зоогийн газар, амралт сувилал, тээвэр, холбоо, үзвэрийн **<u>зэрэг</u>** үйлчилгээг жуулчинд үзүүлж байгаа байгууллагыг” гэж

[50] Consideration, approval or adoption of the UNWTO Framework Convention on tourism ethics, 2020

тодорхойлсноор үйлчилгээний байгууллагыг бүхэлд нь хамруулжээ. Үүнтэй уялдуулан хуульд жуулчины үйлчилгээний байгууллагад тавих шаардлага, тус байгууллагад газар эзэмших зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллагаас олгох зэрэг хэд хэдэн зохицуулалт тусгажээ. Гэтэл нэр томьёоны тодорхойлолт заасан зарим үйлчилгээний байгууллагад тавигдах шаардлага, тэдгээрт зөвшөөрөл өгөх асуудлыг бусад хуулиар зохицуулдаг бөгөөд тэдгээртэй хэрхэн уялдсан нь тодорхойгүй, төрийн чиг үүргийг давхардуулсан, хуулийн этгээд, иргэдэд давхар ачаалал үүсгэх нөхцөлийг бий болгохоор байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон салбарын бусад байгууллагууд хамтран 2021-2022 онуудад аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй 188 аж ахуйн нэгжийн дунд судалгаа явуулахад 43.6% нь тур оператор, 32.4% нь жуулчны бааз, ресорт, амралтын газар, гэр буудал, 19.7% нь зочид буудал, 4.3% нь ресторан байсан бөгөөд Ковид-19 цар тахал бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлсөн тухай тодруулахад нийт судалгаанд оролцсон жуулчны бааз (ресорт, амралтын газар, гэр буудал), зочид буудал, рестораны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчдийн 40% нь үйл ажиллагаагаа түр зогсоосон, дахин эхлэхээр төлөвлөж байгаа бол 55% нь үйл ажиллагаагаа явуулж байна. Харин 4 аж ахуйн нэгж аялал жуулчлалын салбараас бүр мөсөн гарч, үйл ажиллагааны чиглэлээ өөрчилсөн байна.

Бусад улс орны энэ салбарын хууль, эрх зүйн зохицуулалтыг сонирхвол:

- Вьетнам улсын Аялал жуулчлалын тухай хуульд аялал жуулчлал, жуулчин, аялал жуулчлалын үйл ажиллагаа, энэ салбарын хүний нөөц, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг үзэж сонирхох өдрийн аялал, жуулчины хот, жуулчины ресорт, жуулчины бүс, жуулчины аялалын маршрут, жуулчины бүтээгдэхүүн, жуулчины үйлчилгээ гэх зэргээр маш олон нэр томьёог, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд төрийн болон орон нутгийн байгууллага, хуулийн этгээдийн оролцоо зэрэг асуудлыг;

- Японы Аялал жуулчлалын тухай хуульд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэлийн төрөл, хэрэгжүүлэх аяллын төрлийн ангилал, тэдгээр тавигдах шаардлага, хөрөнгийн хэмжээ, хүлээх үүрэг зэрэг асуудлыгд

- Казакстаны Аялал жуулчлалын тухай хуульд нийгмийн аялал жуулчлал, хөтөч-тайлбарлагч, сайн дурын аялал жуулчлал, тур, аялал жуулчлал, аялалын зааварлагч, жуулчин, жуулчдыг байршуулах хэрэгсэл, аялал жуулчлалын агент, аялал жуулчлалын эрхийн бичиг, аялал жуулчлалын үйл ажиллагаа, үйлчилгээнүүд, маршрут, операторын ажиллагаа, бүтээгдэхүүн, хүний нөөц, аялагч, аялал, аялалын хөтөч гэх зэрэг нэр томьёог, мөн үүнд оролцогчид, тэдгээрийн төрөл, хэлбэр, эрх үүрэг, төрийн оролцоо, зөвлөл, жуулчины мэдээллийн төв, тусгай зөвшөөрөл гэх зэрэг асуудлыг тус тус зохицуулжээ.

Аялал жуулчлалын конвенцийн 1 дүгээр зүйлд заасны дагуу “аялал

<table>
<tr><td colspan="3">жуулчлалыг хөгжүүлэхэд оролцогч” нарыг хуульд шинээр тусгаж, тэдгээрийн чиг үүргийн харилцаа уялдааг хуульд тодорхой тусгах шаардлагатайгаас гадна үүнтэй уялдуулан хуульд заасан нэр томьёо, аялал жуулчлалын байгууллага, түүний ангилал, үйл ажиллагаа, эрх хэмжээ, хөтөч-тайлбарлагчид тавих шаардлага, түүний эрх, үүрэг гэх зэрэг ойлголт, тэдгээрийн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэх шаардлагатай гэж үзэж байна.</td></tr>
<tr><td>3.1</td><td>Үнэлгээний хүрээ</td><td>Хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.6:<br>“аялал жуулчлалын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд энэ хуульд заасан захиргааны шийтгэл ногдуулах”,<br>Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг:<br>“Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ”</td></tr>
<tr><td>3.2</td><td>Тогтоосон шалгуур үзүүлэлт</td><td>Практикт нийцэж байгаа байдал</td></tr>
<tr><td>3.3</td><td>Сонгосон харьцуулалтын хэлбэр</td><td>Байх ёстой болон одоо байгаа:<br>-хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагаврыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хуулиар тогтоосон шаардлага, норм зэргийг харьцуулах хэлбэрээр хуулийн энэхүү зохицуулалтын зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтооно.</td></tr>
<tr><td>3.4</td><td>Томьёолсон шалгуур үзүүлэлт</td><td>Хуулийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, тийнхүү хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэлүүд байгаа эсэхийг тодорхойлох, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон эерэг болон сөрөг үр дагавруудыг тодорхойлох</td></tr>
<tr><td>3.5</td><td>Мэдээлэл цуглуулах арга</td><td>Энэ чиглэлээр гарсан ном, эмхэтгэл, илтгэл, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн болон олон улсын эх сурвалжийг ашиглана.</td></tr>
<tr><td colspan="3">3.6.Үнэлсэн байдал</td></tr>
<tr><td colspan="3">Аялал жуулчлалын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд энэ хуульд заасан захиргааны, эрүүгийн, зөрчлийн гэх зэрэг хариуцлага хүлээлгэхээр хариуцлагын асуудлыг тусгасан боловч эдгээр зохицуулалт нь шүүхийн практикт хэрэглэн хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хүндрэл, бэрхшээл гарахаар ойлгомжгүй, зөрчилтэй байгаагаас харахад үүнээс шалтгаалсан хууль хэрэглээнд сөрөг үр дагавар үүсэх бүрэн боломжтой байна.<br><br>Түүнчлэн Хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх талаар тусгаж, салбарт гарсан тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр хуулийг шинэчлэн найруулахаар тусгасан.<br><br>Үндсэн чиглэлд заасан энэ хүрээнд хууль зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх зохицуулалтууд нь хууль, шүүхийн практикт хэрэглээнд хүндрэл үүсгэх зохицуулалтыг сайжруулах зорилго агуулжээ.<br><br>Аялал жуучлалын тухай хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| Зөрчлийн тухай хуулийн 10.14 дүгээр зүйлээр зохицуулсан ба зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шийдвэрлэхээр тус тус зохицуулжээ. Гэтэл хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.6-д “аялал жуулчлалын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд энэ хуульд заасан захиргааны шийтгэл ногдуулах” талаар заасан бөгөөд “захиргааны шийтгэл” гэдэгт юу ойлгох нь тодорхойгүй, Эрүүгийн хуульд заасан хариуцлага, Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл, Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэл зэргээс хэрхэн ялгагдах нь ойлгомжгүй байна.<br><br>Иймд дээрх зохицуулалтаас үүдэн гарах сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлж, хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж байна. | | |
| **4.1** | **Үнэлгээний хүрээ** | **Хуулийн 11 дүгээр зүйл:**<br>“Аялал жуулчлалыг төрөөс хөхүүлэн дэмжих”<br>**Хуулийн 14 дүгээр зүйл:**<br>“Аялал жуулчлалын талаархи Засгийн газрын бүрэн эрх”<br>**Хуулийн 16 дугаар зүйл:**<br>“Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх”<br>**Хуулийн 18 дугаар зүйл:**<br>“Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх |
| **4.2** | **Тогтоосон шалгуур үзүүлэлт** | Практикт нийцэж байгаа байдал |
| **4.3** | **Сонгосон харьцуулалтын хэлбэр** | Тохиолдол судлах:<br>- Үнэлгээний хүрээгээр тогтоосон хуулийн зохицуулалт нь ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд буюу бусад улсад, өөр орон нутагт хэрхэн хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийнэ. |
| **4.4** | **Томьёолсон шалгуур үзүүлэлт** | Хуулийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, тийнхүү хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэлүүд байгаа эсэхийг тодорхойлох, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон эерэг болон сөрөг үр дагавруудыг тодорхойлох |
| **4.5** | **Мэдээлэл цуглуулах арга** | Энэ чиглэлээр гарсан ном, эмхэтгэл, илтгэл, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн болон олон улсын эх сурвалжийг ашиглана. |
| **4.6.Үнэлсэн байдал** | | |
| Аялал жуулчлалын тухай хуулиар аялал жуулчлалын талаархи Засгийн газрын бүрэн эрх, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх зэргийг зохицуулсан хэдий ч төрийн байгууллагын эрх хэмжээ, чиг үүрэг, төр, хувийн хэвшлийн уялдаа холбоог хангалттай зохицуулаагүйгээс хэрэгжүүлэх явцад тулгамдсан асуудал үүсдэг байна.<br><br>Үүнээ гадна аялал жуулчлалыг төрөөс хөхүүлэн дэмжих асуудлын хүрээнд | | |

төрөөс хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэхээр хуулиар зохицуулсан боловч хуулийн зохицуулалт нь бодит байдалтай нийцээгүй, тухайн харилцааг хангалттай зохицуулдаггүйгээс гадна зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй байна. Тодруулбал:

- Хуулийн 11 дүгээр зүйлд "Төрөөс экспортын үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэг, хөнгөлөлтөд аялал жуулчлалын байгууллага, зочид буудлын гадаадын жуулчдад үзүүлсэн үйлчилгээ нэг адил хамаарна." гэж заасан бол Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.8-т нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхөд "... жуулчдад үйлчлэх бааз, ресторан, жуулчин тээвэрлэх, газарчлах болон зочид буудлын үйлчилгээ хамаарахгүй" байхаар зохицуулжээ. Үүнээс дүгнэвэл, аялал жуулчлалыг төрөөс хөхүүлэн дэмжих асуудлын хүрээнд төрөөс хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх зохицуулалт практикт хэрэгжихгүй хуулийн зохицуулалтууд зөрчилдөж байна.

- Хуулийн 14 дүгээр зүйлд аялал жуулчлалын талаарх Засгийн газрын бүрэн эрхийг дараахь байдлаар тусгажээ:

14.1.1. Монгол Улсад аялал жуулчлал хөгжүүлэх бүс нутгийг улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлоготой уялдуулан тогтоох;

14.1.2. аялал жуулчлалын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;

14.1.3. аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр батлах;

14.1.5. аялал жуулчлалын салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, зохистой харьцааг бий болгох;

14.1.7. аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг хэрэгжүүлэх, аялал жуулчлалын улсын хяналтын дүрмийг батлах.

Гэтэл Засгийн газар хуулийн 14.1.1, 14.1.5-д заасан холбогдох бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй буюу Монгол Улсад аялал жуулчлал хөгжүүлэх бүс нутгийг улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлоготой уялдуулан тогтоогоогүй, аялал жуулчлалын салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, зохистой харьцааг бий болгоогүй байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

- Хуулийн 16 дугаар зүйлд аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг дараахь байдлаар тусгажээ:

16.1.1. аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлого боловсруулах, зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах;

16.1.3. аялал жуулчлал хөгжүүлэх төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангах;

16.1.4. улсын болон олон улсын хэмжээнд аялал жуулчлалын байгууллага хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

16.1.5. аялал жуулчлалын салбарт хүний нөөцийн хөгжлийг төлөвлөх, сургалтын бүтэц, хөтөлбөрийг эрх бүхий байгууллагатай хамтран

батлах;

16.1.6. аялал жуулчлалын байгууллага, дээд зэрэглэлийн зочид буудал, жуулчины баазад зэрэглэл тогтоох журмыг батлах;

16.1.7. аялал жуулчлалын бүсэд үйл ажиллагаа явуулах жуулчины бааз, зочид буудал, амралт, рашаан сувиллын газрын тоо, байршлыг тогтоох, тэдгээрийн нэгдсэн бүртгэл хөтлөх;

16.1.8. аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх, Монгол орныг гадаад, дотоодод сурталчлах үйл ажиллагааг санхүүжүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

16.1.9. Монгол орныг гадаад, дотоодод сурталчлах;

16.1.11. аялал жуулчлалын статистик мэдээллийг нэгтгэж, судалгаа, дүн шинжилгээ хийх;

16.1.12. аялал жуулчлалын мэдээллийн нэгдсэн сүлжээ, сан байгуулах;

16.1.13. аялал жуулчлалын бүсэд хүлээн авах жуулчдын тоог тогтоох;

16.1.14. аялал жуулчлалын зам чиглэлийг тогтоох;

16.1.15. аялал жуулчлалын хөгжилд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулахыг хориглох.

Бүгд Найрамдах Сингапур, Япон, Бүгд Найрамдах Солонгос, Оросын холбооны улс, Бүгд Найрамдах Гүрж, Киргизстан, Бүгд Найрамдах Социалист Вьетнам зэрэг улсууд тухайн улсын аялал жуулчлалын брэндийг бусад улсуудад нэгдсэн зохион байгуулалтаар сурталчлах, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, дэмжих салбарын уялаа холбоог хангах, хүний нөөцийг бэлтгэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, жуулчдын тоог нэмэгдүүлэх ажлыг тухайн улсын үндэсний аялал жуулчлалын байгууллагаараа дамжуулан гүйцэтгүүлдэг сайн жишиг олон улсад нэгэнт тогтсон байна.

Манай улсын хувьд Аялал жуулчлалын тухай хуулийн 16.1.1-16.1.15-д заасан үйл ажиллагааг Байгаль орчин, Аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газар зохион байгуулж байгаа хэдий ч тус газар нь 8 хүний бүтэцтэй бөгөөд улс орны хэмжээнд аялал жуулчлалын нэгдсэн үйл ажиллагааг бүхэлд нь зохион байгуулах боломж дутмаг байгааг салбарын оролцогчид хүлээн зөвшөөрсөн бөгөөд аялал жуулчлалын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үндэсний байгууллагыг дэлхийн жишигт нийцүүлэн байгуулах нь зүйтэй байна. /Хавсралтаар Бүгд Найрамдах Сингапур, Япон, Бүгд Найрамдах Солонгос, Оросын холбооны улс, Бүгд Найрамдах Гүрж, Киргизстан, Вьетнам зэрэг улсуудын Аялал жуулчлалын төрийн байгууллагын бүтцийн бүдүүвчийг хавсаргав./

Түүнчлэн Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 16.1.7, 16.1.13-т заасан холбогдох бүрэн эрхээ хэрэгжүүлдэггүй буюу аялал жуулчлалын бүсэд үйл ажиллагаа явуулах рашаан сувиллын газрын тоо, байршлыг тогтоогоогүй, тэдгээрийн нэгдсэн бүртгэл хөтлөөгүй, аялал жуулчлалын бүсэд хүлээн авах

жуулчдын тоог тогтоогоогүй байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Түүнчлэн Улсын тусгай хамгаалалттай газар нутаг нь аялал жуулчлалын үйл ажиллагаанд онцгой ач холбогдолтой бөгөөд нийт аялал жуулчлалын байгууллагын 80 орчим хувь нь тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаагаа явуулж байна. Харамсалтай нь энэхүү бүс нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг эсэхийг нягтлахгүйгээр газар ашиглах зөвшөөрөл олгох, газар ашиглуулах асуудлыг харьяалах нутаг дэвсгэрийн Аялал жуулчлалын асуудал хариуцсан газар, хэлтэстэй зөвшилцдөггүйгээс үүдэн тусгай хамгаалалттай газар нутагт зориулалтын аялал жуулчлалын бус зориулалтаар газар ашиглах, газар ашиглах эрхийг бусдад хууль бусаар шилжүүлэх зэрэг хүндрэлийг бий болгож энэ нь тухайн газар нутагт газрын доройтол, цөлжилт үүсэх нэг шалтгаан болж байна.

Иймээс тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын бүс байгуулах тохиолдолд тухайн газар нутагт аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглах шалгуурыг өндөр тогтоох, мөн хамгаалалтын захиргааны менежментийн төлөвлөгөөтэй зайлшгүй уялдуулах, цаашлаад газар ашиглах зөвшөөрөл олгоход тухайн аж ахуйн нэгж аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулсан байх шалгуурыг нэн тэргүүнд харгалзан үзэх, мөн харьяалах нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын газар, хэлтсийн саналыг заавал нөхцөлийг зайлшгүй харгалзсан үзэх хэрэгтэй байна.

- Хуулийн 18 дугаар зүйлд бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрхийг тусгахдаа “аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь эрх хэмжээнийхээ хүрээнд тухайн газар нутагт байгуулах жуулчины үйлчилгээний байгууллагад газар эзэмших зөвшөөрлийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон тоо, байршлыг баримтлан зохих хууль тогтоомжийн дагуу олгож гэрээ байгуулах бүрэн эрхтэй байхаар заажээ.

- Хуулийн 16.1.8-д “аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх, Монгол орныг гадаад, дотоодод сурталчлах үйл ажиллагааг санхүүжүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх”-ээр хуульчилсан хэдий ч энэхүү заалт хэрэгжиж бусад хууль тогтоомжийн уялдаа хангалтгүй байна. Төрөөс аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчид болон тус үйл ажиллагаанд шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэх, санхүүжүүлэх нь Ковид-19 цар тахлын дараах хүндрэлийг даван туулахад нэн чухал шаардлагатай байгааг салбарын уулзалтад оролцогчид онцолж байна.

- Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2022 оны 03-р сард зохион байгуулсан “Аялал жуулчлалын тухай хууль тогтоомж, тогтоол шийдвэр, дүрэм журам, стандартыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагыг тодорхойлох цуврал хэлэлцүүлэг” сэдэвт 7 удаагийн цуврал хэлэлцүүлгийн үеэр Монгол Улсын Аялал жуучлалын салбарын тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх, гарааны

бизнесүүдийг дэмжих, салбарт ногоон технологийг нэвтрүүлэх, стандартыг олон улсын жишигт нийцүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулах, гадаадад нэгдсэн бодлогоор сурталчлах, судалгаа хийх, сургалт зохион байгуулах, аялал жуулчлалын мэдээллийн сан болон аялал жуучлалын шинэ бүтээгдэхүүнийг бий болгох, Монгол Улсын түүх, соёл, уламжлалыг шингээсэн бүтээн байгуулалтуудыг санхүүжүүлэх чиглэлээр Монгол Улсын аялал жуучлалын хөгжлийг бодитойгоор эрчимжүүлэх санхүүжилтийн тогтолцоог тодорхой болгох зорилгоор олон улсын жишгээр “Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан”-г улсын нийт төсөвт нэмэлт дарамт үзүүлэхгүйгээр бий болгох зайлшгүй шаардлагатай тухай салбарын оролцогчид саналаа илэрхийлсэн[51] бөгөөд сангийн ач холбогдлыг зайлшгүй анхаарч үзэх нь зүйтэй.

Мөн хуулийн 16.1.7-д заасан “... төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон тоо, байршлыг ...” гэх заалт нь хэрэгжээгүй бөгөөд одоогоор тогтоосон тоо, байршил байхгүй байна. Түүнчлэн жуулчины үйлчилгээний байгууллагад газар эзэмших зөвшөөрлийг олгож гэрээ байгуулахад баримтлах “тоо, байршил”-ийг тогтоох гэсэн нь орон нутгийн гэхээс илүүтэй улсын хэмжээнд авч үзэх асуудал байх тул төрийн захиргааны төв байгууллагаас тогтоох нь илүү оновчтой байна.

Дээрхийг нэгтгэн дүгнэвэл, хуульд заасны дагуу Засгийн газар холбогдох бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй буюу Монгол Улсад аялал жуулчлал хөгжүүлэх бүс нутгийг улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлоготой уялдуулан тогтоогоогүй, аялал жуулчлалын салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, зохистой харьцааг бий болгоогүй, харин Төрийн захиргааны төв байгууллага нь холбогдох бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй буюу бүртгэл хөтлөөгүй, холбогдох Засаг дарга, орон нутгийн байгууллага нь хуульд заасны дагуу Жуулчины үйлчилгээний байгууллагад газар эзэмших зөвшөөрлийг олгож гэрээ байгуулахад баримтлах “тоо, байршил”-ийг тогтоох ёстой боловч одоогоор практикт тогтоосон тоо, байршил байхгүй байна. Мөн жуулчны үйлчилгээний байгууллагад газар эзэмших зөвшөөрлийг олгож гэрээ байгуулахад баримтлах “тоо, байршил”-ийг тогтоох гэсэн нь орон нутгийн гэхээс илүүтэй улсын хэмжээнд авч үзэх асуудал байх тул төрийн захиргааны төв байгууллагаас тогтоох нь илүү оновчтой байна.

Иймд Хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд “Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх ... тус салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, салбарын өмнө тулгамдсан асуудлыг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан шийдвэрлэх зорилгоор” Аялал жуулчлалын тухай хуулийг шинэчлэн найруулах талаар тусгасантай уялдуулан хуульд дээрх асуудлыг тодорхой, хэрэгжихүйц байхаар тусгах нь зүйтэй байна.

[51] Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2022 оны 03-р сарын 04-ний өдөр тур оператор, тур агентын үйл ажиллагаа эрхлэгчдийн дунд зохион байгуулсан “Аялал жуулчлалын тухай хууль тогтоомж, тогтоол шийдвэр, дүрэм журам, стандартыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагыг тодорхойлох цуврал хэлэлцүүлэг”-ийн саналын нэгтгэл. Хавсралт - 2.

**ДҮГНЭЛТ**

1. Аялал жуулчлалын тухай хуулийн зорилт нь үндсэн зорилгодоо хүрч чадаагүй буюу аялал жуулчлалын байгууллагуудын үйл ажиллагаагаа хангалттай тодорхой зохицуулагдаж чадаагүй, мөн төрөөс аялал жуулчлалыг дэмжих үндсэн зорилго биелэгдээгүй бөгөөд аялал жуулчлалын байгууллагууд ковид-19 цар тахлын дараах хүнд нөхцөл байдалд үйл ажиллагаагаа явуулсаар байна.
2. Аялал жуулчлалын тухай хууль нь 22 жилийн турш хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хэдий ч Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аялал жуулчлалыг хөхүүлэн дэмжих, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх, жуулчны үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцаатай холбоотой шинэлэг нэмэлт, өөрчлөлтүүд ороогүй бөгөөд энэхүү хууль 22 жилийн өмнөх харилцааг зохицуулсан хэвээр байна.
3. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого" зэрэг Засгийн Газрын мөрийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Аялал жуулчлалын тухай хуульд түшиглэн хэрэгжүүлэх боломжгүй бөгөөд зайлшгүй шинэчлэх шаардлагатай байна.
4. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаас 2015 оны 9 дүгээр сард баталсан "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030", Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас баталсан "Аялал жуулчлалын ёс зүйн конвенц", НҮБ-ын "Цөлжилттэй тэмцэх конвенц"-ид тус тус заасан үүргээ зохих ёсоор биелүүлэхэд аялал жуулчлалын салбарын үүрэг, оролцоо, хариуцлага тэдгээрийн биелэлт чухал хэдий ч холбогдох зорилтуудыг хэрэгжүүлэхэд Аялал жуулчлалын тухай хуулийг холбогдох бусад хууль тогтоомжуудтай уялдуулах (Жишээ нь: тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглахад тавих хяналтыг сайжруулах, аялал жуулчлалын зориулалтаар олгож буй газрын харилцаанд хяналт тавих г.м.) шаардлагатай байх хэдий ч ийнхүү уялдаагүй байна.
5. Аялал жуулчлалын тухай хууль тогтоомж тусгагдсан нэр томъёог НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас 2008 онд гишүүн орнууддаа хандаж гаргасан "Аялал жуулчлалын нэр томьёоны тайлбар" болон Аялал жуулчлалын ёс зүйн конвенцид тус тус нийцээгүй байна.
6. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон аймаг, орон нутгийн салбар нэгжүүд нэгдсэн уялдаа холбоотой ажиллаж чадаагүй бөгөөд аялал жуулчлалтай холбоотой тоон мэдээлэл, нэгдсэн мэдээллийн сан өнөөг хүртэл хуульд заасны дагуу хангалттай хэмжээнд бүрдээгүй байна.
7. Улсын тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын зориулалтаар газар олгоход тухайн байгууллага аялал жуулчлалын зориулалтаар үйл ажиллагаа явуулсан эсэхийг нь зайлшгүй харгалзан үзэх буюу газар олгох шалгуурыг зайлшгүй өөрчлөх шаардлага үүссэн байна.

8. Аялал Сүүлийн жилүүдэд Монгол Улсын аялал жуулчлалын зах зээлд гадаадын компаниуд өрсөлдөх болсноор мянгаас дээш жуулчин хүлээн авч, аялал зохион байгуулах хүчин чадалтай үндэсний компаниудын тоо эрс цөөрч байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэх, дотоодын зах зээлд эрсдэл нүүрлэх, улмаар үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хүртэл нөхцөл үүсч болзошгүй байна. Иймээс дотоодын аялал жуулчлалын байгууллагын чадавх эрс суларч буй энэ үед гадаадаас жуулчин хүлээж авах, гадагшаа жуулчин аялуулах аялал жуулчлалын байгууллагад зайлшгүй дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

Дээрх нэгтгэн дүгнэвэл судалгааны багийн зүгээс Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт "Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний... үндсэн дээр үзэл баримтлалын төсөл боловсруулна.", мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.4-т "тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай болсон" хэмээн тус тус заасны дагуу **Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчлсэн найруулгын** төслийн үзэл баримтлалыг боловсруулах, түүн дээр үндэслэн хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг тус тус боловсруулах зайлшгүй шаардлагатай гэж үзлээ.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ:

Судалгааны ажлын дээрх дүгнэлтэд үндэслэн Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад зайлшгүй анхаарвал зохих дараах хэд хэдэн зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Аялал жуулчлалын тухай хуулийн зорилтыг илүү өргөн хүрээнд тусгах замаар манай улсад аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарын хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, тогтвортой хөгжлийг хангах, тус салбарын олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд анхаарч ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, цаашлаад энэ салбарыг хөгжүүлэх бодлогын баримт бичгүүдэд туссан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхдээ олон улсын жишигт нийцүүлэх;
2. Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх үүднээс Аялал жуулчлалын тухай хуулийг бусад салбарын хууль тогтоомжтой уялдуулан шинэчлэн боловсруулах;
3. Аялал жуулчлалын тухай хуульд "аялал жуулчлалыг хөгжүүлэхэд оролцогч"-д ямар субьект хамаарахыг олон улсын жишигт нийцүүлэн шинээр тусгаж, тэдгээрийн чиг үүргийн харилцан уялдааг хуульд ялгамжтай тусгах, үүнтэй уялдуулан хуульд заасан нэр томьёо, аялал жуулчлалын байгууллага, түүний ангилал, үйл ажиллагаа, эрх хэмжээ, хөтөч-тайлбарлагчид тавих шаардлага, түүний эрх, үүрэг гэх зэрэг ойлголт, тэдгээрийн зохицуулалтыг олон улсын жишигт, тодруулбал конвенцид заасантай нийцүүлэх;
4. Аялал жуулчлалын тухай хуулийн хариуцлагын зохицуулалтыг Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль,

Төрийн албаны тухай хууль зэрэгтэй уялдуулах зорилгоор хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.6 дахь заалтыг хасах;

5. Аялал жуулчлалын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан аялал жуулчлалыг төрөөс хөхүүлэн дэмжих ажил болон хуульд заасан зорилтыг хангах Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх талаарх холбогдох зохицуулалтыг тусгах зорилгоор хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах;
6. Аялал жуулчлалын тухай хуульд аялал жуулчлалын талаарх Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрхийг тусгасан боловч энэ салбарын хөгжилд чухал ач холбогдол бүхий хэд хэдэн чиг үүргийг холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан огт хэрэгжүүлээгүй 22 жил болсон нь тус салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатайг харуулж байх тул хуулийн зохицуулалтыг тодорхой, хэрэгжихүйц байхаар өөрчлөхөөс гадна төрийн байгууллага, албан тушаалтан хуулийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахад хөшүүрэг болох зохицуулалт хуульд тусгах;
7. Аялал жуулчлалын салбарт засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлж буй төрийн зарим чиг үүргийг цаашид илүү тодорхой зохицуулж, Аялал жуулчлалын хуулиар салбарын холбоодын эрх зүйн статусыг баталгаажуулах;
8. Жуулчны эрх, үүрэг болон аюулгүй байдлыг олон улсын тэргүүн туршлагыг судлан нэвтрүүлэх;
9. Аялал жуулчлалын харилцаанд шинэ тутам үүсч буй аялал жуулчлалын байгууллагын мэргэжлийн хариуцлагын даатгал, аялал жуулчлалын үйл ажиллагаанд цахим орчин ашиглах, виртуал аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарыг Улсын Их Хурал, Засгийн газраас бодлогоор дэмжиж байгаа боооцоот морин уралдаан, хонжворт таавар, хонжворт сугалаа болон казинотой хослуулан хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх, аялал жуулчлалын зорилгоор хувийн жижиг онгоц, агаарын хөлөг болон бусад тээврийн хэрэгсэл ашиглах нөхцөлийг бусад хууль тогтоомжтой уялдуулан шинэчлэх, тэдгээртэй холбоотой төлбөр хураамжийг тодорхой болгох замаар агаарын тээврийн либералчлалыг дэмжих, аялал жуулчлалын элчийг томилох, урамшуулах, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх зохицуулалтыг хуулийн шинэчилсэн найруулгад тусгах;
10. Аялал жуулчлалын тухай хуульд жуулчны үйлчилгээний байгууллагад газар эзэмших зөвшөөрлийг олгож гэрээ байгуулахад баримтлах “тоо, байршил”-ийг тогтоох асуудал нь орон нутгийн түвшинд бус улсын хэмжээнд харилцан уялдаатай зохицуулах асуудал байх тул үүнийг анхаарах зэрэг болно.

---oOo---

Хавсралт – 1

# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ДАВХАРДАЛ, ХИЙДЭЛ, ЗӨРЧИЛ

## ДАВХАРДАЛ

**Тухайн хуульд байгаа зохицуулалтын бичвэрийг бусад хуульд давтан хуулбарлан хуульчилсан эсэх;**

<table>
<tr><td>1</td><td>АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ<br><br>/2000.05.05/</td><td>ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР<br>НУТГИЙН ТУХАЙ /1994.11.15/</td></tr>
<tr><td></td><td>16 дугаар зүйл. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх<br><br>16.1. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аялал жуулчлалын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br><br>16.1.14. аялал жуулчлалын зам чиглэлийг тогтоох;</td><td>27 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх<br>Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br>7/аялал, жуулчлалын зам, чиглэл, журам тогтоох;</td></tr>
<tr><td></td><td colspan="2">Дүгнэлт: Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27.7 болон Аялал жуулчлалын тухай хуулийн 16.1.14.-т “аялал жуулчлалын зам, чиглэлийг тогтоох” гэж заасан нь бичвэрийн хувьд давхардуулсан байна. Жич: Аялал жуулчлал гэдэг нь холбоо үг ба “аялал, жуулчлал” гэж дунд нь таслалтай бичих нь Аялал жуулчлалын тухай хуультай нийцэхгүй байна.<br><br>Санал: Энэ хуулийн 16.1.14. дэх заалт эсхүл Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27.7 дахь заалтад өөрчлөлт оруулах./7 тусгай хамгаалалтай газар нутагт дахь аялал жуулчлалын зам, чиглэл, аялах журмыг аялал жуучлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох</td></tr>
</table>

**Тухайн хуульд байгаа зохицуулалтыг уг хуульд болон бусад хуульд агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх;**

<table>
<tr><td>1</td><td colspan="2">АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /2000.05.05/</td></tr>
<tr><td></td><td>3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо</td><td>ХОЁРДУГААР БҮЛЭГ<br><br>Аялал жуулчлалын байгууллага</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | 3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:<br><br>3.1.2. "аялал жуулчлалын байгууллага" гэж аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бүрдүүлэх, сурталчлах, худалдах, худалдан авах, аялал жуулчлалын багц буюу тухайлсан үйлчилгээг зохион байгуулж байгаа ашгийн төлөө хуулийн этгээдийг; | **4 дүгээр зүйл. Аялал жуулчлалын байгууллага, түүний ангилал**<br><br>4.1. Аялал жуулчлалын байгууллага нь дараахь үйл ажиллагаа эрхэлнэ:<br><br>4.1.1. аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөх, бүрдүүлэх, сурталчлах, бөөнөөр болон жижиглэнгээр худалдах, аялал зохион байгуулах;<br><br>4.1.2. виз авахтай холбогдсон болон аяллын бусад бичиг баримтын бүрдүүлэлт хийх;<br><br>4.1.3. онгоц, төмөр зам болон тээврийн хэрэгслээр зорчих билет /тийз/-ийн захиалга хийх, билет /тийз/ худалдах, худалдан авах;<br><br>4.1.4. зочид буудал, жуулчны бааз, байр, үзвэрийн захиалга хийх;<br><br>4.1.5. жуулчныг угтан авах, үйлчлэх, үдэн гаргах ажлыг зохион байгуулах. |
| | ***Дүгнэлт:*** Энэ хуулийн Хоёрдугаар бүлэг, 4 дүгээр зүйлд Аялал жуулчлалын байгууллагыг түүний эрхлэх үйл ажиллагаагаар нь тодорхойлсон ба мөн 3.1. /нэр томъёо/ дэх хэсэг буюу 3.1.2.-т "аялал жуулчлалын байгууллага" гэж аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бүрдүүлэх, сурталчлах, худалдах, худалдан авах, аялал жуулчлалын багц буюу тухайлсан үйлчилгээг зохион байгуулж байгаа ашгийн төлөө хуулийн этгээдийг” гэж томъёолсон нь Аялал жуулчлалын байгууллагыг дээрх 2 заалтуудад агуулгын хувьд давхардуулан зохицуулсан байна. Жич: 3.1.2.-т “... багц буюу тухайлсан ...” мөн 4.1.1.-т ”... бөөнөөр болон жижиглэнгээр ...” гэсэн томъёоллууд нь агуулгын хувьд нэг зүйлийг илэрхийлдэг.<br><br>***Санал:*** Энэ хуулийн 3.1.2 дахь заалтын холбогдох хэсгийг хасах буюу 2 дугаар бүлэг, 4 дүгээр зүйлд “аялал жуулчлалын байгууллага нь ашгийн төлөө хуулийн этгээд байна” гэсэн зохицуулалтыг нэмэх, эсхүл 3.1.2 дахь заалтыг ““аялал жуулчлалын байгуулага” гэж аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх ашгийн төлөө хуулийн этгээдийг” гэж өөрчлөх. | |

| 2 | **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ**<br><br>**/2000.05.05/** | **ИРГЭНИЙ ХУУЛЬ /2002.01.10/** |
|---|---|---|
| | **3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо**<br><br>3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: | **26 дугаар зүйл. Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар**<br>26.7.Ашгийн төлөө хуулийн этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр |

| | | |
|---|---|---|
| | 3.1.2. "аялал жуулчлалын байгууллага" гэж аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бүрдүүлэх, сурталчлах, худалдах, худалдан авах, аялал жуулчлалын багц буюу тухайлсан үйлчилгээг зохион байгуулж байгаа ашгийн төлөө хуулийн этгээдийг;<br><br>8 дугаар зүйл. Аялал жуулчлалын байгууллагын бүрэн эрх<br><br>8.1. Аялал жуулчлалын байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br><br>8.1.2. аялал жуулчлалын бүтээгдэхүүнээ өөрийн нэрийн өмнөөс сурталчлах, худалдах, худалдан авах;<br><br>8.1.7.аялал жуулчлалын бүтээгдэхүүнийхээ үнэ тарифыг тогтоох;<br><br>8.1.8.аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудтай гэрээ байгуулах. | хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлаагүй аливаа үйл ажиллагаа эрхлэх эрхтэй. |
| | ***Дүгнэлт:*** Иргэний хуульд “ашгийн төлөө хуулийн этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлаагүй аливаа үйл ажиллагаа эрхлэх эрхтэй” гэж заасан ба аялал жуулчлалын байгууллагын эрхийг энэ хуульд зааж өгсөн нь агуулгын хувьд иргэний хуулийн дээрх заалттай давхардаж байна. Өөрөөр хэлбэл, энэ хуульд аялал жуулчлалын байгууллагын үйл ажиллагаанд хориглох зүйлсийг зааж өгөх нь зүйтэй ба тэрхүү хориглосноос бусдыг иргэний хуульд заасны дагуу хэрэгжүүлэх эрхтэй юм.<br><br>***Санал:*** Энэ хуулийн 8.1.2., 8.1.7, 8.1.8 дахь заалтуудыг хүчингүй болгох. | |

| | | |
|---|---|---|
| 3 | **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /2000.05.05/** | |
| | **10 дугаар зүйл. Жуулчны үйлчилгээний байгууллага**<br><br>10.2. Дээд зэрэглэлийн зочид буудал болон жуулчны баазын зэрэглэл тогтоох журмыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. | **16 дугаар зүйл. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**<br><br>16.1. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аялал жуулчлалын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br><br>16.1.6. аялал жуулчлалын байгууллагын, дээд зэрэглэлийн зочид буудал, жуулчны баазад зэрэглэл тогтоох, хөтөч-тайлбарлагчийн ангилал, |

| | | |
|---|---|---|
| | | зэрэглэл тогтоох журмыг батлах; |

**Дүгнэлт:** Энэ хуулийн 10.2 дахь хэсэг болон 16.1.6. дахь заалтууд нь агуулгын хувьд давхардсан зохицуулалт байна.

**Санал:** 16.1.6. аялал жуулчлалын байгууллагын, дээд зэрэглэлийн зочид буудал, жуулчны баазад зэрэглэл тогтоох, хөтөч-тайлбарлагчийн ангилал, зэрэглэл тогтоох журмыг батлах;

Дээд зэрэгчлэлийн зочид буудал-зочид буудал гэж өөрчлөх.
Хөтөч тайлбарлагчийн ангилал- хасах
Зэрэглэл –ангилал гэж өөрчлөх

10.2. Дээд зэрэглэлийн зочид буудал болон жуулчны баазын зэрэглэл тогтоох журмыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

“Дээд зэрэгчлэлийн зочид буудал” гэдгийг “зочид буудал” гэж, “Зэрэглэл” гэснийг “ангилал” гэж тус тус өөрчлөх.

| 4 | **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /2000.05.05/** | **ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ /2003.01.03/** |
|---|---|---|
| | **23 дугаар зүйл. Аялал жуулчлалын улсын байцаагчийн эрх, үүрэг**<br><br>23.1. Аялал жуулчлалын улсын байцаагч дараахь эрх эдэлнэ:<br><br>23.1.2.хяналт шалгалт явуулахад шаардагдах мэдээ, баримтыг холбогдох иргэн, албан тушаалтан, байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулж авах;<br><br>23.1.4.хяналт шалгалт хийхээр холбогдох байгууллагад нэвтрэн орох; | **10 дугаар зүйл. Мэргэжлийн хяналтын улсын байцаагч, түүний нийтлэг бүрэн эрх**<br>10.9. Мэргэжлийн хяналтын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч /цаашид "улсын байцаагч" гэх/ дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br>10.9.2. хяналт шалгалт хийх объектод саадгүй нэвтрэн орох;<br><br>10.9.4. хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах; |

**Дүгнэлт:** Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9.2, 10.9.4 дэх заалтуудыг энэ хуулийн 23.1.2. болон 23.1.4. дэх заалтуудад агуулгын хувьд давхардуулан зохицуулсан байна

**Санал:** Энэ хуулийн 23.1.2., 23.1.4. дэх заалтуудийг хүчингүй болгох.

## ЗӨРЧИЛ

**Хууль тогтоомжийн хэсэгт заасан хуулийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;**

| 1 | **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /2000.05.05/** | |
|---|---|---|
| | **2 дугаар зүйл. Аялал жуулчлалын тухай хууль тогтоомж**<br><br>2.1. Аялал жуулчлалын тухай хууль тогтоомж нь Иргэний хууль[1], Газрын тухай[2], Байгаль орчныг хамгаалах тухай[3], Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль[4] болон энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. | **2 дугаар зүйл. Аялал жуулчлалын тухай хууль тогтоомж**<br><br>2.3. Улсын тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахаар бол түүнтэй холбогдсон харилцааг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна. |
| | ***Дүгнэлт:*** Энэ хуулийн нийт зохицуулалтууд болон 2.3.-т "Улсын тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахаар бол түүнтэй холбогдсон харилцааг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна." гэж заасан тусгайлсан зохицуулалтаас үзэхэд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль нь Аялал жуулчлалыг тухай хууль тогтоомжийн бүрдэл хэсэг байна гэсэн энэ хуулийн 2.1 дэх хэсэгт заасантай зөрчилдөж байна.<br><br>***Санал:*** Энэ хуулийн 2.1 дэх заалтын холбогдох хэсгийг хасах эсхүл 2.3 дахь заалтад өөрчлөлт оруулах. | |

**Хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд салаа утгатай эсэх;**

| 2 | **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /2000.05.05/** | |
|---|---|---|
| | **2 дугаар зүйл. Аялал жуулчлалын тухай хууль тогтоомж**<br><br>2.3. Улсын тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахаар бол түүнтэй холбогдсон харилцааг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай | **1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**<br><br>1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аялал жуулчлалыг хөхүүлэн дэмжих, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх, жуулчны үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх |

| | | |
|---|---|---|
| | хуулиар зохицуулна. | харилцааг зохицуулахад оршино. |
| | ***Дүгнэлт:*** Энэ хуульд нэг зүйлийг 2 өөр үгээр илэрхийлсэн нь зөрчилтэй байна.<br><br>***Санал:*** Энэ хуулийн 2.3.-т "... үйл ажиллагаа эрхлэхээр ..." гэж өөрчлөлт оруулах. | |

| | | |
|---|---|---|
| 3 | **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /2000.05.05/** | **ҮНДСЭН ХУУЛЬ /1992.01.13/** |
| | **13 дугаар зүйл. Хөтөч-тайлбарлагчийн эрх, үүрэг**<br><br>13.1. Хөтөч-тайлбарлагч нь дараах эрх, үүрэгтэй.<br><br>13.1.3. Монгол Улсын нийгэм эдийн засаг, төрийн байгуулал, байгаль, түүх, соёл, ард түмний зан заншлын талаар жуулчдад бодит мэдээлэл өгөх, улс, хувь хүн, байгууллагын нууцад хамаарах мэдээллийн нууцыг задруулахгүй байх; | **Арван зургадугаар зүйл**<br>Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:<br>17/ төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална; |
| | ***Дүгнэлт:*** Үндсэн хууль болон бусад хуульд "төр, ... нууцыг" гэсэн нэр томъёог хэрэглэдэг ба энэ хуульд "улс ... нууцыг " гэж оруулсан нь бусад хуультай зөрчилдөж байна.<br><br>***Санал:*** Энэ хууль 13.1.3. дах заалтад "... төр, ... нууцыг" гэж өөрчлөлт оруулах. | |

**Тухайн хуулийн зүйл, заалт өөр хуулийн заалттай зөрчилдөж буй эсэх**

| 4 | АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /2000.05.05/ | ИРГЭНИЙ ХУУЛЬ<br><br>/2002/ |
|---|---|---|
| | **9 дүгээр зүйл. Аялал жуулчлалын гэрээ**<br><br>9.1. Туроператор буюу турагент нь аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг худалдах, худалдан авах тухай гэрээ байгуулна.<br><br>9.2.Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг Иргэний хуулийн 370-379 дүгээр зүйл, энэ хууль, аялал жуулчлалын байгууллага жуулчинтай байгуулсан гэрээгээр зохицуулна. Гэрээнд дараахь нөхцөлийг тусгана: | **243 дугаар зүйл. Худалдах-худалдан авах гэрээ**<br>243.1.Худалдах-худалдан авах гэрээгээр худалдагч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх буюу бараа бэлтгэн нийлүүлэх, худалдан авагч нь худалдагчид хэлэлцэн тохирсон үнийг төлж, худалдан авсан хөрөнгөө хүлээн авах үүргийг тус тус хүлээнэ.<br>**370 дугаар зүйл. Аялал жуулчлалын гэрээ**<br><br>370.1.Аялал жуулчлалын гэрээгээр аялал жуулчлал зохион байгуулагч нь жуулчинд хэлэлцэн тохиролцсон үйлчилгээ үзүүлэх, жуулчин нь ийнхүү үйлчилгээ үзүүлсний төлөө хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ. |
| | ***Дүгнэлт:*** Иргэний хуулийн 370-379 дүгээр зүйлүүдэд мөн Аялал жуулчлалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд Аялал жуулчлалын гэрээ гэсэн нэр бүхий зүйл, зохицуулалт байна. Гэхдээ дээрх 2 хуульд Аялал жуулчлалын гэрээний зохицуулалт нь өөр өөр агуулгатай байгаа нь хоорондоо зөрчилтэй байна.<br><br>***Санал:*** Энэ хуулийн 9 дүгээр зүйлийн нэрийг зохицуулалтынх нь агуулгатай нийцүүлэн өөрчлөлт оруулах /Жишээ нь: 9 дүгээр зүйл. Гэрээ/. | |

| 5 | АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ<br><br>/2000.05.05/ | МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ /1992.01.13/ | ГАЗРЫН ТУХАЙ<br><br>/2008.05.20/ | МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ<br><br>/2006.01.26/ |
|---|---|---|---|---|
| | 15 дугаар зүйл. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын | Хорин тавдугаар зүйл<br>1. Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг | 4 дүгээр зүйл. Засгийн газрыг эмхлэн байгуулах үндэслэл, журам<br><br>1. Засгийн газрыг Үндсэн | 14 дүгээр зүйл. Анхдугаар чуулган<br>14.3. Анхдугаар чуулганаар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | тогтолцоо<br><br>15.4. Зөвлөлийн дарга, гишүүдийг Ерөнхий сайд томилно.<br><br>15.5. Зөвлөлийн дарга нь аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна. | өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:<br>6/ Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах;<br><br>Гучин есдүгээр зүйл<br>3. Засгийн газрын гишүүдийг Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хүн бүрээр хэлэлцэж томилно. | хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, гучин есдүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зургадугаар бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу эмхлэн байгуулна. | дараахь асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:<br><br>14.3.6. Засгийн газрын гишүүдийг томилох. |
| | ***Дүгнэлт:*** Монгол улсын үндсэн хууль болон холбогдох бусад хуульд Засгийн газрын гишүүнийг Улсын их хурал томилно гэж заасантай энэ хуулийн 15 дугаар зүйлд "Засгийн газрын гишүүн нь зөвлөлийн дарга байна, зөвлөлийн даргыг Ерөнхий сайд томилно" гэсэн зохицуулалт нь зөрчилдөж байна.<br><br>***Санал:*** Энэ хуулийн 15.4 дэх хэсгийн зохицуулалтын "Зөвлөлийн дарга ..." гэснийг хасах буюу өөрчлөлт оруулах. | | | | |

| 6 | **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /2000.05.05/** | **ГАЗРЫН ТУХАЙ /2008.05.20/** |
|---|---|---|
| | **18 дугаар зүйл. Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх**<br><br>18.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга аялал жуулчлалын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br><br>18.2.2. эрх хэмжээнийхээ хүрээнд тухайн газар нутагт байгуулах жуулчны | **23 дугаар зүйл. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, эрх хэмжээ**<br><br>23.4. Сумын газрын даамал, дүүргийн газрын алба дараахь эрх хэмжээтэй байна:<br>23.4.2. Засаг даргын шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, |

| | | |
|---|---|---|
| | үйлчилгээний байгууллагад газар эзэмших зөвшөөрлийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон тоо, байршлыг баримтлан зохих хууль тогтоомжийн дагуу олгож гэрээ байгуулах; | байгууллагатай газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлаар гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох; |
| | ***Дүгнэлт:*** Аялал жуулчлалын тухай хуулийн 18.2.2.т “Засаг дарга газар эзэмших зөвшөөрлийг олгож гэрээ байгуулах” тухай заасан нь Газрын тухай хуулийн 23.4.2.-т “Сумын газрын даамал, дүүргийн газрын алба нь Засаг даргын шийдвэрийг үндэслэн газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох” гэсэн заалттай зөрчилдөж байна. Газрын тухай хуульд зааснаар газрын алба нь Засаг даргын газар эзэмшүүлэх шийдвэрийг үндэслэж газрыг эзэмшүүлэх гэрээг байгуулдаг байна.<br>***Санал:*** Энэ хуулийн 18.2.2-т “... олгож шийдвэрлэнэ;” гэж өөрчлөлт оруулах. | |

| 7 | **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ**<br>**/2000.05.05/** | **НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬ**<br>**/2015.07.09/** |
|---|---|---|
| | **11 дүгээр зүйл. Аялал жуулчлалыг төрөөс хөхүүлэн дэмжих**<br>11.1. Төрөөс экспортын үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэг, хөнгөлөлтөд аялал жуулчлалын байгууллага, зочид буудлын гадаадын жуулчдад үзүүлсэн үйлчилгээ нэг адил хамаарна. | **Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх**<br>**13 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх.**<br>13.1.Дараахь барааг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө:<br>13.5.14.аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд гадаад улсын аялал жуулчлалын байгууллагатай гэрээ байгуулж жуулчдыг нь хүлээн авах, уг үйлчилгээг төлөвлөх, сурталчлах, бичиг баримтыг нь бүрдүүлэх зэргээр гадаадын жуулчдад үзүүлсэн /туроператор/ үйлчилгээ.<br>13.8.Энэ хуулийн 13.6.14-т заасан үйлчилгээнд жуулчдад үйлчлэх бааз, ресторан, жуулчин тээвэрлэх, газарчлах болон зочид буудлын үйлчилгээ хамаарахгүй. |
| | ***Дүгнэлт:*** Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13. дугаар зүйлд “туроператорын үзүүлсэн үйлчилгээ нэмэгдсэн өртгийн албан татвараас | |

| | |
|---|---|
| | чөлөөлөгдөх ба энэ чөлөөлөлтөд зочид буудлын үйлчилгээ хамаарахгүй" гэж заасан нь энэ хуулийн 11. дүгээр зүйлд заасан "төрөөс экспортын үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэг, хөнгөлөлтөд аялал жуулчлалын байгууллага, зочид буудлын гадаадын жуулчдад үзүүлсэн үйлчилгээ нэг адил хамаарна" гэсэн зохицуулалттай зөрчилдөж байна.<br><br>***Санал:*** Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.5.14-т зочид буудал гэж нэмэх.Мөн хуулийн 13.8 зүйлээс зочид буудал гэж хасах |

**ХИЙДЭЛ**

**Тухайн хуульд тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бол уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэх;**

| 1 | **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /2000.05.05/** |
|---|---|
| | **14 дүгээр зүйл. Аялал жуулчлалын талаархи Засгийн газрын бүрэн эрх**<br><br>14.1. Засгийн газар аялал жуулчлалын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br>14.1.1. Монгол Улсад аялал жуулчлал хөгжүүлэх бүс нутгийг улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлоготой уялдуулан тогтоох;<br>14.1.5. аялал жуулчлалын салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, зохистой харьцааг бий болгох; |
| | ***Дүгнэлт:*** Энэ хуулийн 14.1.1, 14.1.5. дах заалтуудын дагуу Засгийн газар холбогдох бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй буюу Монгол Улсад аялал жуулчлал хөгжүүлэх бүс нутгийг улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлоготой уялдуулан тогтоогоогүй, аялал жуулчлалын салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, зохистой харьцааг бий болгоогүй байна.<br>***Санал:*** Энэ хуульд заасны дагуу Засгийн газар холбогдох бүрэн эрхээ хэрэгжүүлэх. |

| 2 | **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /2000.05.05/** |
|---|---|
| | **16 дугаар зүйл. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**<br><br>16.1. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аялал жуулчлалын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br><br>16.1.7. аялал жуулчлалын бүсэд үйл ажиллагаа явуулах жуулчны бааз, зочид |

| | |
|---|---|
| | буудал, амралт, рашаан сувиллын газрын тоо, байршлыг тогтоох, тэдгээрийн нэгдсэн бүртгэл хөтлөх;<br>16.1.13. аялал жуулчлалын бүсэд хүлээн авах жуулчдын тоог тогтоох; |
| | ***Дүгнэлт:*** Энэ хуулийн 16.1.7, 16.1.13. дэх заалтуудын дагуу Төрийн захиргааны төв байгууллага холбогдох бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй буюу бүртгэл хөтлөөгүй, тогтоогоогүй байна.<br>***Санал:*** Төрийн захиргааны төв байгууллагын хуулиар заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх эсхүл 16.1.7, 16.1.13. дэх заалтуудад өөрчлөлт оруулах. |

| | |
|---|---|
| 3 | **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /2000.05.05/** |
| | **18 дугаар зүйл. Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх**<br>18.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга аялал жуулчлалын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br>18.2.2. эрх хэмжээнийхээ хүрээнд тухайн газар нутагт байгуулах жуулчны үйлчилгээний байгууллагад газар эзэмших зөвшөөрлийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон тоо, байршлыг баримтлан зохих хууль тогтоомжийн дагуу олгож гэрээ байгуулах; |
| | ***Дүгнэлт:*** Энэ хуулийн 18.2.2.-т "... төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон тоо, байршлыг ..." гэж заасан байх бөгөөд одоогоор тогтоосон тоо, байршил байхгүй байна.<br>***Санал:*** Жуулчны үйлчилгээний байгууллагад газар эзэмших зөвшөөрлийг олгож гэрээ байгуулахад баримтлах "тоо, байршил"-ийг төрийн захиргааны төв байгууллагаас тогтоох. |

**7.3.9. хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь ойлгомжтой байгаа эсэх**

| | |
|---|---|
| 4 | **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /2000.05.05/** |
| | **3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо**<br>3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:<br>3.1.6. "жуулчны үйлчилгээний байгууллага" гэж зочид буудал, жуулчны бааз, |

| | |
|---|---|
| | зоогийн газар, амралт сувилал, тээвэр, холбоо, үзвэрийн **зэрэг** үйлчилгээг жуулчинд үзүүлж байгаа байгууллагыг; |
| | ***Дүгнэлт:*** "... зэрэг... " гэдэг нь нэр томъёог өргөн, тодорхойгүй болгосон байх бөгөөд "Жуулчны үйлчилгээний байгууллага" нь ойлгомжгүй байна.<br><br>***Санал:*** Энэ хуулийн 3.1.6 дэх заалтыг ойлгомжтой болгох буюу өөрчлөлт оруулах. |

<table>
<tr><td>5</td><td colspan="2">АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /2000.05.05/</td></tr>
<tr><td></td><td>8 дугаар зүйл. Аялал жуулчлалын байгууллагын бүрэн эрх<br><br>8.1. Аялал жуулчлалын байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br><br>8.1.10. эрх бүхий байгууллагаар зэрэглэлээ тогтоолгох.<br><br>16 дугаар зүйл. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх<br><br>16.1. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аялал жуулчлалын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br><br>16.1.6. аялал жуулчлалын байгууллага, дээд зэрэглэлийн зочид буудал, жуулчны баазад зэрэглэл тогтоох, хөтөч-тайлбарлагчийн ангилал, зэрэглэл тогтоох журмыг батлах;</td><td>4 дүгээр зүйл. Аялал жуулчлалын байгууллага, түүний ангилал<br><br>4.2. Аялал жуулчлалын байгууллагыг туроператор, турагент гэж ангилна:<br><br>8 дугаар зүйл. Аялал жуулчлалын байгууллагын бүрэн эрх<br><br>8.1. Аялал жуулчлалын байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br><br>8.1.1. аялал жуулчлалын байгууллага нь энэ хуулийн 4.2-т заасан ангилалд нийцүүлэн үйл ажиллагаа явуулах;</td></tr>
<tr><td></td><td colspan="2">Дүгнэлт: "Аялал жуулчлалын байгууллага"-ын хувьд зэрэглэл гэж байхгүй, харин энэ хуулийн 4.2, 8.1.1-т заасны дагуу ангилалтай байх бөгөөд ангилалаа эрх бүхий байгууллагаар тогтоолгоно.<br><br>Санал: Энэ хуулийн 8.1.10, 16.1.6 дах заалтуудын холбогдох хэсэгт өөрчлөлт оруулах.</td></tr>
</table>

| | |
|---|---|
| 6 | **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /2000.05.05/** |

| | |
|---|---|
| | **10 дугаар зүйл. Жуулчны үйлчилгээний байгууллага**<br><br>10.1. Жуулчны үйлчилгээний байгууллага нь дараахь шаардлагыг хангаж ажиллана:<br><br>10.1.4. байгууллагынхаа оноосон нэр, зэрэглэл, жуулчин хүлээн авах эрхийг тодорхойлсон гэрчилгээг ил байрлуулах; |
| | ***Дүгнэлт:*** "Жуулчин хүлээн авах эрхийг тодорхойлсон гэрчилгээг" гэж юуг ойлгох нь тодорхой бус, ойлгожгүй.<br><br>***Санал:*** "Жуулчин хүлээн авах эрхийг тодорхойлсон гэрчилгээ" гэдгийн тодорхой болгох буюу холбогдох нэмэлтийг оруулах. |

| 7 | **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /2000.05.05/** |
|---|---|
| | **9 дүгээр зүйл.** Аялал жуулчлалын гэрээ<br><br>9.1. Туроператор буюу турагент нь аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг худалдах, худалдан авах тухай гэрээ байгуулна. |
| | ***Дүгнэлт***: Энэ хуулийн 9.1.-т "Туроператор буюу турагент нь аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг худалдах, худалдан авах тухай гэрээ байгуулна." гэсэн зохицуулалт нь агуулгын хувьд дутуу буюу ойлгомжгүй байна.<br><br>***Санал:*** Энэ хуулийн 9.1. дэх хэсгийг хасах буюу шинэчлэн найруулах. |

| 8 | **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /2000.05.05/** | **АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ /2001.01.21/** |
|---|---|---|
| | 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо<br><br>3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:<br><br>3.1.8. "дээд зэрэглэлийн зочид буудал" гэж зочид буудлын цогц үйлчилгээний жишиг шаардлагын 3 ба түүнээс дээш од бүхий зэрэглэлийг хангасан үйлчилгээний байгууллагыг. | 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо<br><br>3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:<br>3.1.1. "аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл" /цаашид "тусгай зөвшөөрөл" гэх/ –гэж тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг иргэн, ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдэд эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичгийг;<br><br>15 дугаар зүйл. Тусгай |

| | | |
|---|---|---|
| | | зөвшөөрөлтэйгээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл<br><br>15.1. Энэ зүйлд заасан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ.<br><br>15.15. Зам, тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр:<br><br>15.15.8. дээд зэрэглэлийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх; |
| | *Дүгнэлт:* Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд зааснаар Дээд зэрэглэлийн зочид буудлын үйл ажиллагааг аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй эрхлэх ба энэ хуулийн 5.2.1.- 5.2.3.-т заасан бичиг баримтыг бүрдүүлж тэрхүү тусгай зөвшөөрлийг авахаар энэ хуульд зохицуулсан байна. Түүнчлэн энэ хуулийн 3.1.8.-т ""дээд зэрэглэлийн зочид буудал" гэж зочид буудлын цогц үйлчилгээний жишиг шаардлагын 3 ба түүнээс дээш од бүхий зэрэглэлийг хангасан үйлчилгээний байгууллагыг." хэлнэ гэж томёолсон. Дээрх зохицуулалтууд нь хоорондоо уялдаагүй ойлгомжгүй байна.<br><br>Тодруулбал: энэ хуулийн 3.1.8.-д зааснаар зочид буудлын *үйлчилгээ* нь тодорхой зэрэглэлийг хангаснаар дээд зэрэглэлийн зочид буудал болох ба энэ хуулийн 5.2.1.-5.2.3.-д заасан бичиг баримтыг бүрдүүлсэнээр дээд зэрэглэлийн зочид буудлын *үйл ажиллагаа эрхлэх* тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны байгууллагаас авч байх ёстой. Энэ хуульд дээд зэрэглэлийн зочид буудлын байгууллагын *үйлчилгээ* болоод *үйл ажиллагааг* эрхлэх эрхийн талаар 2 салгасан зохицуулалт байгаа нь ойлгомжгүй байна.<br><br>***Санал:***<br><br>Зочид буудал нь үйлчилгээний тодорхой /энэ хуулийн 3.1.8.-д заасан/ зэрэглэлийг хангаснаар дээд зэрэглэлийн зочид буудал болох буюу *зочид буудлын үйл ажиллагааг тодорхой зэрэглэлээр эрхлэх.* Үүнд нийцүүлэн энэ хуулийн 10.2.-т "Дээд зэрэглэлийн зочид буудал ... " гэснийг "зочид буудал ...", 16.1.6.-т "... дээд зэрэглэлийн зочид буудал, ..." гэснийг "... зочид буудал, ..." гэж тус тус өөрчлөх.<br>Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон энэ хуульд нийцүүлэн энэ хуулийн 3.1.8.-т ""дээд зэрэглэлийн зочид буудал" гэж зочид буудлын цогц үйлчилгээний жишиг шаардлагын 3 ба түүнээс дээш од бүхий зэрэглэлийг хангасан, энэ хуульд заасны дагуу дээд зэрэглэлийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан этгээдийг." гэж нэмэлт өөрлөлт оруулах. | |

| | |
|---|---|
| 9 | **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /2000.05.05/** |
| | **2 дугаар зүйл. Аялал жуулчлалын тухай хууль тогтоомж**<br><br>2.3. Улсын тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахаар бол түүнтэй холбогдсон харилцааг Тусгай хамгаалалттай газар |

| | |
|---|---|
| | нутгийн тухай хуулиар зохицуулна. |
| | ***Дүгнэлт:*** Энэ хуулийн 2.3-т "Улсын тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахаар бол түүнтэй холбогдсон харилцааг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна." гэж заасан ерөнхийлсөн, ойлгомжгүй зохицуулалт байна.<br><br>***Санал:*** Энэ хуулийн 2.3 дахь заалтыг "Улсын тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахаар бол газар ашиглахтай холбогдсон харилцааг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна." гэж өөрчлөлт оруулах. |

| | |
|---|---|
| 10 | **ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ /2017.05.11/** |
| | **10.14 дүгээр зүйл. Аялал жуулчлалын тухай хууль зөрчих**<br><br>1.Жуулчны үйлчилгээний байгууллага нь:<br><br>1.3.онгоц, төмөр зам, тээврийн хэрэгслээр зорчих билет /тийз/-ийн захиалга хийх, билет /тийз/ худалдах, худалдан авах;<br><br>1.4.зочид буудал, жуулчны бааз, байр, үзвэрийн захиалга хийх;<br><br>1.5.жуулчныг угтан авах, үйлчлэх, үдэн гаргах ажлыг зохион байгуулах үйл ажиллагаа явуулсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. |
| | ***Дүгнэлт:*** Гадаад иргэн байршилж байгаа зочид буудлаасаа онгоц, төмөр зам, тээврийн хэрэгслээр зорчих билет, жуулчны бааз, байр, үзвэрийн захиалга хийхээр нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. гэж ерөнхийлсөн, ойлгомжгүй зохицуулалт байна.<br><br>***Санал:*** доор дурдсанаар өөрчлөх<br>Жуулчны үйлчилгээний байгууллага - аялал жуулчны үйлчилгээний байгууллага<br>Зөрчлийн тухай хуулийн 10.1.3, 10.1.4, 10.1.5-ийг хасах. |

## АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ


**I.Хууль тогтоомж, эрх зүйн акт**

1. Хууль тогтоомжийн тухай хууль;
2. Аялал жуулчлалын тухай хууль;
3. Иргэний хууль;
4. Зөрчлийн тухай хууль;
5. Газрын тухай хууль;
6. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль;
7. Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
8. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль;
9. Татварын тухай хууль;
10. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль;
11. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль;
12. Байгууллагын нууцын тухай хууль;
13. Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
14. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль;
15. Соёлын өвийг хамгаалах тухай хууль;
16. Төсвийн тухай хууль;
17. Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль;
18. Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт;
19. Аялал жуулчлалын тухай конвенц;
20. Хөрөнгө оруулалтын тухай.

**II.Ном, гарын авлага, эмхэтгэл, судалгааны материал**

1. Хууль тогтоомжийн тухай хууль /аргачлал, гарын авлага/, Улаанбаатар хот, 2016 он;
2. ХЗДХЯ-ГТХАН хамтарсан төслөөс гаргасан “Иргэн, эдийн засгийн хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлын тайлан/Аялал жуулчлалын тухай хууль/, 2017 он;
3. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2017 оны эхний 10 сарын жуулчдын мэдээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулсан мэдээ, 2017 он.
4. “Аялал жуулчлалын салбарт төрөөс гүйцэтгэх үүргийг оновчтой болгох нь” Илтгэл, Э.Энхзаяа, 2017 он;
5. Нийслэлийн аялал жуулчлалын газар, Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн төв хамтран гаргасан “Улаанбаатар хотод аялсан гадаадын жуулчдын сэтгэл ханамжийн судалгааны тайлан”, 2017 он;

6. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Үндэсний хөгжлийн газар, Үндэсний статистикийн хороо, Ази-Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс, "МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВ ТАЙЛАН";
7. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Аялал жуулчлалын хөгжлийн төв, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим, Аялал жуулчлалын боловсрол, Хөгжлийн нийгэмлэг, "Аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчдэд үзүүлж буй цар тахлын нөлөө", 2022;
8. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2022 оны эхний тавдугаар сарын жуулчдын мэдээг 2021 оны мөн үетэй харьцуулсан мэдээ;
9. Үндэсний статистикийн хороо, Бүртгэгдсэн зам тээврийн осол, бүс, аймаг, нийслэлээр, Шинэчилсэн: 2022.04.0;
10. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2022 оны эхний тавдугаар сарын жуулчдын мэдээг 2021 оны мөн үетэй харьцуулсан мэдээ.

## III. Гадаад улсын хууль тогтоомж

1. Вьетнамын Аялал жуулчлалын тухай хууль;
2. Японы Аялал жуулчлалын тухай хууль;
3. Казакстаны Аялал жуулчлалын тухай хууль;
4. БСНУ-ын Аялал жуулчлалын тухай хууль;
5. Киргизстан;
6. Узбекистан;
7. ОХУ.
8. Турк улс.

## III. Цахим эх сурвалж

1.http://www.legalinfo.mn;
2.http://www.unwto.org;
3.http://www.mne.mn;
4.http://www.mongoliatourism.gov.mn;
5.http://www.travelmongolia.org;
6.http://www.tourism.ub.gov.mn.

# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО ХИЙСЭН ТАЙЛАН

2022 он
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР
ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

## Нэг.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн[1] 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/ батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан доорх зардлын тооцоог хийв.

Энэхүү тайлангийн зорилго нь Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад оршино.

Хуулийн төслийн тухайд ажлын хэсгийн боловсруулсан 2022 оны 11-р сарын 17-ны өдрийн төслийн хувилбарт зардлын тооцоог хийсэн бөгөөд хуулийн төслийн зохицуулалтаар буюу хуулийн төсөл батлагдсанаар зардал үүсэх боломж бүхий гурван субъектээс хуулийн этгээд, төрийн байгууллагад тодорхой зардал үүсгэхээр байна.

Хуулийн төслөөс хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлохдоо хуулийн төсөлд шинээр бий болж буй чиг үүргийн хүрээнд тодорхойлсон болно.

Түүнчлэн хуулийн төслөөр зөвхөн шинээр бий болж буй үүрэгт зардал тооцогдож байгаа тул бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдол нэлээд байсан тул аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, баримжаалах, салбарын мэргэжилтнүүдээс санал авах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон болно.

[1]“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн.

## Хоёр. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Энэ хэсэгт хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдийн хувьд тур операторын үйлчилгээ болон зочид буудлын үйлчилгээ эрхлэхэд аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталсан журмын дагуу бүртгүүлэх үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргана.

Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал"-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- нэг бүрийн зардлыг тооцох;
- тоон үзүүлэлтийг тооцох;
- нийт зардлын дүнг тооцож гаргах;
- хялбарчлах боломжийг шалгах;
- нэмэлт зардлыг тооцох.

### 2.1.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ ТОГТООХ:

Хуулийн төсөлд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Аялал жуулчлалын тухай хуульд[2] байхгүй шинээр үүсэж байгаа үүргийн хэмжээнд зардлын тооцоог хийх болно.

Хуулийн төсөлд хуулийн этгээдэд зардал үүсгэх дараах шаардлага бүхий шинэ үүрэг байна.

*Хүснэгт 1*

| |
|---|
| **Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг.**<br>Энэ хуулийн 5.2-т заасан ангилалд тусгагдаагүй байгууллага тусгай сонирхлын болон бусад төрлийн эрсдэл бүхий аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд энэ хуулийн 29.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бүртгүүлсэн байна. |
| **Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэг.**<br>Тур оператор, аяллын агент нь энэ хуулийн 29.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бүртгүүлсэн байна. |
| **Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг.**<br>Энэ хуулийн 5.2.1-д заасан тур операторын үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.30 дахь заалтад заасан тусгай зөвшөөрөлтэй эрхэлнэ. |

Дээрх үүргүүдийн мэдээллийн агуулгыг тодорхойлоход хуулийн төсөлд энэ талаар тодорхой тусгасан зохицуулалт байхгүй, өөрөөр хэлбэл хуулийн этгээдийн

[2] "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2000 оны 19 дугаарт нийтлэгдсэн

тур операторын үйлчилгээ болон аяллын агент, мөн бусад үйлчилгээ эрхлэхэд тус хуулийн төслийн 29.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээд буюу аялал жуулчлалын мэргэжлийн холбоонд бүртгүүлэхээр тусгасан нь хуулийн төслөөс мэдээллийн агуулгыг тодорхойлоход хүндрэлтэй байсан тул Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 31 дүгээр тушаалаар баталсан “Аялал жуулчлалын ангилал тогтоох журам”[3]-д заасан бичиг баримтын бүрдэл, практик дээрх ижил төстэй шаардлагаас баримжаалж, мөн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны холбогдох мэргэжилтнээс энэ талаарх тодруулж мэдээллийг авах зэргээр гүйцэтгэх үүрэг, мэдээллийн агуулгыг дараахь байдлаар тодорхойлов.

Мөн хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт заасан бүртгүүлэх үүргийг 11 дүгээр зүйлд заасан тур операторын үйл ажиллагаа эрхлэгч нь тусгай зөвшөөрөл авах тохиолдолд биелүүлэх боломжтой юм. Хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.6-д “Энэ хуулийн 5.8-д аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэл олгох, 9 дүгээр зүйлд заасан жуулчны хөтчид үнэмлэх олгох, бүртгэх, 11 дүгээр зүйлд заасан тур операторын тусгай зөвшөөрөл олгох чиг үүргийг Холбоогоор гүйцэтгүүлж болно” гэж заасныэс үзвэл тур операторын үйл ажиллагаа эрхлэгчийг тусгай зөвшөөрөл олгох, мөн бүртгэх үйл ажиллагааг аялал жуулчлалын мэргэжлийн холбоо гүйцэтгэх боломжтой байна. Иймд тур операторын үйл ажиллагаа эрхлэгчийн хуулийн төсөл батлагдсанаар хүлээх үүрэг болох 1.бүртгүүлэх, 2.тусгай зөвшөөрөл авахтай холбоотой биелүүлэх үүргийг нэгтгэн зардлын тооцоолол хийх боломжтой гэж үзлээ.

*Хүснэгт 2*

| Д/д | Гүйцэтгэх үүрэг | Үүргийн мэдээллийн агуулга | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | 1.1.Тур операторын үйлчилгээ эрхлэхэд аялал жуулчлалын мэргэжлийн холбоонд бүртгүүлсэн байна, | Хүсэлт гаргах тухай албан бичиг /маягт бөглөх/ | Энэ харилцаа нь энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгууллагуудыг бүртгэх шинэ нийтийн эрх зүйн этгээд бий болж байгаагаар зохицуулагдахаар хуулийн төсөлд тусгасан тул зардал тооцох шинэ үүрэгт оруулав. |
| | | Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар | |
| | | Өмнөх жилд үйлчилсэн жуулчдын тоо, санхүү, эдийн засгийн үзүүлэлт /үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын тухайд/ | |
| | 1.2.Тур операторын үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.30 дахь заалтад заасан тусгай зөвшөөрөлтэй эрхлэнэ. | Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө | |
| | | Аялал жуулчлалын мэргэжлийн боловсон хүчний талаарх мэдээлэл, диплом, сертификатын хуулбар, хөдөлмөрийн гэрээ | |
| | | Ажлын байрны түрээсийн гэрээ эсвэл өөрийн өмчийн ажлын байр бол үл хөдлөх хөрөнгийн | |

[3] Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 09-р сарын 02-ны өдрийн дугаар 31 “Аялал жуулчлалын айгууллагын ангилал тогтоох журам”, сүүлийн нэвтрэлт, 2022 оны 11 дүгээр сар.

| | | | |
|---|---|---|---|
| | | гэрчилгээний хуулбар | |
| | | Бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаат байдлыг хангах, жуулчдын эрх ашгийг хамгаалах үүднээс жуулчинтай байгуулах гэрээний төсөл /гадаад орон руу/ | |
| | | Аяллын хөтөлбөр, багц үнийн судалгаа /гадаад орон руу жуулчин илгээх тур оператортˊ/ | |
| | | Даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан байх /гадаад орон руу жуулчин илгээх тур оператортˊ/ | |
| 2 | Аяллын агентын үйлчилгээ эрхлэхэд аялал жуулчлалын мэргэжлийн холбоонд бүртгүүлсэн байна. | Хүсэлт гаргах тухай албан бичиг /маягт бөглөх/ | Энэ харилцаа нь энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгууллагуудыг бүртгэх шинэ нийтийн эрх зүйн этгээд бий болж байгаагаар зохицуулагдахаар хуулийн төсөлд тусгасан тул зардал тооцох шинэ үүрэгт оруулав. |
| | | Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар | |
| | | Өмнөх жилд үйлчилсэн жуулчдын тоо, санхүү, эдийн засгийн үзүүлэлт /үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын тухайд/ | |
| | | Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө | |
| | | Аялал жуулчлалын мэргэжлийн боловсон хүчний талаарх мэдээлэл, диплом, сертификатын хуулбар, хөдөлмөрийн гэрээ | |
| | | Ажлын байрны түрээсийн гэрээ эсвэл өөрийн өмчийн ажлын байр бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар | |
| | | Бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаат байдлыг хангах, жуулчдын эрх ашгийг хамгаалах үүднээс жуулчинтай байгуулах гэрээний төсөл /гадаад орон руу/ | |
| | | Аяллын хөтөлбөр, багц үнийн судалгаа /гадаад орон руу жуулчин илгээх тур оператортˊ/ | |
| | | Даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан байх /гадаад орон руу жуулчин илгээх тур оператортˊ/ | |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | Энэ хуулийн 5.2-т заасан ангилалд тусгагдаагүй байгууллага тусгай сонирхлын болон бусад төрлийн эрсдэл бүхий аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд энэ хуулийн 29.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бүртгүүлсэн байна. | | |

## 2.2.НЭГ БҮРИЙН ЗАРДЛЫГ ТООЦОХ:

Энэ шатанд өмнөх шатанд тодорхойлсон тур оператор, аяллын агент болон бусад эрсдэл бүхий аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах бусад төрлийн хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, түүнийг гүйцэтгэхэд нэг хуулийн этгээдээс зарцуулах мөнгөн зардлыг тооцоолон гаргана. Ингэхдээ дараахь дарааллыг баримтална. Үүнд:




Стандарт үйл ажиллагаа болон зарцуулах хугацааг тодорхойлохдоо Засгийн газрын 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтад заасан хугацааг харгалзан үзэхийн зэрэгцээ аялал жуулчлалын байгууллагын албан хаагчидттай уулзалт ярилцлагын дүнд бий болсон үр дүнг ашигласан болно.

*Хүснэгт 3*

| д/д | Гүйцэтгэх үүрэг | Мэдээллийн агуулга | Стандарт үйл ажиллагаа | Хугацаа /мин/ |
|---|---|---|---|---|
| 1 | Тур операторын үйлчилгээ эрхлэхэд аялал жуулчлалын мэргэжлийн холбоонд бүртгүүлсэн | Хүсэлт гаргасан албан бичиг | маягт бөглөх | 20 |
| | | Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар батлуулсан хуулбар | улсын бүртгэлийн гэрчилгээг нотариатаар гэрчлүүлэх | 20 |
| | | Өмнөх жилд үйлчилсэн жуулчдын тоо, санхүү, эдийн | үйлчилсэн жуулчдын тоо бүртгэлийг нэгтгэн гаргах | 20 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | байна.<br><br>Тур операторын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй эрхэлнэ. | засгийн үзүүлэлт /үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын тухайд/ | тайлан мэдээг бэлтгэх | 20 |
| | | Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө | Бизнес төлөвлөгөөг олшруулж бэлтгэх | 15 |
| | | Аялал жуулчлалын мэргэжлийн боловсон хүчний талаарх мэдээлэл, диплом, сертификатын хуулбар, хөдөлмөрийн гэрээ | мэргэжлийн ажиллах хүчний талаарх мэдээлэл бэлтгэх | 60 |
| | | | мэргэжлийн боловсон хүчний диплом, сзртификатыг хуулбарлах | 15 |
| | | | Хөдөлмөрийн гэрээг олшруулж бэлтгэх | 15 |
| | | Ажлын байрны түрээсийн гэрээ эсвэл өөрийн өмчийн ажлын байр бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар | түрээсийн гэрээ эсхүл үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг хуулбарлах | 10 |
| | | Бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаат байдлыг хангах, жуулчдын эрх ашгийг хамгаалах үүднээс жуулчинтай байгуулах гэрээний төсөл | Гэрээний төсөл бэлтгэх | 120 |
| | | | гэрээний төслийг хуулбарлаж хавсаргах | 5 |
| | | Аяллын хөтөлбөр, багц үнийн судалгаа | аялалын хөтөлбөр боловсруулах | 120 |
| | | | үнийн судалгаа хийж үнийн багц гаргах | 120 |
| | | Даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан байх | Даатгалын байгууллагыг судалж гэрээ байгуулах | 240 |
| | | | Даатгалын гэрээг хуулбарлах | 5 |
| **2** | **НИЙТ ЗАРЦУУЛАХ ХУГАЦАА** | | | **805 минут** |

*Хүснэгт 4*

| д/д | Гүйцэтгэх үүрэг | Мэдээллийн агуулга | Стандарт үйл ажиллагаа | Хугацаа /мин/ |
|---|---|---|---|---|
| 1 | Аяллын агентын үйлчилгээ эрхлэхэд аялал жуулчлалын мэргэжлийн холбоонд бүртгүүлсэн байна. | Хүсэлт гаргасан албан бичиг | маягт бөглөх | 20 |
| | | Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар батлуулсан хуулбар | улсын бүртгэлийн гэрчилгээг нотариатаар гэрчлүүлэх | 20 |
| | | Өмнөх жилд үйлчилсэн жуулчдын тоо, санхүү, эдийн засгийн үзүүлэлт /үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын тухайд/ | үйлчилсэн жуулчдын тоо бүртгэлийг нэгтгэн гаргах | 20 |
| | | | тайлан мэдээг бэлтгэх | 20 |
| | | Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө | Бизнес төлөвлөгөөг олшруулж бэлтгэх | 15 |
| | | Аялал жуулчлалын мэргэжлийн боловсон хүчний талаарх мэдээлэл, диплом, сертификатын хуулбар, хөдөлмөрийн гэрээ | мэргэжлийн ажиллах хүчний талаарх мэдээлэл бэлтгэх | 60 |
| | | | мэргэжлийн боловсон хүчний диплом, сзртификатыг хуулбарлах | 15 |
| | | | Хөдөлмөрийн гэрээг олшруулж бэлтгэх | 15 |
| | | Ажлын байрны түрээсийн гэрээ эсвэл өөрийн өмчийн ажлын байр бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар | түрээсийн гэрээ эсхүл үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг хуулбарлах | 10 |
| | | Бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаат байдлыг хангах, жуулчдын эрх ашгийг хамгаалах үүднээс жуулчинтай байгуулах гэрээний төсөл | Гэрээний төсөл бэлтгэх | 120 |
| | | | гэрээний төслийг хуулбарлаж хавсаргах | 5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Аяллын хөтөлбөр, багц үнийн судалгаа | аялалын хөтөлбөр боловсруулах | 120 |
| | | | үнийн судалгаа хийж үнийн багц гаргах | 120 |
| | | Даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан байх | Даатгалын байгууллагыг судалж гэрээ байгуулах | 240 |
| | | | Даатгалын гэрээг хуулбарлах | 5 |
| **2** | **НИЙТ ЗАРЦУУЛАХ ХУГАЦАА** | | | **805 минут** |

*Хүснэгт 5*

| **д/д** | **Гүйцэтгэх үүрэг** | **Мэдээллийн агуулга** | **Стандарт үйл ажиллагаа** | **Хугацаа /мин/** |
|---|---|---|---|---|
| 2 | Энэ хуулийн 5.2-т заасан ангилалд тусгагдаагүй байгууллага тусгай сонирхлын болон бусад төрлийн эрсдэл бүхий аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд энэ хуулийн 29.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бүртгүүлсэн байна. | Бүртгүүлэх тухай хүсэлт | хүсэлт гаргах тухай албан бичиг боловсруулах | 30 |
| | | Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар | Улсын бүртгэлийн гэрчилгээг хуулбарлах | 5 |
| | | Аялагч болон жуулчдыг шаардлагатай даатгалын үйл ажиллагаанд хамруулсан талаарх баримт | Даатгалын гэрээг хуулбарлах | 5 |
| | **НИЙТ ЗАРЦУУЛАХ ХУГАЦАА** | | | **40 минут** |

**Ажлын хөлсийг** тооцож гаргахдаа ажилтанд олгох сарын үндсэн цалинг ажиллах хугацаанд хувааж ажлын хөлсийг өдөр, цаг, минутаар гаргана. Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар нэг ажилтанд ногдох сарын дундаж цалин 2022 оны 02-р сарын байдлаар 1,544,400 (нэг сая таван зуун дөчин дөрвөн мянга дөрвөн зуу) төгрөг[4] байна.

Ажиллах хугацааг тооцоолохдоо Хөдөлмөрийн тухай хуульд заасан хөдөлмөрийн цагийг үндэслэв.

[4]http://1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0400_022V1&Salbar_select_all=0&SalbarSingleSelect=_1&Gender_select_all=0&GenderSingleSelect=_1&YearQ_select_all=0&YearQSingleSelect=_202202_202102_202002&YearY_select_all=0&YearYSingleSelect=&viewtype=linechart.

| Ажлын хөлс = Үндсэн цалинг : ажиллах хугацаа |
|---|
| 1,544,400 : 22 өдөр : 8 цаг : 60 минут = 146,25 төгрөг |

Дээрх үүргийг хэрэгжүүлэхэд нэг хуулийн этгээдэд үүсгэж байгаа зардлыг үйл ажиллагаа тус бүрд зарцуулж буй хугацааг ажлын хөлсөөр үржүүлэх замаар тооцоолох юм.

*Хүснэгт 6*

| д/д | Гүйцэтгэх үүрэг | Зарцуулах хугацаа | Ажлын хөлс | Нэг бүрийн зардал |
|---|---|---|---|---|
| 1 | Тур операторын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авах, аялал жуулчлалын мэргэжлийн холбоонд бүртгүүлсэн байна. | 805 минут | 146,25 төгрөг | 117,731.25 төгрөг |
| 2 | Аяллын агентын үйлчилгээ эрхлэхэд аялал жуулчлалын мэргэжлийн холбоонд бүртгүүлсэн байна.. | 805 минут | 146,25 төгрөг | 117,731.25 төгрөг |
| 3 | Тусгай сонирхлын болон бусад төрлийн эрсдэл бүхий аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх байгууллага аялал жуулчлалын мэргэжлийн холбоонд бүртгүүлсэн байх. | 40 минут | 146,25 төгрөг | 5,850 төгрөг |

## 2.3.ТООН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОГТООХ:

Энэ үе шатанд өмнөх үе шатуудад тогтоосон Аялал жуулчлалын тухай хуулийн төсөл батлагдсан гарснаар шинээр болж буй дээрх үүргүүдийг хичнээн хуулийн этгээд, жилд хэдэн удаа гүйцэтгэх вэ гэдгийг хуанлийн нэг жилээр тооцоолон гаргах юм.

Энэ үзүүлэлтийг гаргахын тулд тохиолдлын тоо болон давтамжийг холбогдох статистик мэдээ ашиглан тодорхойлж гаргах бөгөөд тэдгээрийн үржвэрээр "тоон үзүүлэлт" нь илэрхийлэгдэх юм. Үүнийг дараах томъёогоор илэрхийлнэ.

| ТОХИОЛДЛЫН ТОО х ДАВТАМЖ = ТООН ҮЗҮҮЛЭЛТ |
|---|

Дээрх томъёог ашиглан Аялал жуулчлалын тухай хуулийн төсөл батлагдснаар шинээр нэмэгдэж байгаа гэж тодорхойлогдсон үүрэг тус бүрд тоон үзүүлэлтийг тогтооё.

*Хүснэгт 7*

| Д/д | Гүйцэтгэх үүрэг | Тохиолдлын тоо | x | Давтамж | = | Тоон үзүүлэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Тур операторын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авах, аялал жуулчлалын мэргэжлийн холбоонд бүртгүүлсэн байх. | 570[5] | x | 1 | = | 455 |
| 2 | Аяллын агентын үйлчилгээ эрхлэхэд аялал жуулчлалын мэргэжлийн холбоонд бүртгүүлсэн байх. | 520[6] | x | 1 | = | 488 |
| 3 | Тусгай сонирхлын болон бусад төрлийн эрсдэл бүхий аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх байгууллага аялал жуулчлалын мэргэжлийн холбоонд бүртгүүлсэн байх. | Тооцоолох боломжгүй[7] | x | 1 | = | |

## 2.4.НИЙТ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫН ДҮНГ ТООЦОЖ ГАРГАХ:

Энэ үе шатанд өмнөх үе шатанд гаргасан үүрэг тус бүрд ногдох нэг бүрийн зардлыг "тоон үзүүлэлтээр үржүүлснээр гаргах юм.

| НЭГ БҮРИЙН ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ x ТООН ҮЗҮҮЛЭЛТ = НИЙТ ЗАРДАЛ |
|---|

*Хүснэгт 8*

| Д/д | Гүйцэтгэх үүрэг | Нэг бүрийн зардал | x | Тоон үзүүлэлт | = | Нийт зардал[8] |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Тур операторын үйлчилгээ эрхлэхэд аялал жуулчлалын мэргэжлийн холбоонд бүртгүүлсэн байна. | 117,731.25 төгрөг | x | 570 | = | 67,106,812.5 |
| 2 | Аяллын агентын үйлчилгээ эрхлэхэд аялал жуулчлалын мэргэжлийн холбоонд бүртгүүлсэн байна. | 117,731.25 төгрөг | x | 520 | = | 61,220,250 |

[5]БОАЖЯ-аас гаргаж ирүүлсэн статистик мэдээллээр 2021 онд 570 тур оператор үйл ажиллага явуулж байгаа бөгөөд хуулийн төсөл батлагдсан эдгээр нь бүгд бүртгүүлэх шаардлагатай болох тул одоо үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн тоогоор тоихолдлын тоог авлаа.
[6]БОАЖЯ-аас гаргаж ирүүлсэн статистик мэдээллээр 2021 оны байдлаар 520 зочид буудал үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд хуулийн төсөл батлагдаж хэрэгжснээр эдгээр нь бүгд бүртгүүлэх шаардлагатай болох тул одоо үйл ажиллаагаа явуулж байгаа зочид буудлын тоогоор тохиолдлын тоог тодорхойлов.
[7]Манай улсад энэ төрлийн үйл ажиллагаа жил бүр зохион байгуулагддаг хэдий ч одоогийн нөхцөлд эдгээр үйл ажиллагааг бүртгэх, хянах, нэгдсэн тоон мэдээллийг гаргах чиг үүрэг бүхий байгууллага байхгүй байгаа тул тоон мэдээллийг тооцоолох боломжгүй байна.
[8]"Нийт зардал" гэдэг нь уг хуулийн төсөл батлагдан гарснаар хуулийн төсөлд тусгагдсан үүргийг биелүүлэх нийт хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал юм.

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | Тусгай сонирхлын болон бусад төрлийн эрсдэл бүхий аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх байгууллага аялал жуулчлалын мэргэжлийн холбоонд бүртгүүлсэн байх. | 5,850 төгрөг | x | | = | |
| 4 | ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЧ БУЙ НИЙТ ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ | **128,327,062.5** | | | | |

## 2.5.ХУВИЛБАРЫГ НЯГТАЛЖ, ХЯЛБАРЧЛАХ БОЛОМЖИЙН ТАЛААР:

Тур операторын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах, бүртгүүлэх, аяллын агентын бүртгэл хийлгэх, мөн тусгай сонирхлын аялал, бусад төрлийн эрсдэл бүхий аялал зохион байгуулахтай холбогдуула бичгээр, цахимаар холимог бус цахимаар дагнан бүртгэхэд хуулийн этгээдэд үүсэх зардлыг багасгах, хялбарчлах боломжтой гэж үзэж байна.

Төрийн байгууллагууд хоорондоо мэдээлэл солилцох замаар олж мэдэх боломжтой баримт бичгийг хуулийн этгээдээс шаардахгүй байх нь нотариатаар батлуулах, хуулбарлах, хүргүүлэх, олшруулах зэрэг нэмэлт зардал, хүнд суртал, чирэгдлийг бууруулахад тодорхой нөлөөтэй гэж үзлээ. Түүнчлэн хуулийн төслийн 30 дугаар зүйл 30.1 дэх хэсэгт “Аялал жуулчлалын салбарын эдийн засагт үзүүлж байгаа өсөлтийг тодорхойлох, аялал жуулчлалын судалгаа, шинжилгээ, статистик мэдээллийг хөгжүүлэх зорилго бүхий аялал жуулчлалын мэдээллийн сан байна” гэж заасан бөгөөд тус санг Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сантай холбосон тохиолдолд зардлын тооцооллын өмнөх хэсэгт дурдсан дараах мэдээлэлтэй холбоотой зардлыг шууд хэмнэж болохоор байна. Үүнд:

*Хүснэгт 9*

| Бүрдүүлэх баримт бичиг | Гүйцэтгэх үүрэг | Хугацаа /мин/ |
|---|---|---|
| Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар батлуулсан хуулбар | улсын бүртгэлийн гэрчилгээг нотариатаар гэрчлүүлэх | 20 |
| Өмнөх жилд үйлчилсэн жуулчдын тоо, санхүү, эдийн засгийн үзүүлэлт /үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын тухайд/ | үйлчилсэн жуулчдын тоо бүртгэлийг нэгтгэн гаргах | 20 |
| | тайлан мэдээг бэлтгэх | 20 |
| Аялал жуулчлалын мэргэжлийн боловсон хүчний талаарх мэдээлэл, | мэргэжлийн ажиллах хүчний талаарх мэдээлэл бэлтгэх | 60 |

| | | |
|---|---|---|
| диплом, сертификатын хуулбар, хөдөлмөрийн гэрээ | мэргэжлийн боловсон хүчний диплом, сэртификатыг хуулбарлах | 15 |
| | Хөдөлмөрийн гэрээг олшруулж бэлтгэх | 15 |
| Нийт | | 150 |

Дээрхийг нэгтгэн тооцвол нийт 150 минут, түүнд ногдох зардлыг хэмнэх боломжтой буюу тусгай зөвшөөрөл хүсэгч болон бүртгэл хийлгэх үүрэг хүлээсэн байгууллага тус бүрийн гарах зардлаас нийт 117,731.25 төгрөгийн зардлаас 21,937.5 төгрөгийг хэмнэх боломжтой байна.

### 2.6.НЭМЭЛТ ЗАРДЛЫГ ТООЦОХ:

Аялал жуулчлалын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийн этгээдээс хуульд заасан үүргийг биелүүлэхийн тулд зайлшгүй төлөхөөр хуулиар тогтоосон төлбөр хураамж, тоног төхөөрөмж, материал зэргийг нэмэлт зардал гэсэн ойлголтонд хамруулах юм. Үүнийг нэмэлт зардлыг тоон үзүүлэлтээр үржүүлэх замаар гаргаж авна. Өмнөх шатанд тодорхойлогдсон үүргүүдэд нэмэлт зардал гарахгүй гэж үзлээ.

## ГУРАВ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1-д зааснаар “Аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн $21^4$.1-д заасан дараах үйл ажиллагааг санхүүжүүлнэ” гэж тусгасан байна. Энэ нь хуулийн төслийн хүрээнд шинээр бий болж байгаа бүтэц байх тул бүтцийг дагаж зардал гарна хэмээн үзэж үүсэх зардлыг тооцоолох болно.

| |
|---|
| **Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг.**<br>Аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн $21^4$.1-д заасан дараах үйл ажиллагааг санхүүжүүлнэ:<br><br>**Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1.1-1.4 дэх заалт.**<br>16.1.1.агаарын зорчигч тээврийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;<br>16.1.2.аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх;<br>16.1.3.Монгол Улсыг гадаад, дотоодод сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах;<br>16.1.4.аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгох, хөгжүүлэх;<br><br>**Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг.**<br>Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан нь аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд ажиллана |

Хуулийн төсөл батлагдснаар төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцоолохдоо дараахь дарааллаар гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Аялал жуулчлалын сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын алба бий болсноор хэрэгжүүлэх чиг үүргийг тогтоох;
- Уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох;
- Гарах зардлыг тооцох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж зардлыг бууруулах боломжийг эрэлхийлэх.

### 3.1.ГҮЙЦЭТГЭХ ЧИГ ҮҮРГИЙГ ТОГТООХ:

Хуулийн төслөөр дараахь чиг үүргийг шинээр бий болж буй Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан нь хэрэгжүүлэхээр байна.

- агаарын зорчигч тээврийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх;
- Монгол Улсыг гадаад, дотоодод сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах;
- аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгох, хөгжүүлэх.

### 3.2.ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ХҮНИЙ НӨӨЦИЙГ ТОДОРХОЙЛОХ:

Тухайн чиг үүрэг, түүнд хамаарах ажил үйлчилгээг хэрэгжүүлэх хугацаа болон уг ажил үйлчилгээг нэг жилд хэдэн удаа /хэдэн иргэн, хуулийн этгээдэд/ гүйцэтгэх тоо /тохиолдлын тоо/, шаардагдах нийт ажлын цаг гэсэн гурван үзүүлэлтээр тооцоолон гаргана.

Зарцуулах хугацааг тодорхойлохдоо төрийн байгууллагын адил төстэй өөр бусад чиг үүргийг судлах болон аялал жуулчлалын асуудал эрхэлсэн байгууллагын холбогдох асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй харилцан санал солилцсны дүнд баримжаалан чиг үүрэгт тус бүрээр тогтоолоо.

*Хүснэгт 10*

| Д/Д | Үүргийг хэрэгжүүлэх байгууллага | Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ | Стандарт үйл ажиллагаа | Зарцуулах хугацаа | Тохиолдлын тоо | Хүний нөөцийн хэрэгцээ /цагаар/ |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | цагаар | | |
| 1 | Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан | агаарын зорчигч тээврийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх /16.1.1/ | Монгол Улсын аялал жуулчлалын орчин нөхцөлд судалгаа, дүн шинжилгээ хийх | 160 | 3 | 480 |
| | | | Агаарын зорчигч тээврийн нэмэгдүүлэх боломжит хувилбарыг боловсруулах | 160 | 3 | 480 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Агаарын зорчигч тээврийн нэмэгдүүлэх бодлого, хөтөлбөрийг эрх бүхий байгууллагаар батлуулах | 80 | 3 | 240 |
| | | | батлагдсан бодлого, хөтөлбөрийг олон нийтэд таниулах | 40 | 3 | 120 |
| | | | бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах | 160 | 3 | 480 |
| | | **НИЙТ ХУГАЦАА** | | | | 1800 |
| **1800/ 8 цаг = 225 ажлын өдөр / 200 нэг жилийн ажлын өдөр = 1.12 хүний нөөц** | | | | | | |

*Хүснэгт 11*

| **Д/Д** | **Үүргийг хэрэгжүүлэх байгууллага** | **Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ** | **Стандарт үйл ажиллагаа** | **Зарцуулах хугацаа** | **Тохиолдлын тоо** | **Хүний нөөцийн хэрэгцээ /цагаар/** |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | **цагаар** | | |
| 2 | Аялал жуулчлалын хөгжүүлэх сан | аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх /хуулийн төслийн 16.1.2/ | Сургалт зохион байгуулах | 40 | 4 | 160 |
| | | | судалгаа шинжилгээ хийх | 80 | 4 | 240 |
| | | | төсөл хөтөлбөр шалгаруулах | 160 | 1 | 160 |
| | | | төсөл, хөтөлбөрийг хэрэгжилтэд хяналт тавих | 80 | 4 | 240 |
| НИЙТ ХУГАЦАА | | | | | | 800 |
| **800 цаг / 8 цаг = 100 ажлын өдөр / 200 нэг жилийн ажлын өдөр = 0.5 хүний нөөц** | | | | | | |

*Хүснэгт 12*

| **Д/Д** | **Үүргийг хэрэгжүүлэх байгууллага** | **Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ** | **Стандарт үйл ажиллагаа** | **Зарцуулах хугацаа** | **Тохиолдлын тоо** | **Хүний нөөцийн хэрэгцээ /цагаар/** |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | **цагаар** | | |
| 3 | Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан | Монгол Улсыг гадаад, дотоодод сурталчлах үйл ажиллагааг зохион | Сурталчилгааны кино хийх | 320 | 1 | 320 |
| | | | Сурталчилгааны нэвтрүүлэг хийх | 240 | 1 | 240 |
| | | | дүрс болон дууны бичлэг хийх | 240 | 1 | 240 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулах /хуулийн төслийн 16.1.3/ | ном, ил захидал, танилцуулга, цомог хэвлэх | 320 | 1 | 320 |
| | | | мэргэжлийн сэтгүүл гаргах | 80 | 4 | 240 |
| | | | хурал зөвлөгөөн зохион байгуулах | 80 | 3 | 240 |
| | | | Үзэсгэлэн, яармаг зохион байгуулах | 120 | 2 | 240 |
| НИЙТ ХУГАЦАА | | | | | | 1840 |
| **1840 цаг / 8 цаг = 230 ажлын өдөр / 200 нэг жилийн ажлын өдөр = 1.15 хүний нөөц** | | | | | | |

*Хүснэгт 13*

| **Д/Д** | **Үүргийг хэрэгжүүлэх байгууллага** | **Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ** | **Стандарт үйл ажиллагаа** | **Зарцуулах хугацаа** | **Тохиолдлын тоо** | **Хүний нөөцийн хэрэгцээ /цагаар/** |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | **цагаар** | | |
| 4 | Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан | аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгох, хөгжүүлэх /хуулийн төслийн 16.1.4/ | Аялал жуулчлалын дэд бүтэц байгуулаж буй төсөл хөтөлбөрүүдийг хүлээж авах | 8 | 12 | 96 |
| | | | дэд бүтэц байгуулах төсөл, хөтөлбөрийг үнэлэх | 40 | 12 | 480 |
| | | | дэд бүтэц байгуулах төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх боломж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх | 16 | 12 | 182 |
| | | | төсөл, хөтөлбөрийг санхүүлэх | 24 | 12 | 288 |
| | | | төсөл, хөтөлбөрийг хэрэгжилтэнд хяналт тавина. | 40 | 12 | 480 |
| **Нийт хугацаа** | | | | | | **1526** |
| **1526 цаг / 8 цаг = 190.75 ажлын өдөр / 200 нэг жилийн ажлын өдөр = 0.95 хүний нөөц** | | | | | | |

*Хүснэгт 14*

| **Д/Д** | **Үүргийг хэрэгжүүлэх байгууллага** | **Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ** | **Стандарт үйл ажиллагаа** | **Зарцуулах хугацаа /цагаар/** | **Тохиолдлын тоо** | **Хүний нөөцийн хэрэгцээ /минутаар/** |
|---|---|---|---|---|---|---|
| 5 | Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний сан | Дотоод ажил | Дотоод ажил | 1600 | 1 | 1600 |
| | | | **НИЙТ ХУГАЦАА** | | | 1,600.00 |
| **1600 цаг / 8 нэг өдрийн ажлын цаг = 200 ажлын өдөр / 200 нэг жилийн ажлын өдөр = 1 хүний нөөц** | | | | | | |

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан байгуулагдан ажиллахад дараах чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг нэгтгэн үзүүлбэл:

*Хүснэгт 15*

| д/д | Хэрэгжүүлэх чиг үүрэг | Шаардлагатай хүний нөөц |
|---|---|---|
| 1 | агаарын зорчигч тээврийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх | 1,12 |
| 2 | аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх | 0,5 |
| 3 | Монгол Улсыг гадаад, дотоодод сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах | 1,15 |
| 4 | аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгох, хөгжүүлэх | 0.95 |
| 5 | Дотоод ажил | 1,8 |
| **6** | **НИЙТ** | **6 албан хаагч** |

Хуулийн төсөлд тусгаагүй боловч дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхэд “дотоод ажил” хариуцах нэг ажилтанг автоматаар тооцоонд оруулав.

## 3.3.ГАРАХ ЗАРДЛЫГ ТООЦООЛОХ:

Аялал жуулчлалын тухай хуулийн төслийн улмаас улсын төсөвт үүсэх төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалд заасны дагуу

- Хүний нөөцийн зардал[9]
- Материаллаг зардал[10]
- Бусад зардал[11] гэсэн зардлын төрлүүдийг тооцоолон гаргах юм.

Сан нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэд ажиллах бөгөөд өмнө дурдсанчлан сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 6 албан хаагчийн зардал гархаар байна.

### А.Хүний нөөцийн зардал

Хүний нөөцийн зардлыг тооцохдоо тухайн ажил үйлчилгээ буюу үүргийг гүйцэтгэх төрийн захиргааны байгууллагын албан хаагчид зарцуулах цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал зэрэг төрөөс даадаг бүх зардлыг нэгтгэн авч үзэх ба эдгээрийн дундаж хэмжээгээр тооцож тогтооно.

Хүний нөөцийн зардлыг тооцоход нэг ажилтанд оногдох зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05-р сарын 11-ний өдрийн дугаар 192 “Тогтоол,

[9]Хүний нөөцийн зардал гэдэгт тухайн үүргийг гүйцэтгэх төрийн албан хаагчийн авч болох цалин хөлс, бусад нэмэгдэл, тусламж, төрөөс албан хаагчдаа зориулан даадаг хүний нөөцтэй холбоотой гаргасан зардлыг нэг албан хаагчид оногдох хэмжээгээр тооцоолсныг ойлгоно.

[10]Материаллаг зардал гэдэгт тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг ойлгоно. Цахилгаан дулаан, бичиг хэрэг, урсгал засвар, тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын гэх мэт
[11]Бусад зардал гэдэгт тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах шуудзардлыг ойлгоно.

тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" тогтоолын "Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ"-ний ТҮ-1-ээс ТҮ-12 хүртэлх албан тушаалын зэрэглэлийн цалингийн доод хэмжээний дундаж ТҮ-6 буюу 709,576 төгрөг байхаар тооцов.

Мөн нэг албан хаагчид зарцуулах зардлыг тооцохдоо түүний үндсэн цалингаас гадна 1/ бүх төрлийн даатгал, 2/ хоол, унааны нэмэгдэл, 3/ ажилласан жилийн нэмэгдэл, 4/ зэрэг дэвийн нэмэгдэл, 5/ буцалтгүй тусламж, 6/ шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Эдгээрийн хэмжээг тодорхой тогтоох боломжгүй тохиолдолд нэг албан хаагчийн цалингийн дундаж хэмжээний 15%-иар нийтлэг зардлыг, 10%-иар дагалдах зардлыг, 30%иар нэмэгдэл, урамшууллын зардлыг тооцох боломжтой юм. Албан хаагчид 1 жилд зарцуулах цалингийн зардлын хэмжээг хүснэгт 16-д авч үзэв.

*Хүснэгт 16*

| Албан тушаал | Цалингийн зэрэглэл | Үндсэн цалин | Нэмэгдэл, урамшуулал [12] | Дагалдах зардал | НДШ [13] | 1 сарын цалин | 12 сарын цалин |
|---|---|---|---|---|---|---|---|
| Сангийн ажлын албаны ажилтан | ТҮ-6 | 709,576 | 212,872.8 | 70,957.6 | 90,116.152 | 1,083,522.55 | 13,002,270.624 |

Дээрх зардал нь сангийн ажлын албаны нэг албан хаагчид зарцуулах хүний нөөцийн зардал бөгөөд сан нь байнгын үйл ажиллагаатай, мөн 6 ажилтан тогтмол ажиллана гэж тооцвол нэг жилд нийт 78,013,623 төгрөг зөвхөн хүний нөөцийн шаардлагатай байна.

## Б.Материаллаг зардал

Энэхүү зардалд тухайн ажлын байранд ажиллах ажилтны шаардлагатай нийт зардлын тоймлон авч үзнэ. Тухайлбал цахилгааны зардал, техник тоног төхөөрөмжийн зардал, бичиг хэргийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал орох бөгөөд бүгд нийлээд "ажлын байрны ердийн дундаж материаллаг зардал"-ыг бүрдүүлнэ. Материаллаг зардал, ажлын байрны зардлын жишээг Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газрын нэг ажилтны нэг ажилтны материаллаг зардлыг тооцсон 2020 оны жишээгээр авав.[14][15][16] Нэг албан хаагчид гарах материаллаг зардлыг хүснэгт 17-д авч үзэв.

[12] Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "*Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-д заасан хугацааны дундаж болон бусад шагнал, урамшууллын зардлыг нэгтгэн тооцов. Эх сурвалж:* https://www.legalinfo.mn/annex/details/9070?lawid=13946

[13] Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлд үндэслэн тогтоов. Эх сурвалж: https://www.legalinfo.mn/law/details/390

[14] Батлагдсан төсөв.

*Хүснэгт 17*

| Зардлын нэр | Зардлын төрөл | Хэмжээ /төгрөг/ |
|---|---|---|
| Урсгал зардал | Бичиг хэргийн зардал | 124,000 |
| | Ном, хэвлэл авах | 54,745 |
| | Шуудан холбоо | 306,812 |
| | **Нийт** | **485,557** |
| Барилга, байгууламж, өрөө тасалгааны зардал | Түлш, халаалт | 263,408 |
| | Гэрэл, цахилгаан | 128,239 |
| | Цэвэр, бохир ус | 599,438 |
| | Урсгал засвар | 127,752 |
| | Газрын төлбөр | 22,253 |
| | **Нийт** | **1,141,090** |
| Элэгдэл, хорогдлын зардал[14] | Техник, тоног төхөөрөмж[15] | 160,000 |
| | Тавилга, эд хогшил[17] | 100,000 |
| | Барилга, байгууламж[18] | 65,670 |
| | **Нийт** | **325,670** |

Дээр дурдсан зардлууд бүгд нийлээд "ажлын байрны ердийн дундаж материаллаг зардал"-ыг бүрдүүлнэ. Хүснэгт 18-д Ажлын байртай холбоотой үүсэх дундаж материаллаг зардлыг авч үзэв.

*Хүснэгт 18*

| **Материаллаг зардал** | **Зардлын хэмжээ /төгрөг** |
|---|---|
| Урсгал зардал | 485,557 |

[15] Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам, Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдэлийн хэмжээ.

[16] Нэг албан хаагчид хэрэглэгдэж буй техник, тоног төхөөрөмжийн үнийг дунджаар 800,000 төгрөгөөр тооцож, түүний элэгдэл хорогдлын хэмжээг ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолоор баталсан "Үндсэн

[17] Тавилга, эд хогшлын үнийг дунджаар 1,000,000 төгрөгөөр тооцож, түүний элэгдэл, хорогдлыг ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад тусгаснаар 10%-иар тооцов.

[18] Барилга байгууламжийг элэгдэл, хорогдлын зардлыг Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслэлийн нийтлэг жишиг"–т заасны дагуу нэг дэс түшмэлд ноогдох ажлын өрөөний талбай 8$м^2$ талбай байна. Гэх зохицуулалтад үндэслэв. Үнээс 2,300,000,000 төг /4483$м^2$ = 513,049 төг нь 1$м^2$ талбайн өртөг бөгөөд 8$м^2$ талбайн өртөг нь 4,104,394 төгрөг болно. Нэг албан хаагчид оногдох талбайн өртөг 4104394 төгрөг гэж тооцоход элэгдэл хорогдол нь үнийн 1,6%[17] буюу 65670 төг гэж тооцов.

Эх сурвалж: http://www.legalinfo.mn/annex/details/1941?lawid=2888 –

| | |
|---|---|
| ! "#$%&" '() "*&++%", -'(.#.. (/"0"%&""12 ( 3"#4"% (( | 5'565'787 (( |
| 9 %:&4:%'(;<#<&4%2 1 (3"#4"% (( | =>?'@A7 (( |
| ! "#$%%( | &'()*'+&,%( |

%(

-./01.%

| |
|---|
| 2345 6%78#965 %9;"#6%<6;83%/8$:9"8448=%89;84%( |
| B (( |
| C#0&"% (3"#4"% (D(! "#$%&" '() "*&++%", -'(.#.. (/"0"%&""12 (/<<E<</(3"#4"% (D( 9 %:&4:% (;<#<&4<%2 1 (3"#4"% (( |

(

F::#;(/<,GH<&( "I $&%"1 (/.#4 (JJ0:;(, "/K#$"%%"&( 3"#4%2 &( /<<EL<% (1:&( "-$%/"14 (6M?'??D (5'565'787 (D (=>?'@A7B&'()*'+&,%N(1:&(0"O (K0.1 (3++1 (/"L$1 (;<H#( ,O1&" (&+#L"1 (3++1 ("#L"1 (4<%<<1N(/.&#.&$*1 (, "/K#$"%%"&(3"#4"% (JJ0:;().&..4( JJ1$*&(1$*/(& ("%) "1 (;""&P""# (/<<EL<% (&'()*'+&,%N(1:&(0"O (K0.1 (3++1 (/"L$1 (;<H#( ,O1&" (&+#L"1 (3++1 ("#L"1 (4<%<<1N(/.&#.&$*1 (3"#4"% (&"#";""#() "*1"Q(((

?@A<B8;%89;84%(

!+0"4 (3"#4"%4 (/.#$*1 () "*&++%%"&""0 (JJ#:&() $K%JJ%::;4 ()+R+(O, "#(1:&:1( "-$% (J*%P$%&::(&J*E:/&:;:4 (&"#";(3"#4%2 &() $I '(;"#$1 (/+;"*1 ("-$% (J*%P$%&::&( &J*E:/&:;:4 ( 4"&"%4"1 ( &"#";( 3"#4"% ( )+R+( /+;"*%) "% ( ) "*&++%%"&2 1 ( J*%( "-$%%"&""/"* ( ;<%) <</<* ( ;.14%.1&$*1 ( ;O1"%/'( I "%&"%/( ;$*%&:;'( /+0&"*%0"1 ( S#<&#", (;"1&", -() <%<LO#++%";'(/K14K# (3"#%"; (&:; (3:#:&(3"#4"% () "&/"1"Q((

(

T++%$*1 (/.0%$*1 ((=7 (4+&""# (3J*%$*1 (=7Q (4";U(;:0:&/(3""0"1 (4"#"";(J140:1 (@( , :4::%%$*&( VO%"% ( -++%P%"%2 1 ( "0++4"% ( :#;:%0:1 ( /.#$*1 ( 3";$#&""12 ( /.L( ) "*&++%%"&" (E";$, (, :4::%%$*&(0"14 (<#++%";""# (3""0"1QWJ14X((

( ( ( (

- ( "O%%2 1 (, "#I #+/2 1 (, :4::%:%Y(
- ( &"4""42 1 () <%<1 (4</<<42 1 ("O%"&P () <%<1 (-++%P12 () J#/&:%'(, :4::%:%Y(
- ( "O%"% (-++%P%"%2 1 () "*&++%%"&2 1 () J#/&:%'(, :4::%:%Y(
- ( :1:(;++%$*1 (>7 ( 4+&""# ( 3J*%4 ( 3""0"1 ( "O%"% ( -++%P%"%2 1 ( ) J0$*1 ( , :4::%:%Y(
- ( :1:(;++%$*1 (>5 (4J&::# (3J*%4 (3""0"1 (</<&%<; (E:&$*1 (, :4::%:%Y(
- ( :1:(;++%$*1 (5?Q@Z4 (3""0"1 (-++%P4"4 (+P$#P () <%3<I &J* ("R+%'(;"%4L"#/( .LP$1'(/";"% () <%<1 (3<#P$;<4 ("R+%/"* (&"3"#'() "*#I %2 1 (-"&0""%/2 1 ( , :4::%:%Q(

(

!J#/&:%$*1 (1:&40:1 (0"1 () "*&++%";"4 (I ""#4"&4";(0"1;JJ-$%/$*1 (;:, -::&( [.#$*1 ( ;+4"%4"1 ( "L";( "-$%%"&""12 ( E";$, ( 0$0/K, ( \\\Q^ '^abcdQe Z4 ( ) "*#I ++%0"1 (:1:(/.#%$*1 ("-$%'(J*%P$%&::(;+4"%4"1 ("L";( @ ( +#$%&2 1 (J1$*1 ( 4J1&$*1 ( 4+14"- ( ;:, -::&::#( /<<E<- ( J3:;:4 ( >7A ( 0"O[19] ( /.&#.&(!) "*1"Q( f*, ::0(

---

[19] Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем.
Эх сурвалж: https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1579683294306

хуулийн төсөл дэх цахим бүртгэлийн сан байгуулахад шаардагдах нэг удаагийн зардлыг дээрх мөнгөн дүнгээр тооцов.

### 4.3.Зардлыг нэгтгэн тооцож гаргах:

Энэ үе шатанд төрийн захиргааны байгууллагаас буюу төрд үүсэх нийт зардлыг тооцож гаргана. Ингэхдээ хүний нөөцийн зардал, материаллаг зардлын нийлбэрийг хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлэн тооцох ба үүн дээр бусад зардлыг нэмснээр нийт зардлын хэмжээ гарах юм.

| Зардлын төрөл | Зардлын хэмжээ | Хүний нөөцийн хэрэгцээ | Нийт зардал |
|---|---|---|---|
| Хүний нөөцийн зардал | 13,002,270 | 6 | 78,013,623 |
| Материаллаг зардал | 1,952,317 | 6 | 11,713,902 |
| Бусад зардал | 207,000,000 | - | 207,000,000 |
| **НИЙТ ЗАРДАЛ** | | | **296,727,525** |

Дээрх хүснэгтээс харахад хуулийн төсөлд тусгасан ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад **296,727,525** /хоёр зуун ерөн зургаан сая долоон зуун хорин долоон мянга таван зуун хорин тав/ төгрөгийн зардал үүсэхээр байна.

**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДАГУУ ДАРААХ БУСАД ЗАРДАЛ УЛСЫН ТӨСӨВТ ҮҮСЭХ БОЛОМЖТОЙ.** Үүнд:

- Төсөл хөтөлбөр санхүүжүүлэх зардал
- Байгалийн болон соёлын бүтээлийг нөхөн сэргээх, хадгалах хамгаалах зардал
- Хурал зөвлөгөөн, үзэсгэлэн яармаг зохион байгуулах зардал
- Кино, дүрс бичлэг, дуун бичлэг бүтээх зардал
- Ном, сэтгүүл, танилцуулга зэрэг хэвлэмэл бүтээл хэвлэх зардал

Эдгээрийг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн зардлаас гадна "бусад буюу шууд"зардал улсын төсөвт үүснэ гэдийг анхаарах шаардлагатай.

### 3.5.ХУВИЛБАРЫГ НЯГТАЛЖ ХЯЛБАРЧЛАХ БОЛОМЖИЙГ СУДЛАХ:

Хуулийн төслөөс дүгнэлт хийхэд төслийн 18.3.1 дэх хэсэгт Аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн чиг үүрэгт "аялал жуулчлалын бодлого, хууль, хөтөлбөрүүд, бүсчилсэн хөгжлийн болон үндэсний хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх" гэж тусгагдсан нь Байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хэрэгжүүлэх чиг үүрэгтэй давхардсан байх тул үүнийг хасах нь хуулийн төслийг боловсронгуй болгох болон зардлыг бууруулахад чиглэгдэнэ.

----------oOo----------

# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ САЛБАРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ДУНД ХИЙСЭН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ДҮНД ГАРСАН САНАЛЫН ТОВЬЁОГ

| № | Санал хүргүүлсэн | Хаъяа байгууллага, холбоо | Ирүүлсэн санал | Тусгагдсан эсэх |
|---|---|---|---|---|
| 1 | Мөнхжаргал 9112961 | Хүннү Эйр компаний гүйцэтгэх захирал | Энэхүү хуулийн төсөлд дараах нэмэлтүүдийг оруулах саналтай байна. Үүнд:<br>• 14 дүгаар зүйл 14.1.6 “Монгол улсад аялах гадаад жуулчдын урсгал шинээр бий болгох зорилгоор олон улсын нислэг нээж байгаа бол тухайн нислэгт санхүүгийн дэмжлэг үзүүлэх” | **Тусгагдсан.**<br>Хуулийн төслийн 16.1.1-д заасан. |
| | | | • 6 дугаар зүйл 6.2. “Олон улсын Монголд аялах аялал жуулчлалыг экспорт гэж үзэх бөгөөд холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих хөнгөлөлт урамшуулал эдэлнэ.” хэмээн тусгах. | **Тусгагдсан.**<br>Хуулийн төслийн 4.4-т заасан. |
| 2 | Д.Ганболд 91004747 | Нийслэлийн Аялал Жуулчлалын байгууллагын төлөөлөл | Аялал жуулчлалын тухай хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:<br>• “Хил орчмын аялал жуулчлал”гэж тухайн хөрш оронтой байгуулсан Засгийн газар хоорондын гэрээний дагуу хөнгөлөлттэй виз аван хил орчмын жуулчны байгууллагаар үйлчлүүлэн улсын хилээс ..... км тогтоосон бүсэд аялан 24 цагт багтаан буцаж гарах үйл явдлыг, | **Тусгагдаагүй.**<br>Хуулийн төслийн 12.3-т Хил орчмын бүсэд аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах журмыг Засгийн газар батлахаар заасан тул журамд оруулах нь зүйтэй байна. |
| | | | • “Өдрийн гийчин” гэж тухайн улс, орон нутаг, хил орчмын аялал жуулчлалын байгууллагаар үйлчлүүлж 24 цаг хүрэхгүйгээр буцаж буй хүнийг, | **Тусгагдаагүй.**<br>Нэр томьёоны тайлбарт жуулчин болон аялагчийг томьёолсон бөгөөд өдрийн гийчэн гэх томьёоллоыг журам оруулах нь зүйтэй байна. |
| | | | • Хил орчмын жуулчны визний асуудлыг Засгийн газар хоорондын гэрээгээр зохицуулна. | **Тусгагдсан.**<br>Хуулийн төслийн 12.3-т заасан журмаар зохицуулна. |
| | | | • Хил орчмын аялал жуулчлалын харилцааг зохицуулах журмыг Монгол улсын засгийн газраас батална. | **Тусгагдсан.**<br>Хуулийн төслийн 12.3 дахь хэсэг. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | • Хил орчмын жуулчны байгууллагын тусгай зөвшөөрлийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгож гэрээ байгуулна. | **Тусгагдсан.** Хуулийн төслийн 12.1 дэх хэсэг. |
| | | | • Хил орчмын жуулчны байгууллагын үйл ажиллагаанд сум дүүргийн Иргэдийн хурал, Засаг дарга бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавьж ажиллана хэмээн тусгах. | **Тусгагдаагүй.** Ажлын хэсгийн 2022.11.10-ний өдрийн хурлаар хэлэлцэн боломжгүй талаар хариу өгсөн. /Тус хуралд санал гаргасан Д.Ганболд оролцсон болно./ |
| 3. | Б.Индра 99111523 | Үндэсний Аялал жуулчлалын байгууллагын тэргүүн | Аялал жуулчлалын тухай хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:<br>• Аялал жуулчлалын салбар ЖДҮ болон бичил бизнесээс бүрддэгээс гадна дотроо 16 дэд салбарыг уялдуулсан катализт үүрэгтэй тул эдийн засгийн үр өгөөж талыг нь дурьдсанаар холбогдох э/з хөшүүрэг дэмжлэгт илүү хамрагдагдах боломж нь нээгдэнэ. Иймд хуулийн төслийн 1.1 дүгээр зүйлд "байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн үйлдвэрлэл болгон улмаар тогтвортой аялал жуулнлалын тэргүүлэх улс болох зорилгоор" гэх хэсгийг хасахгүй байвал зүйтэй. | **Тусгагдсан.**<br>Хуулийн төслийн 1.1 дэх хэсэг. |
| | | | • Дэлхий даяар төрийн аппаратын ачаалал мөн төсвийн ачааллыг багасгах мөн хувийн хэвшлийг чадавхжуулах хүрээнд олон нийт, хувийн хэвшлийн мэргэжлийн байгууллага болон холбоодуудад тур оператор, тур агент, байршуулах хэрэгсэл, мөн хүний нөөцийн асуудлыг зөвшөөрөл олгох, ангилал тогтоох эрхийн шилжүүлээд багадаа 10 гаруй жил болж байна. Бид олон улсын жишгийн мөрдөх цаг аль хэдийнээ болсон. | **Тусгагдсан.** Хуулийн төслийн 29.1 дэх хэсэгт Аялал жуулчлалын мэргэжлийн холбоог хуулиар байгуулахаар тусгасан. 29.6-д тусгай зөвшөөрөл олгох, бүртгэл хийх эрхийг гүйцэтгэж болохоор болохор заасан. |
| | | | • Энэ хуулийн 7.2-т заасан тур операторын ангиллыг тогтоох журам болон 7.3-т заасан аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зэрэглэл тогтоох журмыг Аялал жуулчлалын мэргэжлийн байгууллага батална хэмээн тусгах. | **Тусгагдаагүй.** Тур операторын ангилал тогтоох журмын заалтыг Тусгай зөвшөөрөл олгохоор төслийн 11-р зүйлд тусгасан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | • Хуулийн төслийн 9.2. дугаар зүйлд "Эрх бүхий байгууллагаас гэрчилгээ авсан хуулийн өмнө харицлага хүлээх насны Монгол Улсын иргэн жуулчны хөтчийн үйлчилгээ үзүүлнэ." хэмээсэн нь Хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхсан асуудалд орох эрсдэл байна! | **Тусгагдсан.** Төслийн холбогдох заалтыг өөрчлөн төслийн найруулж 9.1-д үнэмлэх авсан хүн гэж тусгасан. |
| | | | • Тур оператор, хөтөч, г.м. салбарын гэрчилгээжүүлэлтийг аялал жуулчлалын мэргэжлийн байгууллагууд олгодог байх нь зүйтэй ингэснээр төр болон төреес аялал жуулчлал хариуцдаг төрийн захиргааны байгууллагууд төрийн бодлогын хэрэгжилт, хяналтаа л хийнэ. Энэ нь урт хугацаанд аялал жуулчлалын тогтолцоо, үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хангахаас гадна улсын төсөвт санхүүгийн дарамтыг бууруулдаг. Олон улсын сонгодог туршлага юм. | **Тусгагдсан.** Хуулийн төслийн 29.1 дэх хэсэгт Аялал жуулчлалын мэргэжлийн холбоог хуулиар байгуулахаар тусгасан. 29.6-д тусгай зөвшөөрөл олгох, бүртгэл хийх эрхийг гүйцэтгүүлж болохоор заасан. |
| | | | • Аялал Жуулчлалыг Хөгжүүлэх Сангийн хувьд:<br>Санхүүгийн боломжит эх үүсвэрүүд:<br>1. Улсын төсвийн орлогын тодорхой хувийг аялал жуулчлалыг хөгжүүлэх санд зориулдаг.<br>2. Нийслэл, аймаг, орон нутгийн төсвийн орлогын тодорхой хувийг аялал жуулчлалын санд зориулдаг.<br>3. Байршуулах хэрэгслийн ор/хоногийн татвар буюу нэг зочин/нэг хоногт. Европын Холбооны 18 улсад тус татвар нь харилцан ижилгүй; Зүүн Европын орнуудад илүү бага, жишээ нь: Болгар улсад Euro 0.10 (хамгийн доод) байхад Бельги улсад Euro 7.50 (хамгийн өндөр). Хүүхдүүд татварын хөнгөлөлт эдлэдэг эсвэл бүрэн чөлөөлөгддөг. Итали улсад зочид буудлын зэрэглэлээс хамаарч Euro 1.00 – Euro 5.00 байна.<br>4. Улсын хилээр нэвтрэх үед хурааж авах нэг удаагийн жуулчны татвар буюу tourist tax.<br>5. Аялал жуулчлалын тодорхой сегментийг тодорхой хугацаанд хөгжүүлэхэд зориулсан тусгай татвар, жишээ нь: байгаль орчныг хамгаалах/сэргээх "ногоон татвар". | **Тусгагдсан.**<br>Хуулийн төслийн 16 дугаар зүйлд Аялал жуулчлалыг хөгжүүлэх сан байхаар тусгаж, Дагалдах хуулийн төсөлд сангийн эх үүсвэрийг жуулны нэг удаагийн татвар болон бусад эх үүсвэрийг заасан. |
| 4. | Ч.Буянбадрах 91913166 | Mongolian Guide Tour компанийн захирал | Аялал жуулчлалын тухай хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:<br>• Хуулийн төслийн 1.1 дүгээр зүйлд "Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан иргэн, хуулийн этгээд хооронд үүсэх харилцаа болон төреес аялал жуулчлалыг дэмжих, аялал жуулчлалын нөөцийг хамгаалах, хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино". | **Тусгагдсан.**<br>Хуулийн зорилт хэсэгт "аялал жуулчлалын нөөцийг хамгаалах" гэх агуулгаас бусад нь тусгагдсан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | • Хуулийн төслийн 2.1 дүгээр зүйлд Аялал жуулчлалын тухай хууль тогтоомж нь Иргэний хууль, Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Гадаадын иргэний эрхзүйн байдлын тухай хууль, Төрийн тусгай сангийн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ. | **Тусгагдаагүй.** Аялал жуулчлалын харилцаанд Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Гадаадын иргэний эрхзүйн байдлын тухай хууль зэрэг хууль тогтоомжууд шууд хамааралтай биш тул тусгаагүй. |
| | | | • Хуулийн төслийн 4.1.2 дугаар зүйлд "жуулчин" гэж өөрийн байнга оршин суудаг газар нутгаасаа 183 хоног хүртэлх хугацаагаар суралцах, ажил хөдөлмөр эрхлэхээс бусад зорилгоор аялан явж аялал жуулчлалын байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээг худалдан авч буй гадаад, дотоодын хувь хүнийг, | **Тусгагдаагүй.** Жуулчны нэр томьёог ажлын хэсгийн хурлаар ярилцан, НҮБ-ийн Дэлхийн Аялал жуулчлалын байгууллагаас гаргасан нэр томьёоны тайлбарт нийцүүлэн тусгасан. |
| | | | • Хуулийн төслийн 4.1.4 дүгээр зүйлд "аялал жуулчлалын үйлдвэрлэл" гэж жуулчинд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлалын үйл ажиллагаанд зориулагдсан объект, аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцогч хуулийн этгээд, иргэний үйл ажиллагаа, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг зуучлан оролцож буй хуулийн этгээдээс бүрдэх эдийн засгийг, | **Тусгагдаагүй.** Аялал жуулчлалын үйлдвэрлэлийн ойлголтын хуулийн 4 дүгээр зүйлд 4 заалтаар тодотгон тусгаж, нэр томьёоны тайлбар хэсгээс хассан. |
| | | | • Хуулийн төслийн 4.1.1 дүгээр зүйлд "аялал жуулчлал" гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гадаад, дотоодын зочид, жуулчдад зориулан явагдах бүтээгдэхүүн үйлдвэрлэл, байршуулах үйлчилгээ, зочлох үйлчилгээ, Монгол Улсаас гадаад улс орон руу хийх хил дамнасан аяллын бүтээгдэхүүн, түүний зохион байгуулалт, тэдгээрийг эрхэлж, хүргэж, зуучилж буй гадаад, дотоодын хуулийн этгээд, хувь хүний үйл ажиллагаа, тэдгээрт оролцож буй гадаад, дотоодын аялагч, жуулчид, тэдгээрийн оролцоо, үйл ажиллагааг бүхэлд нь, | **Тусгагдаагүй.** Аялал жуулчлалыннэр томьёог ажлын хэсгийн хурлаар ярилцан, НҮБ-ийн Дэлхийн Аялал жуулчлалын байгууллагаас гаргасан нэр томьёоны тайлбарт нийцүүлэн тусгасан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | • Хуулийн төслийн 4.1.5, 4.1.6 болон 4.1.7 дугаар зүйл хуульд тусгагдах шаардлагагүй гэж үзэж байна. | **Тусгагдсан.** Саналыг хүлээн авч нэр томьёоны тайлбар хэсгийн холбогдох заалтуудыг хассан. |
| | | | • Хуулийн төслийн 4.1.11 дүгээр зүйлд "аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага" гэж эрх бүхий байгууллагаас үйл ажиллагааны зөвшөөрөл авсан зочид буудал, жуулчны бааз, бусад хэлбэрийн байршуулах байр, сууц, зоогийн газар, бусад хоол үйлчилгээний газар, жуулчин тээвэрлэх эрх бүхий тээврийн хэрэгслийг, | **Тусгагдсан.** Хуулийн төслийн 3.1.6 дахь заалтад тусгагдсан. |
| | | | • Хуулийн төслийн 4.1.16 дугаар зүйлд "Жуулчны хөтөч" гэж жуулчинд үндэсний өв соёл, байгаль, газарзүй болон бусад шаардлагатай мэдээллийг өгөх, аяллын бүтээгдэхүүнийг тайлбарлах, газарчлах зорилгоор бэлтгэгдсэнийг гэрчлэх үнэмлэх, сертификаттай Монгол Улсын иргэн хүнийг, Монгол Улсын эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан гадаад иргэнийг, | **Тусгагдсан.** Хуулийн төслийн 3.1.9, 9 дүгээр зүйлд тус тус заасан. |
| | | | • Хуулийн төслийн 8.2.9 дүгээр зүйлд аяллын даатгал хийлгэх, жуулчны аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авах; | **Тусгагдсан** |
| | | | • Хуулийн төслийн 11.2 дугаар зүйлд Эрх бүхий байгууллагаас жуулчинд үйлчилгээ үзүүлэх гэрчилгээ авсан гадаадын иргэн хөтөч тайлбарлагчийн үйлчилгээ үзүүлж болно. | **Тусгагдсан** Энэхүү заалтыг ажлын хэсгийн хурлаар өөрчлөн найруулж 9.1-д тусгасан. |
| | | | • Хуулийн төслийн 12.1 дүгээр зүйлд Жуулчны үйлчилгээ үзүүлэгч иргэн нь жуулчныг нийтийн болон амины орон сууц, гэрт байршуулах, ердийн хөсөг, уналганд сургасан адуу мал, гаршуулсан амьтан унуулах /цааг буга, нохойн чарганы нохой гэх мэт/, хоол ундаар үйлчлэх, усан тээвэр ба хуурай замын тээврийн хэрэгслээр үйлчлэх, бэлэг дурсгалын худалдаа үйлчилгээ эрхлэх, урлаг соёлын үйлчилгээ үзүүлэх, жуулчинд хөтөчлөх /орон нутгийн хөтчүүд, тусгай сонирхлын аяллын хөтөч, газарчууд/, гадаад хэлээр орчуулгын үйлчилгээ үзүүлэх хувь хүн байна. | **Тусгагдаагүй.** Энэхүү заалтыг ерөнхий байдлаар өөрчлөн найруулж дараах байдлаар томьёолсон: 10.1.Жуулчны үйлчилгээ үзүүлэгч иргэн нь өөрийн орон нутгийн онцлогийг илэрхийлсэн бэлэг дурсгалын худалдаа, урлаг, соёлын үйлчилгээ болон бусад аялал жуулчлалын дагалдах бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэх хүн байна. |
| | | | • Хуулийн төслийн 12.4 дүгээр зүйлд Жуулчны үйлчилгээ үзүүлэгч иргэн нь аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталсан "Жуулчны үйлчилгээ үзүүлэгч иргэний үйл ажиллагааг зохицуулах журам"-ыг дагаж мөрдөнө. | **Тусгагдсан** Төслийн 10.3-т Жуулчны үйлчилгээ үзүүлэгч иргэнд дэмжлэг үзүүлэх, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Жуулчны үйлчилгээ үзүүлэгч иргэн нь дараах шаардлагыг хангасан байна.<br>- Монгол Улсын иргэн байх,<br>- Жуулчны үйлчилгээ үзүүлэх техник ур чадварын гэрчилгээ авсан байх,<br>- Жуулчинд жижиг оврын агаарын тээвэр, усан зам, хуурай замын тээврийн хэрэгслээр үйлчлэх иргэн нь тээврийн хэрэгслийн эзэмшлийн гэрчилгээтэй, жолоодох эрхтэй, даатгалтай байх,<br>- Татварын албанд болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлэх. | үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлагыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байхаар заасан тул тус журамд тусгах боломжтой. |
| | | | • Хуулийн төслийн 13.1 дүгээр зүйлд тодорхой газар нутагт байгаль, түүх соёлын нөөцөд түшиглэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх, орон зайн зохистой төлөвлөлтийг бий болгох, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний идэвхтэй харилцааг үүсгэх зорилгоор аялал жуулчлалын бүсийг хөгжүүлж болно. | Тусгагдсан<br>Төслийн 20 дугаар зүйлд саналд тусгагдсан агуулгыг тодорхойлсон. |
| | | | • Мөн Аялал жуулчлалын сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хуулинд маш тодорхой зааж оруулмаар байна. Хэрвээ энэ чигээр нь оруулах юм бол анх хуулинд байсан заалттай адилхан болох бөгөөд явцын дунд бүүр хасаад хаячихсантай адилхан жишээ үлдэнэ. Нийслэл хот үйлчилгээний газруудаас 1%-ийг хот руу татдаг шиг тийм арга механизмыг агуулсан үг өгүүлбэрээр оруулахыг хүсэж байна. Жишээ нь Монгол улсын хил гаалийн боомтод орж буй гадаад жуулчнаас 5 доллар, гарч буй монгол жуулчнаас 10000 төгрөг авахад л Монголын аялал жуулчлалын салбарт олгож буй жилийн төсвийн 3,4-хөн тэрбумыг төгрөгийг хэд нугалах хэмжээний мөнгөн хөрөнгө хуримтлагдах, төвлөрөх боломжтой. ЭНЭ САНААГ ХУУЛИНД ТОДОРХОЙ ЗААЛТААР ОРУУЛЖ ӨГНӨ ҮҮ. Харин дараах саналуудыг "АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САН"-тай холбоотой тусдаа журамд тусгаж өгнө үү. Энэ зорилгыг хэрэгжүүлэхийн тулд бүхий л улс төр, эдийн засгийн түвшинд "лобби"-гоо хийх хэрэгтэй болов уу. Ганцхан УЛСЫН ТӨСВӨӨС БҮРДҮҮЛНЭ гэсэн бүрхэг өгүүлбэр байж болохгүй ээ. | Тусгагдсан<br><br>Хуулийн төслийн дагалдах төслүүдэд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар заасан бөгөөд тус хэсэгт сангийн эх үүсвэрийг санал тусгагдсан эх үүсвэр буюу улсын төсвийн бус эх үүсвэр байхаар заасан. |
| | | | • Тухайлбал Сангийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ.<br>a. Төрийн захиргааны төв байгууллага, агентлаг, төрийн өмчит үйлдвэрийн газар, улсын болон орон нутгийн төсвөөс олгох эх үүсвэр, татаас, санхүүгийн дэмжлэг,<br>b. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй зочлох үйлчилгээний салбарын орлогын ... хувийн татварын орлого,<br>c. Монгол Улсын нутаг дэвсгэрт зорчих жуулчнаас авах хураамжийн орлого, | Тусгагдсан<br><br>Хуулийн төслийн дагалдах төслүүдэд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар заасан бөгөөд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | d. Агаар, төмөр зам, автозамаар гадаад орон руу зорчих зорчигчоос авах хураамжийн орлого,<br>e. Аялал жуулчлалын байгууллагад олгох тусгай зөвшөөрлийн хураамжийн орлого,<br>f. Сангийн үйл ажиллагаанаас олох орлого<br>Хураамжийн хэмжээг Засгийн газраас тогтоож батална.<br>Сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг Засгийн газрын тусгай сангийн хуулиар зохицуулна.<br>Сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөг төрийн захиргааны төв байгууллага жил бүр боловсруулж, Засгийн газар батална. | тус хэсэгт сангийн эх үүсвэрийг санал тусгагдсан эх үүсвэр буюу дараах үүсвэр байхаар заасан:<br>• Казиногийн төлөх онцгой албан татварын орлогын 5 хувь;<br>• Иргэний нисэхийн тухай хуулийн 11.2.16-д заасан аялал жуулчлалын төлбөрийн орлого;<br>• аялал жуулчлалын хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн торгууль, шийтгэврийн орлого;<br>• Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.1.30-д заасан зөвшөөрлийн хураамжийн орлого. |
| | | | • ...... зүйл. Аялал жуулчлалыг дэмжих сангийн зарцуулалт<br>• Сангийн хөрөнгийг дараах зориулалтаар зарцуулна.<br>1. Аялал жуулчлалын зориулалт бүхий барилга байгууламж барих, сэргээн засварлах,<br>2. Аялал жуулчлалын тусгай үйлчилгээний зориулалт бүхий тээврийн хэрэгсэл худалдан авах, засвар үйлчилгээ хийх,<br>3. Аялал жуулчлалын дэд бүтцийг байгуулах, засвар үйлчилгээ хийх,<br>4. Аялал жуулчлалын үндэсний хэмжээний ач холбогдол бүхий судалгаа, эрдэм шинжилгээний төв байгуулах, судалгаа эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх,<br>5. Аялал жуулчлалын брэнд бүтээгдэхүүн болон бүс нутаг, олон улсад өрсөлдөхүйц давуу тал бүхий бүтээгдэхүүн хөгжүүлэх, турших, зах зээлд нэвтрүүлэх төсөл хөтөлбөр, үйл ажиллагааг дэмжих, санхүүжүүлэх,<br>6. Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчилах, хөхиулэн дэмжих үндэсний хэмжээний ач холбогдол бүхий үйл ажиллагаа, арга хэмжээ, хөтөлбөр зохион байгуулах, | **Тусгагдсан**<br><br>Хуулийн төслийн 16 дугаар зүйлд сангийн зарцуулалтыг үндсэн 4 зорилгоор зарцуулахаар заасан бөгөөд тухайн агуулгуудад эдгээр саналууд багтана. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 7. Аялал жуулчлалын брэнд болох хэмжээний ач холбогдол бүхий томоохон арга хэмжээ, эвент зохион байгуулах,<br>8. Жуулчид, ижил эрх ашиг бүхий бүлгүүдийг татах тухайн салбар, чиглэлийн буюу сэдэвчилсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийг дэмжих,<br>• Сангийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой гарах урсгал зардлыг санхүүжүүлэх | |
| | | | • Сангийн хөрөнгийг дараах нөхцөлөөр бизнесийн байгууллагад зээл болон татаас хэлбэрээр олгож болно.<br>1. Гадаадын жуулчдад зориулсан мэдлэг мэдээллийн лавлах, гарын авлага боловсруулах хөтөлбөр хэрэгжүүлэх,<br>2. Аялал жуулчлалын цахим мэдээллийн санг хөгжүүлэх, бүх нийтийн аялал жуулчлалын боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх,<br>3. Аялал жуулчлалын салбарын хүний нөөц болон удирдах ажилтнуудын боловсрол, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх,<br>4. Монголын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг гадаадад сурталчлах, гадаад жуулчдын урсгалыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх,<br>5. Аялал жуулчлалын улирлын уртасгах, улирлын чанартай аялал жуулчлалын эвент арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх,<br>6. Аялал жуулчлалын цогцолбор, аялал жуулчлалын бүсэд жуулчинд зориулсан үзвэр үйлчилгээний байгууламж барих, тоног төхөөрөмж суурилуулах,<br>7. Олон улсын бизнес, эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, сургалт семинар зэрэг албан хэргийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, шинэ төрлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, тэдгээрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зохион байгуулах төсөл, санаачилгыг дэмжих,<br>8. Нийгмийн эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үндэсний аялал жуулчлалын бүтээгдэхүүн, халамжийн хөтөлбөр хэрэгжүүлэх,<br>9. Үндэсний уламжлалт болон үндэсний уламжлалыг сэргээн хөгжүүлэх шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг аялал жуулчлалд ашиглах, жуулчдад сурталчилан таниулах хөтөлбөр хэрэгжүүлэх, | **Тусгагдаагүй.**<br><br>Сангийн хөрөнгийг татаас хэлбэрээр олгох, зарцуулах нарийвчилсан зохицуулалтыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд тусгах боломжтой хэдий ч татаас хэлбэрээр ийнхүү 9 төрлийн үйл ажиллагаанд зарцуулах байдлаар тусгасан практик байхгүй. |
| | | | • Аялал жуулчлалын салбарт бизнесийн байгууллага, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах зорилгоор дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагад сангаас хөрөнгө оруулж болно. Үүнд: | **Тусгагдаагүй.**<br><br>Сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалт хэлбэрээр олгох, зарцуулах нарийвчилсан |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td>1. Аялал жуулчлалын цогцолбор, жуулчдын зорих газруудыг бий болгох, хөгжүүлэх төсөл, хэрэгжүүлж буй байгууллагын төслийн санхүүжилтэд,<br>2. Жуулчид, эрх ашиг бүхий бүлгүүдийн тогтмол урсгал бий болгох тухайн салбар чиглэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах байгууламж, дэд бүтэц байгуулах, технологи нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэх байгууллагын төслийн санхүүжилтэд,<br>3. Олон улсын уулзалт, хурал зөвлөгөөн, үзэсгэлэн, эвент, сэдэвчилсэн арга хэмжээ, сургалт семинар, албан бус арга хэмжээ зохион байгуулах, албан бизнес, ажил хэргийн аялал жуулчлалд зориулагдсан барилга байгууламж, дэд бүтэц барих, өргөтгөх төсөл хэрэгжүүлж буй байгууллагын төслийн санхүүжилтэд,<br>4. Сангаас зээл болон татаас авсан хуулийн этгээд нь уг зээл болон хөрөнгийг гэрээнд зааснаас бусад зориулалтаар ашиглахыг хориглоно.<br>5. Гэрээнд зааснаас бусад зориулалтаар сангийн хөрөнгийг ашигласан тохиолдолд гэрээг цуцалж, хөрөнгийг эргүүлэн татаж, хохирлыг нөхөн төлүүлнэ.<br>6. Сангаас журмын дагуу шаардлага хангасан байгууллагад зээл ба татаас олгоно.<br>• Сангийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан байгууллага, хуулийн этгээдтэй 3 жилийн дотор дахин гэрээ байгуулахыг хориглоно</td><td>зохицуулалтыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд тусгах боломжтой.</td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td>• Аялал жуулчлалын тухай хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:<br>Хуулийн төслийн 1.1 дүгээр зүйлд энэ хуулийн зорилт нь тогтвортой хөгжлийн зорилтот нийцсэн Монгол Улсын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын үйлдвэрлэлийн салбар хоорондын уялдаа холбоог хангах, бизнесийн үйл ажиллагаа, үйлчилгээ эрхлэхтэй холбогдуулан олон улсын байгууллага, хуулийн этгээд хооронд үүсэх харилцаа болон төрөөс аялал жуулчлалыг хөхиүлэн дэмжих, салбар хоорондын хамтын ажиллагааг хангах, дэлхий дахинд Монгол улсыг сурталчлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</td><td>Тусгагдсан.<br><br>Хуулийн зорилт хэсэгт "тогтвортой хөгжлийн зорилтот нийцсэн, салбар хоорондын хамтын ажиллагааг хангах, дэлхий дахинд Монгол улсыг сурталчлахтай" гэх агуулгаас бусад нь тусгагдсан.</td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td>• Хуулийн төслийн 2.1 дүгээр зүйлд Төрөөс экспортыг дэмжих тухай, Татварын хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиуд, Төрөөс төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль нэмж оруулах</td><td>Тусгагдаагүй.<br><br>Эдгээр хууль тогтоомжууд нь Аялал жуулчлалын шууд зохицуулалтыг агуулдаггүй бөгөөд Монгол Улсын иргэн, хуулийн этгээд эдгээр</td></tr>
</table>

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | хууль тогтоомжийг заавал дагаж мөрдөх шаардлагатай тул Аялал жуулчлалын тухай хуульд тусгах шаардлагагүй. |
| | | | • Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд "Аялал жуулчлалын үйлдвэрлэл" гэж эхлэх. **Дэлхийн** Аялал Жуулчлалын байгууллагын гаргасан тодорхойлолтыг оруулах. | **Тусгагдсан.**<br><br>НҮБ-ын **Дэлхийн** аялал жуулчлалын байгууллагын гаргасан нэр томьёоны тайлбарын "Tourism industries"-д нийцүүлэн аялал жуулчлалын үйлдвэрлэлийг хуулийн төслийн 4-р зүйлд тусгасан. |
| | | | • Аялал жуулчлалын үйлдвэрлэл нь дараах салбаруудаас бүрдэнэ. Үүнд<br>- Тээврийн үйлчилгээ / Transportation /<br>- Байршуулах хэрэгсэлүүд / Accomodation /<br>- Хоол ундааны үйлчилгээ / Food and Beverage service sector /<br>- Амралт, зугаа цэнгэлийн үйлчилгээ / Recreation and Entertainment /<br>- Жуулчны үйлчилгээ / Travel service / Энэ 5-н бүрэлдэхүүнээ томъёолоод явах саналтай байна. Бусад нэр томъёог хасах саналтай байна. Оновчтой үгээр илэрхийлж чадаагүй байж болох тул саналаа хэлээрэй | **Тусгагдсан.**<br><br>Хуулийн төслийн 4-р зүйлд ирүүлсэн санал тусгагдсан үйлчилгээний салбаруудыг тусгасан. |
| | | | • Хуулийн төслийн 2 бүлгийн жуулчлалын үйл ажиллагаа Энэ хэсэгээ тохирчихвол дараагийн бүлгүүд рүү өөрчлөлт хийгээд орох саналтай байна. 6, 7 , 8,9, 11, 12 –г өөрчлөх. | **Тусгагдсан.** |
| | | | • Хуулийн төслийн 13.2.1 дүгээр зүйлд Аялал жуулчлалын бүс Үүнийг задалж **тодорхой болгомоор** байна. Жишээлбэл: Жуулчны үзмэр /attraction / -р **байршуулах** хэрэгсэлийг 1 км радиус дотор байршуулахгүй гэх мэт. **Учир нь: Хэрэв** ийм зохицуулалт хийвэл эдийн засгийн нэлээд ашигтай **байна. Тухайн** газарт зарцуулах ор хоног нэмэгдэнэ мөн нэмэлт үйлчилгээгээр **орлог олох** боломж нэмэгдэнэ. | **Тусгагдаагүй.**<br><br>Аялал жуулчлалын тухай хуульд аялал жуулчлалын бүсийн талаарх зохицуулалтыг тусгасан бөгөөд улсын аялал жуулчлалын бүсэд тухайн бүсэд байрлах үзмэр, аялал жуулчлалын |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | нөөцтэй холбоотой зохицуулалтыг Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хийхээр, орон нутгийн аялал жуулчлалын бүсийг харьяалах Засаг дарга зохицуулахаар тусгасан холбогдох төлөвлөлтөд тусгах боломжтой. |
| | | | • Хуулийн төслийн 5.1.1 дүгээр зүйлд аялал жуулчлалыг зохион байгуулах үйлчилгээ Үүнийг сайн ойлгохгүй байна. Аялал жуулчлалыг үйлчилгээ гэхээр доорх бүгдийг гэж ойлгогдож байна. Энэ хэсэг АЖ-н үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсэгт орж байгаа байгууллагуудаа томъёолж болох уу | **Тусгагдсан.**<br>Аялал жуулчлалыг зохион байгуулах үйлчилгээнд тур оператор, аяллын агентын үйл ажиллагаа орохоор тусгасан. |
| | | | • Хуулийн төслийн 14.1 дүгээр зүйл дээр Хүний нөөцийг чадавхижуулах гэж нэмэх | **Тусгагдаагүй.**<br>Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулах чиг үүргийг Засгийн газар болон салбарын мэргэжлийн холбоод хэрэгжүүлэхээр тусгасан. |
| 5. | С.Мөнхбат 91915533 | Монголын Зочид буудлуудын холбооны ерөнхийлөгч | • Сангийн зарцуулалт дараах чиглэлтэй байх<br>1. Монгол улсыг ОУ-д сурталчилах. Үүнд контент бүтээх, эвент арга хэмжээ зохион байгуулах, санхүүжүүлэх<br>2. Хүний нөөцийн хөгжүүлэх мэргэшүүлэх, сургах ажлын байр нэмэгдүүлэхэд<br>3. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх / / Идэвхигүй улиралд нислэгт татаас өгөх, зээлийн хүүгийн зөрүүг даах гэх мэт /. | **Тусгагдсан.**<br><br>Хуулийн төслийн 16 дугаар зүйлд сангийн хөрөнгийг санал тусгагдсан байдлаар зарцуулах агуулгыг тусгасан. |
| 6. | Нараа 99030928 | "Номадик" ХХК | Аялал жуулчлалын тухай хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:<br>• Жуулчны эрх үүрэг хуулинд байх ёстой. Хуулинд нэр томъёо болон бусад оролцогчдын эрх үүрэг хариуцлага гээд олон зүйлсийг илүү тодорхой нэмэх хэрэгтэй санагдсан. Тухайлбал жуулчны визтэй холбоотой асуудалд энэ эрх үүргийг үндэслэл болгож хэрэглэх, АЖ компаниуд гэрээ байгуулахдаа үндэслэл болгох гэх мэт. | **Тусгагдаагүй.**<br>Жуулчны эрх, үүргийг төсөлд тусгасан байсан хэдий ч ажлын хэсгийн гишүүдийн нийт саналаар хассан бөгөөд Гадаадын иргэний эрх зүйн байдлын |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | тухай хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасны дагуу, мөн Тур оператор, аяллын агенттай байгуулсан гэрээгээр зохицуулагдах боломжтой. |
| | | | • Жуулчин хувиараа аялж байгаа тохиолдолд, ТО аар үйлчлүүлээлээд хохирох тохиолдолд . Жуулчид МУ ын талаар илтэд худлаа мэдээлэл цацах, тараах, хууль бус үйлдэл гаргах зэргийг яаж шийдэх үү? Жуулчин чинь бидний нэг харилцагч субьект мөн биз дээ? Ер нь шийдэгддэггүй маш олон асуудал гардаг. ТО компаниуд түнштэй бол гэрээгээ хийгээд даатгал бүх асуудлуудаа хуулийн дагуу хийгээд харьцангуй болоод байна. Гэтэл ямар нэгэн юм болоход английн хуулиар шийднэ гээд заалт оруулаад ирдэг. Эх газрын буюу эсвэл тухайн орны хуулийн хамгаалалт барих үндэслэл байхгүй тул ТОууд зөвшөөрөхөөс өөр аргагүй болдог. Арбитр дээр ч ялгаагүй. Нөгөө талаас жуулчид ТО тай шууд гэрээ хийх тохиолдолд бид бас тодорхой хуулийн заалтуудыг эрх үүрэг дээр нь үндэслэл болгож тавьж өгөх шаардлагатай байдаг. Визгүй орнуудаас насанд хүрээгүй хүүхдүүд ирээд аялвал яах вэ ч гэсэн кэйс байдаг. Тухайн орны аялал жуулчлалын хуулийг судлаад ирж байгаа ч хүн байдаг. Ганц хэдхэн байгууллага салбар гээд явцуурмааргүй байнаа. ЭСЯ даас хүртэл санал авмаар байгаа. | **Тусгагдаагүй.** Жуулчны эрх, үүргийг төсөлд тусгасан байсан хэдий ч ажлын хэсгийн гишүүдийн нийт саналаар хассан бөгөөд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасны дагуу зохицуулагдах боломжтой гэж үзсэн болно. |
| | | | • Жуулчны хөтчийн гэрчилгээг ТО ын гэрчилгээг олгодог шиг Төрийн чиг үүргийг ТББ олгох гэдэг шиг гэрээний үндсэн дээр яамнаас баталсан журмынх нь дагуу явах саналтай байдаг. | **Тусгагдсан.** Хуулийн төслийн 29.6-д жуулчны хөтчийн үнэмлэх олгох, бүртгэх чиг үүргийг мэргэжлийн холбоо гүйцэтгэж болохоор заасан. |
| | | | • 3.1.8 жуулчны хөтөч нэр томьёон дээр тайлбар - тайлбарлан таниулах, аяллыг удирдан зохион байгуулах гэсэн үг хэрэглэх саналтай байна. Хөтлөн явуулах гэдэг үг нийцэхгүй байна. Тур агентийн тодорхойлолтоо хувь хүн гэснээ 5.6 ТО ТА нь нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлсэн байх гэж оруулсан байна. Жуулчны хөтөч бол аяллын компанийн жуулчинтай харилцан тохиролцсон маршрутын дагуу үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй гэсэн үндсэн санааг анхааралдаа авч үзэхийг хүсэж байна. | **Тусгагдаагүй.** Жуулчны хөтчийг жуулчинд үндэсний өв соёл, байгаль, газар зүйн онцлог болон шаардлагатай бүхий л мэдээллийг хүргэж аяллыг хөтлөн явуулах энэ хуульд заасан шаардлага хангасан хүнийг ойлгохоор зохицуулсан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 7 | Б.Мөнхбат 99168471 | Монголын хөтөч тайлбарлагч нарын холбоо | Аялал жуулчлалын тухай хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:<br>• Жуулчны үүрэг хариуцлага бүлэг болгож тусгах шаардлагагүй шүү дээ. Энэ харилцаа иргэний хуулийн хүрээнд үйлдэгдэж болно. | **Тусгагдсан.** Жуулчны эрх, үүргийг хасаж, жуулчны аюулгүй байдлыг хангах зохицуулалтуудыг тодорхой тусгасан. |
| | | | • Зэрэглэлийн комисс, тогтмол үйл ажиллагаатай байх. Албан ёсны эрх бүхий үнэлгээчин, үнэлгээ баталгаажуулагч нар байх. | **Тусгагдаагүй.** Жуулчны хөтчийн зэрэглэл тогтоох комиссын талаарх зохицуулалт тусгагдаагүй. Хуулийн төслийн 9.3-т заасан журмаар зохицуулагдах боломжтой. |
| | | | • "Жуулчны хөтөч"-д холбогдох журамд саналаа хүргүүлэн, боловсруулах ажилд хамтран ажиллаж байна. | **Тусгагдсан.** Монголын хөтөч тайлбарлагч нарын холбооны төлөөлөлтэй хамтран хуулийн төслийн 9.3-т заасан журмын төслийг хамтран боловсруулж байна. |
| 8 | Батболд | Монголын Аялал Жуулчлалын холбоо | Аялал жуулчлалын тухай хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:<br>• Хуулийн төсөл дээр АЖ-ын мэргэжлийн байгууллага гэсэн зохицуулалт байхгүй байх шиг харагдсан. Уул нь өмнөх төсөл дээр нь манайхаас оруулж өгч байсан. ДАЖБ-аас өмнө хуулийн төсөлд өгсөн санал дээр мөн тусгасан байсан. Бид өөрсдийгөө мэргэжлийн холбоо гэж ярьж бичээд байгаа боловч АЖ-ын мэргэжлийн байгууллага гэсэн зохицуулалт байхгүй. | **Тусгагдсан.** Хуулийн төслийн 29 дүгээр зүйлд Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны зохицуулалтыг албан ёсоор хуульчилсан. |
| | | | • Салбар хоорондын, лизенц зөвшөөрөл, үйлчилгээний, гээд хяналтын тогтолцоогоо ангилж байгаад л схемээ гаргавал. Эрх бүхий байгууллага, мэргэжлийн холбоо , мэргэжлийн байгууллага гэж тодорхойлоод байгааг илүү ойлгомжтой тодорхойлох шаардлагатай байх. | **Тусгагдсан.** Хуулийн төслийн 29 дүгээр зүйлд Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны зохицуулалтыг албан ёсоор хуульчилсан бөгөөд тухайн хэсэгт дурдагдсан нэр томьёог бусад хэсэгт ижил байдлаар ашигласан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | • Хуулийн төслийн 29.2 дугаар зүйл дээр энэ хуулийн 5.2.1-д заасан тур операторын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь Холбоонд заавал гишүүн болох үүрэгтэй. Хүчээр гишүүн болгодог нь ОУ-ын туршлага уу? | Олон улсад гэхээс илүүтэйгээр энэхүү практик нь манай улсад тогтсон бөгөөд Тусгай зөвшөөрөлтэй |
| | | | • Хуулийн төслийн 9.1. заалтанд Аялал жуулчлалын мэргэжилтэй гэсэн гурван үг нэмэх нь саналтай байна. Хуулийн төслийн 9.1. Аялал жуулчлалын мэргэжилтэй, эсхүл хөтөч, тайлбарлагчийн сургалтад хамрагдаж, энэ хуулийн 29.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бүртгүүлж, үнэмлэх авсан хүн жуулчны хөтчийн үйлчилгээ үзүүлнэ. | **Тусгагдсан.** |
| 11 | Барсболд Батаасүрэн 99110410 | Монголын Аялал Жуулчлалын холбоо | Аялал жуулчлалын тухай хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:<br>• Тур операторын эрх үүрэг Аялал жуулчлалын мэргэжлийн холбоонд (29 зүйл) хамаарах юм байна. Буудлууд, жуулчны бааз амралтын газрууд, зоогийн газрууд, хөтөч жолооч, тогооч, сургалтын байгууллгууд холбогдох газрыг бас зааж өгөх нь зөв гэж бодож байна.<br>• Аялал жуулалчлал салбар хүний үйл ажиллагаа хамгийн их шаарддаг, өнгөрсөн 2 жилийн хугацаанд ажлын байр 63% буурсан. Иймд АЖ хөгжүүлэх сан 16 заалтанд "Аялал жуулчлалын хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх" гэж оруулах саналтай байна. Аялал жуулчлалын үйлдвэрлэл хэмээх нэршил дээр эсрэг байр суурьтай байна. 1. Салбар нь хэд хэдэн үйлдвэрлэлээс бүрддэг. Жишээ нь: Санхүүгийн салбар нь банк, даатгал, хөрөнгийн менежмент гэх мэт хэд хэдэн үйлдвэрлэлээс бүрдэж байна. Аялал жуулчлалын салбар нь тур операторууд, зочид буудал, бааз, авиа компани гэх мэт хэд хэдэт үйлдвэрлэлээс бүрдэх нь. 2рт Хуулинд үйлдвэрлэл гээд бичээд явах гэхээр сонсогдох байдал, хэллэгийнг хувьд таарамжгүй байна. Жишээ нь: Аялал жуулчлалын үйлдвэрлэлийн хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх эсвэл Аялал жуулчлалын салбарийн хүний нөөцийг бэлтгэх гэх үү. | **Тусгагдсан** |
| 12 | Бадам 99004797 | Монголын Аялал Жуулчлалын холбоо | Аялал жуулчлалын тухай хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:<br>• Өмнө тавьсан илтгэлээс ялгаатай зүйлс, нэмэгдэж хасагдсан онцолсон зүйлсийг тодотгох<br>• Хуралдааны үеэр өгсөн чиглэл, тавьсан санал, асуулга, тодруулга, шаардлагыг тусгасан эсэх<br>• Хэлэлцүүлэх, чиглэл авах хувилбар, саналыг тодотгох (Тухайлбал маргаантай асуудал байгаа эсэх)<br>• Цаашид яах вэ, хугацаат ажил, чиг үүргийг тодотгох. Ямар дэмжлэг шаардлагатай байна. | **Тусгагдсан** |
| 13 | Нэргүй 99112402 | Нью жуулчин турс | Аялал жуулчлалын тухай хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:<br>• Аялал жуулчлал бол экспорт гэсэн хуучин заалт нь байхгүй бна.шаардлагагүй гэж үзсэн юм болов уу? НӨТ чөлөөлөх гол заалт | **Тусгагдсан** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | гэжанх үзэж байсан.Мөн эспортын хөнгөлөлтөнд хамрагдах боломжтой.НӨТ -өөс чөлөөлнө гэсэн заалт нь хасагдсан бна.НӨТ-ийн хуулиар зохицуулагдана гэж үзсэн үү? | |

# Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулга

ТӨСЛИЙН ФАЙЛЫГ ТАТАХ

## ТӨСЛИЙН ХАВСРАЛТУУД

Үзэл баримтлал

Танилцуулга

Дагалдах хуулиуд

Судалгаа, лавлагаа, тооцоо, бусад мэдээлэл

2022-11-18 at 5:30 pm

Posts About Photos ▾ Mentions

**БОАЖЯ-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газар** is at **Туушин**.

Posted by Batsukh Bolortuya
3 Nov · Ulaanbaatar ·

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэж байна.

⚖️ Аялал жуулчлалын тухай хууль 2000 онд батлагдсан цагаасаа хойш 12 удаа нэмэлт, өөрчлөлт орсон боловч нь энэ нь бусад хуулийг даган өөрчлөгдсөн байдаг.

⚖️ Өнгөрсөн хугацаанд тус хуулийг шинэчлэн батлуулахаар үе үеийн салбарын удирдлага, аж ахуй нэгж байгууллагууд ажиллаж ирсэн.

⚖️ Монгол Улсын Засгийн газраас 2023, 2024 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан Аялал жуулчлалын тухай хуулийг ондоо багтаан батлуулах зорилготой байна.

⚖️ Аялал жуулчлалтай шууд болон шууд бусаар холбогдож буй аж ахуй нэгж, үйлчилгээ үзүүлж

⚖️ Монгол Улсын Засгийн газраас 2023, 2024 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан Аялал жуулчлалын тухай хуулийг ондоо багтаан батлуулах зорилготой байна.

⚖️ Аялал жуулчлалтай шууд болон шууд бусаар холбогдож буй аж ахуй нэгж, үйлчилгээ үзүүлж буй малчин иргэний асуудал ч тус хуульд хамаарах тул салбарын төлөөлөл идэвхтэй оролцож байна.



# УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНД ОРОЛЦОХ НЭРС

*Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэх*

| № | ОВОГ, НЭР | АЛБАН ТУШААЛ |
|---|---|---|
| 1 | Б.Бат-Эрдэнэ | Байгаль орчин, аялал жуулчлалын сайд |
| 2 | Х.Нямбаатар | Хууль зүй, дотоод хэргийн сайд |
| 3 | Э.Баттулга | Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| 4 | П.Сайнзориг | Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| 5 | Б.Болортуяа | Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга |
| 6 | Б.Буяннэмэх | Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ногоон хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын дарга |
| 7 | С.Цогтгэрэл | Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хуулийн хэлтсийн дарга |
| 8 | П.Цогтсайхан | Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Амьтан, ургамал, байгалийн нөөцийн хэлтсийн дарга |
| 9 | Д.Цолмон | Хууль зүй, дотоод хэргийн яамны газрын дарга |
| 10 | Н.Жамъянхүү | Хууль зүй, дотоод хэргийн яамны ах шинжээч |
| 11 | Д.Гансүх | Судлаач, доктор |
| 12 | Д.Гантөмөр | Монголын аялал жуулчлалын холбооны тэргүүн |
| 13 | Р.Лхагвабаяр | “Монголын эрх зүйн судалгаа хөгжлийн төв” ТББ-ын хуульч, судлаач |